



ОЮУНЛАГ БҮТЭЭЛЧ СЭТГЭЛГЭЭНИЙ ТӨЛӨӨ

ЦАЦ

**СУРГАЛТ, СУДАЛГАА,
АРГА ЗҮЙН УЛИРАЛ
ТУТМЫН СЭТГҮҮЛ**

/№27/50 2024

■ Н

■

■

■



ҮНДЭСНИЙ БАТЛАН ХАМГААЛАХЫН ИХ СУРГУУЛИАС ЭРХЛЭН ГАРГАВ





ОЮУНЛАГ БҮТЭЭЛЧ СЭТГЭЛГЭЭНИЙ ТӨЛӨӨ

СЭТГҮҮЛИЙН РЕДАКЦИЙН ЗӨВЛӨЛ

Ерөнхий эрхлэгч:

Хурандаа Б.Өлзийхуяг ҮБХИС-ийн Эрдэм шинжилгээ, хамтын ажиллагаа хариуцсан дэд захирал, доктор (Sc.D), профессор

Хариуцлагатай нарийн бичгийн дарга:

Хошууч Д.Идэшноров ҮБХИС-ийн Эрдэм шинжилгээ, инновацын хэлтсийн дарга, доктор (Ph.D)

Редакцийн гишүүд:

Хошууч Л.Одмаа ЦНДС-ийн Цэргийн холбоо, кибер аюулгүй байдлын тэнхимийн ахлах багш, доктор (Ph.D)

Б.Баатарсүрэн БХЭШХ-ийн Батлан хамгаалахын дүн шинжилгээний төвийн эрдэм шинжилгээний ажилтан, доктор (Ph.D)

Х.Орхончимэг БХЭШХ-ийн Аюулгүй байдал, батлан хамгаалах судлалын төвийн эрдэм шинжилгээний ажилтан, доктор (Ph.D)

Техник редакцийн гишүүд:

Д.Энх-Од Техник редактор
Д.Насанжаргал Дизайнер

Редакцийн хаяг:

Монгол Улс, Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг, БНМАУ-ын баатар Д.Нянтайсүрэнгийн гудамж, 16 дугаар хороо, Улаанхуаран

Утас/факс: 976 11 480172

Шуудангийн хайрцаг: 13300

Веб хаяг: www.mndu.gov.mn

Цахим шуудан: tsats@mndu.gov.mn

Олон улсын индекс: ISSN 2313-8076

Эрхлэх байгууллага: Монгол Улсын Үндэсний батлан хамгаалахын их сургууль

Хэвлэх үйлдвэр: ҮБХИС-ийн ЭШИХ-ийн Хэвлэх үйлдвэр



FOR INTELLECTUAL AND CREATIVE THINKING

EDITORIAL BOARD

Editor-In-Chief:

Colonel Ulziikhuyag.B Deputy Director for Research and cooperation, MNDU, Prof. (Sc.D)

Deputy Editor-In Chief:

Major Ideshnorov.D Chief of Division for Research and innovation, MNDU, Ph.D

Editorial Panel:

Major Odmaa.L Senior Lecturer of Military Signaling and cyber security Department of Joint Military School, MNDU, Ph.D

Baatarsuren.B Research fellow, Center of Defense Analyses, Institute of Defense Studies, MNDU, Ph.D

Orkhonchimeg.Kh Research fellow, Center of Security and Defense Studies, Institute for Defense Studies, MNDU, Ph.D

Technical Editor:

Enkh-Od.D Technical editor

Nasanjargal.D Designer, Illustrator

Address:

Mongolian National Defense University
Nyantaisuren Street, Bayanzurkh District, Ulaanbaatar, Mongolia, 13300

Phone: 976 11 480177

Fax: 976 11 480172

Mail box: 13300

Website: www.mndu.gov.mn

E-mail: news@mndu.gov.mn

ISSN: 2313-8076

Host: Mongolian National Defense University

Published by: Defense Press



ҮНДЭСНИЙ
БАТЛАН ХАМГААЛАХЫН
ИХ СУРГУУЛИАС
ЭРХЛЭН ГАРГАВ.

2024
№ 27/50/

СУРГАЛТ,
СУДАЛГАА, АРГА
ЗҮЙН УЛИРАЛ
ТУТМЫН СЭТГҮҮЛ

ДУГААРЫН ТОВЧООН

Аюулгүй байдал, батлан хамгаалах судлал

Аюулгүй байдал, батлан хамгаалах судлал	6
Монгол– Британийн цэрэг, батлан хамгаалахын гадаад харилцаа, хамтын ажиллагааны товч түүхэн тойм, хөгжлийн цаашдын хэтийн төлөв		14
НАТО ба Япон улсын хамтын ажиллагааны түүхэн тойм		18
Зүүн хойд азийн аюулгүй байдлын орчны өөрчлөлт ба БНСУ–Монгол Улсын хамтын ажиллагааны хэрэгцээ		23
<u>Батлан хамгаалах боловсрол, цэргийн сургалт</u>		30
		35

41

Судалгаа, боловсруулалтын ажил

Мэргэдийн сургаалиас эшлэн мэдлэг бүтээх ур ухаан хүртэлх асуудал, шийдэл		47
Батлан хамгаалахын политехник коллежийн эмэгтэй сонсогчдод тулгамдаж буй асуудлууд түүнд хийсэн шинжилгээ		55
Англи хэлний сургалтад “ухамсарлан харилцах –каллан” арга зүйн хувилбар боловсруулан туршсан нь		60
Дээд боловсролын сургалтын байгууллагын мэдээллийн системийн өнөөгийн байдалд хийсэн судалгаа		66
Оюутан төвтэй суралцахуй багшлахуйн үйл явцыг үнэлэх нь		72

80

Цэргийн зэвсэглэл техник, инновац судлал

Телло дрон ашиглан зургаар өгөгдсөн байг илрүүлэн устгах боломжийн судалгаа		
---	--	--

86

Шинжлэх ухаан судлал, дайны туршлага сургамж

		96
VIII Богд Жавзандамба хутагтын тусгаар тогтнолоо олон улсад хүлээн зөвшөөрүүлэх дипломат гадаад бодлогын зарим асуудал		102
Монгол цэргийн урлагийн түүх бичлэгийн асуудалд		108

112

116

120

125



МОНГОЛ–БРИТАНИЙН ЦЭРЭГ, БАТЛАН ХАМГААЛАХЫН ГАДААД ХАРИЛЦАА, ХАМТЫН АЖИЛЛАГААНЫ ТОВЧ ТҮҮХЭН ТОЙМ, ХӨГЖЛИЙН ЦААШДЫН ХЭТИЙН ТӨЛӨВ

Р.ОНОН /УБХИС-ийн ГХСТ-ийн Англи, герман хэлний багш, докторант/

Түлхүүр үг: Энхийг дэмжих ажиллагаа, НАТО, Хүйтэн дайн, англи хэлний сургалт, харилцан айлчлал, цэргийн сургуулилалт

Key words: Peacekeeping operations, NATO, Cold War, English language mutual visit, military training

Хураангуй. Энэхүү өгүүлэлд Монгол–Британийн цэрэг, батлан хамгаалахын гадаад харилцаа, хамтын ажиллагааны хөгжлийн түүхэн товч тоймыг зарим талаас нь авч үзэхийг зорив.

Өнгөрсөн зуунд Британи улс нь тухайн үеийн БНМАУ–тай анхны өрнөдийн улсуудаас анх 1963 онд дипломат харилцаа тогтоосон нь хоёр туйлт ертөнц ноёлсон “Хүйтэн дайн” гэх тухайн цаг үед ховор сонин содон үйл явдал байв.

Энэхүү үйл явдал зөвхөн манай хоёр улсын найрсаг харилцааны тулгын чулууг тавьсан төдийгүй Өрнөдийн буюу хуучин цагт бидний хэлж заншсан бусад хөрөнгөтөн оронтой харилцаа тогтоох боломж, бололцоог ч зарим талаар мөн адил нээж өгчээ.

2000–аад оноос хойш, ялангуяа дэлхийн халуун цэгт Монгол Улсын Зэвсэгт Хүчин НАТО–ийн тэргүүлсэн энхийг сахиулан дэмжих олон үндэстний цэргийн ажиллагаанд идэвхтэй оролцох болсон нь Британи болон Монгол Улсын цэрэг, батлан хамгаалах харилцаа, хамтын ажиллагаа улам бүр эрчимтэй хөгжих шалтгаан нөхцөлийг бүрдүүлсэн юм.

Хоёр улсын батлан хамгаалахын салбарын цаашдын харилцаа, хамтын ажиллагаа дээр дурдагдсан ажил, арга хэмжээгээр хязгаарлагдахгүй, нөөц бололцоо нь шавхагдашгүй бөгөөд цаашид өөр олон төрлийн агуулга, хэлбэрээр баяжин хөгжих ирээдүйтэй гэдэг нь дамжиггүй-юм.

Оршил. Хуучин ЗХУ, Америк, Англи, Франц тэргүүтэй ялагч гүрнүүд 1945 онд фашист Герман улсыг үг дуугүй бууж өгөх гэрээнд гарын үсэг зуруулж, 4 жил орчим үргэлжилсэн дэлхийн түүхэнд хамгийн олон сая хүний амь

нас, эд материалын гарз хохирол учруулсан дайн сая нэг юм шувтарсан билээ. Харамсалтай нь дэлхийн дайнд ялагчаар тодорсон их гүрнүүд болох хуучин ЗХУ болон Америк тэргүүтэй улсууд бусад зарим улс орнуудад өөрийн нөлөөгөө тогтоох, дотоод хэрэгт нь шууд ба шууд бусаар гаднаас оролцож улмаар тэрхүү орнуудыг өөрсдийн дохио зангаагаар хөдөлдөг дэглэмт улсыг алсаас удирдах маягаар явж ирсэн нь хоёр туйлт систем тогтох хөрс суурь бүрдүүлсэн. Энэхүү “Хүйтэн дайн”–ны гэх цаг үеийн дайсагналцал мөнөөх хоёр системийн ил, далд сөргөлдөөн 1990–ээд он хүртэл бараг 40 орчим жил үргэлжилсээр 1991 онд хуучин ЗХУ задарч 10 гаруй бие даасан улс болсноор дууссан гэж үзэж болно.

Дээр дурдсан цаг үеийн туршид БНМАУ хуучин ЗХУ тэргүүтэй бусад социалист гэх улс орнууд дэлхийн бусад орнуудтай ч мөн адил эрх тэгш, ижил өргөн харилцаа хамтын ажиллагааг хөгжүүлэхийн төлөө зүтгэсний эцэст 1961 оны 10 дугаар сарын 27–нд НҮБ–ын бүрэн эрхт гишүүн болж тусгаар улсаа дэлхий дахинд тунхагласан билээ.

Дэлхийн хамтын нийгэмлэгийн нэгэн гишүүн болсон хэдий ч хуучин ЗХУ–аас хараат хэвээр, бие даасан гадаад бодлого явуулах боломж, бололцоо тэр бүр олддоггүй байсан тухай ахмад дипломатч нарын дурсамж яриа, зарим ном зохиолд цөөнгүй дурдагддаг.

Энэхүү бүх хүндрэл бэрхшээлийг үл хайхран тухайн үеийн төр засгийн тэргүүн, удирдагч, дипломатч нарын эх оронч зүрх сэтгэл, уйгагүй хүчин чармайлт, оролдлого, хичээл зүтгэлээр бидний хуучин хэлж заншсанаар капиталист гэх зарим Өрнөдийн орнуудтай харилцаа, холбоо тогтоож чадсан юм.




Тэрхүү улс гүрний хамгийн анхдагч нь дэлхийн улс төр, эдийн засгийн гол бодлогыг тодорхойлогч их гүрэн, НҮБ-ын байнгын 5 гишүүн орнуудын нэг болох ИБУИНХУ билээ. Нэгдсэн Хаант Улсын Гадаад хэрэг, хамтын нөхөрлөл, хөгжлийн асуудал хариуцсан төрийн сайд, хатагтай Анне-Мари Тревелян харилцаа тогтоосон тухайд "...We highly value our relationship with Mongolia and remain proud of being the first Western nation to establish relations, all the way back in 1963, though our historic relationship dates back even further¹" гэж онцлон тэмдэглэсэн байдаг. Тус улстай хамгийн анх харилцаа холбоо тогтоосны гол ач холбогдол нь мөнхүү улсаар дамжуулан өрнөдийн бусад улс, орнуудтай харилцаа хамтын ажиллагааг хөгжүүлэх үүд хаалгыг нээж өгсөн, гол гарц буюу анхны шанг нь татаж өгсөн явдал гэж үзэх бүрэн үндэстэй².

Ийнхүү БНМАУ-ын хувьд тус улс нь дипломат харилцаа албан ёсоор тогтоосон дэлхийн 25 дахь улс болжээ. Одоогоор манай улс "дэлхийн 193 улстай албан ёсоор дипломат харилцаатай"³. Хамгийн сүүлд "2023 оны 12 сарын 06-нд АНУ-ын Нью-Йорк хотод Ботсвани улсын Гадаад хэргийн сайд Лемоган Квапетай манай улсын Гадаад хэргийн дэд сайд Г.Амартүвшин гарын үсэг зурснаар НҮБ-ын гишүүн бүх улстай дипломат харилцаа тогтоох зорилгоо хугацаанаасаа өмнө биелүүлжээ"⁴.

Ийнхүү "дипломат харилцаа тогтоосноос хойш манай хоёр орны найрсаг харилцаа, хамтын ажиллагаа худалдаа хөрөнгө оруулалт, боловсрол, ардчиллыг бэхжүүлэх, иргэдийн тэгш эрхийг хангах, хүрээлэн буй байгаль дэлхийгээ хайрлан хамгаалах, олон улсын энх тайван, аюулгүй байдал"⁵ зэрэг олон салбарт эрчимтэй хөгжсөөр иржээ.

"...Монгол орны гадаад харилцаанд тус

оронтой харилцах харилцааны гүйцэтгэх үүрэг зэрэг олон асуудал цаашид судалгаа шинжилгээний чухал талбар болон хүлээгдэж судлаачдын өмнө нээлттэй байгаа..."⁶ цаг үед цэрэг, батлан хамгаалахын салбарт тус хоёр улс харилцаа, хамтын ажиллагааг хэрхэн хөгжүүлж ирснийг товч гэсэн авч үзэн тодруулах хэрэгцээ шаардлага эндээс урган гарч байна.



1 дүгээр зураг. Хошууч генерал З.Болдбаатар ИБУИНВУ-ын цэргийн төлөөлөгчдийн хамт 2007 он

Их Британи, Умард Ирландын Нэгдсэн Хаант Улс-тай (ИБУИНХУ) батлан хамгаалах албан ёсны харилцаа 1999 оны 3 дугаар сарын 31-ний өдөр Монгол Улсын Засгийн газрын хуралдааны шийдвэрээр тогтоожээ⁷. Тухайлбал, 1990–2015 он буюу 25 жилийн хугацаанд хоёр улсын цэрэг, батлан хамгаалах хамтын ажиллагаа, дээд түвшний харилцан айлчлалууд хэр зэргийн өргөн цар хүрээ, далайцтай, олон шинэ агуулгаар баяжин хөгжиж харилцан итгэлцлийг бэхжүүлэн ирсэн түүхэн он жилүүдийн тухай, үүнийг гэрчлэх баримтын хураангуй, товч, тодорхой мэдээллийг арын хавсралтаас үзэж болно⁸.

Өнөөг хүртэл өрнөж ирсэн хоёр улсын цэрэг, батлан хамгаалах харилцаа, хамтын ажиллагааг агуулга, хэлбэр, хамрах хүрээгээр нь доорх үндсэн чиглэлд авч үзэж болох юм:

¹ www.diplomatmagazine.com "uk-mongolia 1963-2023", 11 т

² https://thediplomat.com/2023/02/mongolia-uk-celebrate-60th-anniversary-of-diplomatic-relations/

³ https://mfa.gov.mn/mongolian-foreign-policy/дипломат-харилцаа/states-with-diplomatic-relations

⁴ https://asiarussia.ru/news/38524/ "Монголия теперь имеет дипломатические отношения со всеми странами-членами ООН"

⁵ www.diplomatmagazine.com "uk-mongolia 1963-2023", 15 т


⁶ Золбоо Д. Монгол дахь британи судлал. Олон улс судлал сэтгүүл. (2007). №1 (75), 113–114

⁷ Сосорбарам Ч. "Батлан хамгаалах гадаад харилцаа, хамтын ажиллагаа, энхийг сахиулахын цагаан ном 1990–2015". УБ., 2015.т.237 т

⁸ Мөн номын 237–240.т



1. Сургалт (Богино хугацааны англи хэлний болон бусад мэргэжил дээшлүүлэх дамжаа, Монгол Улсын цэргийн албан хаагчдад зориулсан “Энхийг сахиулахын англи хэлний сургалт” хөтөлбөр, Команд штабын коллеж);



2 дугаар зураг.

Анх 1997–1999 оны хооронд манай улсын цэргийн албан хаагчид буюу тухайн үеийн ЦИС–ийн (Цэргийн Их Сургууль) англи хэлний багш Б.Нансалмаа, Г.Наранчимэг болон зарим багш, офицерууд Англи улсын Рипон &Йорк Сэинт Жон их сургуулийн коллеж дээр богино хугацаагаар 3 долоо хоногийн англи хэлний заах арга зүйн дамжаанд хамрагдаж байжээ.

Энэ харилцаа улмаар өргөжин хөгжиж манай улсын цэргийн албан хаагчдын англи хэлний мэдлэг, чадварыг дээшлүүлэх зорилгоор “Монголын энхийг сахиулагчдын англи хэлний сургалтад хамруулах төсөл 2006–2009 болон 2014–2017 онд тус тус хэрэгжсэн”⁹ нь манай улсын цэргийн албан хаагчид гадаад оронд энхийг сахиулах ажиллагаанд оролцож үүрэг гүйцэтгэхэд зохих хувь нэмрээ оруулсан билээ.

2005 оноос эхлэн 3 жил хагасын хугацаатай “Энхийг сахиулах англи хэл” төсөл Монгол



3 дугаар зураг. ИУИНВУ–аас БНХАУ–д суугаа ЭСЯ–ны Батлан хамгаалахын атташе Зэвсэгт хүчний Гадаад хэлний сургалтын нэгдсэн төвд зочилж англи хэлний сургалтын материал, хэрэгсэл гардуулав. 2006 он.

Улсын Зэвсэгт хүчинд үр дүнтэй хэрэгжин дуусжээ.

Энэхүү төсөл Зэвсэгт хүчний Гадаад хэлний сургалтын нэгдсэн төв болон 150–р цэргийн анги зэрэг газруудад хэрэгжсэн.




4 дүгээр зураг.

Мөн түүнчлэн 2015 онд Нэгдсэн Хаант улсын Зэвсэгт хүчний шууд хөрөнгө оруулалт, дэмжлэгээр УБХИС–ийн ГХСТ дээр байгуулагдсан “Гадаад хэл бие даан сурах төв” үйл ажиллагаагаа тогтмол явуулсаар 8 орчим жилийн нүүр үзэж байна. Янз бүрийн төрөл цэргийн анги, байгууллагаас ирсэн офицер, ахлагч нарт зориулсан БХЯ–ны захиалгат англи хэлний дамжаа тус төвийн анги, тэнхимд жил бүр тогтмол хичээллэдэг. Шууд хөрөнгө оруулалт, буцалтгүй тусламж дотор тухайн үеийн ханшаар нийт 12 сая гаруй төгрөгийн үнэ өртөг бүхий англи хэлний төрөл бүрийн сурах бичиг, аудио, видео хуурцаг, толь бичиг, компьютер болон сургалтын бусад хэрэгсэл багтаж байжээ.

“Энхийг сахиулах англи хэл” төслийн хүрээнд (PEP–Peacekeeping English Project)

⁹ <https://mn.embassyofmongolia.co.uk/хоёр-талын-харилцаа/монгол-британи-харилцаа>



5–6 дугаар зураг.

дээрх төвийг 2015 онд байгуулахад англи хэл, соёлыг дэлхийд түгээн дэлгэрүүлэх үүрэг, зорилготой тус улсын Засгийн газрын байгууллага “Бритиш Консул”-ын дэмжлэг оролцоо, туслалцаатайгаар дээр дурдагдсан багц ажил дотроо багтааж тус сургуулийн ГХСТ-ийн англи хэлний багш, зохиогч миний бие болон бусад багш нарыг ажлын байр дээр нь мэргэжил, заах арга зүйн богино хугацааны сургалтад хамруулсан. Тухайн үед өөр нэг мэргэжил дээшлүүлэх сургалт нь Зэвсэгт хүчний Гадаад хэлний сургалтын нэгдсэн төвд мөн адил явагдаж мэргэжил нэгт англи хэлний багш Б.Золзаяа нарын цөөнгүй багш нар оролцож байв.

Энэхүү тусламж, дэмжлэгийн үр өгөөж их бөгөөд англи хэлний сургалт тасралтгүй чанартай явагдах таатай нөхцөлийг бүрдүүлсэн. Тухайлбал, ҮБХИС-ийн харьяа сургуулиудын төрөл бүрийн цэргийн бакалаврын үндсэн ангиудад цэргийн мэргэжлийн онцлогтой англи хэлний сурах бичиг “Campaign-1” багц номыг өнөөг хүртэл сургалтад өргөн

ашигласаар байна.

Мөн түүнчлэн, Их Британийн Зэвсэгт хүчний Команд штабын коллежийг БХЯ-ны Гадаад хамтын ажиллагааны газрын дарга, хурандаа Т.Наранхүү, Монгол Улсын Зэвсэгт хүчний Жанжин штабын орлогч дарга, хурандаа Т.Галбадрах, дэд хурандаа Т.Энхцогт, Э.Гантөмөр, хошууч Г.Төмөр-Очир¹⁰ нар амжилттай төгсөж БХЯ, ЗХЖШ болон ТХЦК-ын удирдах албан тушаалд ажиллаж байна.



7 дугаар зураг.

¹⁰ Хувийн зургаа ашиглуулах зөвшөөрөл өгсөн эрхэм дүүд энэ ялдамд талархал дэвшүүлье.

2. Энхийг сахиулах, энхийг дэмжих ажиллагаа болон хамтарсан сургууль (2003 оноос хойш Монгол Улсад жил бүр уламжлал болон явагддаг олон улсын “Хааны эрэлд” (Khan quest)¹¹ сургууль мөн түүнчлэн янз бүрийн бүс нутаг, тивд явагдсан НАТО-ийн тэргүүлсэн олон үндэстний төрөл бүрийн энхийг сахиулах, дэмжих ажиллагаанууд, жишээлбэл Иракийн “Эрх чөлөө ажиллагаа”, ПСОТМОН зэрэг¹²;



8 дугаар зураг. Монгол Улсын Ерөнхийлөгч У.Хүрэлсүх “Хааны эрэлд-2023” сургууль дээр

ИБУИНХУ-аас 2008 оноос хойш тус сургуулийн хүрээнд зохион байгуулагддаг Команд штабын сургуульд тогтмол оролцож ирсэн билээ.

Манай улсын Зэвсэгт хүчин цэрэг, батлан хамгаалахын салбарт тус улстай НАТО-ийн тэргүүлсэн зарим ажиллагаанд тухайлбал, 2006–2007 онуудад Косовод буюу “КФОР”-д “...Монгол Улс салааны бүрэлдэхүүнтэй цэргийн багийг 2 удаа явуулсан бөгөөд анх удаагаа НАТО-гийн тэргүүлсэн ажиллагаанд оролцсон мөн Европ тивд энхийг сахиулсан анхны тохиолдол болжээ¹³”.

Улмаар 2009–2014 онд ИБНАУ-д явагдсан “Аюулгүй байдалд дэмжлэг үзүүлэх олон улсын хүчин” (ISAF) “...Мармал бааз дээр нийт 10 ээлжийн цэргийн багийн 1114 цэргийн албан хаагч оролцжээ¹⁴”. Үүний дараахан тун удалгүй үргэлжлүүлэн 2015–2020 онд “Шийдвэртэй

дэмжлэг” (RS) ажиллагаанд “...13 ээлжийн нийт 1439 (30 эмэгтэй) цэргийн албан хаагч үүргээ нэр төртэй гүйцэтгэжээ”¹⁵ гэдгийг Монгол Улсын Ерөнхийлөгчийн зөвлөх асан Г.Түвшинзаяа мөн түүнчлэн батлан нотолж, хэд хэдэн удаагийн олон үндэстний цэргийн ажиллагаанд дэлхийн халуун цэг Афганистан улсад Британийн генералын удирдлага доор мөнхүү улсын цэргүүдтэй мөр зэрэгцэн харилцан туршлага солилцож энхийн үйлст хувь нэмрээ оруулан хүчин зүтгэснийг тэмдэглэн үлдээсэн байна¹⁶.

Мөн 2022 онд манай улсад зохиогдсон “Говийн чоно” гамшгийн хор уршгийг арилгах сургалт, дадлага, туршлага солилцох олон улсын сургуульд Нэгдсэн Хаант улсын төлөөлөгч оролцжээ.

1. Тогтмол уулзалт, айлчлалууд

Монгол улсыг Япон улсаас хавсран суудаг ИБУИНХУ-ын цэргийн атташе манай улсад хийдэг айлчлалууд мөн тогтмолжиж ирсэн.



9 дүгээр зураг.

Үүний зэрэгцээ харилцаа, хамтын ажиллагааны дээд түвшний айлчлалыг ИБУИНХУ-ын Парламентын гишүүн, Зэвсэгт хүчний сайд Жэймс Хиппи, тус улсаас Монгол Улсад суугаа Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд хатагтай Фиона Блит болон албаны бусад төлөөлөгчийн хамт 2023 оны 09 сарын 28, 29-ний өдрүүдэд манай улсад анх удаа

¹¹ <https://president.mn/26665/>

¹² “Small-power diplomacy: Mongolia’s peacekeeping commitment” Friedrich Ebert Stiftung & Mongolian Institute for Innovative Policies., UB, 2021. 13 т

¹³ “Энхийг дэмжих ажиллагааны туршлага, сургамж” (Судалгаа, шинжилгээний бүтээл) УБ., 2023. 162 т

¹⁴ Мөн номын 166 т

¹⁵ Мөн талд

¹⁶ <https://www.politicshome.com/thehouse/article/mongolian-british-armies-found-common-purpose-working-together>



хийж Монгол Улсын Засгийн газрын гишүүн, Батлан хамгаалахын сайд Г.Сайханбаяртай Батлан хамгаалах яаманд албан ёсны уулзалт хийжээ. Энэхүү айлчлалын түүхэн ач холбогдол нь тус хоёр улс дипломат харилцаа тогтоосны 60 жилийн ойн босгон дээр ирж буй гэдгийг Батлан хамгаалахын сайд Г.Сайханбаяр онцлон тэмдэглэж “...Мөн “Батлан хамгаалах салбарт хамтран ажиллах тухай Монгол Улсын Засгийн газар, Их Британи Умард Ирландын Нэгдсэн Хаант Улсын Засгийн газар хоорондын харилцан ойлголцлын санамж бичиг”-ийн хүрээнд хоёр улсын Батлан хамгаалахын харилцаа, цэргийн хамтын ажиллагаа олон чиглэлээр өргөжин хөгжиж байгааг тэмдэглээд, цаашид НҮБ-ын энхийг сахиулах ажиллагаа, цэргийн боловсрол, боловсон хүчний чадавхыг бэхжүүлэх чиглэлээр идэвхтэй хамтран ажиллахыг эрмэлзэж байгаагаа илэрхийлэв. ИБУИНХУ-ын Зэвсэгт хүчний сайд Жэймс Хиппи Монгол Улсад айлчлан ирсэндээ сэтгэл өндөр байгаагаа хариу илэрхийлж, Батлан хамгаалах, цэргийн харилцаа, хамтын ажиллагааны санал санаачилгуудыг бүрэн дэмжиж байгаа бөгөөд цаашид идэвхжүүлэх, олон чиглэлд өргөжүүлэн хөгжүүлэх боломжтой гэдгийг тодотгов”¹⁷ хэмээн “Соёмбо редакц” өөрийн фэйсбүүкийн мэдээллийн хуудсандаа айлчлалын гол агуулгыг ийнхүү тун тодорхой дурджээ.

“Батлан хамгаалах салбарт хамтран ажиллах тухай Монгол Улсын Засгийн газар, Их Британи Умард Ирландын Нэгдсэн Хаант Улсын Засгийн газар хоорондын харилцан ойлголцлын санамж бичиг”-т 2012 онд гарын үсэг зурснаар хоёр улсын батлан хамгаалах салбарын харилцаа, хамтын ажиллагааг өргөжүүлэн хөгжүүлэх боломж бүрдсэн хэдий ч түүнээс ч урьд өмнө батлан хамгаалах салбарт харилцаа, хамтын ажиллагаагаа эхлүүлсэн бөгөөд тухайлбал, 2004 онд олон улсын энхийг дэмжих ажиллагааны хамтарсан сургуулийг Монгол Улсын Зэвсэгт хүчин, Их Британи улстай хамтран НҮБ-ын Аюулгүйн зөвлөлийн

байнгын 4 гишүүн оронтой амжилттай зохион байгуулж байсан ажээ.

Дээрх харилцан ойлголцлын санамж бичгийг 10 жилийн хугацаатай байгуулсан бөгөөд өнгөрсөн 2022 онд гэрээний хугацаа дуусгавар болсон тул хоёр талаас яаралтай хамтран ажиллаж, гэрээгээ шинэчлэн хоёр талын хамтын ажиллагааг өргөжүүлэн хөгжүүлэх боломжийг бүрдүүлэх саналыг тус айлчлалын үеэр манай улсын БХЯ-аас ИБУИНХУ-ын Зэвсэгт хүчний сайд, ноён Жэймс Хиппи-д мөн хөндөн тавьжээ.

2. Бусад хамтарсан ажил, арга хэмжээ (Морин поло нийгэмлэг гэх мэтчилэн):

Хоёр улсын батлан хамгаалах харилцаанд бас нэгэн өвөрмөц өнгө нэмсэн хамтарсан ажил, арга хэмжээ бол 2015 онд хамтран “Морин поло нийгэмлэг” байгуулсан явдал юм.



10 дугаар зураг.

Мөн онд морин пологийн хамтарсан сургалт, нөхөрсөг тоглолтыг Хэнтий аймаг болон Их Британийн Лондон хотноо амжилттай зохион байгуулсан. Хамтарсан сургалтын өмнө Их Британийн Зэвсэгт хүчний Цэргийн морин пологийн нийгэмлэгийн дарга, хурандаа Саймон Ледгер тэргүүтэй Их Британийн 4 цэргийн албан хаагч Зэвсэгт хүчний 232 дугаар ангид байрлаж, тус ангийн морин пологийн багийг /нийт 10 хүн/ дасгалжуулж, сургалтыг зохион байгуулж байжээ. Үүнээс хойш дээрх арга хэмжээ хэд хэдэн удаа өөр өөр газарт болж байжээ.

Монгол Улсын Гадаад хэргийн сайд, хатагтай Б.Батцэцэг манай хоёр улсын харилцаа, хамтын ажиллагааг дүгнэж цэгнэн “Дэлхийн

¹⁷ <https://www.facebook.com/photo?fbid=661113366116962&set=pcb.661113742783591>



энх тайван, амар амгаланд оруулж буй Монгол Улсын хувь нэмэр” өгүүлэлдээ“...We do not allow our unique characteristics to limit us. Mongolia is a prime example of how any country, regardless of its economic and military capacity, has the potential to contribute to global peace and security”¹⁸ хэмээн бичсэнтэй судлаач миний бодол санаа бүхий л талаар нийцэж байна.

Дээр дурдагдсан хэд хэдэн удаагийн олон үндэстний удаагийн энхийг сахиулах ажиллагаанд манай улсын Зэвсэгт хүчин идэвхтэй оролцож цэрэг хандивласан явдал нэг талаас цэргийн албан хаагчид өөрсдийн мэргэжлийн ур чадвараа сайжруулан ахиулж дадлага, туршлага хуримтлуулах мөн түүнчлэн олон улсын тавцанд Монгол Улсын нэр хүнд өсөх зэргийн олон талын ач холбогдолтой төдийгүй нөгөө талаас “This military contribution resulted in close political and defence ties with the United States and NATO members as of 2003.

The other endeavour was the conclusion of an investment agreement with Anglo–Australian mining giant Rio Tinto and Canadian Ivanhoe Mines to develop the Oyu Tolgoi copper and gold deposit”¹⁹ гэж Монгол Улсын гуравдагч хөршийн бодлого, аюулгүй байдал, эдийн засгийн хараат бус байдалд оруулсан ихээхэн хувь нэмэр, ашиг тусын талаар зарим судлаачид үнэлж дүгнэснийг энэ ялдамд мөн адил зайлшгүй онцлон дурдах ёстой билээ.

Манай хоёр улсын олон талт харилцаа, хамтын ажиллагааны зөвхөн нэг л салбар болох батлан хамгаалах салбарын нэгэн жарны үүх түүхийг товчхон сөхөхөд ийм бөлгөө. Эцэст нь тэмдэглэхэд цаашдын харилцаа, хамтын ажиллагаа урьдынхтайгаа адил олон баялаг хуудсаар дахин зузааран баяжих нь гарцаагүй юм хэмээн миний бие тун өөдрөгөөр хөгжлийн ирээдүй, хэтийн төлөвийг төсөөлөн харж байна.

Ашигласан материал:

1. Золбоо Д. “Монгол Британийн харилцаа”. УБ., 2005.
2. Золбоо Д. (2007). Монгол дахь британи судлал. Олон улс судлал сэтгүүл. 91 (75),
3. Мэндээ Ж. Нямсүрэн Ч. нар “Монгол улсын энхийг сахиулах үйлсэд оруулсан хувь нэмэр, үүрэг, оролцоо” Соёмбо-ҮБХИС, УБ., 2021.12.28 21 (196)
4. Сосорбарам Ч. “Батлан хамгаалах гадаад харилцаа, хамтын ажиллагаа, энхийг сахиулахын цагаан ном 1990-2015”. УБ., 2015.
5. “Энхийг дэмжих ажиллагааны туршлага, сургамж” (Судалгаа, шинжилгээний бүтээл) УБ., 2023.

Цахим эх сурвалж

1. www.diplomatmagazine.com “UK-Mongolia 1963-2023”
2. https://thediplomat.com/2023/02/mongolia-uk-celebrate-60th-anniversary-of-diplomatic-relations/
3. https://mfa.gov.mn/mongolian-foreign-policy/дипломат-харилцаа/states-with-diplomatic-relations
4. https://mn.embassyofmongolia.co.uk/хоёр-талын-харилцаа/монгол-британи-харилцаа
5. https://president.mn/26665/
6. https://www.politicshome.com/thehouse/article/mongolian-british-armies-found-common-purpose-working-together
7. https://www.facebook.com/photo?fbid=661113366116962&set=pcb.661113742783591
8. https://researchbriefings.files.parliament.uk/documents/cdp-2023-0162/cdp-2023-0162.pdf house of commons library (uk-mongolian relations)
9. “small-power diplomacy: mongolia’s peacekeeping commitment” friedrich ebert stiftung & mongolian institute for innovative policies., ub, 2021.
10. “renewed geopolitical rivalries: challenges and options for mongolia” friedrich ebert stiftung & mongolian institute for innovative policies., ub, 2020.

¹⁸ www.diplomatmagazine.com “UK–Mongolia 1963–2023”, 9 т

¹⁹ “Renewed Geopolitical Rivalries: Challenges and Options for Mongolia”, Friedrich Ebert Stiftung & Mongolian Institute for Innovative Policies., UB, 2020. 10 т



Улс орнуудын харилцааны лавлах

МОНГОЛ УЛС, ИБУИНВУ-ЫН БАТЛАН ХАМГААЛАХ САЛБАРЫН ХАРИЛЦААНЫ ЛАВЛАХ

1996
ИБУИНВУ-аас Монгол улсад суугаа элчин сайдаар уламжлалтан Британий БХЯ-ны холбогдох албадаг үүсгэж тавьсаны дагуу манай ЭХ-ний цэргийн албан хаагчдыг тус улсад англи хэлний сургалтанд хамруулж эхэлсэн.

1997-1999
Монгол Улсын Зэвсэгт хүчний удирдах албан тусхаалтнууд, Батлан хамгаалахын их сургуулийн багш, анги салбарын офицер нийт 22 хуви Их Британий Батлан хамгаалах яамны олон улсын хөтөлбөрийн хүрээнд Ригон & Йорк-ийн коллежийн англи хэлний богино хугацааны сургалтын төвд суралцсан болно. Мөн энэ хөтөлбөрийн хүрээнд 15 цэргийн албан хаагч Британий талин санхүүжилтээр дотоодын англи хэлний курст суралцаж, давтан суралцаж байсан боловч хөтөлбөр санхүүгийн хүндрэлийн улмаас 2000 оноос зогссон.

1999
3 дугаар сарын 31-ний өдөр Монгол Улсын Засгийн газрын хуралдааны шийдвэрийн дагуу Их Британи, Умард Ирландын Нэгдсэн Вант Улс /ИБУИНВУ/-тай батлан хамгаалах салбарт албан ёсны харилцаа тогтоосон.

2002
12 дугаар сард ИБУИНВУ-ын Батлан хамгаалах яамны эхнийг сахиулах хүчний шинжээчийн мөнхийн ажиллагаа эхэлжээ. Зэвсэгт хүчний Эхнийг сахиулах хүчний сургалтын төв, эхнийг сахиулах хүчний ангид зочилж, үйл ажиллагаатай нь танилцсан. Энэхүү айлчлалын дор хоёр улс эхнийг сахиулах ажиллагааны чиглэлээр хамтран ажиллаж, манай цэргийн албан хаагчдыг сургаж, хамтарсан сургалт зохион байгуулах, сургалтын төвийг тохижуулахад Их Британий дүгээс туслах боломжтой гэж үзсэн юм.

2003
1 дүгээр сард Монгол Улсын Ерөнхий сайд Н.Энхбаяр ИБУИНВУ-д айлчлах үеэр хоёр орны Батлан хамгаалах салбарын харилцаа, хамтын ажиллагааг хөгжүүлэх, Эхнийг сахиулах ажиллагааны чиглэлээр хамтран ажиллах, сургалт, сургалтын материаллаг баазыг сайжруулахад дэмжлэг авах талаар хүсэлтийг албан ёсоор тавьсан. Үүний үр дүнд Британий тал Монгол Улсын эхнийг сахиулах чадавгийг нэмэгдүүлэхэд тусална гэдгийг ИБУИНВУ-ын Батлан хамгаалахын сайд 2003 оны 6 дугаар сард БХЯ-ны сайд Гүррагчаатай Сингапурт уулзахдаа мэдэгдсэн. Үүний дагуу 2003 оны ИБУИНВУ-ын Эхнийг сахиулах ажиллагааны сургалтын дэмжлэг үзүүлэх бүлэг /ОРТАГ/-ийн цэргийн ажиллагч, сургагч багшийн дэмжлэг, Хуррай Замбын цэргийн сургалтын төвөөс зохион байгуулагдсан Эхнийг дэмжих ажиллагааны сургалтын ЭХ-ний өндөрвөрд орлоход эхэлсэн. Орлогийн байлдаар нийт 6 офицер дарагч сургалтуудад хамрагдаж байна.

2004
6 дугаар сарын 28-наас 7 дугаар сарын 09-ний өдрүүдэд ИБУИНВУ-ын санхүүжилтээр НҮБ-ын Аюулгүйн зөвлөлийн байнгын 5 гишүүн улс (АНУ, БНХАУ,

Улс орнуудын харилцааны лавлах

ОХУ, ИБУИНВУ, БНФУ) болон Монгол Улсын Зэвсэгт хүчний цэргийн багийг оролцуулан эхнийг сахиулах ажиллагааны олон улсын дадлагыг манай улсад амжилттай зохион байгуулсан. Манай талваас тус дадлага-сургалтыг үргэлжлүүлэн бүс нутагт цэргийн сайдаар дахь итгэлцлийн бэлтгэлээр нэгэн хэлтэст болон тогтмолжуулах санал тавьсан боловч НҮБ-ын ЗСАГ болон оролцогч зарим орны дэмжлэгийг аваагүй тул зогссон.

2005
Британий БХЯ, тус улсын Гадаад тусламжийн асуудал эрхэлсэн "British Council" байгууллагаар дамжуулан "Эхнийг сахиулахын англи хэлний сургалт" хөтөлбөрийг албан ёсоор эхлүүлж байгаа. Тус хөтөлбөрийн сургалт манай ЭХ-нээс эхнийг сахиулах ажиллагаанд оролцох албан хаагчид англи хэлний мэдлэгийг дээшлүүлэх, англи хэлний бэлтгэл нээх арга зүйг сайжруулах, сургалтын баазыг сайжруулахад чиглэсэн тусламж, дэмжлэг үзүүлсэн. Энэ ажлын хүрээнд интернэтэд холбоо бүхий 10 компьютер, телевизор, DVD тоглуулагч, сурах бичиг бүхий бүрэн хэмжээний хэлний кабинетыг ЭХЖШ болон ЭХ-ний 150 дугаар ангид байгуулсан.

2006
7 дугаар сарын 10-28-ны өдрүүдэд Кени Улсын Найроби хот дахь Эхнийг дэмжих сургалтын төвийн НҮБ-ын цэргийн ажилчгийн дэмжлэгээр манай Зэвсэгт хүчний 2 албан хаагчийг бүх зардлыг даан сургаасан.

2007
Их Британийн Засгийн газрын санхүүжилтээр "Эхнийг сахиулахын англи хэлний сургалт" хөтөлбөрийн хүрээнд интернэтэд холбоо бүхий 10 компьютер, телевизор, DVD тоглуулагч, сурах бичиг бүхий бүрэн хэмжээний англи хэлний 2 дахь кабинетыг ЭХ-ний 330 дугаар анги дээр байгуулсан.

12 дугаар сарын 03-04-ний өдрүүдэд ИБУИНВУ-аас Монголдоо хавсран суугаа Батлан хамгаалахын атташе бригадын генерал В.Руди Монгол Улсад ажлын айлчлал хийсэн. Уг айлчлалаар Батлан хамгаалах яамны Төрийн нарийн бичгийн дарга хошууч генерал М.Борбоатар, Батлан хамгаалах яамны Гадаад хамтын ажиллагааны хэлтсийн зөвлөх хурандаа Г.Лүндэн, Зэвсэгт хүчний Жанжин штабын нэгдүгээр орлогч дарга, Цэргийн удирдлага, стратегийн төлөвлөлтийн газрын дарга хошууч генерал А.Габтар нартай өөрийн хүлээлтээр тус тус болж Монгол-Их Британийн цэргийн хамтын ажиллагааны тухай санал солилцсон.

2008
1 дүгээр сарын 11-ний өдөр Батлан хамгаалах яамны Гадаад хамтын ажиллагааны хэлтсийн дарга хурандаа Ж.Мэнхэд Их Британийн "Эхнийг сахиулах ангийн хэлний төсөл"-ийн удирдагч ноён Перт Харре(Peter Hare)-тай улсын, Манай санаачилгаар зохион байгуулсан ал улзалтад БХИС-ийн Гадаад хэлний сургалтын төвийн дарга хошууч Г.Болор, ЭХЖШ-ын Гадаад хэлний сургалтын төвийн дарга өмхөд Ч.Нямсүрэн, яамны Гадаад хамтын ажиллагааны хэлтсийн мэргэжилтэн Б.Ууга-билэг, Б.Бамбилэг нар байцсан.

Ноён П.Харе хөтөлбөрийн тухай товч танилцуулав. Их Британий Засгийн газар "Global Conflict Prevention Pool" сангийн хүрээнд хөгжиж буй улс орнуудын эхнийг сахиулах ажиллагаанд оролцох бие бүрэлдэхүүний англи хэлний мэдлэгийг нэмэгдүүлэх зорилготой "Эхнийг сахиулах ангийн хэлний төсөл" (Peacekeeping English Project)-ийг хэрэгжүүлж байгаа. Энэ төслийг тус улсын Гадаад хэргийн нам

Улс орнуудын харилцааны лавлах

(Foreign and Commonwealth Office), Батлан хамгаалах яам, Олон улсын хөгжлийн яам хамтран санхүүжүүлж, Их Британийн Консул, соёлын тэргүүлэх байгууллага болох Их Британийн Консул зохион байгуулдаг.

Төслийн 2008 оноос эхлэн манай улсад хэрэгжүүлж байгаа, 2009 оны 3 дугаар сард төслийн хугацаа дууссан. Гэхдээ төслийг нэг жилийн хугацаагаар санхүүжүүлдэг тул цаашид үргэлжлүүлэх боломжтой. Төслийн 20 орны улсад хэрэгжүүлж байгаа болохоор өрсөлдөөн ихтэй, Зүүн болон Төв Европын улс орнууд НАТО-д элссэнээр зүгээр улс орнуудад хэрэгжүүлж буй төслүүд хаагдаад байна.

Төслийн хэрэгжүүлэх удирдах зөвлөлд монголын талваас ЭХЖШ-ын дарга, ЦУДСТГ-ын дарга, ЗДХАГ-ын дарга, ажилчин талваас, Их Британийн Батлан хамгаалахын атташе, Бээжин дэх Их Британийн Боловсролын Консулын менежер, Элчин сайд нар ордог.

2010
2010 оны 10 дугаар сарын 19-22-ны өдрүүдэд БНСУ-ын нийслэл Соул хотноо болсон Ази, Номхон далайн бүс нутгийн орнуудын Зэвсэгт хүчний Жанжин штабын дарга нарын уулзалтын үеэр Монгол Улсын Зэвсэгт хүчний Жанжин штабын дарга дэслэгч генерал Ц.Бямбажав ИБУИНВУ-ын Зэвсэгт хүчний Жанжин штабын Олон улсын бодлого хариуцсан дэд дарга хошууч генерал Жонатан Шо-той уулзан хоёр талын хамтын ажиллагааны асуудлуудаар санал солилцсон.

2010 оны 11 дүгээр сарын 30-ны өдөр БНХАУ-аас Монгол Улсыг хавсран суугаа ИБУИНВУ-ын Батлан хамгаалахын атташе бригадын генерал Дункан Франсис Монгол Улсад танилцах айлчлал хийсэн.

2012
2012 оны 02 дугаар сарын 28-29-ний өдрүүдэд БНХАУ-аас Монгол Улсыг хавсран суугаа ИБУИНВУ-ын Батлан хамгаалахын атташе бригадын генерал Дункан Франсис Монгол Улсад ажлын айлчлал хийсэн ба айлчлалын үеэр түүнийг яамны ГХАГ-ын дарга хурандаа И.Батболд, ЭХЖШ-ын АГТ-ын дарга бригадын генерал Ж.Бадармаа нар хүлээн авч уулзав.

Яамны Стратегийн удирдлага, төлөвлөлтийн газрын захирлын дарга хурандаа Ч.Баттулга Их Британи, Умард Ирландын Нэгдсэн Вант Улсын Батлан хамгаалах Академийн Удирдлага, технологийн коллеж дээр 2012 оны 3 дугаар сарын 12-ноос 4 дүгээр сарын 24-ний өдрүүдэд зохион байгуулсан "Өргөн хүрээтэй аюулгүй байдлын орчинд батлан хамгаалах үйл ажиллагааг удирдах нь" сэдэвт дэмжлэгт тус улсын БХЯ-ны дэмжлэгийг зэр хамрагдав.

2012 оны 7 дугаар сарын 31-нээс 8 дугаар сарын 01-ний өдрүүдэд БНХАУ-аас Монгол Улсыг хавсран суугаа ИБУИНВУ-ын Батлан хамгаалахын атташе бригадын генерал Дункан Франсис Монгол Улсад ажлын айлчлал хийсэн ба айлчлалын үеэр түүнийг яамны ГХАГ-ын дарга хурандаа И.Батболд, БХИС-ийн захирал бригадын генерал З.Болдбаатар нар хүлээн авч уулзав. Мөн энэ үеэр бригадын генерал Дункан Франсис "Монгол Улс, ИБУИНВУ-ын Батлан хамгаалах салбарт хамтран ажиллах тухай Засгийн газар хоорондын хэлэлцээр"-ийн төслийг яамны ГХАГ-ын дарга хурандаа И.Батболдод өргөн бэрив.

Лондон хотноо 2012 оны 11 дүгээр сарын 28-нд болсон Монгол-Британийн Дүгуй ширээний ээлжит уулзалтад яамны төлөөлөгч, Гадаад хамтын ажиллагааны газрын орлогч дарга хурандаа Д.Ганхууг оролцсон. Тус уулзалтын үеэр Монгол Улс, ИБУИНВУ-ын Засгийн газар хоорондын батлан хамгаалах салбарт хамтран ажиллах тухай харилцан ойлголцсон Санамж бичигт төлөөлөгчдийн монголын талын

Улс орнуудын харилцааны лавлах

ахлагч, ГХЯ-ны дэд сайд Д.Ганхууг гарын үсэг зурав.

2015
2015 оны 06 дугаар сард зохион байгуулагдсан "Хааны эрэлд" олон үндэстний хэргийн сургалт, дадлагын нэлэлтэн ажиллагаанд БНХАУ-аас Монгол Улсыг хавсран суугаа ИБУИНВУ-ын Батлан хамгаалахын атташе бригадын генерал Саймон Леви оролцов.

Монгол Улсын Зэвсэгт хүчинд Морин биеэ даасан морин полог нийгэмлэгийг Английн армийн морин полог нийгэмлэгийг хамтран хөгжүүлэх зорилгыг тавьж 2015 оны 5 дугаар сард Хэнтий аймгийн Дэлгэрхан сум буюу Хэрлэнгийн хөдөө аравд байрлах Зэвсэгт хүчний 232 дугаар ангийн морьт ажиллагааны материаллаг баазыг тусгайлан цэргийн морин полог байгуулахад боллоо. Арга хэмжээнд Гадаад харилцааны сайд Л.Пүрэвсүрэн, Батлан хамгаалахын дэд сайд А.Баттөр, Гадаад харилцааны дэд сайд Д.Ганхууг, ЭХЖШ-ын газрын дарга, бригадын генерал Д.Давваа нарын албаныхан оролцсон. Цэргийн морин полог байгуулахаас урьдаж Английн армийн морин полог нийгэмлэгийн зэрэгтэй дөрвөн тоглогч, дагалдуулагч багш нар манай улсад ирж дөрвөн өдрийн турш дадлага сургалт явуулсан.

12 дугаар сарын 5-ны өдөр Батлан хамгаалахын сайд Ц.Цогмоон ИБУИНВУ-аас Монгол Улсад суугаа Онц бөгөөд Бүрэн Эрх Элчин сайд хатагтай Катрин Арнолдыг хүлээн авч уулзсан.



НАТО БА ЯПОН УЛСЫН ХАМТЫН АЖИЛЛАГААНЫ ТҮҮХЭН ТОЙМ

Ж.БАТЖАРГАЛ /Судлаач МВА, Олон улсын харилцааны магистр/

Түлхүүр үг: НАТО, Япон, түншлэл, НАТО ба Япон улс, хамтын ажиллагаа, түүх

Key words: NATO, Japan, partnership, NATO and Japan, cooperation, history

Оршил. НАТО (Англиар: North Atlantic Treaty Organization (NATO); Францаар: *Organisation du traité de l'Atlantique nord (OTAN)* „Умард Атлантын Гэрээний Байгууллага“) нь 1949 оны 4 дүгээр сарын 4-нд хүйтэн дайны үед Зөвлөлт Холбоот Улс болон түүний холбоотнууд болох социалист орнуудын эсрэг чиглэсэн Умард Атлантын гэрээний дагуу байгуулагдсан цэрэг, улс төрийн эвсэл юм¹.

НАТО болон Япон улс нь НАТО-гийн Энэтхэг–Номхон далайн бүс нутаг дахь түншүүдтэйгээ тогтоосон өргөн хүрээний хамтын ажиллагаагаараа дамжуулан кибер аюулгүй байдал, далайн аюулгүй байдлын шинэ технологиуд гэх мэт аюулгүй байдлын нийтлэг сорилтуудын хүрээнд хоёр талын хамтын ажиллагааг хэрэгжүүлж байна. Өнөө цагт олон улсын аюулгүй байдлын нарийн төвөгтэй орчинд НАТО болон Япон улс нь дүрэм журамд суурилсан олон улсын дэг журмыг дэмжих болон бэхжүүлэхийн тулд улс төрийн яриа хэлэлцээг нэмэгдүүлэх болон бодит хамтын ажиллагааг дэмжих үүрэг хүлээгээд байна².

Энэхүү өгүүлэлдээ дэлхийн аюулгүй байдлын тавцанд нөлөө бүхий байр эзэлж байгаа НАТО буюу Умард Атлантын Гэрээний Байгууллага болон Ази тивд төдийгүй Энэтхэг–

Номхон далайн бүс нутаг дахь цэрэг зэвсэг, аюулгүй байдал, батлан хамгаалах салбартаа тэргүүлэгч Япон улсын хамтын ажиллагаа, түншлэлийн түүхийн талаар тоймлон авч үзсэн болно.

Нэг. Харилцааны эхэн үе, албан ёсны харилцааны үндэс суурийг бий болгосон нь

Япон, НАТО-гийн хамтын ажиллагааны замнал нь Японы 1947 оны Үндсэн хуулийг зохиогчид болон 1949 онд НАТО-г үүсгэн байгуулагчдын ашиг сонирхлын давхцалыг нэгтгэснээр тавигдсан³. Япон улс бол НАТО-гийн үйл ажиллагааны талбараас гадуурх хамгийн урт хугацааны түнш бөгөөд 1979 оноос хойш Японы сайд нар болон парламентын гишүүдийн зүгээс албан бусаар харилцаа тогтоох алхмуудыг хийж эхэлсэн байдаг⁴. Атлантын далай дамнасан нийгэмлэгтэй хамтын ажиллагаагаа өргөжүүлэхийн тулд Японы Батлан хамгаалахын сайд нар 1979, 1981, 1984 онд Брюссельд албан ёсны айлчлал хийсэн ба АНУ-аас гадна НАТО-гийн удирдагчид Европын аюулгүй байдлыг хангах, ЗХУ-ын дэлхийд ноёрхлоо тогтоохын эсрэг тэмцэлд анхаарлаа хандуулж байсан тул Япончууд Бельгид багахан дэмжлэг авснаас гадна НАТО Зүүн Азид их хэмжээний хөрөнгө оруулалт хийх сонирхолгүй байв⁵. Хэдийгээр

¹ <https://mn.wikipedia.org/wiki/NATO#>

² https://www.nato.int/cps/en/natohq/topics_50336.htm

³ Schriver, R., & Ma, T. (2010). The Next Steps in Japan–NATO Cooperation. Project 2049 Institute. pp 3

⁴ Японы Батлан хамгаалахын сайд нар 1979, 1981, 1984 онд НАТО-гийн төв байранд айлчилсан ба 1986 онд Японы Гадаад Хэргийн Сайд НАТО-гийн ЕНБД-тай уулзалт хийсэн. 1980 оноос хойш Японы парламентын гишүүд НАТО-гийн Парламентын Ассемблейд ажиглагчаар оролцсон. Эх сурвалж: Masashi Nishihara, “Can Japan Be a Global Partner for NATO?,” Riga Papers, NATO and Global Partners: Views from the Outside, Ronald D. Asmus, Editor, Riga, Latvia, November 27–29, 2006, pp. 36, 37; and Brian Bridges, “Japan and Europe: Rebalancing a Relationship,” Asian Survey, Vol. 32, No. 3 (March 1992), p. 236.

⁵ Masashi Nishihara, “Can Japan Be A Global Partner for NATO,” in Ronald D. Asmus (ed.), “NATO and Global Partners: Views From The Outside” (Riga, Latvia: Riga Papers, 27–29 November 2006), pp. 34–43.

НАТО–Япон Улсын албан ёсны харилцаа 1990–ээд оноос эхтэй ч Япон Улс 1980–аад оны эхээр НАТО–той илүү албан ёсны харилцаа тогтоох эхний амжилтгүй оролдлогуудыг Ерөнхий сайд Ясүхиро Накасоне–гийн Засгийн газрын Гадаад хэргийн сайд Шинтаро Абэ–гийн Ерөнхий сайд агсан Шинзо Абэ–гийн аав) чармайлтаар хэрэгжүүлэхийг оролдож байв⁶. 1983 онд Абэ НАТО–Япон Улсын яриа хэлэлцээний механизмыг хөгжүүлэх Баруун Европ дахь аюулгүй байдлын яриа хэлэлцээнд Япон Улсын ашиг сонирхлыг тусгах зорилгоор Европын томоохон нийслэл хотуудаар аялсан байна. ОХУ задран унасны дараа НАТО олон улсын тавцанд гүйцэтгэх үүргээ дахин нягталж эхэлсэн ба хуучин ЗХУ–ын бүрэлдэхүүнд байсан улсууд гэх мэт шинэ түншүүдийг “Энх тайвны төлөөх түншлэл” хөтөлбөрөөрөө дамжуулан бүрэлдэхүүндээ хүлээж авав. Эдгээр түншлэлд чухал сэдэл байснаас гадна байгууллагын (НАТО) оршин тогтнох үндэслэл болох мэдээллийн технологийн хурдацтай өсөлт, үлэмж сайжирсан тээвэр болон асар хурдацтай интеграцлагдаж байсан дэлхийн зах зээл нь урьд өмнө нь алслагдсан бүс нутгуудтай НАТО–гийн ашиг сонирхол улам ихээр холбогдоход хүргэж байв. Дэлхийн хамгийн хурдацтай хөгжиж буй эдийн засагтай, улс төрийн хүчнүүд өсөн нэмэгдэж байгаа Зүүн Ази нь НАТО–гийн оролцооны хувьд содон талбараас гадна аюулгүй байдлын анхаарах асуудал болж эхлэв. Үүний үр дүнд НАТО Япон болон Азийн бусад орнуудтай өмнө нь орхигдуулсан боломжуудаа судалж эхлэв⁷. 1990–ээд онд НАТО–Японы хамтын ажиллагаа шинэ үе шатанд гарав.

Япон – НАТО–гийн анхны аюулгүй байдлын Бага хурлыг 1990 оны 7–р сард⁸ болон 1991 онд тус тус Бельгид хуралдуулсан ба 1991 онд НАТО–гийн Ерөнхий нарийн бичгийн дарга Манфред Вёрнер Токиод айлчилсан нь НАТО–гийн Ерөнхий нарийн бичгийн даргын хувиар Японд хийсэн анхны айлчлал юм⁹. Эдгээр ололт амжилтууд нь Япон, Европын харилцааг өргөжүүлэх ерөнхий чиг хандлагын нэг хэсэг байв. Японы удирдагчид Европтой хамтын ажиллагаагаа өргөжүүлэхээр зорьж 1991 онд Европын хамтын нийгэмлэгтэй хамтарсан тунхаг бичигт гарын үсэг зурсан ба 1992 онд Европын аюулгүй байдал, хамтын ажиллагааны байгууллага (ЕАБХАБ)–тай түншлэл тогтоож 1996 онд Европын Зөвлөлд ажиглагчаар элсэв¹⁰. Япон Улсын Гадаад Хэргийн Яамны Хойд Америкийн Асуудал хариуцсан захирал Юкио Сато Япон Улс НАТО–гийн хамтын ажиллагааны үр шимийн талаар 1992 онд NATO Review сэтгүүлд хэвлэгдсэн өгүүлэлдээ тод томруунаар өгүүлэлдээ дурдсан бол¹¹ 1995 онд Япон Улсын Гадаад Хэргийн Дэд Сайд Хироши Фүкүда аюулгүй байдлын талаарх хоёр талын ашиг сонирхлын талаар 1995 онд мөн сэтгүүлд хэвлэгдсэн өгүүлэлд¹² дурдсан байдаг. АНУ, Япон, Европын хооронд НАТО–гоор зуучлуулан өрнөсөн "Гурвалсан яриа хэлэлцээ" явуулахын ач холбогдлыг болон Япон болон НАТО–гийн харилцааг АНУ дэмжиж байгаа талаар АНУ–ын Ерөнхийлөгч Жорж Буш болон Япон Улсын Ерөнхий Сайд Кийчи Миязава нарын гарын үсэг зурсан АНУ–Японы хамтын ажиллагааны тухай 1992 оны Токиогийн Тунхагт онцлон тэмдэглэсэн байдаг¹³. 1992 оноос хойш Японы парламент

⁶ Henry Scott Stokes, "France Blocks Japanese Bid for Informal Ties to NATO," New York Times, April 2, 1983

⁷ H.E.M. Naito, "The Japan Security Policy," NATO Website, 17 March 2005.

⁸ Хоёр жил тутамд болдог хурлын эхнийх нь 1990 онд, хоёр дахь, гурав дахь, дөрөв дэх болон тав дахь удаагийн хурлууд 1992, 1994, 1997 болон 1999 онд тус тус зохион байгуулагдсан.

⁹ Үүний дараа НАТО–гийн Ерөнхий нарийн бичгийн дарга нар болох Хавьер Солана 1997 онд, Яаап дэ Хүүп Шеффер 2005 онд тус тус айлчилсан. Nishihara, "Can Japan Be A Global Partner for NATO."

¹⁰ Мөн тэнд

¹¹ Yukio Satoh, "Japan and NATO Agenda for Political Dialogue," NATO Review, Vol. 40, No. 3, June 1992, pp. 18–22

¹² Hiroshi Fukuda, "Regional Security Initiatives and NATO–Japan Relations," NATO Review, Vol. 43, No. 4, July 1995, pp. 22–26

¹³ National Graduate Institute for Policy Studies (GRIPS), "Tokyo Declaration on the U.S.–Japan Global Partnership," the World and Japan Database Project,



аюулгүй байдалтай холбоотой 20 гаруй хуулийг баталсан ба эдгээр нэмэлт өөрчлөлт нь Япон Улсын хувьд Балкан дахь НАТО-гийн ажиллагааг идэвхтэй дэмжих боломжийг олгосон байна. 1990-ээд оноос хойш Япон улс Баруун Балканы орнуудад боловсрол болон эмнэлгийн салбарт тусламж үзүүлж, аюулгүй усаар хангахаас эхлээд дайнаас буцаж ирсэн цэргүүдийг эргээд нийгэмд хөл нийлүүлэхэд нь туслах зэрэг төслүүд хэрэгжүүлсэн юм. Мөн сонгуулийн ардчилал, дэд бүтэц, сэргээн босголтын төслүүдэд туслалцаа үзүүлсэн¹⁴. Босни Герцеговиний асуудлаар НАТО болон Японы албаны хүмүүс 1990-ээд оны дунд болон эхэн үед хэд хэдэн уулзалт хийсэн ба талууд Босни Герцеговинд Энх тайвныг тогтоох олон талт Зөвлөлд оролцсон ба талуудын хүчин чармайлт хамтран ажиллах гэхээсээ илүү параллель түвшинд байв¹⁵. НАТО “Холбоотон гүрнүүд” гэх нэр томъёог 2004 онд хэрэглэж эхэлсэн ба үүнд Япон, БНСУ, Австрали, Шинэ Зеланд улсууд багтаж байв. Энэхүү шинэ ангилал нь далайн тээврийн замын хамгаалалт болон энхийг сахиулах ажиллагааг дэмжих, терроризмын эсрэг ажиллагаануудад албан ёсны гишүүнчлэлгүйгээр оролцох боломжийг бий болгов¹⁶. Япон улсын хувьд Транс-Атлантын нийгэмлэгтэй хамтарч ажиллах томоохон үүд хаалга нээгдсэн бол НАТО-гийн хувьд Ази руу чиглэсэн цонх нээгдсэн үйл явдал болсон юм. Хамтын ажиллагааны энэ хэлбэр нь харилцан ашиг тусыг авчирсан ирээдүйн хамтын ажиллагааны суурийг тавив.

Хоёр: Шууд хамтын ажиллагаа

2001 оны 9-р сарын 11-нд АНУ-д хийсэн халдлага нь Япон, НАТО-гийн хамтын ажиллагааг өргөжүүлэхэд түлхэц болсон юм. Шинээр гарч ирж буй терроризм, зэвсэглэл тархалт, далайн дээрэм зэрэг үндэстэн дамнасан аюул заналхийллийн эсрэг дэлхий нийтээр хамтран ажиллах хэрэгцээг улам

бүр ухамсарласан нь энэ харилцааг улам гүнзгийрүүлэв. Япон Улсын Ерөнхий Сайд асан, тухайн үед Гадаад Хэргийн Сайдаар ажиллаж байсан Таро Асо “энэхүү нийтлэг ойлголттой холбогдуулан Япон Улс НАТО-гийн чухал ач холбогдлыг шинээр нээсэн үйл явдал боллоо гэдэгт би итгэж байна, НАТО-гийн хувьд ч мөн адил гэж найдаж байна” хэмээн цохон тэмдэглэсэн байдаг. Энэхүү мэдэгдэл нь хоёр талын ашиг сонирхол дээр үндэслэгдсэн бөгөөд Афганистан дахь НАТО-гийн ажиллагаанд чухал хувь нэмэр оруулах үйл ажиллагаа руу хөтөлсөн алхам болсон. НАТО-гийн тэргүүлсэн Олон Улсын Аюулгүй Байдлын Тусламжийн Хүчин (International Security Assistance Force, ISAF) нь 2001 оноос хойш Афганистан дахь аюулгүй байдлын нөхцөл байдлыг сайжруулахаас гадна хөгжлийн төслүүдэд хяналт тавих зорилготой байв. Олон Улсын Аюулгүй Байдлын Тусламжийн Хүчин нь олон талаараа Япон Улс болон НАТО-гийн хамтын ажиллагааны хувьд хамгийн чухал үед тооцогддог. НАТО-гийн хувьд энэ нь гэрээний хамтын батлан хамгаалах заалтыг анх удаа хэрэглэсэн үйл явдал болов. Харин Япон Улсын хувьд олон улсын аюулгүй байдлын орчинд оролцох шинэ үе шатыг бий болгосон үйл ажиллагааг дэмжихэд идэвхтэй бөгөөд өргөнөөр оролцохоо амласан хэрэг явдал болов. Найман жил гаруй хугацаанд Япон Улсын Далай Тэнгисийн Өөрийгөө хамгаалах хүчин Энэтхэгийн далай дахь түлш ханган нийлүүлэх ажиллагаанд оролцож дийлэнх нь АНУ-ын, нийт 12 улсын байлдааны оноцуудад хагас сая килолитр түлш нийлүүлэв¹⁷. Япон Улсын Өөрийгөө хамгаалах хүчин 2001 оноос эхлэн Афганистан дахь ажиллагаанаас гадна НАТО-гийн гишүүн орнуудтай хамтран төрөл бүрийн ажиллагаанд оролцсон байдаг. Тухайлбал, 1996 оноос хойш Япон Улсын цэргүүд Ойрхи Дорнодод Голаны өндөрлөгт Канад болон Польшийн цэргүүдтэй

¹⁴ “Japan's Actions Towards Construction of Peace in the Western Balkans,” Ministry of Foreign Affairs of Japan, July 2004.

¹⁵ Solana, “NATO's Role in Building Cooperative Security in Europe and Beyond.”

¹⁶ RADM Tomohisa Takei, “Japan Maritime Self Defense Force in the New Maritime Era,” November 2008.

¹⁷ “Japan Ends MSDF Refueling Mission,” Asahi Shimbun, 16 January 2010



хамт НҮБ-ийн энхийн сахиулах ажиллагаанд оролцсон. Өөрийгөө хамгаалах хүчний цэргүүд Нидерланд болон Их Британий цэргүүдийн хамтаар Иракд хүмүүнлэгийн болон сэргээн босголтын төслүүдэд хамтран оролцов. 2002 онд Өөрийгөө хамгаалах хүчний бие бүрэлдэхүүн Азид, Зүүн Тиморын сонгуулийг ажиглах үйл явцад оролцов. Энэ үед Их Британи, АНУ, Канад, Испани, Норвеги болон Португалын цэргүүдээс бүрдсэн олон улсын хүчин жинтэй хувь нэмэр оруулсан юм. Үүнээс гадна Өөрийгөө хамгаалах хүчин Өмнөд Азид аврах ажиллагаанд оролцсоноос гадна НАТО-гийн хүчинтэй хамтран 2005 онд Пакистанд болсон газар хөдлөлтийн дараах аврах ажиллагаанд тус тус оролцов. Үүний дараа Өөрийгөө хамгаалах хүчин НҮБ-ийн ивээл дор явагдсан Гайти дахь гамшгийн тусламжийн ажиллагаанд НАТО-гийн гишүүн нэлээд хэдэн орны хамтаар оролцов. НАТО өөрийн хүрэнээс гадуурх ажиллагаануудад оролцохын хажуугаар талууд НАТО-гийн бус ажиллагаанууд дээр огтлолцох болов. 2007 онд Ази тив дэх аюулгүй байдлын сүлжээгээ шат ахиулан гэрээт орнуудтайгаа “Tailored Cooperation Packages” (TCP) буюу “Тусгайлан нийцүүлсэн хамтын ажиллагааны багц”-ийн суурийг тавив. “Тусгайлан нийцүүлсэн хамтын ажиллагааны багц”-ын хүрээнд түншлэгч орнууддаа НАТО-гийн тэргүүлсэн ажиллагаануудад хамтран оролцох, чадавхжих боломжуудыг санал болгов. Япон Улсын “Тусгайлан нийцүүлсэн хамтын ажиллагааны багц”-ын хувьд жил бүр бодит хамтын ажиллагаа төлөвлөх хүрээнд багтаж байна. Нэмж дурдахад, НАТО болон Япон Улсын хамтын ажиллагаа Афганистан дахь Олон Улсын Аюулгүй Байдлын Хүчин-д дэмжлэг үзүүлж хамтран ажилласнаас гадна онцгой үеийн төлөвлөлт, терроризм, цөмийн зэвсгийг үл дэлгэрүүлэх болон гамшгийн менежментийн асуудалд чиглэгдэж байна¹⁸. Япон Улс Афганистаны асуудлаар олон улсын

түвшинд хэд хэдэн томоохон үйл ажиллагаанд оролцсон ба нэг томоохон жишээ нь 2002 онд Токио хотноо НАТО-гийн голлох холбоотнууд болон нийт 61 улсын төлөөлөл оролцсон олон улсын хурлыг зохион байгуулж Афганистаны сэргээн босголт болон хөгжилд зориулагдах 61 тэрбум америк долларыг босгож чадсан явдал юм. Япон Улсын хувьд Афганистаны асуудлаар цэргийн ажиллагаанд оролцолгүйгээр эдийн засгийн хөгжлийн болон санхүүгийн тусламж үзүүлэх бодлого барьсан чиг хандлага нь НАТО болон түүний холбоотнуудтай харилцах өвөрмөц платформ болсон байна. Энэхүү платформ болон Япон Улсын гаргаж байсан хүчин чармайлт, санаачилгууд нь НАТО-д эзлэх байр суурийг бэхжүүлсэн юм. Үүний үр дүнд 2008 оны эхээр болсон Афганистаны асуудлаарх НАТО-гийн дээд хэмжээний уулзалтад Япон Улс цэргийн хүчнээ оролцуулаагүй, холбоотон биш цорын ганц улсын хувиар уригдан оролцсон¹⁹. Япон Улс Афганистанд үзүүлэх тусламжийн харилцаанд хүчин чармайлт гарган ажиллаж байсан ба 2002 оны Токиод болсон Афганистаны асуудлаар хурлаар олон улсын санхүүжилтийн хурлыг ээлжлэн зохион байгуулахаар тохирсны дагуу 2012 оны хурлыг Япон улс Токио хотод зохион байгуулж 16 тэрбум долларыг босгохоор тохиролцов²⁰. 2006 онд Абэ Япон Улсын Ерөнхий сайдаар сонгогдсоны дараа 2007 онд НАТО-гийн төв байранд айлчилсан ба энэхүү айлчлал нь Японы Засгийн Газрын тэргүүний хувиар айлчилсан анхны айлчлал болсон юм. 2012 онд Абэ хоёр дахь удаа Ерөнхий Сайд болсныхоо дараа 2013 онд НАТО-Японы хамтарсан улс төрийн тунхаг гаргасан нь ирээдүйн хамтын ажиллагааны голлох чиглэлүүдээ тодорхойлж, албан ёсны хамтын ажиллагааны гэрээ байгуулахад чиглэсэн алхам болсон юм. Үүнээс нэг жилийн дараа албан ёсны хамтын ажиллагааны гэрээ болох “Онцгой Түншлэл ба Хамтын Ажиллагааны Хөтөлбөр” (IPCP) батлагдсан нь

¹⁸ “NATO’s Relations with Contact Countries,” NATO Website

¹⁹ North Atlantic Treaty Organization, “ISAF nations affirm long-term commitment to Afghanistan,” April 3, 2008

²⁰ https://www.nato.int/cps/en/natohq/official_texts_87595.htm



НАТО–Японы харилцааг шинэ шатанд гаргав. Онцгой Түншлэл ба Хамтын Ажиллагааны Хөтөлбөрийн зорилго нь улс төрийн яриа хэлэлцээг нэмэгдүүлэх, холбоотнуудын болон түншүүдийн хамтын ажиллагааг бэхжүүлэхэд оршиж байв. Ерөнхий Сайд Абэ 2014 оны 5 сард НАТО–гийн төв байранд айлчлах үед НАТО–Японы харилцаа дараах чиглэлүүдээр өрнөхөөр тодорхойлж Онцгой Түншлэл ба Хамтын Ажиллагааны Хөтөлбөрт тусгав. Үүнд: Кибр, зэвсгийн хяналт ба үл дэлгэрүүлэх, хүмүүнлэгийн тусламж ба гамшгийн тусламж, далай тэнгисийн аюулгүй байдал болон терроризмтэй тэмцэх асуудлууд багтаж байна²¹. НАТО–Японы харилцаа өргөжин тэлсний бас нэг хэлбэр нь НАТО урьдаас хүсэлт тавьж ирсний дагуу Япон Улс 2018 онд НАТО дахь албан ёсны байнгын төлөөлөгчийн газраа нээв. 2021 оны 11 дүгээр сард тус эвслийн аюулгүй байдлын орчны 2030–2040 оны зураглалыг НАТО–гийн Батлан хамгаалах коллежийн судлаачид 5 хувилбар, зураглалтайгаар таамаглаж гаргасан ба үүний 4–рт Япон Улстай хамтран ажиллах талаар дараах байдлаар тусгажээ:

НАТО–гийн ирээдүйн цорын ганц гол аюул занал БНХАУ болно. Үүнд мөн БНХАУ–ОХУ-ын болзошгүй ойртолт, дотносол нөлөөлнө. Тиймээс Энэтхэг–Номхон далайн бүс нутагт НАТО нь нэг талаас Япон, БНСУ, Австрали, Шинэ–Зеланд улсуудтай ойртон холбоолж нөгөө талаас Европын Холбоотой бодлогоо уялдуулж БНХАУ–аас учруулах аюул заналыг тогтоон барих явдал тус эвслийн үндсэн зорилго болно²².

2022 оны 6 дугаар сарын 28–30–ны өдрүүдэд НАТО–гийн орнуудын дээд хэмжээний уулзалт Испани улсын нийслэл Мадрид хотод явагдаж өнгөрсөн ба уг уулзалтын хөтөлбөрөөр үндсэн 7 чиглэлийн хүрээнд олон чухал дэд сэдвүүд хэлэлцэн баталсан байна. Япон Улс

болон Энэтхэг Номхон далайн бүс нутаг дахь түншүүдтэйгээ дараах байдлаар хамтран ажиллахаар томьёолсон байна²³.

Ирээдүйн аюул занал гэж үзэж буй БНХАУ–ын эсрэг НАТО Энэтхэг–Номхон далайн бүс нутаг дахь түнш–холбоотнуудаа өөртөө ойртуулах суурь тавив. Япон, БНСУ, Австрали, Шинэ–Зеланд гэсэн ойрын түншүүдээ НАТО Мадридын уулзалтад анх удаа урьж оролцуулснаар цаашид эдгээр улстай харилцаагаа холбоотны хэмжээнд хүргэж хөгжүүлэх алхам хийж бодлого, үйл ажиллагаагаа уялдуулж эхлэв.

Орос–Украины дайнтай холбоотойгоор НАТО–Японы хамтын ажиллагаа тогтвортой өрнөж Японы Гадаад хэргийн сайд Камикава Йоко Украин улсад 2024 оны 1–р сарын 7–нд гэнэтийн айлчлал хийж, Оросын түрэмгийллийн эсрэг тэмцэж буй тус улсад нэмэлт дэмжлэг үзүүлэх зорилгоор НАТО–гийн санд 37 сая ам. доллар хандивлахаа амлав²⁴.

Дүгнэлт. Хүйтэн дайны үед байгуулагдсан цагаасаа эхлэн НАТО дэлхий дахины аюулгүй тогтвортой байдлыг хангах зорилготойгоо уялдуулан олон арга хэмжээ авч явуулж ирсний нэг томоохон хэлбэр нь бүс нутгийн хувьд өргөжин тэлэх бодлого явуулсан ба Ази тивээс Япон Улстай илүү ойр дотно түншилж хамтын ажиллагааны хэд хэдэн үе шатыг туулж ахиц гарсаар өнөөгийн түвшинд хүрсэн байна. Энэ хугацаанд хамтран ажиллах эрхзүйн үндсийг бүрдүүлэх, холбогдох гэрээ хөтөлбөр байгуулах, хамтын ажиллагааны боломжуудыг эрэлхийлэх, өндөр түвшний харилцан айлчлал, яриа хэлэлцээ хийх, хамтын ажиллагааныхаа хүрээг өргөжүүлэх алхмуудыг тууштай авч хэрэгжүүлсэн нь өнөөгийн НАТО–Японы нягт бөгөөд тогтвортой хамтын ажиллагааг бий болгоход чухал үүрэг гүйцэтгэсэн гэж дүгнэж болохоор байна. Хамтын ажиллагааны явцад дан ганц цэрэг, батлан хамгаалах салбарт

²¹ North Atlantic Treaty Organization, “Individual Partnership and Cooperation Programme between Japan and NATO,” May 6, 2014

²² https://niss.gov.mn/archives/2627#_edn8

²³ https://niss.gov.mn/archives/2627#_edn18

²⁴ <https://montsame.mn/mn/read/334898>



гэлтгүй хөгжлийн тусламжийн хөтөлбөрүүд, гамшгийн тусламж, кибер аюулгүй байдал, зэвсгийн хяналт ба үл дэлгэрүүлэх, хүмүүнлэгийн тусламж ба гамшгийн тусламж, далай тэнгисийн аюулгүй байдал болон терроризмтой тэмцэх асуудлууд гэх мэт олон салбарт хамтран ажиллах чиглэлүүдээ албан ёсны бичиг баримтуудад баталгаажуулан тусгасан нь хамтын ажиллагааны цар хүрээ

өргөжин тэлснийг харуулахын сацуу цаашид энэхүү хамтын ажиллагаа шинэ түвшинд гарч НАТО-гийн хувьд Япон Улсын эзлэх байр суурь бэхжиж, статус шат ахих асуудал нь энэхүү өгүүлэлд тоймлон дурдагдаагүй НАТО-Япон Улсын хамтын ажиллагааны маш олон үйл явдал, албан ёсны яриа хэлэлцээнүүд өрнөж, гэрээ бичиг баримтууд зурагдсантай холбоотойг дурдах нь зүйтэй.

Ашигласан материал:

1. Schriver, R., & Ma, T. (2010). The Next Steps in Japan-NATO Cooperation. Project 2049 Institute.pp 3
2. Masashi Nishihara, "Can Japan Be a Global Partner for NATO?," Riga Papers, NATO and Global Partners: Views from the Outside, Ronald D. Asmus, Editor, Riga, Latvia, November 27-29 2006, pp. 36, 37
3. Brian Bridges, "Japan and Europe: Rebalancing a Relationship," Asian Survey, Vol. 32, No. 3 (March 1992), p. 236
4. Masashi Nishihara, "Can Japan Be A Global Partner for NATO," in Ronald D. Asmus (ed.), "NATO and Global Partners: Views From The Outside" (Riga, Latvia: Riga Papers, 27-29 November 2006), pg. 34-43
5. Henry Scott Stokes, "France Blocks Japanese Bid for Informal Ties to NATO," New York Times, April 2, 1983
6. H.E.M. Naito, "The Japan Security Policy," NATO Website, 17 March 2005.
7. Yukio Satoh, "Japan and NATO Agenda for Political Dialogue," NATO Review, Vol. 40, No. 3, June 1992, pp. 18-22
8. Hiroshi Fukuda, "Regional Security Initiatives and NATO-Japan Relations," NATO Review, Vol. 43, No. 4, July 1995, pp. 22-26
9. National Graduate Institute for Policy Studies (GRIPS), "Tokyo Declaration on the U.S.-Japan Global Partnership," the World and Japan Database Project
10. "Japan's Actions Towards Construction of Peace in the Western Balkans," Ministry of Foreign Affairs of Japan, July 2004.
11. Solana, "NATO's Role in Building Cooperative Security in Europe and Beyond."
12. RADM Tomohisa Takei, "Japan Maritime Self Defense Force in the New Maritime Era," November 2008.
13. "Japan Ends MSDF Refueling Mission," Asahi Shimbun, 16 January 2010
14. North Atlantic Treaty Organization, "ISAF nations affirm long-term commitment to Afghanistan," April 3, 2008
15. North Atlantic Treaty Organization, "Individual Partnership and Cooperation Programme between Japan and NATO," May 6, 2014

Цахим эх сурвалж

1. <https://mn.wikipedia.org/wiki/HATO#>
2. https://www.nato.int/cps/en/natohq/topics_50336.htm
3. "NATO's Relations with Contact Countries," NATO Website
4. https://www.nato.int/cps/en/natohq/official_texts_87595.htm
5. https://niss.gov.mn/archives/2627#_edn8
6. https://niss.gov.mn/archives/2627#_edn18
7. <https://montsame.mn/mn/read/334898>



ЗҮҮН ХОЙД АЗИЙН АЮУЛГҮЙ БАЙДЛЫН ОРЧНЫ ӨӨРЧЛӨЛТ БА БНСУ – МОНГОЛ УЛСЫН ХАМТЫН АЖИЛЛАГААНЫ ХЭРЭГЦЭЭ

СОН ЖЭЮУН /УБХИС-ийн, БХУА-ын магистрант/

Түлхүүр үг: Реализм, Хүчний шилжилтийн онол, Завсарын бүс,

АНУ, БНХАУ-ын ноёрхлын өрсөлдөөн, БНСУ – Монголын хамтын ажиллагаа

Key words: Realism, Power transition theory, Buffer system, US-China hegemony competition, Korea-Mongolia military cooperation

Хураангуй. Өнгөрсөн зууны “Хүйтэн дайн”-ы дараах үнэмлэхүй ноёрхож асан АНУ төвтэй нэг туйлт дэлхий ертөнц хувьсан өөрчлөгдөж өнөөгийн байдлаар АНУ болон шинээр хурдацтай хүч түрэн гарч ирсэн БНХАУ хоёрын хооронд хүчтэй өрнөж байна. Тэр дундаа Солонгос, Монгол хоёр орны оршдог Зүүн хойд Азийн бүс нутагт АНУ, БНХАУ-ын ноёрхлын өрсөлдөөн шууд нөлөөлж байна гэж хэлж болохоор байна.

Хоёр их гүрний түүхэнд байгаагүй өрсөлдөөн дунд БНСУ, Монгол Улс хоёр оршин тогтнож, үндэсний ашиг сонирхлоо хэрэгжүүлэхийн тулд үр дүнтэй хамгаалалтын бүс байгуулах хэрэгтэй гэж үзэв. Хамтын ажиллагааны үүднээс хоёр улс зохих чиглэл, түвшинд хамтран ажиллах замаар батлан хамгаалах чадавхийг нэмэгдүүлбэл хоёр орны хамтран байгуулсан “Буферийн бүс”-ийн үр нөлөө нэмэгдэх боломжтой. Иймд БНСУ ба Монгол Улс хамтын ажиллагааны шинж төлөвийг тодорхойлж, шийдвэрлэж, ирээдүйд чиглэсэн хамтын ажиллагааны харилцааг хөгжүүлэх нь зүйтэй.

There has been a US-centric monopoly since the Cold War past century, but currently there is conflict and competition between the US and rising China. North-East Asia, including South Korea and Mongolia, is directly impacted by this rivalry between the US and China. The formation of an efficient coastal zone is imperative for South Korea and Mongolia to ensure their survival and advance their respective national interests amidst the unprecedented

struggle between the two superpowers. From the standpoint of interstate cooperation, South Korea and Mongolia working together to create a “zone of reconciliation” and strengthen national defense can make their cooperation more effective. In order to achieve this, bilateral cooperation needs to be established.

Нэг. Реализм ба Зүүн хойд азийн аюулгүй байдлын орчны өөрчлөлт

Реализм нь олон улсын харилцааны талбар дахь үндэсний аюулгүй байдлын судалгааны үндсэн парадигм юм. Олон улсын харилцаан дахь аюулгүй байдлыг хангах талаар улс төрийн бодлогын зан төлөвийг системчилдэг. Либерализм ба конструктивизм нь олон улсын аюулгүй байдлыг тайлбарлахад тустай боловч улс хоорондын зөрчилдөөний шалтгаан, үйл явцыг бие даан тайлбарлахын оронд реализмын тайлбарлаж чадахгүй зүйлийг хүчтэй нөхөж өгдөг. Реализмд аливаа улс орны хамгийн чухал зорилго бол оршин тогтнох бөгөөд нэг улсыг нөгөө улс руу довтлохыг зогсоож чадах дээд эрх мэдэл байхгүй тул бусад улстай хүчний тэнцвэрийг хадгалах нь чухал юм. Улс орнууд болон дайсагнагч улсуудын хүчний тэнцвэрийг хадгалах үед хоёр үндэстний харилцаа хамгийн тогтвортой гэж тооцогддог¹. Учир нь тухайн улсын дотоод дэг журамтай адилгүй, олон улсын хамтын нийгэмлэгт улс орнуудын үйл ажиллагааг хянаж чадах (дэлхийн) засгийн газар байдаггүй тул аль нэг тал нь дангаараа хүчтэй байвал эрх мэдлээ сул бүс нутаг дэвсгэрт тэлэх сэдэл төрдөг.

Реалистууд цэрэг-улс төрийн эвслийг

¹ Waltz, Kenneth, “Theory of International Politics”, New York: Random House, 1979



хүчний тэнцвэрт байдлыг хангах ашигтай хэрэгсэл гэж харуулдаг ч эцсийн дүндээ улс орны аюулгүй байдал, үндэсний ашиг сонирхлын төлөө эвсэл байгуулагддаг тул ямар ч үед эвсэл эвдэрвэл онцгой сонин зүйл байхгүй гэдгийг хүлээн зөвшөөрдөг. АНУ-ын төрийн нарийн бичгийн дарга асан Хенри Киссинжерийн хэлснээр үндэсний эрх ашгийн тухай ярихад байнгын найз, байнгын дайсан гэж байдаггүй. Чухамдаа үндэсний аюулгүй байдалд эрсдэл учирсан ямар ч үед эвсэл эвдэрдэг нь түүхээр нотлогдсон. Тухайлбал: Дэлхийн 2-р дайны үед Германы эсрэг тулалдаж хамт байсан АНУ, ЗХУ дайны дараа бие биеийнхээ хамгийн том дайсан болсон. Нөгөө талаар дэлхийн 1,2-р дайны үед маш ширүүн тулалдсан Их Британи, Франц, Герман улсууд одоо их дотнын найзууд болсон.

Үүний зэрэгцээ орчин үеийн улс орнуудын эрх мэдлийн өөрчлөлт, тэр өөрчлөлт нь олон улсын улс төрийн бүтцэд хэрхэн нөлөөлсөн талаар Органски (Organski) Хүч дамжуулах онолоор дамжуулан 1-р байрт орсон улсын үндэсний хүч чадлын өсөлт 2, 3-р байрын орнуудынхаас удаашралтай байсныг хэлсэн². Өнгөрсөн хугацаанд их гүрнүүдийн ноёрхлын өрсөлдөөнийг харахад түүхэнд нэг ч улс ноёрхлоо үүрд хадгалж байгаагүй.

Вальц (Waltz), Мирсхаймер (Mearsheimer) зэрэг анхны реалистууд бол улс орны онцлог, улс төрийн дэглэмийн хэлбэрийг үл тоомсорлодог гэж шүүмжилдэг. Реалистууд улс төрийн дэглэмийн төрөл (ардчилалсан эсвэл ардчилалсан бус) нь тухайн үндэстний оновчтой шийдвэрт төдийлөн нөлөөлдөггүй гэж үздэг. Дэлхийн 2-р дайны дараах АНУ, ЗХУ-д төвлөрсөн хүйтэн дайны үед ч томоохон дайн болоогүйн шалтгаан нь хоёр тал хүчний тэнцвэрт байдалд хүрсэнтэй холбоотой гэж үздэг. Нэмж дурдахад "Пелопоннесийн дайн", "Дэлхийн 1 ба 2-р дайн", "Их Британи, АНУ-ын эрх мэдлийн төлөөх тэмцэл", "АНУ, БНХАУ-ын хооронд ноёрхохын төлөөх сүүлийн үеийн өрсөлдөөн" зэрэг зохиол бүтээлүүд нь "Үндэсний тогтолцоо нь пирамид бүтэцтэй анархийн байдал бөгөөд эрх баригч улсын

хүч ба сэтгэл ханамжгүй их гүрний хүчний хороондоо тэнцвэртэй байдалд ойртоход сэтгэл хангалуун бус их гүрэн эхлээд шинэ хяналтаа авахын тулд сорилт дайн эхлүүлдэг эсвэл тэр их гүрэн ноёрхогч болгоход энх тайвны замаар хяналтаа авах үед тохиолддог" гэж эрх мэдлийн шилжилтийн онолын жишээ болж болно.

Завсрын бүс (Buffer system)-ийн онолын дагуу буферийн нөлөөний хэмжээ нь тухайн улсын үндэсний хүч чадал, тусгаар тогтнолын төлөөх хүсэл эрмэлзэлтэй пропорциональ хамааралтай байдаг. Энэ нь буфер улс нь буферийн үүргийг хэвийн явуулж, тусгаар тогтносон улсын хувьд оршин тогтнохын тулд тодорхой түвшний үндэсний хүч чадал, идэвхтэй хүсэл зоригийг дэмжих ёстой гэсэн үг юм. Энэ нь түүхийн туршид өөрийгөө хамгаалах үндэсний эрх мэдэлгүй, буферийн үүргээ зохих ёсоор гүйцэтгээгүйгээс халдлагад өртсөн олон тооны буфер мужуудын жишээнээс харж болно³. Буферийн системийн онолын дагуу ийм нөхцөл байдалд завсрын бүс нь өөрийн тогтвортой байдлын төлөө гуравдагч гүрэн эсвэл хэд хэдэн жижиг улсуудын хооронд бүс нутгийн холбоо тогтоохыг эрмэлздэг тохиолдол байдаг. Өөрөөр хэлбэл, их гүрнүүдийн хоёр талын маргаанд ялах боломжгүй хүрээнд тус тусын төвийг сахисан завсрын улсын үндэсний эрх мэдэл хангагдах замаар тэнцвэртэй буферийн бүсийн үр нөлөө нэмэгдэнэ.

"Хүчний шилжилтийн онол" нь одоо байгаа "ноёрхогч" ба шинээр гарч ирж буй гүрнүүд хоорондын эрх мэдлийн шилжилтийн үйл явцыг судалдаг олон улсын харилцааны реалист онолын чиглэл юм. Нэмж дурдахад, реалист онолын нэг ангилалд хүчирхэг орнуудын дунд байрладаг харьцангуй сул орнуудын оршин тогтнох стратеги болох "Завсарын бүс" /буфер систем- *Buffer system* /-ийн онол бас байдаг. Энэхүү судалгаанд Зүүн хойд Азийн бүс нутгийн аюулгүй байдлын өөрчлөлтийн нөхцөл байдлыг олон улсын харилцааны реалист онолын чиглэлүүд болох ийм **"Хүчний шилжилтийн онол", "Буферийн системийн онол"**-ын үүднээс үнэлж байна.

Зүүн хойд азийн аюулгүй байдлын орчинд

² A. F. K. Organski, *World Politics* (New York : Alfred A. Knopf), 1958.

³ Kim-Yeonji, *Geopolitical research on international war surrounding the Korean Peninsula: Focusing on buffer system theory*, 2014

гарч буй өөрчлөлтийг авч үзвэл.

1. Солонгосын хойгийн асуудал
2. АНУ ба БНХАУ G2-н хоорондын эрх мэдлийн талаарх маргаан.
3. АНУ ба ОХУ-н хоорондын зөрчилдөөний нөхцөл байдал.
4. БНХАУ ба ОХУ-н хоорондын зөрчилдөөний нөхцөл байдал.
5. Япон ба БНХАУ/ Япон ба ОХУ-н газрын маргаан.
6. ОХУ ба БНАСАУ-н харилцаанд гарч буй өөрчлөлт
7. Хятад –Тайван зөрчилдөөнөөс гарах Зүүн хойд азийн Аюулгүй байдалд үзүүлэх нөхцөл байдал зэрэг долоон хүчин зүйлээр үнэлж болох юм.

Үүнээс гадна Орос-Украйн дайн, Израиль-Хамасын дайны нөлөө дэлхийн цэрэг улс төрийн байдлын өөрчлөлт нөлөөлөх боломж асар их байна.

Нэгдүгээрт: Хойд Солонгос, Өмнөд Солонгос, АНУ-ын төлөөлөлтэй Солонгосын хойгийн асуудал байна. Хойд Солонгос 2023 онд нийт таван ICBM (тив хоорондын баллистик пуужин) хөөргөсөн нь жилийн тоогоор түүхэн дэх хамгийн өндөр тоо юм. Түүнчлэн 2024 онд нэмэлт тагнуулын хиймэл дагуул, цөмийн зэвсэг, пуужин хөөргөх зэрэг цэргийн чадавхыг бэхжүүлэхэд хүчин чармайлт гаргана. Цаашлаад манай улс найрсаг орнуудтай, тэр дундаа албан ёсны харилцаагаа улам ойртуулна гэж үзэж байна. Оростой эв нэгдлээ бэхжүүлэх бодлогоо зарлаж байна.

Үүний зэрэгцээ АНУ, Өмнөд Солонгос хариу арга хэмжээ авч, Хойд Солонгосын өдөөн хатгалгатай тэмцэх олон улсын хамтын нийгэмлэгийн хамтын ажиллагаагаа бэхжүүлж, 2023 оны 12 дугаар сар гэхэд Хойд Солонгосыг цөмийн зэвсгээс ангижруулах, цэргийн хамтын ажиллагааг хориглох үүргийг онцлон тэмдэглэж байна. Ийнхүү Өмнөд Солонгос, АНУ Хойд Солонгосын цөмийн зэвсгийн талаарх өөрсдийн байр суурь нь “зэвсэг хураах”

гэхээсээ илүү “цөмийн зэвсгээс ангижрах” гэдгийг дахин тодорхой харуулж байгаа тул хэлэлцээ хийх боломж буурч байна. Түүнчлэн, Өмнөд Солонгос, АНУ-ын хамтарсан цэргийн сургуулилалтын цар хүрээ багасаж, хэсэг хугацаанд хумигдаж, БНАСАУ үүнийг эрс эсэргүүцэж, ээлжит өдөөн хатгалга, Солонгосын хойгийн аюулгүй байдлын хямралыг урьдчилан таамаглаж байна. Хойд Солонгост төвлөрсөн байдал аажмаар нэмэгдэж байна.

Хоёр дахь нь: АНУ, Хятадын ноёрхлын төлөөх өрсөлдөөн юм. БНХАУ 2010 онд ДНБ (GDP)-ийхээ хэмжээгээр Японыг гүйцэж, дэлхийд хоёрдугаарт орсон нь АНУ, БНХАУ-ын хооронд “Их 2 (том хоёр улс) эрин” эхэлж байгааг харуулж байна. Судалгааны хүрээлэнгүүдийн хооронд зарим нэг ялгаа байгаа ч БНХАУ улс хамгийн эртдээ буюу 2034 он гэхэд нийт ДНБ-ий хэмжээгээр АНУ-ыг гүйцэж, дэлхийн номер нэг эдийн засгийн гүрэн болно гэж таамаглаж байна. БНХАУ-ын хүчирхэг улс болох стратегийн гол цөм болсон “Нэг бүс, Нэг зам” санаачилга нь Хятадад төвлөрсөн дэлхийн чөлөөт худалдааны бүс байгуулах стратеги билээ. 2013 оноос эхлэн Америк Хятадын худалдааны сөргөлдөөн ширүүсэхээс өмнө БНХАУ хуурай газар, далайг холбосон БНХАУ тэргүүтэй дэлхийн өртгийн сүлжээг байгуулах стратегийг хэрэгжүүлж эхэлсэн⁴.

БНХАУ хүчирхэгжиж буй нь дэлхий нийтийн анхаарлыг татаж эхэлснээр энэ өсөлт хөгжлөөс айх, болгоомжлох хандлага ч их болсон⁵. “Нэг бүс, Нэг зам”-ын хариуд АНУ “Энэтхэг-Номхон далайн стратеги”-ийг сурталчилж байгаа бөгөөд энэ нь Обамагийн үеийн “Ази, Номхон далайн тэнцвэрийг сэргээх” бодлогын газарзүйн тэлэлт юм. АНУ-ын Батлан хамгаалах яамны 2019 оны “Энэтхэг-Номхон далайн стратеги”-ийн тайланд: “Чөлөөт, нээлттэй Энэтхэг-Номхон далайн бүс нутаг”-ыг зорилго болгон танилцуулж байгаа бөгөөд БНХАУ олон улсын дэг журмыг эвдэхийг эрмэлзэж буйн хувьд богино хугацаанд болон дэлхийн хэмжээнд

⁴ Kim Do-young, A study on ways to promote military cooperation between Korea and China under the US-China hegemony competition. ,2023

⁵ Максимын Хишигтуяа, БНХАУ-ын Зөвлөн хүчний бодлогын онцлог ба Монгол Улс., 2023

бүс нутгийн ноёрхлыг тогтоохыг эрмэлзэж, урт хугацаанд ноёрхохоор хөөцөлдөж байна гэж үзсэн. АНУ үүнд БНХАУ-д үзүүлэх бүх талын дарамт шахалтаа нэмэгдүүлнэ гэж тодорхой заасан⁶.

Гурав дахь нь: АНУ, Оросын харилцаа. Дэлхийн 2-р дайны дараа Хүйтэн дайны үед Орос, АНУ хоёр бие биеийнхээ хамгийн том, хамгийн хүчтэй өрсөлдөгчид байсан бол ЗХУ задран унасны дараа, Хүйтэн дайн дууссаны дараа Америкийн үндэсний хүч илүү давамгайлсан тухай олон ажиглалт байсан. Түүнчлэн хоёр улсын хооронд томоохон мөргөлдөөн Хүйтэн дайны үетэй харьцуулахад маш ховор байсан. Гэсэн хэдий ч Орос, НАТО-гийн сэргэлдөөний бэлгэдэл гэж хэлж болох Орос-Украины дайн саяхан дэгдсэнтэй холбоотойгоор АНУ-д төвлөрсөн НАТО-гийн гүрнүүд Орос, Оросыг шалгаж байгаа харилцаа нь ноцтой асуудал гэж үзэж байна. аюулгүй байдлын заналхийлэл нь одоогоор олон улсын хамтын нийгэмлэгийн хамгийн чухал асуудал болоод байгаа бөгөөд энэ нь ихээхэн сонирхол татсан сэдэв болоод байна.

Энэ байдал Зүүн хойд Азид нөлөөлж болох шалтгаан нь НАТО-гийн хүчтэй шахалтаар Орос улс Хятад, Хойд Солонгос зэрэг Зүүн хойд Азийн орнуудтай харилцаагаа улам бэхжүүлж байгаатай холбоотой юм. Тодруулбал, БНАСАУ сүүлийн үед Орост их хэмжээний пуужин, их бууны сум нийлүүлсэн нь мэдэгдэж байгаа бөгөөд ОХУ хариуд нь Хойд Солонгост пуужин, хиймэл дагуулын технологи нийлүүлсэн бололтой. Энэ нь өмнө нь тэнгисийн болон тивийн гүрнүүдийн эсэргүүцэлтэй тулгарч байсан Зүүн хойд Азийн гүрнүүдийн хоорондын сэргэлдөөнийг бэхжүүлэх хүчин зүйл болж байна.

Дөрөвдүгээрт: Орос, Хятадын харилцааны өөрчлөлтийн нөлөө. Энэ нь дээр дурдсантай төстэй бөгөөд саяхан НАТО болон Оросын хооронд үүссэн мөргөлдөөнд Орос Хятадтай илүү ойр дотно харилцаатай болж байна. 2023 оны 9 дүгээр сард Владивосток хотноо болсон Дорнын эдийн засгийн чуулга уулзалтын үеэр

Ерөнхийлөгч Путин “Орос-Хятадын харилцаа түүхэн дэх хамгийн сайн үе шатанд орлоо” гэж мэдэгдсэн⁷. Орос, Хятадын харилцаа бэхжихийн хэрээр Зүүн хойд Азийн Солонгос, АНУ, Япон гэсэн гурван улсын үзүүлэх дарамт нэмэгдэж байгаа нь гурван талт эвслийг бэхжүүлж чадна.

Тавдугаарт: Япон, Хятад, Япон, Оросын нутаг дэвсгэрийн маргааныг харах ёстой. Хятадын шинэ өмнөд бодлогын дагуу Хятад, Японы Сэнгаку арлуудын маргаан дахин ширүүсэж байна. Сенкаку арлууд нь Зүүн Хятадын тэнгис дэх арлууд бөгөөд Японы Йонагуни арлаас 160 км, Тайвань, Японы Ишигаки арлаас 170 км, Хятадаас 330 км зайд оршдог. Сүүлийн үед Хятад улс Өмнөд Хятадын тэнгист Вьетнам, Филиппинтэй газар нутгийн маргаан үүсгэж, Хятадын тэнгисийн флотыг эрчимтэй бэхжүүлж, сэргэлдэж байна. Сенкаку арлууд нь халуун Өмнөд Хятадын тэнгисийн яг хажууд оршдог. Одоогоор тус арлыг Япон эзэлж байгаа ч Хятад улс тусгаар тогтнолоо зарлаж байна.

Энэ бол зүгээр нэг арлын бүрэн эрхт байдлын асуудал биш, аажмаар хүчээ тэлж буй Хятад, түүнийг зогсоохыг оролдож буй Япон хоёрын зөрчил гэж ойлгож болно. Цаашилбал, энэ нь АНУ-Японы эвсэлд суурилсан далайн гүрнүүд болон тивийн гүрнүүд хоорондын зөрчил гэдгийг бид дахин баталж чадна.

Нэмж дурдахад, Орос, Япон хоёр Өмнөд Курилын арлуудын нутаг дэвсгэрийн маргаантай байгаа. Япон улс 1855 онд Оростой байгуулсан хоёр талын худалдаа, хилийн гэрээний үндсэн дээр эдгээр арлуудыг тусгаар тогтносон гэж үздэг. Нөгөөтээгүүр, архипелагийг хянаж буй Орос улс Өмнөд Курилын арлуудыг олон улсын эрх зүйн гэрээний дагуу (1951 оны Сан Францискогийн энх тайвны гэрээ гэх мэт) хууль ёсоор ОХУ-д буцаан өгсөн гэж буцаж ирэхгүй гэсэн байр сууриа хадгалсаар байна. Дэлхийн 2-р дайн дууссаны дараа ялсан болон ялагдсан орнуудын нөхөн төлбөрийн асуудал⁸. Үүний хариуд ОХУ-тай зөрчилдөж байгаа бүс нутаг бөгөөд 2020 онд АНУ өөрийн баримт бичигт тус бүс нутагт төрсөн хүмүүсийг Япон гэж тооцож,

⁶ Kim Do-young, A study on ways to promote military cooperation between Korea and China under the US-China hegemony competition. ,2023

⁷ <https://www.voakorea.com/a/7264936.html>

⁸ <https://www.yna.co.kr/view/>



уг бүсийг Японы нутаг дэвсгэр гэж хүлээн зөвшөөрнө гэж заажээ.

Зургаадугаарт: Орос, Хойд Солонгосын харилцаанд гарсан өөрчлөлтийг харах хэрэгтэй. Орос, Хойд Солонгос хоёр нь дэлхийн хоёрдугаар дайнаас хойш найрсаг харилцаатай байсан. БНАСАУ-ын цөмийн болон пуужингийн хөгжүүлэлтийн улмаас олон улсын хамтын нийгэмлэг Хойд Солонгосын эсрэг эдийн засгийн хориг арга хэмжээ авах үед ч ОХУ тэдний эсрэг байр сууриа хадгалсаар ирсэн. Нэмж дурдахад, дээрх гурав дахь зүйлээс харахад Орос-Украины дайны үеэр хоёр улсын хамтын ажиллагаа улам бэхжсэн.

Долоодугаарт: Хятад, Тайванийн хооронд асуудал бий. Одоогийн Орос-Украины дайн бол Европын хамгийн том асуудал юм. Нөгөөтээгүүр, Хятад-Тайванийг Зүүн хойд Азийн дайн дэгдэх хамгийн магадлалтай бүс нутаг гэж олон мэргэжилтнүүд ярьж байна. Хятад улс ард түмний амьдрал, аюулгүй байдал, үндэсний тогтолцоо, өвөрмөц онцлогтой холбоотой асуудлуудыг "үндсэн ашиг сонирхол" гэж тодорхойлдог. Тайваний асуудал бол тэдний дундаас хамгийн чухал бөгөөд эмзэг асуудал юм. Иймээс Тайвань төвлөрсөн Хятад болон АНУ, Өмнөд Солонгос зэрэг гүрнүүдийн хоорондын олон улсын маргаан зэрэг том жижиг зөрчилдөөн гарч ирсэн. Ялангуяа Тайванийн Америкийг дэмжигч ерөнхийлөгч саяхан улиран сонгогдсон тул олон ажиглалтууд гарч ирсэн. Хятад улс Тайванийг эзлэн түрэмгийлэх боломжийн талаар хийсэн.

Хоёр. БНСУ – Монгол Улсын хамтын ажиллагааны хэрэгцээ

Олон улсын улс төрийн реалист онолын үүднээс авч үзвэл БНСУ-нь одоогийн байдлаар тэнгисийн хүчирхэг гүрэн АНУ болон шинээр гарч ирж буй хүчирхэг гүрэн болох БНХАУ хоорондын сөргөлдөөн бүхий ердийн буфер улсын байрлалд байна. Түүнчлэн Монгол Улс бол ЗХУ-ын үеэс Орос, Хятадын хооронд буфер улсын үүрэг гүйцэтгэж, ЗХУ-ыг дэмжигч улс байж ирсэн, өнөө үед их гүрнүүдийн дунд төвийг сахисан байр сууриа илэрхийлдэг улс юм. Дээр дурдсан онолын дагуу БНСУ, Монгол Улс хоёр тус бүрдээ хамгаалалтын орон зайн үүрэг гүйцэтгэх тодорхой нөхцөлтэй бөгөөд хоёр

орны аюулгүй байдал, үндэсний эрх ашгийн үүднээс хөрш орнуудтай эв нэгдэлд суурилсан үр дүнтэй хамгаалалтын бүс байгуулах нь тустай байх болно. Тиймээс хоёр улс зохих түвшинд хамтын ажиллагаагаар дамжуулан үндэсний хүчээ нэмэгдүүлэхийг эрмэлзэх шаардлагатай гэж үзэж байна.

БНСУ-Монгол Улсын хамтын ажиллагаа тогтвортой, бат бөх хэлбэрээр үргэлжлэхийн тулд хамтын ажиллагаа зайлшгүй гэдгийг хүлээн зөвшөөрөх үндэс суурь байх ёстой. Монгол улс "Гуравдагч хөршийн бодлого"-оор ОХУ, БНХАУ-аас бусад улстай харилцаагаа өргөжүүлэн үндэсний эрх ашгийнхаа төлөө явж байгаа ч далайд гарцгүй газар зүйн онцлогоос шалтгаалан хил залгаа хоёр орны нөлөөнөөс мултрах амаргүй нь үнэн. Гэсэн хэдий ч Монгол Улсын үндэсний хүчээ тогтвортой өсгөж, батлан хамгаалах чадавхыг сайжруулах замаар бүс нутагт нөлөөгөө нэмэгдүүлж, өөрийн орны үнэлэмжийг нэмэгдүүлбэл газарзүйн хязгаарлалтыг үл харгалзан үндэсний ашиг сонирхлоо итгэлтэйгээр хэрэгжүүлэх боломжтой болно.

БНСУ-ын хувьд илүү хатуу байр суурьтай болохын тулд үндэснийхээ батлан хамгаалах чадавхыг сайжруулахаас гадна үндэснийхээ хүч чадлыг сайжруулах нь чухал юм. Гэвч явцуу нутаг дэвсгэрийн хязгаарлагдмал байдлаас үүдэн цэргийн хээрийн дадлага сургуулилтад хүндрэл гарч байгаа бөгөөд эдгээр асуудлыг шийдвэрлэхэд Монгол Улстай хамтын ажиллагаа зайлшгүй шаардлагатай гэдгийг ойлгуулах ёстой.

БНХАУ эсвэл ОХУ-ын зүгээс БНСУ-Монгол Улсын хамтын ажиллагааг бодит аюул занал гэж үзэх магадлалтай. Хэрэв эдгээр асуудлуудыг шийдвэрлэхгүйгээр БНСУ-Монгол Улсын хамтын ажиллагаа өндөр түвшинд хүрвэл БНХАУ, ОХУ, БНАСАУ-ын аюулгүй байдлын салбарын харилцаа харьцангуй бэхжиж магадгүй юм. Тиймээс БНСУ-Монгол Улс хоёр хөрш зэргэлдээх орнуудын түгшүүрийг арилгахын тулд хамтын ажиллагаагаа ил тод, нээлттэй байлгах ёстой. Тухайлбал, цэргийн бэлтгэл сургуулилын үеэр Хятад, Оросын цэргийн албан хаагчдыг урьж сургуулилтыг ажиглах зэрэг арга хэмжээ авах шаардлагатай гэж болно. Түүнчлэн, БНСУ-



Монгол Улсын хамтын ажиллагааны чиглэл нь хоёр орны зөвхөн өөрийгөө хамгаалах хүрээнд цэргийн чадавхыг дээшлүүлэх хамтарсан бэлтгэл сургуулилтаас хэтрүүлэхгүйгээр, Зүүн хойд Ази болон олон улсын хамтын нийгэмлэгийн энх тайван, тогтвортой байдалд хувь нэмэр оруулахад чиглэх, цаашлаад хөрш орнуудтай хамтран ажиллах талаар идэвхтэй үүрэг гүйцэтгэх боломжтой байх ёстой. Өөрөөр хэлбэл, Энхийг дэмжих ажиллагаа, Гамшгаас аврах ажиллагаа зэрэг уламжлалт бус цэргийн салбарт хамтран ажиллах замаар хоёр орны ард түмний итгэлцлийг нэмэгдүүлж, хөрш орнуудын санаа зовнилыг арилгахын тулд хүчин чармайлтаа үргэлжлүүлэх ёстой.

Монгол Улс үндсэн хуульдаа төвийг сахихыг идэвхтэй дэмжиж, Монгол Улсын нутаг дэвсгэрт гадаадын бусад цэргийг байрлуулахыг хориглодог шиг БНСУ ч мөн адил хилийн чанадад цэрэг, техникээ илгээхийн тулд Үндэсний ассамблейн зөвшөөрлийг авах тухай заасан. Хоёр улсын хамтын ажиллагааг илүү үр дүнтэй хөгжүүлэхийн тулд улс орон бүрийн дотоодын хууль тогтоомжид заасан хязгаарлалтыг тодорхойлж, шийдвэрлэх үйл явцыг эхлүүлэх ёстой. Үүнийг дэлхий даяар ижил төстэй тохиолдлуудыг хайж, шийдлүүдийг ашиглан хийвэл сайжрах болно.

Дээр дурдсанчлан БНСУ, Монгол Улсын хамтын ажиллагааг илүү идэвхтэй явуулахын тулд хөрш орнуудын эрх ашиг, хоёр улсын дотоодын хууль тогтоомж зэрэг олон хязгаарлалтыг шийдвэрлэх шаардлагатай байна. Түүгээр ч зогсохгүй Зүүн хойд Ази нь АНУ, БНХАУ-ын хооронд ноёрхлын төлөөх өрсөлдөөн ширүүссэн үед онцгой бүс нутаг гэдгийг харгалзан үзэх ёстой. АНУ-тай цэргийн холбоотон байгаа БНСУ-тай Монгол Улс хамтын ажиллагаагаа өргөжүүлэхийг БНХАУ ялангуяа хүчтэй эсэргүүцэж байх болно. Ийм нөхцөлд БНСУ-Монгол Улсын хамтын ажиллагааны бодитой чиглэл нь БНХАУ зэрэг хөрш орнуудыг өдөөн хатгахгүйгээр терроризмын эсрэг сургалт, энхийг сахиулах ажиллагааны сургалт, гамшгийн эсрэг аюулгүй байдлын хариу арга хэмжээний сургалт, цэргийн мэргэжилтэн, цөөн тооны нэгж салбаруудыг харилцан солилцон сургалт зохион байгуулах чиглэлээр бага хэмжээний хамтарсан сургалтаас эхлэх

нь зөв. Энэ бол хамтын ажиллагааг цаашид өргөжүүлэх эхлэл бөгөөд цаашид өргөжүүлэхэд түлхэц болно.

Хэрэв БНХАУ-ын зүгээс БНСУ-Монгол Улс хоёрт шударга бус шаардлага тавих, Зүүн хойд Азид ноёрхогч хандлагыг харуулбал, дунд болон урт хугацааны хэтийн төлөвийн үүднээс БНСУ-Монгол Улсын хамтын ажиллагаа стратегийн түвшинд илүү дэвшилтэт шатандаа хөгжих шаардлага үүснэ. БНСУ, Монгол Улсууд их гүрнүүд болох АНУ, БНХАУ-тай харьцуулахад сул орон учраас дээр хэлэлцсэн шигээр өөрсдийн аюулгүй байдлыг хангахын тулд тодорхой хэмжээний үндэсний эрх мэдэл, цэргийн хүчин чадал бүхий завсрын бүсийн үүрэг гүйцэтгэх шаардлагатай байна. Өөрөөр хэлбэл, БНСУ-Монгол Улсын хамтын ажиллагааны цаашдын чиг хандлага нь хоёр орны хамтын ажиллагааг цэргийн доод түвшнээс өндөр түвшинд гаргаж, бие биеийнхээ батлан хамгаалах чадавхыг дээшлүүлэх явдал юм.

Тодорхой жишээ дурдахад, БНСУ орчин үеийн техник хэрэгслээр зэвсэглэсэн боловч газар нутгийн давчуу байдал, хүн амын шигүү суурьшсан гэх мэт хязгаарлагдмал байдлын улмаас практик сургалт явуулахад (хээрийн сургалтын төв) хүндрэлтэй байгаа. Монгол өргөн уудам газар нутагтай ч зарим талаараа барилга байгууламж, техник хэрэгсэл, төсөв хөрөнгийн хязгаарлагдмал нөхцөлтэй. Иймд хоёр улсын хамтын ажиллагааны төлөвлөгөөнд БНСУ-Монгол Улс болон бусад улс хамтран ашиглах боломжтой хээрийн сургалтын төвийг Монголд байгуулж, хамтарсан сургалтыг тогтмол явуулах зэрэг багтаж болно. Ингэснээр БНСУ-ын арми дутуу байгаа сургалтын чанараа дээшлүүлж, Монголын Улсын Зэвсэгт хүчин БНСУ-ын армитай цэрэг техникийн солилцоо хийснээр шинжлэх ухаан, технологийн дэвшилтэт технологи, тоног төхөөрөмжтэй болж, байнга ашиглах боломж бүрдэх юм. Цаашид батлан хамгаалах аж үйлдвэртэй болох, батлан хамгаалах чадавхыг сайжруулахад нөлөөлнө.

БНСУ-ын хувьд АНУ-тай аюулгүй байдал, БНХАУ-тай эдийн засаг гэсэн чиглэлээр тэнцвэрийг хангах дипломат бодлогоор үндэсний эрх ашгаа хангаж байгаа бол, Монгол Улс ч “Гуравдагч хөрш”-ийн бодлогоор төвийг



сахисан дипломат харилцааны стратегийг баримталж байна. Гэвч Америк-Хятадын хооронд өрнөж буй өнөөгийн өрсөлдөөн цаашид хэзээ нэгэн цагт Зүүн хойд Азид оршдог БНСУ, Монгол Улс хоёр улсын хувьд аль нэгийг нь сонгоход хүргэх бололтой.

Дүгнэлт. Зүүн хойд Азид АНУ, Япон, БНСУ зэрэг далай тэнгисийн гүрнүүд болон Хятад, Орос, Умард Солонгосоор төлөөлдөг тивийн гүрнүүдийн ашиг сонирхлын уулзвар Солонгосын хойгийн газарзүйн байрлал дээр төвлөрсөн байдаг. Түүнчлэн, Солонгосын хойгийн асуудал, Хятад-Японы асуудал, Америк-Оросын асуудал, Хятад болон Зүүн өмнөд Азийн янз бүрийн улс хоорондын асуудал зэрэг олон хүчин зүйл Зүүн хойд Азийн аюулгүй байдлын байдлыг байнга өөрчилж байна. Түүнчлэн одоо үргэлжилж буй Орос-Украины дайн, Израиль-ХАМАС-ын дайны чиглэл Зүүн хойд Азийн дэг журамд ямар нэгэн байдлаар нөлөөлнө. Ялангуяа 2010-аад оноос хойш Хятад улс эдийн засгийн хурдацтай өсөж, бүс нутагт нөлөөгөө өргөжүүлснээр эхэлсэн АНУ, Хятадын эрх мэдлийн төлөөх тэмцэл гүнзгийрсэн байдал нь Зүүн хойд азийн аюулгүй байдалд маш чухал юм.

21-р зуунд Зүүн хойд Азийн олон улсын нөхцөл байдал хямарч, хөрш зэргэлдээх хүчирхэг орнуудын хүчний тэнцвэрт байдалд ашиг сонирхлын зөрчил үүсэж, БНСУ-Монгол хоёр улс эдгээр гүрнүүдийн дунд зохицуулагч

бүсийн үүрэг гүйцэтгэх нөхцөл бүрдсэн гэж үзэж болохоор байна. Иймд БНСУ-Монгол Улс хөрш зэргэлдээх орнуудын нөлөөллийн тэнцвэрт байдлыг хадгалах оролдлого нь хоёр улсын дипломат стратегид тусгагдсан гол зорилтуудын нэг бөгөөд үндэсний аюулгүй байдлыг илүү үр дүнтэй хангахад чиглэж байна.

Монгол Улс нь БНХАУ, Оросын дунд оршдог геополитикийн үнэ цэнтэй, байгалийн баялаг ихтэй орон учраас сүүлийн үед болж буй АНУ, БНХАУ-ын ноёрхлын өрсөлдөөнд стратегийн үнэ цэн улам бүр нэмэгдэж байна. Гэсэн хэдий ч БНХАУ, Оросоор хүрээлэгдсэн далайд гарцгүй орон болох газар зүйн хязгаарлалтын улмаас хоёр улсын нөлөө маш их байдаг тул гуравдагч хөршийн бодлого гэж томьёолсон төвийг сахисан, энх тайван бодлого, дипломат харилцааны тусламжтайгаар өөрийн статусыг сайжруулахыг хичээж байна.

БНСУ нь Монгол Улсын ийм стратегийн үнэ цэнийг өндрөөр ойлгон мэдэрч, Монгол Улстай эдийн засаг, аюулгүй байдлын хамтын ажиллагааг хөгжүүлэхэд хүчин чармайлт гаргаж байна. Гэсэн хэдий ч дээрх дипломат харилцааны хөгжилтэй харьцуулахад батлан хамгаалах салбарын хамтын ажиллагаа хамгийн бага түвшинд байсаар байна. Үүний үндсэн дээр Солонгос, Монгол хоёр улс аюулгүй байдал, үндэсний ашиг сонирхлоо ахиулах үүднээс цэргийн салбарт илүү үр дүнтэй хамтын ажиллагаа явуулах ёстой.

**Ашигласан материал:**

1. Kim Do-young , "A study on ways to promote military cooperation between Korea and China under the US-China hegemony competition" , 2023.
2. Д.Уламбаяр, "Монгол Улс, БНСУ-ын стратегийн түншлэл: газрын ховор элементийн салбар дахь хамтын ажиллагааны шинэ боломж", 2023.
3. Максимын Хишигтуяа, "БНХАУ-ын Зөөлөн хүчний бодлогын онцлог ба Монгол Улс", 2023.
4. Jang Jae-hyuk, Kim Ki-seon, "Searching for the alternatives to Korea-Mongolia diplomatic cooperation in the 21st century", 2021.
5. Kim-Yeonji, "Geopolitical research on international war surrounding the Korean Peninsula: Focusing on buffer system theory", 2014.
6. Waltz, Kenneth, "Why Iran Should Get the Bomb: Nuclear Balancing Would Mean Stability", Foreign Affairs, Vol. 91, No. 4, 2012.
7. Jeffrey Reeves, "Mongolia's evolving security strategy: omni-enmeshment and balance of influence". The Pacific Review, Vol. 25., 2012.
8. Kahl, Colin & Kenneth Waltz, "Iran and the Bomb: Would a Nuclear Iran Make the Middle East More Secure?", Foreign Affairs, Vol. 91, No. 5., 2012.
9. Энх-Эрдэнэ, "Монгол Улсын аюулгүй байдал, цөмийн зэвсгээс ангижруулах бодлого", 2011.
10. Lee Seok-su, "Development process of inter-Korean military cooperation (2000-2007): Types, achievements, characteristics", 2008.
11. Organski and Jacek Kugler, "The Power Transition: A Retrospective and Prospective Evaluation," in Manus I.Midlarsky ed., Handbook of War Studies(Boston: Unwin Hyman), 1989
12. Waltz, Kenneth, "Theory of International Politics", New York: Random House, 1979.
13. A. F. K. Organski, World Politics (New York : Alfred A. Knopf, 1958).



“МЭРГЭДИЙН СУРГААЛИАС ЭШЛЭН МЭДЛЭГ БҮТЭЭХ УР УХААН ХҮРТЭЛХ АСУУДАЛ, ШИЙДЭЛ...”

Д.БОЛОД /УБХИС-ийн ГХСТ-ийн багш/

Түлхүүр үг: Мэдлэг, үнэн, туршлага, сургамж, дүгнэлт
Key words: Knowledge, true, experience,, conclusion

Оршил. Мэдлэг бол та бидний таньж мэдсэн үнэний хэмжээ, (үнэн гэж таны л бодол, нэг нь үгүйсгэж, нөгөөх нь эргэлзэж, гурав дахь нь үнэний тухай юу ч ойлгодоггүй, үнэн ийм олон янз) **туршлага бол** алдаа (амьдрал санаснаар болдоггүйг бид туршлага гэж ойлгодог), **сургамж** нь зааж сургасан үг, **дүгнэлт** бол үр дүнг хураангуйлсан баталгаат хариу)

Эрдэм мэдлэгийн аргал түүхээр араг үүрч, үзгэн савар барьж явахдаа олж мэдсэнээ исгэж, элгэн тараг бүрсэн минь эрхэм багш, эрдэмтэн судлагчдад “билгийн зул”, “рашааны дусал” болог... “Эрдмийн эрх чөлөө” – (дээд боловсролын хуулийн 5.1.1.) – г эдлэх... (үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх) – ийн үүднээс УБХИС – ийнхаа эрдэмтэн судлагчдын мэлмий, оюунд энэхүү өгүүллийн ерөнхий санааг хүргэж байгаа нь энэ. Хэнээс ч хараат бус судалгааны ажлын үр дүнгээ эрдэмтэн судлагчдад танилцуулах, хэвлэн нийтлэх, нийтэд түгээх ... (судалгааны ажлын үр дүн” гэж шинэ болон нэмэлт мэдлэгийг хэлнэ) зорилтыг дэвшүүлснээр эрдэмтэн судлагчидтай үзэл бодлоо хуваалцахыг эн тэргүүнд зорив.

Эрдэм шинжилгээний илтгэл, өгүүллийн талаарх өөрийн ойлголтыг товч тайлбарлая.

Олон жилийн ажлын арвин туршлага, судлан шинжлэх ажлын явцдаа бие дааж олж авсан мэдлэгтээ тулгуурлан оюунаа уралдуулж номын үгээр мэтгэлцэхдээ тухайн сэдвийнхээ утгад **гүнзгий нэвтэрсэн шинэлэг санаа нь** аливаа эрдэм шинжилгээний итгэлийн амин сүнс. Гэхдээ судалгааны ажлын үр дүн (шинэ болон нэмэлт мэдлэг) – гээ товч тайлбарлан илтгэх нь эрдэм шинжилгээний илтгэлд тавих үндсэн шаардлага. (Эшлэлгүй бол эрдэм шинжилгээний үндэслэлтэй судалгаа биш

ердийн хуулан бичлэг, оюуны хулгай)

Бидний мэдэхгүйгээ мэдэж авсан мэдлэг бол ердийн шинэ мэдлэг, нийгмийн хөгжилд өөрийн гэсэн хувь нэмрээ оруулахын тулд бүтээсэн мэдлэгийг шинжлэх ухааны шинэ мэдлэг гэж үзнэ. (ЭШ – ний **илтгэл** ердийн шинэ мэдлэг, ЭШ – ний **өгүүлэл** шинжлэх ухааны шинэ мэдлэгийг бүтэээнэ)

Төрийн шагналт, анагаахын шинжлэх ухааны гранд доктор, гавьяат эмч Миеэгомбын Амбагын бичсэн ном “Lamber” – т хэвлэгдсэн шиг, гадаадын нэр хүндтэй “СКОПУС” (Шинжлэх ухааны мэдээллийн сан буюу 2006 онд бүртгэгдсэн ашгийн төлөө байгууллага) – д бүртгэлтэй шинжлэх ухааны сэтгүүлд англиар өгүүлэл хэвлүүлэх замаар Монгол **“үндэстнээрээ овоглосон”** шинэ мэдлэгээр **дэлхийн шинжлэх ухааны мэдлэгийн орон зайг тэлсэн** эрдэм шинжилгээний өгүүлэл маш чухал. Энэ нь дэлхийн түвшний судалгаанд **“Монгол хүн оролцож байгааг, ертөнцийн шинжлэх ухааны хөгжилд монгол хүн хувь нэмрээ оруулж байгаа”** – г харуулсан хэрэг. Монголын эрдэмтэд дэлхийн эрдэмтэдтэй санаа бодлоо чөлөөтэй хуваалцаж, тэднийг алмайруулах мэргэн санаагаа бичээд бас биднийг гайхшируулах гарамгай санааг тэднээс авч ажиллах бололцоог зөвхөн эрдэм шинжилгээний “өгүүлэл” олгодог. **ИМПАКТ ФАКТОР** (Шинжлэх ухааны сэтгүүлийн үнэлгээ болохоос судлагчийн үнэлгээ биш)

БАГШ гэж хэн бэ? уншсанаа хуваалцъя.

Хамгийн шилдэгт нь өөрөө суралцаж, хамгаас шилдэгт нь бусдыг сурга. ФАЛЕС Эртний Грекийн философич МЭӨ 626–548. (Багшийн мэргэжлийн мэдлэг чадвар шавийнх



нь амжилтаар хэмжигддэг. Зааж буй хичээлдээ оюутныхаа сэтгэлийг татна гэдэг онцгой чадвар. Ийм чадвар аливаад чин сэтгэлээсээ ханддаг цөөхөн хүнд л заяадаг Жинхэнэ шавь багшийнхаа түвшин рүү улам ойртож байдаг)

Өөрийнхөө нөр их хөдөлмөрөөр олж авсан мэдлэгээ (...800 оноогоо нүүр бардам авчихсан ...) ихийг мэдэх гэж улайрсан шавьдаа өвлүүлэхээс илүү сэтгэлийн жаргал гэж хаана байхав. ТОМАС УАЙЛДЕР.

Их сургуулийн багш гэдэг бол өөрийгөө үнэлэх үнэлэмжээ нэгэнт олчихсон, итгэл үнэмшил, бие даасан байдлаараа хэнээс ч хараат бус эрдэм судалгааны ажилдаа сэтгэл зүрх, хүч хөдөлмөрөө бүрэн зориулсан эрдмийн ухвартай¹ аль ч улс төрийн хүчин, ямар ч даргаас ангид зөвхөн өөртөө дарга болчихсон нэгэн. Өөрөөр хэлбэл чухам А. Юу хийх, Б. Яаж хийх арга зүйгээ эзэмшихсэн зарим талаараа өөрийгөө ч олчихсон хүн. /Ийм хамт олныг арга залиар удирдах боломжгүй/.

Их сургуулийн удирдлага /тэнхимийн даргаас ректор хүртэл/ манлайлагч байхаас гадна хамгийн гол нь хамт олондоо аль ч талаараа зөвшөөрөгдсөн байх нь чухал. Их сургуулийн эрдмийн хамт олныг удирдана гэдэг бол а.Манлайлагч, б.Сэтгэгч, в.Санаачлагч байна гэсэн үг. (МУИС–ийн жишиг) Их сургуулийн ректор гэдэг бол эрдмийн хамт олны оюуны түүчээ (манлайлагч).

Манай багт надаас ухаантай хүн олон байгаа гэдэг үзлээр хамт олныг удирдана. Аливаа хамт олныг “БОДЛОГО, ДҮРЭМ ЖУРАМ, ЁС СУРТАХУУН”–аар удирдана. Энэ гурвыг удирдлага болгосон хамт олонд “Хөгжлийн боломж” хаалгаа нээнэ. “Би та нараас ухаантайдаа захирал болоогүй. Мэргэн санаа та нараас л төрнө, намайг хараад хэрэггүй, хэрэг болбол намайг дуудаарай” хэмээн нэгэн манлайлагч хэлсэн гэдэг.

Багш– 1.Хүний дайтай хүн байх, 2.Үлгэр дуурайлал, 3.Эрдэмтэн байх. Өрөөлийн төлөө өгөөмөр сэтгэл багшид л байх... (Хүн байх боловсролтой байх хоёр тэмээ ямаа

шиг ялгаатай. “Хүн болоогүй хүнд боловсрол эзэмшүүлэх гэж оролдвол босоо ороолонд алтан шүд хийгээд босгосонтой ав адил” Чой. Лувсанжав. “Бусдыг сургах явцдаа өөрөө шинэ зүйлд суралцдаг нь багшийн мэргэжлийн онцлог. Хүмүүсийг сургах цорын ганц ухаалаг арга бол тэдэнд өөрийн биеэр үлгэрлэх явдал”. А.Эйнштейн.

Хийсэн ажилдаа сэтгэл ханахгүй байна гэдэг багш хүнийг мөнхийн эрэлд хөтөлдөг. Энэ нь багш хүний гол мөн чанар. Р.ГАМЗАТОВ (1923–2003) Дагестаны яруу найрагч, ЗХУ–ын социалист хөдөлмөрийн баатар.

Тэгэхээр шинэ цагийн багш бол ХӨТӨЧ, ЧИГЛҮҮЛЭГЧ, ЗӨВЛӨГЧ, ҮЛГЭР ДУУРАЙЛАЛ ЯАХЫН АРГАГҮЙ МӨН.

“Хамгийн сайн үйл бол хийж байгаа ажилдаа эзэн болох...Бусдын төлөө өөрийгөө бүрэн зориулсан хүн л ХАМГИЙН САЙН ХҮН. Өөрийгөө хүндэлдэг хүн л бусдаар хүндлүүлдэг. Тийм хүн ядаж ичих нүүртэй байдаг” гэж нэгэн ухаантан сургажээ.

Боловсролын талаар бодлоо хуваалцъя.

Хүн ухаантай байх тутам өөрийнхөө тэнэгийг амархан хүлээн зөвшөөрдөг. А.ЭЙНШТЕЙН (1879–1955) Онолын физикч

Намайг сурч мэдэхэд саад болж буй ганц зүйл бол миний олж авсан боловсрол. А.Э Сэтгэн бодохын туйлд нь хүргэж, санааныхаа ааганд тултал сэтгэсэнээрээ хүн төрөлхтний өмнө ер бусын гайхамшиг бүтээхэд нь бидний олж авсан нийтийн боловсрол тэр эрхэмд чөдөр тушаа болж байсан....

...Домогт Р.Чойном Хэнтийд дунд сургуульд сурч байхдаа багшдаа “таны заах зүйлийг би мэдэж байгаа. Шалгалтаа өгөөд шат ахиж дэвшин суралцах хүсэлтэй” гэдгээ илэрхийлснийг сургуулийн захиргаа нь зөвшөөрөөгүй учир 6 дугаар ангиас сургуулиа хаясан гэдэг. Гэвч түүний зохиолоос найруулгын алдаа хэн ч олоогүй.

Хамгийн сайн боловсрол бол бие дааж, өөрөө олж авсан боловсрол. ВАЛЬТЕР СКОТ

¹ Ухаж ойлгох чадвар



(1771–1832) Английн зохиолч. Өөрийгөө олж авсан хүн орчлон дээр ахиж юуг ч гээдэггүй. Нэгэнт доторх хүнээ таньсан бол өөрийгөө ч бусдыг ч ойлгодог. Өөрийгөө таниагүй хүн үргэлж бусдын доор явдаг. (Өөрийгөө таньсан хүн сул талаа мэддэг. Хүний орчлонд өөрийгөө олох л чухал. Тэгвэл хэнийг ч, өөрийгөө ч зовоохгүй) Ухаантай хүн өөр лүү нь довтолж буй хүний ярианаас өөрийнхөө сул талыг олж хардаг. РАЛЬФ ЭМЕРСОН (1803–1882) Америкийн уран илтгэгч... Энэ үед боловсролтой хэр нь юмны учир ойлгохгүй хүн олон болсон цаг..)

Байгалиасаа авьяастай төрсөн хүнийг боловсролтой гэхгүй. Харин мэдэж байгаа бүхнээ ухаалаг, хамгийн ашиг тустайгаар бусдад түгээж байгаа, өөрийнхөө мэдлэгт юу дутууг бүрэн нөхөж чаддаг хүнийг л боловсролтой хүн гэнэ. ИОХИМ РАХЕЛЬ (1618–1669) Германы яруу найрагч. Удам сайн байх нь сайн хэрэг ч эцэг өвгөдийн л өмч. Алдар нэр, эд хөрөнгө бол түр зуурынх. Эрүүл мэнд чухал боловч амархан доройтно. Хүч чадал атаархам боловч өтөлж, өвдөхийн цагт оргүй алга болно. Харин эрдэм боловсрол л үхэшгүй мөнхийн баялаг. **Ухаантай, бусдад хэлэх үгтэй хүнд үүнээс илүү эрхэм зүйл гэж үгүй.** ПЛУТАРХ (НТ 46–127) Грекийн философич.

Өөрөөр хэлбэл үзсэн харсан, сонссон дуулсны дээр уншсанаа нэмбэл **боловсрол** ургуулан бодож, ухаарч өөрийн болгосон нь мэдлэг чадвараа хөгжүүлж тодорхой үр дүнд хүрч, нийтэд зөвшөөрөгдвөл эрдэмтэн болно. Д. Б (Эрдмийн бүтээлээрээ хүлээн зөвшөөрөгдсөн хүнийг л эрдэмтэн гэдэг)

Докторын талаар дотнчлон ярилцъя.

Доктор нь боловсролын дээд зэрэг, шинэ мэдлэг бүтээх, шинжлэх ухааныг хөгжүүлэх, үр шимийг нь хүртэх, түгээх хэмжээний боловсрол. Оюуны өндөр чадамжтай, судалгаа шинжилгээний ажил хийх авьяас, чин хүсэл сонирхолдоо хөтлөгдөн түүнийгээ **амьдралын зорилгоо болгосон хүн.** Докторын зэргийн олон улсад тогтсон нийтлэг нэр нь

философийн доктор **Ph.D** Энэ нэрийг манай ШУА “Боловсролын доктор” хэмээн орчуулсан нь олон улсад түгээмэл хэрэглэдэг нэр томъёог мушгин гуйвуулсан. Зүй нь боловсролын доктор гэвэл боловсрол судлалын чиглэлээр доктор хамгаалсан гэж ойлгоно. Харин шинжлэх ухааны ямар салбар, чиглэлээр доктор хамгаалснаас нь шалтгаалан Байгалийн ухааны **Ph.D Sci**, инженерчлэл **Ph.D Eng**, боловсрол судлал **Ph.D Edu**, Хүмүүнлэг **Ph.D Hum**, хөдөө аж ахуй **Ph.D Agr** гэх мэтээр товчлон бичдэг нь олон улсад тогтсон жишиг.

Нэг сая хүнд ноогдох шинжлэх ухааны бүтээлийн тоо (чанар)–аар нь аливаа улсын хөгжлийг хэмждэг болжээ. Их сургуулийн багшийн чанарыг докторын зэрэгтэй багшийн тоогоор биш, бичсэн бүтээл (өгүүлэл)–ийн чанараар нь үнэлэх нь хамгийн шударга бөгөөд зөв алхам. Бидний багад шинжлэх ухаанд “тооноос чанар чухал” гэж заадаг байсан бол хожим нь “тоо нь чанараа цохидог” гэдгийг амьдралаас яс махандаа шингэтэл ойлгосон. Хүн цөөн байх тусмаа хүчилтөрөгч их байдаг гэдэг шиг доктор цөөн байх тусмаа эрдмийн бүтээлийн чанар, эрдэмтний нэр хүнд сайн байна. Доктор зэрэгтэн хэт олширвол шинжлэх ухааны нэр хүндэд үлэмж халтай. Докторын зэргийг шинжлэх ухааны эрхэм сайхан нэр хүнд сүүдэр шиг дагаж явдаг. Энэ цагт эрдмийн зэрэг авч чадсан эрдэмгүй толгой Ph.D дэндүү олон болж байгаад сэтгэл үнэхээр дундуур... МУИС–ийн эрдэмтэн судлагчдын судалгааны чанарын үзүүлэлтээс үзвэл 2023 оны 8 сарын байдлаар 832 багшаас 429 буюу нийт багшийн 52 хувийг боловсролын зэрэг цолтой багш эзэлж байв. Энэ тоо чанарын үзүүлэлт биш.

Уг нь эрдэмтэн болох тун энгийн. Эхлээд судлах сэдвээр материал цуглуулж, дараа нь арга зүйгээ сонгоно. Энэ хоёрыг нийлүүлэхээр танаас хамаарахгүй үр дүн гарна. Үүнийг шинжлэх ухаан гэнэ. Шинжлэх ухаан өөрөө ярьж, бичиж чаддаггүй тул гарсан үр дүнг өөрийн нэрээр хэвлүүлнэ. Тэр нь урьд мэдэгдээгүй зүйл тогтол (учир зүйгээр тогтож хэвшсэн зүйл) байвал олон улсад зөвшөөрөгдөж эрдэмтэн болно. Гэтэл олон улсад **плагиат** гэх оюуны хулгайг онцгой анхаардаг. (plagiat хулгайлагдсан гэх Франц



үг) Бид докторыг эрдэмтэн гэж өнөөг хүртэл эндүүрсээр ирсэн. Эндүүрэх бол буруу ойлгох. Үнэндээ бол боловсролын доктор (Ph.D) их, дээд сургууль, коллежид багшлах, шинжлэх ухааны доктор (Sc.D) нь хамгаалсан сэдвээрээ цаашид судалгааны ажил хийх “бүрэн эрх”. Ингэж бусдын бичсэнийг хуулж өөрийн нэрийг тавьснаар эрдэмтэн гэж эндүүрэгдсэн оюуны хулгайч монголд олшров. **Үр дүнд нь тэднээр хичээл заалгасан оюутнууд төгсөөд ажил хийх чадваргүй болчих нь тэр.** Тиймээс БСШУЯ шинэ журам гаргаж, докторантуудад олон улсын шинжлэх ухааны жинхэнэ сэтгүүлд ядаж нэг судалгааны өгүүлэл өөрийн нэрээр хэвлүүлсэн байхыг шаардаж эхлэв. Гэтэл жинхэнэ докторууд нь аль хэдийн шинжлэх ухааны жинхэнэ сэтгүүлд судалгааны өгүүлээ хэвлүүлчихсэн байдаг. **Тэднээр заалгасан оюутнууд төгсөөд ажлын чадвартай болсон нь судалгааны ажлын үр шимийг хүртэж байгаа нь тэр. Дэлхийд плагиат, манайд доктор бүр эрдэмтэн².**

Дэлхийн нэр хүндтэй их сургуулиуд сургуулиа олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн QS (Quacquarelli Symonds, QS World University Ranking) байгууллагаар эрэмбэлүүлэхийн тулд их сургууль дотроо “**профессоруудаа эрэмбэлж**, чансааг нь тогтоодог”. (АШУҮИС профессоруудаа жилд дор хаяж нэг эрдэм шинжилгээний өгүүлийг “Скопус” (Шинжлэх ухааны мэдээллийн сан буюу 2006 онд бүртгэгдсэн ашгийн төлөө байгууллага) платформд бүртгэлтэй сэтгүүлд нийтлүүлсэн байхыг шаарддаг. “Скопус” платформд бүртгэлтэй олон улсын болон дотоодын сэтгүүлд **хариуцлагатай зохиогч, нэгдүгээр зохиогч, хамтран зохиогчоор** өгүүлэл хэвлүүлэх (Шинжлэх ухаанд оруулсан хувь нэмрээр нь зохиогчийг 14 ангилж, шинжлэх ухаанд хувь нэмэр оруулсан бол зохиогч гэж үзнэ), олон улсын болон дотоодын санхүүжилттэй төсөл хөтөлбөр удирдах зэрэг үзүүлэлтээр дүгнэвэл судалгааны ажлын чанар өсөхийн зэрэгцээ өрсөлдөөнд суурилсан зарчим үйлчилж, эрэмбэлэгдэнэ. Профессор цолыг олгох шалгуурт тухайн эрдэм шинжилгээ, судалгааны мэргэжлийн ИМПАКТ ФАКТОР (Шинжлэх

ухааны сэтгүүлийн үнэлгээ болохоос судлагчийн үнэлгээ биш) өндөр сэтгүүлд өгүүлээ хэвлүүлсэн тохиолдолд профессор цолыг шууд олгодог **нь олон улсад үнэлэгдсэн багш тус сургуульд ажиллагчийн баталгаа.** Үүнээс гадна судалгааны олон бүтээлд судлагчийн нэр орохоос гадна эшлэл авагдсан тоо маш чухал. Ингэснээрээ докторын зэрэг хамгаалуулах тооны хойноос хөөцөлдсөн хэлбэрийг халж байгаа юм) АШУҮИС–ийн жишиг.

Ном уншиж эрдэмтэй болдог, эрдэмтэй болж байж ном бичдэг талаар...

Ном сурахад 3 гэм буй.

а. Хөмөрсөн сав. Ямар ч сургаалыг хүлээн авдаггүй, ямар ч сайн багш ойлгуулж чаддаггүй.

б. Цоорхой сав. Мэдлэг тогтохгүй. (Багшийн заасныг цааш нь хөгжүүлээд аваад явж чадахгүй хүнд ном заах хэрэггүй, үр дүнгүй)

в. Бохир сав. Итгэл бишрэлгүй, сэтгэл буруу хүмүүс. Бохир саванд хийсэн рашаан ч угаадсаас дор болдог.

Номын номоос хүний ном илүү. (Эрдмийн зэргээс хүний зэрэг чухал. Эрдмийн зэрэг өвлөгддөг бол хүний зэрэг өвлөгдөггүй) Р.ГАМЗАТОВ

Уншихад үнэ цэнтэй зүйл бич. Эсвэл бичихээр үнэ цэнтэй зүйл хий. БЕНЖАМИН ФРАНКЛИН (1706–1790) Америкийн үүсгэн байгуулагч, (Бичихээр үнэ цэнтэй зүйл үгүй бол ном бүү бич. Учир нь муу ном мэргэн ухааныг бүрмөсөн үгүй хийдэг нүгэлтэй)

Номд маш хатуу шалгуур хэрэгтэй. Хэрэв шалгуургүй бол уншигчдын цагийг үрж, хойч үедээ өвлүүлэх мэргэн ухааныг бүрмөсөн үгүй хийдэг. ЖОН МИЛЬТОН (1608–1674) Улс төрийн зүтгэлтэн

Профессор бол их сургуулийн сэтгэдэг тархи...

1. Профессор хөгжлийн хурдасгуур, **соён гэгээрүүлэгч**, эрдэм мэдлэгийн оньсыг тайлагч, оюун ухааныг тэлэгч, амьд, ярьдаг ном, үндэстний “ХЭЛ

² Өдрийн сонин 2024.02.05№024



- СЭТГЭЛГЭЭ”–ний сор... (Б. Ринчен)
2. Профессор нь эрдмийн ажлын үнэлгээ... Бусдаас илүү өөрийгөө хөгжүүлж, бусдаас илүү бодож СЭТГЭН, шинжлэн судална гэсэн үг. Профессор гэж насаараа СУРЧ, СЭТГЭЖ, ЗОХИОЖ, ХЭВЛЭН НИЙТЭЛЖ, ТҮГЭЭН ДЭЛГЭРҮҮЛЭХИЙН НЭР. (МУИС–ийн ЭШ–ий бичиг)
 3. Докторын жолоодогч (Өвөр монголын их сургууль). Профессор нь онол, эшлэлийг хослуулсан мэдлэгийн, оюун санааны удирдагч, их багштан сартваахь (номч мэргэн) шүүмжилбэл би л хувьдаа огт хүлээж авахгүй. Чухам тийм л сайхан нэр нөлөө...
 4. Номын эрдэм, хүний эрдэм хоёрыг хамтад нь нэвтэрхий (өргөн мэдлэг, ойлгоц гүн) эзэмшсэн багштан.
 5. Мэргэжлийн мэдлэгээрээ шилдэг нь учир профессорын бүтээл улс үндэстнийхээ хэмжээнээс давж, эрдэм шинжилгээ, лавлагааны ач холбогдлоороо олон улсад бүрэн хүлээн зөвшөөрөгдсөн байдаг.
 6. Профессор бол их сургуулийн оюуны цөм нь буюу “сэтгэдэг тархи” нь “мозг орган мышление” юм. (ОХУ)
 7. Шинжлэх ухааны салбар, салбарынхаа оюунлаг хэсгийг дагуулж яваа “оюуны түүчээ, эрдмийн хамт олны эрдэнэ”. (МУБИС)
 8. **“Хоёр профессор хэрэлдэхэд аль алиных нь зөв байдаг” (АНУ)**

Шинжлэх ухаантай холбогдуулж санаагаа нэмэрлэе...

Шинжлэх ухаан бол ертөнцийн нууцад нэвтрэх, амьдралын утга учрыг тайлахад чиглэгдсэн мэдлэг ухааны сан хөмрөг. (Шинжлэх ухааны салбарт асуудлыг олонхоороо шийддэггүй. Хэн зөв сэтгэж, хэн онол гаргасан нь аяндаа зөвшөөрөгддөг. Тиймээс асуудлыг санал хураалтаар шийддэггүй. Шинжлэх ухааны салбарт ардчилал нь тэргүүлж буй

цөөнхдөө байдаг. Яаж хүлээн авах нь тухайн судлагчийн ёс зүйн асуудал. (Тухайлбал, “Олон улсын шилдэг бүтээл”, “Шинжлэх ухааны шилдэг өгүүлэл” цаашилбал, Эйнштейн, Стивен Хокины бүтээлийг шүүн тунгаахад хамт олны санал хураалт огт хэрэггүй. Их хүний явдлыг эгэл олон шүүдэггүй. Хаадын сунтгийг далай багш, ноёдын хунтгийг богд л шүүдэг гэдэгсэн) Өндөр хөгжилтэй орны шинжлэх ухааны байгууллагад ажиллаж байгаа судлагчид бүгд том сэтгэгчид байдаггүй гэдэг. Тэднийг галт тэрэгний зүтгүүр шиг цөөн хэд нь чирч явдаг. Тэр зүтгүүрийнхээ ажиллах бололцоог бусад нь бүрдүүлж, тусалж, дэмжин тэднийхээ нөмөрт явж байгаа гэдгээ ч бусад нь сайн мэддэг...)

(Олонхын санал шударга ёсны хэмжүүр байж таарахгүй. ФРИДРИХ ШИЛЛЕР. Хүмүүс яагаад олонхыг дэмждэгийн учир нь тэдний зөв биш олуулаа хүчтэй учраас л тэр. Тэгвэл хүмүүс яагаад эртний ёс заншлыг баримталдаг вэ гэхээр ёс заншил нь ухаалагтаа биш, нийтээрээ хүлээн зөвшөөрөгдчихсөн учраас л тэр. Б. ПАСКАЛЬ Сайн үйлийг олонх дэмждэг нь үйл нь сайндаа биш, өөрт нь ашигтай учраас тэр ...

Нийтээрээ хүлээн зөвшөөрч байна гэдэг бол оюун ухаан шаардсан ажилд хамгийн муу үр дүн үзүүлдэг. Ухаант мэргэдийн үг, нийтийн мөрддөг хууль дүрмийн тун цөөхөнд нь нийцдэг. ДЕКАРТ (1591–1650) Францын философич, орчин үеийн философийн эцэгб

(Шинжлэх ухаан гэж бидний нэрийддэг танин мэдэхүйн арга өөрийн хязгаараас хальсан ойлголтод харгис хандаж, хүний дотоод мөн чанар, орчлон хорвоогийн нууцыг таньж нээсэн үзэл номлолыг “шашны бурангуй үзэл” гэдэг нэрийн доор хавчин хяхсаны улмаас хүн төрөлхтөн байгаль ертөнцөө хөнөөгч хар хүчин болж хувираад буй энэ цаг үед далд ертөнцийг шимтэн судлах нь маш чухал) (Өнөөдрийн шинжлэх ухааны судалгааг 100 хувь гэж үзвэл 95 хувь нь амьгүй зүйлийг судалжээ. Амьд зүйлийг судалсан нь тавхан хувь. Тэрхүү 5 хувийн ганцхан хувь нь хүний судалгаа. Судлагдаагүй хүнээ судлаагүй байж яаж хөгжүүлэх гээд байгаа нь сонин.



Хүн өөрчлөгдөж байж нийгэм өөрчлөгдөнө. Г.Лхагва Хүнийг гүнзгий судалсан шинжлэх ухаан буддизмаас өөр алга Өдрийн сонин 2020.10.16 №209 Бид эх дэлхийнхээ дотор талыг ойлгохоосоо илүү нарны дотор талын тухай илүү их мэдлэгтэй байгаа нь хачирхалтай. РИЧАРД ФЕЙНМЕН 1918–1988 Америкийн физикч/Дэлхийн гадаргуугаас дэлхийн төв халуун хайлмаг хүртэл 6370 км/

РЕФОРМ бол ШИНЭТГЭЛ. Энэ нь сайжруулах гэсэн санаа.

МОДЕРНИЗАЦИЯ бол ШИНЭЧЛЭЛ. Энэ нь үндсээр нь өөрчлөх гэсэн санаа.

ЭРДЭМТЭН (номын ид хавыг гайхуулсан), (МЭРГЭД мэдлэгийн далай) –гэх үгийн талаар эргэцүүлэн бодвол...

(Эрдэмтнийг нээлтийн, эрлийн, **онолын, эшлэлийн** гэж ялгаж болно. Б.Л.Эрдэмтэн хүнийг яаж амьдарснаар биш, бүтээлийнх нь үзэл санаа, онол арга зүй нь нийгэмд хэр хүрч байгаагаар нь үнэлдэг. Онол арга зүй нь амьд байх ёстой. Онол, эшлэл хоёроороо олныг араасаа дагуулж чадвал жинхэнэ эрдэмтэн болдог) Тэгэхээр номын ид хавыг гайхуулж, олон түмэндээ хүлээн зөвшөөрөгдсөн хүнийг **эрдэмтэн гэх** нь. Харин номын шидийг эзэмшиж чадсан сод ухаантныг **мэргэд** гэдэг. Хорвоогийн гайхамшиг бол хүн, хүний гайхамшиг нь мэргэд. ГАМИЛЬТОН 1755–1804 Америкийг үндэслэгч.

Эцгийн бахархал хүү эх орны бахархал эрдэмтэн Жинхэнэ ЭРДЭМТЭН хүний ухаан хамгаалсан сэдвийнхээ хүрээнд халгиж, цалгиж, булгиж байх ёстой бол жинхэнэ “ЭРДЭМТЭЙ ХҮН”–ий ухаан эрдэм мэдлэгийн далайд буцалж, оргилж, даргилж (хэтэрхий оргилох) давлагаалан, сагаж “УХААНЫ ДАЛАЙ” руу их мөрөн лугаа цутгаж байх ёстой. (Их аварга Дагвадоржийн ид барилдаж байсан үе шиг...) Хуучин цагийн эрдэмтэн гэдэг бол их сургуулийн мэргэжлийн тэнхим (лаборатори)–ийн дайтай толгой байсан бол эрдэмтэй хүн их сургуулийн дайтай толгой байж.

Эртний эрдэмтэд өөрийгөө өв тэгш боловсруулахын тулд суралцдаг байсан бол

өнөө цагийн хусран (үр төлгүй, үржил шимгүй, өгөөжгүй) эрдэмтэд зөвхөн албан тушаал дэвших, нэр хүндийн төлөө суралцдаг болжээ. ШҮН – ЦЗЫ Хятадын их философи

Миний Дагестанд толгойгоо өндийлгөж байгаа гурван дайсан буй. Эхнийх нь архидалт, хоёр дахь нь танхайрал. Гурав дахь эрдмийн зэрэг гориллох дон. Тийм донтон өөрсдийгөө эрдмийн зэрэггүй бол хүн биш гэж санадаг. Муу эрдэмтэн нэр нүүргүйн дээр, нүдний булай.

Хүнд эрдмийн зэрэг бус хүний зэрэг нэн чухал. Эрдмийн зэргийг өвлүүлж болдог бол хүний зэрэг өвлөгддөггүй. РАСУЛ ГАМЗАТОВ (Их нигүүлслээс хортон төрдгийн учир энэ. Бурхнаас чөтгөр, чөтгөрөөс бурхан төрөх нь бий)

“Газар”, “гэр орон”, “бүх хөрөнгө”–өө алдсан ч болно. Харин “**хүн чанараа л гэж болохгүй**” Энэ бол уулынхны мэргэн үг. Эрдэм чадлаа харуулах амархан ч хүн чанараа харуулах амаргүй.

Өр авлагын хорвоод өчнөөн юмаа алдан байж өөрийгөө авч үлдэх гэж өдий хүртэл би их зовсон. Гэсэн ч би хүн байж чадсан. Д. Пүрэвдорж ардын уран зохиолч, хөдөлмөрийн баатар. Энэ цагт хүний сайн нь хүлгийн хурдан нь бусдаасаа илүү зовж явдаг.

Боловсролоо мэдлэг болгож, мэдлэгээ ухаан болгох хэрэгтэй. Эрдэмтэн, эрдэмтэй хүн хоёр тэмээ ямаа шиг ялгаатай. Эрдэмтэй хүн зөв үзэл, сэтгэлээр олж авсан боловсролоо эрдэм (ухаан) болгон эзэмшиж, бусдын тусын тулд хэрэглэж чаддаг хүн. Өдрийн сонин 201712.11 №263 Ж.Бор, Д.Баатар)

Сайн төрийн толгойд хууль дүрэм, муу төрийн толгойд ноёд, түшмэд. Манайхан “эрдэм ном” гэхээр “эрдмийн зэрэг цол” магистр, доктор, академичийн үнэмлэх гээд хадуураад явчихдаг. Монголд магистр, доктор, академичийн хавтас бол эрдэм номын илэрхийлэл (мэдлэг, мэргэшил, туршлага, чадвар) гэх утгаа аль хэдийн алдсан. Тэдгээр **эрдэмгүй эрдэмтдийг аттестатчилах, эрэмбэлэх, бүтээлийг нь дахин шүүлтэд оруулах, яаж зэрэг, цол авсан талаар мониторинг хийхэд** болохгүй нь үгүй. Ц.Өлзийтогтох “Төрийн хэлхээ эрдэм

ном” Өдрийн сонин 2016.03.08 №054

“Зуун зуурмал заанаас нэг амьд илжиг дээр

Түмэн түүхий зэрэгтнээс нэгэн оюутан дээр”,

“Мунхаг хүнд зэрэг байвч эрдэмгүй, гагцхүү түмний шившиг төрийн хохирол” Б. Ринчен Худалч эрдэмтэнг яах вэ? гэхэд Хуурамба гэхэд оноо доо ...” “Худалч эрдэмтэнг яах вэ? Хуурамба гэхэд оноо доо ...” Д.Оюунцэцэг Өдрийн сонин 2013.12.21 №307

Зөв сэтгэж сураагүй хүн их сургуулиа төгсөхдөө ч, эрдмийн зэрэг хамгаалахдаа ч мэдэрч амжилгүйгээр өнгөрдөг зүйл бол зөв найруулах эрдэм ухаан. (**Аливаа эрдмийн бүтээл нь хэл шинжлэлийн талаасаа маш үнэ цэнтэй байх ёстой. Үнэн зөв байдагтаа л шинжлэх ухааны үнэ цэн оршдог. Жинхэнэ үнэ цэнтэй мэдлэг л үнэн зөв, ямар ч алдаа мадаггүй бичигдсэн байдаг**).

Монголын шинжлэх ухаан “ҮНДЭС, ҮНДЭСТЭН” хоёрыг ялгаж чадахгүй болчихсон гэвэл дэгс биш гэлтэй. Үндэсний (үндэстний гэх) аюулгүй байдлын тухай их ярьж бичих болсон энэ цагт монгол үндэстний аюулгүй байдлыг хангах, хамгаалах талаар ярьж байгаа бол монгол үндэстний талаас илүү нь БНХАУ-ын салшгүй хэсэг болсон болсон. Хэдэн зуун мянга нь ОХУ-д суурьшин амьдарсаар олон зууныг үдсэнийг санахад илүүдэхгүй. Энэ нь монгол үндэстнээ Орос, Хятадаас хамгаалах гэж байгаа юм шиг хоёр их хөршид ойлгогдвол яана. Ингэж мушгиж ойлговол асуудал ноцтой болно. Харин туурга тусгаар монгол улс аюулгүй байдлаа хангах, хамгаалах бүрэн эрхтэйг хоёр их хөрш маань сайн ойлгож байгаа.

Горилогчид сэдвээ томьёолохдоо “... зарим асуудал”, “... зарим арга замыг судлах нь” (гэх тодорхойгүй юмыг төлөөлөн нэрлэх нь заримыг нь судлаад заримыг нь яах болж байна), “... хөгжлийн талаарх зарим бодрол”, “... төгөлдөржүүлэх нь” (гэх нь төгсийн төгс болгоно. Энэ нь эрдэм чадал хэтийдсэн хосгүй, ижилгүй гэсэн санааг тоон ухаанд шилжүүлбэл 100 % гэсэн үг . Энэ бол амьдрал дээр ямар ч боломжгүй. Учир нь төгс амьдрал, төгс хүн гэж үгүй), “... сайжруулах нь”, “боловсронгүй болгох

нь” гэх зэргээр агуулга сэдвээсээ хазайсан, бүрхэг, оновчгүй үгээр нэрлэсэн нь харагддаг.

Эрдмийн бүтээл төдийгүй номын гарчиг, товч тодорхой, агуулгаа оновчтой илэрхийлсэн бэлгэдэлтэй сайхан нэртэй байх нь монголын хийгээд дорно дахины бичгийн мэргэдийн уламжлал. Тэд бүтээлийнхээ нэрийг “Зүрхэн толт” (хүн амьтны зүрхний угийн бүдүүн судастай хэсэг), “Билгийн зул”, “Тодорхой толь”, “Эрдэнийн эрих”, “Рашааны дусал”, “Чандманий чимэг”, “Хэлний чимэг”, “Эрдэнэт толь” хэмээн нэрийдсэнийг үлгэр болгон уламжлуштай.

Шинжлэх ухааны жинхэнэ мэтгэлцээн өрнүүлж чаддаггүй хүн “эрдэмтэн” биш гэсэн эртний үг бий. Жинхэнэ мэтгэлцээний дүнд эрдэмтэн төрдөг болохоос нэг сэдэв барьж аваад зөвхөн түүндээ зориулж эрдмийн зэрэг горилсон бүтээл маягийн юм бичсэн болоод зэрэг авах амархан. Доктор болох амархан доктор байх хэцүү. Тэр тусмаа монголдоо наалдах юмгүй бүтээл байх юм бол нэг их сургуулийн номын санд ч юм уу өөрийнх нь фейсбүүкийн буланд хаягдсан үнэ цэнгүй зүйл болж хувирдаг жамтай. **Ц.Гомбосүрэн** Гадаад харилцааны сайд асан, төрийн шагналт, СГЗ, дуун хөрвүүлэгч, дипломатч/ (Мэтгэлцээн бол цэц булаалдан үгээр тэмцэлдэх)

- Академик ертөнцөд **хэнээс ч үл хамаарах тодорхой ажлын үзүүлэлт, шалгуур, олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн бүтээл** л маш чухал.
- Орчин үед эксперт (шинжээч)–гүй судалгаа бол судалгаа биш, дэмий хөрөнгө, цаас, цаг үрсэн ажил. Экспертгүй газар эрдэмтэд нь тухайн байгууллагынхаа явцуу эрх ашигт захирагдсан хөлсний ажилтан болж хувирдаг. Төр өгсөн захиалгынхаа дагуу өөртөө тохирсон дүгнэлтийг тэднээр хүчээр гаргуулдаг. Өөр дүгнэлт гаргавал хохирдог. Ийм нөхцөлд шинжлэх ухаан нь шинжлэх ухаан биш эрдэмтэд нь эрдэмтэн биш болдог. Ингэж аргаар академич, залиар захирал болох нөхцөл



бүрддэг. Ц.Дэмбэрэл Судалгааны их сургууль ба дөрвөн шинэчлэл Өдрийн сонин 2019.12.12 №252)

- Эрдэм судлалд дундуур авьяастай нь дуурайж бичдэг, дууссан авьяастай нь хуулж бичдэг. Д. ЛУВСАНДЭЛЭГ
- (Судлаач гэдэг нь шаардан захирсан үйл үгийн хэлбэр. Судлах дургүй, магадгүй чадваргүй, судалгаа шинжилгээний ажил хийх огт сонирхолгүй хүнийг хүчээр судалгаа хийлгэж байгаа мэт болно. Өмнөд монголд судлагч гэж нэрлээд нэгэнт тогтчихсон. Энэ нь байлдагчийг “байлдаач” гэсэнтэй адилхан)
- Эрдэм судлалын ажил бол оюунаа чилээж, үсээ цайлгаж, чөмгөө дундалж, ясаа хавталзуулан байж, унтаж байхдаа ч зүүдэлж хийдэг хүнд хөдөлмөр В. Инжинаш. Өөрөөр хэлбэл мэдрэлээр наадсан хүнд ажил.

Дүгнэлт. Биеийн жаргал эрүүл мэндэд, ухааны жаргал мэдлэгтэй байдаг. ФАЛЕС Грекийн гүн ухаантан МЭӨ 623– 545 (Гагцхүү мэдлэг л хүнийг чөлөөтэй, агуу болгодог Д

И.Писарь) Саруул ухаан, эрүүл бие хоёрыг жаргалтай амьдрал гэдэг.

Оюун санааны ертөнцөд хэн мэдлэгтэй нь амжилтад хүрдэг. УИЛЬЯМ ЖЕЙМС (1898–1944) Хамгийн өндөр IQ–тэй. Түүний ухааны чансаа 250–300 байсан гэдэг. Америкийн нягтлан бодогч. Төсөөлөл бол мэдлэгээс ч чухал. А.Э

Бид 1.Төрөлхийн мэдрэмжээрээ олж авсан зүйлээ, 2. Өөрийн амьдралын туршлагаараа олж таньсан зүйлээ, 3. Номоос уншсан биш, **номын ачаар олж мэдсэн, (өөрөөр хэлбэл уншсанаа эргэцүүлэн бодоод учрыг нь олсон зүйл)**–ээ хамгийн сайн мэддэг. ШАМФОР Францын зохиолч 1741–1794

- Авах хүнд нэг үг ч билиг, орхих хүнд мянган сургаал ч улиг Д. РАВЖАА
- Энэхүү өгүүлэл та бүхэнд амьдралын сургаал, оюуны цэнэг, тархины тэжээл, шинэ ойлголт, мэдлэг болтугай...
- Эрдэмтэй хүнийг 4 уулын сүлд тэтгэдэг гэж судраас уншсан. Баянзүрх, Хан –Уул, Сонгино, Чингэлтэй хайрхны сүлд ивээг.

Ашигласан материал:

1. Д. Болод “Мэргэдийн сургаалиас эшилсэн 1000 өгүүлбэр”
2. Д. Болод “Шинжлэх ухааны хэл найруулга”
3. Өдрийн сонин 2024.02.05°024 Дэлхийд плагиат, манайд доктор бүр
4. эрдэмтэн
5. Өдрийн сонин 201712.11 °263 Ж. Бор, Д. Баатар
6. Ц. Өлзийтогтох “Төрийн хэлхээ эрдэм ном” Өдрийн сонин 2016, 03.08 °054
7. ...“Худалч эрдэмтэнг яах вэ? Хуурамба гэхэд ононо доо ...” Д.
8. Оюунцэцэг Өдрийн сонин 2013.12.21 °307
9. Ц.Дэмбэрэл Судалгааны их сургууль ба дөрвөн шинэчлэл Өдрийн сонин 2019.12.12 №252
10. Түдэв Л. Сүүдэр сүүдэр цаашаа УБ., 2015
11. Сүхбаатар Ц. Монгол хэлний найруулга зүй УБ., 2012
12. Оюун Ц. Их дээд сургуулийн үйл ажиллагааны онол арга зүй УБ., 2015
13. Батхүү Ж. Эрдмийн зэрэг цолоо эмхэлж цэгцэлье Өдрийн сонин 2020.05.06 ° 093
14. Амарсайхан Д. Монгол Улсад шинжлэх ухаан хэрэгтэй юу? Өдрийн сонин 2012.01.13№010
15. Аюурзана Г. Цэцэн мэргэний нэвтэрхий толь УБ.,2015
16. Болдбаатар Л. Докторын боловсрол ба дэлхийн жишиг / ШУТИС-ийн Олон Улсын дээд боловсрол судлалын төвийн захирал, проф “Өдрийн сонин” 2007.11.24. 280
17. Баттогтох Д. Эрдэм шинжилгээний зохиолын найруулга УБ., 2007



АНГЛИ ХЭЛНИЙ СУРГАЛТАД “УХАМСАРЛАН ХАРИЛЦАХ–КАЛЛАН” АРГА ЗҮЙН ХУВИЛБАР БОЛОВСРУУЛАН ТУРШСАН НЬ

Б.ОТГОНСҮРЭН /УБХИС-ийн ГХСТ-ийн англи хэлний багш, доктор,(Ph.D)/

Түлхүүр үг: Каллан арга, сургалт, бичих чадвар, ярих чадвар, сонсох чадвар, унших чадвар
Key words: Callan method, methodology, writing skill, speaking skill, listening skill, reading skill.

Abstract: The aim of the research is to improve the ways of training quality for the curriculum, methods, handbooks and technology. With the rapid development of Information Technology and International Relations worldwide the globalization and countries' external and internal relationships have been broadening as well. Considering the above circumstances happening around the world, people need to learn not only advanced scientific technology but also foreign languages specifically the English language since it is a communication line of the globalization process and technological achievement.

There are four practices of the foreign languages that make up perfect compromises: learning (speaking, listening, reading, and writing), and more are expected from these compromises based on good knowledge of foreign languages.

Оршил. Боловсролын даяаршил нь Монгол хүний нөөцийг хөгжүүлэх тэдэнд чанартай

боловсрол эзэмших, улам бүр даяаршиж буй хөдөлмөрийн зах зээл дээр өрсөлдөх чадвартай монгол мэргэжилтэн болох боломжийг өргөтгөж байгаагийн зэрэгцээ манай оронд хэл соёлын олон талт орчин үүсэж, олон хэл зэрэгцэн орших нөхцөлийг бүрдүүлж, улмаар англи хэл даяаршлын гол хэл болж, гадаад хэлний сургалтад англи хэлийг чухалчлах талаар БСШУЯ–ны шийдвэр гарч, амжилттай хэрэгжиж¹ байна.

Дэлхийн интернэт мэдээллийн 70 орчим хувь болон дэлхийн шилдэг 500 гаруй их, дээд сургууль англи хэлээр үйл ажиллагаагаа явуулж, гэрээ хэлэлцээрийн дийлэнх нь англи

хэл дээр хийгдэн улс хоорондын болон олон улсын түвшинд англи хэлний гүйцэтгэх үүрэг, хэрэглээ эрс өссөөр² байна. “Хэлний бодлогыг оновчтой болгох асуудалд” сэдэвт судалгаагаар судалгаанд оролцогчдын 74,4 хувь нь англи хэл мэддэг, 85 хувь нь цаашид англи хэл судлахын чухал³ болохыг тодорхойлжээ.

Их дээд сургуулийн суралцагчдад **англи хэлийг** заах нь цаг үеэ олсон, өнөөгийн оюутны хэрэгцээ шаардлагад нийцсэн, олон улсын хэмжээнд гадаад хэлний талаар баримталж буй бодлоготой дүйцсэн, шинэ үеийн глобалчлалын эрин үетэй хөл нийлэн алхах мэргэжилтнүүдийг бэлтгэх сургалтын зорилго болсон билээ.⁴

Монгол Улсын бакалаврын боловсролын стандартын үлгэрчилсэн загварт: “аль нэг гадаад хэлийг өдөр тутмын болон мэргэжлийн үйл ажиллагаандаа ашиглах **чадвартай байх**” гэж төгсөгчдийн нийтлэг шаардлагыг тодорхойлсон. 2008 онд Монгол Улсын засгийн газрын 12–р тогтоолоор батлагдсан Монгол Улсын Мянганы хөгжлийн зорилтод суурилсан үндэсний хөгжлийн цогц бодлогод “2015 онд багтаан бүх нийтийн англи хэлний сургалтын чанарыг дээшлүүлж, дээд боловсрол эзэмшигчдийг ажил мэргэжлээрээ шаардлагатай мэдээллийг англи хэлээр ашиглах чадвартай болгох...”, 2021 он гэхэд төрийн захиргааны төв байгууллагын ажилтнууд албан ажлаа англи хэл явуулах чадамжтай болох.⁵ Мөн дээд боловсролын чанарын баталгаажуулалт, сургалт, эрдэм шинжилгээний стандарт, агуулгын шинэчлэлийн бодлогын хүрээнд: “... дээд боловсрол эзэмшигчдийг

¹ Бэгз.Н Боловсролын хөгжлийн онол, арга зүйн асуудлууд. УБ. 2007.

² Зууны мэдээ. 2007.3.28. Даяаршил ба хэлний бодлого

³ Гэрэлмаа, Г. (2012). Хэрэглээний хэл шинжлэл. Сосудай, ХХК, УБ 47х

⁴ Мөнхбаяр. Н. Дээд боловсролын салбарын англи хэлний бодлогын хэрэгжилтийг судалсан нь. УБ.2016 он. 33х

⁵ Монгол Улсын мянганы хөгжлийн зорилтод суурилсан Үндэсний хөгжлийн цогц бодлого.



ажил мэргэжлээрээ шаардлагатай мэдээллийг англи хэлээр ашиглах чадвартай болгох”⁶ зэрэг стратегийн зорилтуудыг дэвшүүлсэн.

Англи хэлний боловсролыг эрчимжүүлэх багц төсөл (2009) англи хэлний минимум шаардлагыг дээд боловсролын хэмжээнд 7 түвшинд тодорхойлж, суралцагчид мэргэжлийн судалгааны чиглэлээр баримт мэдээллийг олж авах, боловсруулах, үзэл бодлоо чөлөөтэй, цэгцтэй илтгэн илэрхийлэх чадвар эзэмшинэ”⁷ гэж заасан.

Гадаад хэлний сургалтын талаар төрөөс баримтлах бодлого (2014–2024 он)–д “Гадаад хэлний сургалтыг эх хэлний суурь чадамжийг бүрэн эзэмшүүлэхтэй уялдуулан зохион байгуулах ба сургуульд заах үндсэн гадаад хэл нь англи хэл байна” гэж заасан байна.

Эдгээр бодлого, зорилтуудыг хэрэгжүүлэхийн тулд их, дээд сургуульд суралцагчдын англи хэлний хэрэглээний чадварыг дээшлүүлэх, **сургалтын арга зүйг боловсронгуй болгох болон багшийн заах арга зүй**, суралцагчдын сурах арга барил эзэмшилтэд онцлон анхаарах шаардлагатай юм.

Үндсэн хэсэг. “Хичээл сургалтын технологи гэдэг ухагдахуун нь... дидактик бүтцийн хүрээнд өөртөө сургалтын зорилго, агуулга нөхцөл, хэрэглэгдэхүүн, түүнийг зохион байгуулах хэлбэр, багш, сурагч сургалтын арга, үр дүн гэсэн олон бүрэлдэхүүн хэсгийг агуулах өргөн хүрээтэй ухагдахуун юм”⁸ гэж Д.Ванчигсүрэн тодорхойлсон бол “Сургалтын технологи нь сургах үйл явцыг хэрэгжүүлэх хамгийн оновчтой эрэмбэ дэс дараалал, түүний хувилбар”⁹ гэж эрдэмтэн Г.Эрдэнэ–очир томъёолсон байдаг. Цаг хугацаа, зохион байгуулалт болон зорилго, агуулга, арга зүйн хувьд бие даасан шинжтэй сургалтын процессыг нэг үе шатны хичээл гэнэ.

Гадаад хэлний сургалтын зорилго нь гадаад хэлээр ярих, сонсох, унших, бичих чадварт иж бүрэн зэрэг сургах явдал юм. Өнөөдөр дэлхийн олон оронд Каллан аргыг англи хэлний сургалтад өргөн хэрэглэж байна. Каллан арга: 1960 онд байгуулсан дэлхийн хамгийн том англи

хэлний хувийн сургууль болох Лондон хотын Каллан сургуульд хэрэглэж буй энэхүү арга нь бусад аргаас 4 дахин хурдан сургах, англи хэлний TOEFL, IELTS, CAMBRIDGE ESOL зэрэг бүх төрлийн шалгалтад суралцагчдыг бэлтгэхэд тохиромжтой, хэл сурах шууд аргуудын нэг ба сонсохоос ярихад илүү анхаарч, “ярьж сурахын тулд ярих хэрэгтэй”, “давтаж хэлэх, бас дахин давтаж хэлэх” хэмээх зарчмыг баримталдаг. Хичээлийн явцад багш их хурдан ярих бөгөөд багш суралцагчид хором бүрд харилцан ярилцах учир хичээлийн цагийг дэмий үрэх, өөр зүйл бодох зэрэг алдагдал огт гардаггүй. Минутадаг багш, суралцагчид нийлээд доод тал нь 210 үг хэлэх буюу 1 цагт 12600 үг эргэлтэд орж байх хэрэг юм. Ингэснээр суралцагчид танхимаас гадна орчинд радио, телевиз сонсох, гадаад хүнтэй ярилцах зэргээр минутадаг 180–аад үг хэрэглэдэг энгийн ярианы хурдыг гүйцэн ойлгодог болох боломжтой.

Кембриджийн Их Сургуулийн Профессор хэл судлаач, арга зүйч Робин Каллан анх цэргүүдэд зориулж сэтгэл судлаач, хэл шинжлэлийн мэргэжилтэн О.Хесперсен, П.Пэсси, Г.Свитт, В.Фиестери нарын боловсруулсан шууд аргад үндэслэн хөгжүүлсэн ба эх хэл, орчуулгыг тойрч, ойлголттой холбож, тухайн үгийг агуулгаар нь судлах, индукцэд суурилсан дүрмийн судалгаа явуулдаг, англи хэл заах, сурах эрчимжүүлсэн арга юм.

“Ухамсарлан харилцах –Каллан” арга зүйн онолын үндэс: Өнөө үед энэ арга нь 35 орны 425 сургууль болон Англи, Итали, Франц, АНУ, Хятад, Польш, Япон, Бразил гэх мэт дэлхийн өнцөг булан бүрд тархсан байна. Нобелийн шагналт Габриэль Гарсиа Маркес тэргүүтэй 1 сая гаруй хүн, мөн домогт зохиолч Паоло Коэльо хүртэл энэ аргаар гадаад хэлийг судалжээ. **Calan Method Organization** (КМО) байгууллага нь олон жилийн туршлага, эрчимтэй судалгаагаар хэл сурах хугацааг *дөрөв дахин багасгах* боломжийг олгодог.

Каллан арга нь англи хэл сурах уламжлалт аргаас өөр юм. Суралцагчдыг шууд хэлний орчинд аваачдаг. Асуултад хариулахдаа тэр

⁶ <http5/www.mecs.gov.mn/article-398-435.mw>

⁷ Англи хэлний боловсролын тулгамдсан асуудлууд, шийдвэрлэх арга зам. УБ., 2009.145–146–р тал

⁸ Ванчигсүрэн, Д. Сургалтын технологи УБ. 1992, 28х

⁹ Эрдэнэ–очир, Г. Ерөнхий дидактикийн үндэс УБ, 1995, 29х



орчуулгад цаг алдахгүй, харин бодолгүйгээр хариулдаг. Англи хэл сурч буй аливаа хүнд тулгардаг хэлний бэрхшээлийг байгалийн хэлний орчинд ууссанаар даван туулдаг байна. Каллан аргыг ашиглан англи хэл сурах нь бусад мэддэг гадаад хэл заах аргуудаас **дөрөв дахин хурдан** байдаг ба энэ аргын үр ашиг, санхүүгийн аль алинд нь мэдэгдэхүйц хэмнэлттэй бөгөөд бараг гэрийн даалгаваргүй юм. Суралцах дараалал **чих, ам, нүд, гар**. Хэлийг хэрхэн ярихыг сонсож, дараа нь сонссон зүйлээ дуурайж, дараа нь бичсэн үгсийг харж, эцэст нь өөрөө бичиж эхэлдэг. Хүүхэд төрөлх хэлээ сурч байхдаа сонссон зүйлээ давтаж хэлдэг, хэлснийг нь ойлгодоггүй, ойлголт дараа нь ирдэг гэсэн зарчмаар явагддаг. Каллан арга нь 12 түвшинд хуваагдсан нарийн зохион байгуулалттай хөтөлбөр бөгөөд сурагчийг ярих гарцаагүй байдалд оруулдаг заах хичээлүүд үр дүнтэй болж сурагчид үг цээжлэх, сурсан материалаа байнга давтаж, дүрэм, хэллэгийг байнга нэгтгэх шаардлагатай болдог.

Иймд бид суралцагчдын англи хэлний хэрэглээний чадварыг дээшлүүлэх зорилгоор “Ухамсарлан харилцах – Каллан” нэртэй аргазүйн загвар боловсруулан туршилт-сургалтыг зохион байгуулсан

“Ухамсарлан харилцах –Каллан” арга зүйн зорилго: Суралцагчдыг сонсоод ойлгох, уншаад ойлгох, бичих, ярих чадварт богино хугацаанд иж бүрэн зэрэг сургаж, түүнийгээ практик дээр шууд хэрэглэх чадварыг эзэмшүүлж, төрөлх хэл рүүгээ хөрвүүлэх бус, англиар сэтгэн бодох, үгийн нөөцийг хурдацтай нэмэгдүүлж, үг, өгүүлбэрийн бүтэц, дүрмийг ойлгуулж, суралцагчдын хэл сурах идэвх сонирхлыг дээшлүүлж, хэл сурах итгэл үнэмшил, урам зоригийг бий болгоно.

“Ухамсарлан харилцах –Каллан” арга зүйн сургалтад хэрэглэх ач холбогдол:

- Суралцагч хэл сурах арга барилыг богино хугацаанд хялбархан эзэмшинэ;
- Суралцагчдын сурах арга барил сайжирч, хэл сурах идэвх, сонирхол нэмэгдэнэ;
- Багш суралцагч бүрд хүрч ажиллах ба суралцагчийг бүтээлч үйл ажиллагаанд сургана;
- Маш богино хугацаанд суралцагчийн

үгийн нөөц нэмэгдэж, хэлний дүрмийг эзэмшиж практик дээр хэрэглэх чадварт суралцана;

- Хичээлийн явцад цаг минут, хором бүрийг үр дүнтэй ашиглах ба хэлний хэрэглээний чадварыг цогцоор эзэмшинэ;
- Суралцагчийн сэтгэн бодох, оюуны үйл идэвхжиж, анхаарал, ой тогтоолтын процесс эрчимжиж, зоригийн үйл, сэтгэл хөдлөлийг зохицуулах, айдсаа намжаах чадварт суралцана.
- Суралцагч багшийн дэмжлэг туслалцааг хүлээн авах, дүрмийн болон дуудлагын алдааг засаж залруулах чадварыг эзэмшинэ.

“Ухамсарлан харилцах –Каллан” арга зүй

нь сонсож ойлгох, уншиж ойлгох, бичих, ярих чадварыг хэрэглээ болгох ба энэхүү хэлэхүйн 4 үйл нь тасралтгүй эргэх холбоогоор явагдах бөгөөд тухайн хичээлийн зорилгоос хамаарч аль нэг чадварт голлон бусад чадварт цогцоор сургана. Англи хэлний сургалтад хэрэглэж буй “Каллан” арга зүй нь зөвхөн ярих чадварт сургах зорилготой бол “Ухамсарлуулан харилцах –Каллан арга зүй” нь хэлэхүйн 4 чадварыг хамтад нь эзэмшүүлэхийн тулд суралцагчдаар сонсох, унших, бичих, ярих үйл ажиллагааг гүйцэтгүүлэхдээ үг, өгүүлбэр, эхийн агуулга, утга санаа, хэлбэр, бүтэц зэргийг хэрхэн илэрхийлж, хэрэглэж буйг ойлгох, тогтоох өөрөөр хэлбэл, ухамсарлах боломжийг олгохын зэрэгцээ суралцагчдын идэвхтэй, бүтээлч, сэтгэн бодох чадварыг хөгжүүлэхэд оршино.

“Ухамсарлан харилцах –Каллан” арга зүйн онцлог:

- Хэлэхүйн хэрэглээг чухалчилж, хэлний орчинд түргэвчлэн сургах явдал юм.
- Сургалтыг маш өндөр хурдацтай голлон асуулт-хариултын хэлбэрээр зохион байгуулна.
- Маш богино хугацаанд олон тооны үг, өгүүлбэрийг маш хурдацтай сонсож, чанга унших, давтан унших, ярих, цээжээр бичих зэргээр үгийн агуулга,



өгүүлбэрийн бүтцийг ойлгож, хэлний дүрмийг эзэмшиж, үгийн нөөцөө эрчимтэй нэмэгдүүлж, түүнийгээ практикт шууд хэрэглэх чадварыг эзэмшинэ.

- Сонсох, харах үйлийг тулгуур болгож, унших, бичих ярих болон харилцан яриаг эрхэмлэнэ.
- Анхаарлаа төвлөрүүлэх, ой тогтоолтын процессыг эрчимжүүлэх, хэл сурах итгэл үнэмшлийг бий болгоно.
- Сургалтыг зохион байгуулахдаа нэг бүлэгт 15–20 суралцагчийг хамруулж болно.

1 дүгээр зураг

Ухамсарлан харилцах–Каллан арга зүйн загвар



А. Сонсох, ярих, унших, бичих

2 дугаар зураг

Сонсох, ярих, унших, бичих загвар



А. Сонсох, ярих, унших, бичих гэсэн дарааллыг баримтална. Жишээлбэл: оюутан эхлээд шинэ үгтэй танилцах бөгөөд тэр үгийг сонсоод, давтаж хэлээд дараа нь шинэ үгсийг оролцуулсан асуултад хариулна. Хэсэг хугацааны дараа оюутан энэ үг орсон өгүүлбэр, эхийг уншиж, эцэст нь танилцсан үгийг агуулсан цээж бичиг бичнэ.

1 дүгээр хүснэгт

“Ухамсарлан харилцах –Каллан” арга зүйн зарчим:

№	Үзүүлэлт	Онцлог
1	Хэрэглэгдэхүүн сонгох зарчим	Хэлний загварууд, тэдгээрийг хэл ярианд хэрэглэж сургах
2	Шинэ хэрэглэгдэхүүн эзэмших	Хэлний хэрэглээ чухал, бодит харилцааны явцад хэл сургах, мэдээлэлд дүн шинжилгээ хийж ухамсарлаж, тогтоох.
3	Зорилго	Хэлэхүйн дөрвөн үйлээр чөлөөтэй харилцах, хэлний бүтцийн болон харилцааны чадварыг хөгжүүлэх
4	Хөтөлбөр, хичээлийн хэрэглэгдэхүүн хийх зарчим	Хэлний зүйн бүтцийг тодорхойлж, үг жагсааж, өгүүлбэр зохиолгох, цээж бичиг, эхийн загвар.
5	Үйл ажиллагааны төрөл	Гол нь харилцаа, харилцаанд оролцох, мэдээлэл дамжуулах, тайлбарлах, хянах, засаж сайжруулах, хэлэхүйн үйлийг идэвхтэй гүйцэтгэх.
6	Суралцагчийн үүрэг	Дуурайх, дахин дахин давтах, дүн шинжилгээ хийх, мэдрэх, ухамсарлах, сонсох, унших, бичих, ярих
7	Багшийн үүрэг	Харилцааг зохион байгуулах, бүх үйл ажиллагаанд өөрөө идэвхтэй, тасралтгүй оролцох, хянах, туслан дэмжигч, засан залруулагч, идэвхжүүлэгч, биет загвар болох
8	Сургалтын хэрэглэгдэхүүний ашиг тус	Сургалтын эхийн тогтолцоо, сурах бичиг, үзүүлэх үйлдэл

2 дугаар хүснэгт.

“Ухамсарлан харилцах–Каллан” арга зүйн үйл ажиллагааны онцлог:

Алхам	Үйл ажиллагаа
1	Багшийн яриаг анхааралтай сонсох, дагаж хэлэх, дуурайж хэлэх, сонсоод ойлгох
2	Ухамсарлан ажиглах, дагаж унших, давтан унших, чанга унших, гүйлгэж унших, ойлгож унших
3	Багшийн асуултад хариулах замаар эхийн утгыг задлан шинжилж ярилцах,
4	Сонсоод ойлгосноо ярих, уншаад ойлгосноо ярих
5	Сонсоод ойлгосноо бичих, уншаад ойлгосноо бичих, бичсэнээ ярих
6	Суралцагч багшийн заавар, зөвлөгөөг анхааралтай сонсож ойлгож, алдаагаа засаж, залруулах ба өөрийгөө хянах
7	Өгөгдсөн даалгавар, дасгалыг хийж гүйцэтгэх, шаардлагатай тохиолдолд багшийн тусламж дэмжлэгийг авах, багш болон бусадтай хамтран ажиллах гэх мэт



“Ухамсарлан харилцах –Каллан” арга зүйг хэрэглэх суралцагчдын ярих чадварыг хөгжүүлэх загвар:



Туршилт судалгаа

1. Их, дээд сургуулийн оюутнуудын асуулгын судалгаа, үр дүн


Тус судалгаанд УБХИС, МУБИС, болон төрийн өмчийн бус УБИС хэлний бус ангийн буюу монгол хэлний багш, бага ангийн багш, сургуулийн өмнөх боловсролын багш, аялал жуулчлалын менежмент, инженер механик, төрийн удирдлага I-III курсийн 400 оюутныг хамруулсан. Судалгааны үр дүнгээс үзэхэд, суралцагчдын дийлэнх буюу 59.3% нь англи хэл сурах сонирхолтой байхад 40.7% нь сонирхолгүй, мэдэхгүй гэж хариулсан байна.

Англи хэл сурах зорилго чиглэлийн судалгаанаас харахад суралцагчдын дийлэнх буюу 59% нь мэргэжилдээ хэрэгтэй, дэлхий нийтийн хэл, 6.3% нь цаашид сурах гэж хариулжээ.

Оюутны англи хэл сурах хэрэгцээ шаардлагыг тодорхойлох судалгаанаас харахад суралцагчдын дийлэнх буюу 52% нь мэдээлэл авах, чөлөөтэй харилцах (ярих, сонсох унших, бичих) гэж хариулсан байна. Тиймээс суралцагчид цахим хэрэгсэл ашиглан дэлхий нийтийн мэдээ, мэдээллээс хоцрохгүй, англи хэлтэн хүмүүстэй харилцаагаа өргөжүүлж, тэдгээрийн зан заншил, соёлын талаар харилцан санал бодлоо солилцох, ирээдүйд ажил, мэргэжилдээ өсөн дэвших зорилгоор англи хэлийг сурч эзэмшиж байна.

4 дүгээр зураг.

Оюутнуудын ярих хэрэглээний чадвар эзэмшихэд тулгардаг бэрхшээлүүд



Англи хэлний ярих чадварыг хөгжүүлэхэд тулгарч буй гол бэрхшээл нь хичээл дээр ярих үйл ажиллагаа бага хийлгэдэг гэж суралцагчдын ихэнх буюу 78.0% нь, хамгийн бага нь 24.5% үгийн нөөц хомс гэж хариулжээ. Ярих чадварыг хөгжүүлэх нь чухал асуудал болоод байна.

3 дугаар хүснэгт.

Оюутны англи хэл сурах арга барил эзэмшиж буй байдал (сонсох, ярих)

№	Сурах арга барилууд	Гол төлөв	Зарим үед	Огт үгүй
А. Оюутны сонсох арга барилыг хэрэглэж буй байдал				
1	Сонсож буй зүйлээс түлхүүр үгийг олох, тэмдэглэх.	8%	23%	69%
2	Сонсож буй зүйлээс агуулга, гол санаа, үйл явдлыг ойлгохыг эрмэлзэх, тэмдэглэл хөтлөх.	11.2%	23.5%	65.3%
3	Сонсоод гол мэдээлэл болон хэрэгтэй зүйлийг тухай бүрд нь хянаж, тэмдэглэдэг.	7.7%	30.8%	61.5%



4	Сонсож буй зүйлээс шинэ үг, хүнд үгийг нягталж, тогтоохыг хичээдэг.	9.9%	35.2%	54.9%
5	Сонсож байгаа зүйлийг дүрсэлж болон эргэцүүлэн бодож, дүгнэлт хийдэг.	13%	28.6%	58.4%
6	Сонссон зүйлтэй холбоотой ном зохиол, бусад материал дээр ажилладаг.	2.5%	8.8%	88.7%
7	Сайн ойлгохын тулд ямар арга техник хэрэглэсэн болон яавал сайн ойлгож болох талаар эргэцүүлэн боддог.	14.8%	30.0%	55.2%
8	Бичлэг хийгээд дахин сонсох болон давтан сонсдог.	31.3%	32.3%	36.4%
9	Сонссон зүйлийн талаар бүрэн ойлголттой болохын тулд толь бичиг, сурах бичиг, компьютер зэргийг ашигладаг.	6.3%	24.5%	69.2%
В. Оюутны ярих арга барилыг хэрэглэж буй байдал				
1	Зөв дуудлага, аялга, хурдыг тохируулж ярихыг хичээдэг.	7%	25%	68%
2	Утга агуулгыг оновчтой илэрхийлж ярихыг эрмэлздэг.	13.5%	30.5%	56%
3	Загвар, схем, тулгуур дохио ашиглаж ярих дасгал хийдэг.	17%	34.2%	48.8%
4	Шинэ болон хүнд үг, өгүүлбэрийг идэвхтэй хэрэглэн ярих дасгал хийдэг.	25%	33.2%	41.8%
5	Сонссон, уншсанаа ойлгож, тогтоож ярих, дэлгэрүүлж ярих дасгал даалгавар хийдэг.	11%	31.6%	57.4%
6	Англи хэлтэй гадаад хүмүүстэй харилцах.	6.5%	31.5%	62.0%
7	Англи хэлний дүрмээр ярихыг хичээдэг.	1.0%	6.5%	92.5%
8	Ярьж байх үедээ санаандаа үг, өгүүлбэр, сэдвийн орчуулга хийдэг.	0.5%	31.0%	68.5%
9	Англиар ярихдаа төрөлх хэлнийхээ тогтолцоотой харьцуулан бодож ярьдаг.	4.5%	33.0%	62.5%

Оюутны сонсох арга барилыг эзэмшиж буй байдлыг судлахад, суралцагчдын ихэнх буюу 31.3% нь бичлэг хийгээд дахин сонсох болон давтан сонсох арга барилыг гол төлөв, 35,2% нь сонсож буй зүйлээс шинэ үг, хүнд үгийг нягталж, тогтоох арга барилыг зарим үед хэрэглэдэг бол 88,7% нь сонссон зүйлтэй холбоотой ном зохиол, бусад материал дээр ажиллах арга барилыг огт хэрэглэдэггүй байна. Үүнээс дүгнэхэд сонсох арга барил сайн эзэмшээгүй нь судалгаанаас харагдаж байна.

Ярих арга барилыг эзэмшиж буй байдлыг судлахад, суралцагчдын ихэнх буюу 13.5% нь Утга агуулгыг оновчтой илэрхийлж ярихыг эрмэлздэг гол төлөв гэ хариулсан бол 34,2% нь загвар, схем, тулгуур дохио ашиглаж ярих дасгал хийдэг бол 92,5% Англи хэлний дүрмээр ярих арга барилыг огт хэрэглэдэггүй байна. Үүнээс дүгнэхэд ихэнх суралцагч ярих арга барил сайн эзэмшээгүй нь байна.

ҮБХИС-ийн АБС-ийн Холбоо Электроникийн тэнхимийн Ф-308, 309 ангийн 50 оюутан хяналтын бүлэг, туршилтын Ф-310 ангийн 43 оюутан туршилтын бүлэгт хамрагдсан.

4 дүгээр хүснэгт.

Суралцагчдын хэрэглээний чадварын даалгаврын нэгдсэн үр дүн


Чадвар	Бүлэг	Тоо	Дундаж	Стандарт хазайлт	T төстийн утга	P(sig) утга
Бичих	хяналт	50	53.224	21.3411	-3.471	.001
	туршилт	43	66.107	12.5893		
Сонсох	хяналт	50	35.672	10.3338	-7.104	.000
	туршилт	43	51.084	10.5151		
Унших	хяналт	50	45.548	11.8144	-5.774	.000
	туршилт	43	61.102	13.8551		
Ярих	хяналт	50	38.644	8.5690	-10.630	.000
	туршилт	42	57.376	8.2919		

Энэ хэсэгт туршилтын ба хяналтын бүлэгт тус бүрд 50,43 оюутан хамрагдсан бөгөөд 4 чадварын хувьд харьцуулсан үр дүнг нэгтгэн харууллаа. Эндээс харахад чадвар бүрийн хувьд туршилтын бүлэг нь хяналтын бүлгээс




илүү байна. Үүнийг статистикийн хамааралгүй түүврүүдийн t тестийн аргаар шалгахад бүх тохиолдолд ач холбогдлын **sig P** утга 0.05–аас бага гарсан тул эдгээрийн хооронд статистикийн ач холбогдол бүхий ялгаа байна гэсэн үг юм. Өөрөөр хэлбэл туршилтын бүлгийн хувьд хяналтын бүлгээс 4 чадварын хувьд илүү сайн үр дүн үзүүлсэн байна.

5 дугаар зураг
Хяналтын ба туршилтын бүлгийн хувьд 4 чадвараар харьцуулсан үр дүн



Үүнээс дүгнэж үзэхэд хэлний хэрэглээний дөрвөн чадвар бичих чадвар 12.8%, сонсох чадвар 15.4%, унших чадвар 15.6%, ярих чадвар 18.7 хувиар өссөн байна.


6 дугаар зураг.
Туршилтын бүлгийн үр дүнг туршилтын өмнө ба хяналтын бүлгийн үр дүнтэй харьцуулсан үр дүн



Бүх судалгааны үр дүнг нэгтгэн харуулбал туршилтын өмнө оюутнуудын англи хэлний хэрэглээний чадварын түвшний ерөнхий дундаж 30,66 байсан бол сургалтын дараа хяналтын бүлгийн дундаж ерөнхий дундаж оюутнуудын 43,27 ба туршилтын бүлгийн оюутнуудын ерөнхий дундаж 58,917 болсон байна.

Туршилт сургалтыг амжилттай явуулсны эцэст бид дараах сэтгэл ханамжийн судалгааг авлаа.

7 дугаар зураг.
Туршилт сургалт таны хэрэгцээ шаардлагад нийцэж байна уу?



Дээрх графикаас үзэхэд сургалтын хэрэгцээ шаардлагад нийцтэй 71% гэж үзсэн нь бидний явуулсан **туршилт сургалт нь гадаад хэлний сургалтын хэрэгцээ шаардлагыг хангаж зорилгодоо хүрэх боломжтойг харуулж байна.** Мөн сурагчидтай ярилцлага хийхэд тэдний үгийн сан, хэл зүйн дүрэм, сонсох, ярих, бичих унших чадварт ахиц гарсан, өөртөө илүү итгэлтэй болсон, хичээл дээр хэрэглэж буй аргууд илүү их таалагдсан гэсэн хариултыг өгсөн.

Дүгнэлт. Судалгааны ажлаар дэвшүүлсэн зорилгоо биелүүлж, суралцагчдын англи хэлний хэрэглээний чадварыг хөгжүүлэх зорилгоор суралцагчдын ярих хэрэглээний чадварыг эрчимтэй хөгжүүлэхэд нөлөөлж буй “Каллан” болон бусад бүтээлч сэтгэлгээний арга зүйд тулгуурлан суралцагчдын англи хэлний хэрэглээний чадварыг эрчимжүүлэх зорилгоор “Ухамсарлуулан харилцах–Каллан” арга зүйг боловсруулан туршилт–судалгааг зохион явуулахад суралцагчдын сонсоод ойлгох, уншаад ойлгох, бичих болон ярих чадвар эрчимтэй сайжирсан байна. Энэхүү байдлаас үзэхэд, суралцагчдын англи хэлний хэрэглээний чадварыг хөгжүүлэхэд юуны өмнө англи хэлний сургалтыг зохион байгуулахдаа суралцагчдад хэлний чадварыг цогц байдлаар эзэмшүүлэх, суралцагчдын бүтээлч үйл ажиллагааг дэмжих, суралцагчдад хэл сурах арга барилыг эзэмшүүлэхэд анхааран ажиллах нь зүйтэй байна.

Мөн суралцагч нэг бүрд хүрэлцэж ажиллах арга зүйг чухалчлах, суралцагчдын идэвхтэй харилцах орчин, хэрэглэгдэхүүнийг бүрдүүлэх, сургалтын аргыг оновчтой сонгон хэрэглэх шаардлагатайг тус судалгааны үр дүн харуулж, англи хэлний сургалтад заах шинэ аргыг оновчтой хэрэглэсний үр дүнд оюутны гадаад хэл сурах идэвх, сонирхол нэмэгдэж, тэдний хэлзүйн мэдлэгээ хөгжүүлж практикт хэрэглэх чадвар өсөн нэмэгдэж, сурлагын чанарт эерэг өөрчлөлт гарах бололцоо бүрдэнэ гэсэн таамаглал батлагдлаа.

Дээрх хэрэгцээ шаардлагаас үүдэн гадаад хэлний багш мэргэжлийн хичээл



бүрээр тодорхой чадварыг хөгжүүлэх арга барил эзэмшүүлэх арга зүй, үйл ажиллагааны аргачлал боловсруулж, жишээлэн үзүүлэх, загварчлан тайлбарлах, мөн суралцагчдын бие даан ажиллах чадварыг хөгжүүлэхэд мэргэжлийн туслалцаа үзүүлэхэд хэрэг болно гэж үзэж байна.

Гадаад хэлний сургалтын эцсийн үр дүн бол суралцагчдад тухайн суралцаж буй гадаад хэлний хэлзүйн болон хэрэглээний чадварыг хөгжүүлэх гадаад хэлээр чөлөөтэй ярих, бичих, унших, сонсох хэлний цогц чадвартай болгох хэрэгтэй.

Санал

1. Гадаад хэл зааж буй багш нар мэргэжил дээшлүүлэх, сургалтын арга зүйн хувилбар боловсруулж турших,

туршлага солилцох

2. Суралцагчдын эрэлт хэрэгцээнд нийцсэн мэргэжлийн сурах бичиг хангалтгүй байна. Гадаад хэлний нэгдсэн стандарт, хөтөлбөрийг боловсронгуй болгох
3. Англи хэлний сургалтын технологийг цогцоор нь сайжруулах хэрэгтэй. Мэргэжлийн (цэргийн) англи хэлний хэл шинжлэлийн програмчлал, аудио, видео, мульти гэх зэрэг мэдээллийн дэвшилтэт технологийг ашиглаж цогц хичээлүүдийг бэлдэж сургалтад ашиглавал англи хэлний сургалтын чанарыг сайжруулахад нөлөө үзүүлнэ гэж бодож байна.

Ашигласан материал:

1. Батмөнх, Ц., Эрдэнэмаам, С., (2014). Гадаад хэл заах онол, арга зүй. УБ.
2. Батхуяг, С. (2015). Дээд боловсролын сургалтын арга барилын шинэчлэл. УБ
3. Бэгз,Н.,(2007). Боловсролын хөгжлийн онол, арга зүйн асуудлууд. УБ. 2007
4. Ванчигсүрэн.Д., (1992) Сургалтын технологи УБ.
5. Гэрэлмаа, Г. (2012). Хэрэглээний хэл шинжлэл. Сосудай, ХХК, УБ
6. Нямжав Д. (2011). Гадаад хэлний сургалтын онол заах арга зүй. УБ,
7. Ичинхорлоо, Ш. (2013). Сургалтын онол, хэрэглээ. УБ.
8. Наранчимэг.Г., (2018) Цэргийн ажиллагааны нэр томъёоны Англи-Монгол толь УБ,
9. Равдан, Э. (2013). Хэрэглээний хэл шинжлэл, хэл сурахуйн онол. УБ
10. Мөнхбаяр, Н.(2016). Дээд боловсролын салбарын англи хэлний бодлогын хэрэгжилтийг судалсан нь. Хэл шинжлэлийн ухааны докторын зэрэг горилсон нэг сэдэвт бүтээл. УБ
11. Эрдэнэ-Очир.Г (1995) Ерөнхий дидактикийн үндэс УБ,
12. Azar, В.С. Understanding and Using English Grammar”, USA
13. Marianne,С.М (1996) “Teaching English as a Second or Foreign Language” ,
14. Harmer, J.(1998). English language teaching.Oxford., Oxford University Press
15. Callan,R. (2003) Callan Method Organisation Commercial Users Guide
16. Callan, R. (1995) Callan Method: Teacher's Handbook. 3rd edition
17. www.callan.co.uk/preface/tr
18. www.callanonline.com
19. <http://www.englishlistening.com>
20. <http://www.english-test.net/toeic/>.
21. <http://www.ets.org/toefl>

ДЭЭД БОЛОВСРОЛЫН СУРГАЛТЫН БАЙГУУЛЛАГЫН МЭДЭЭЛЛИЙН СИСТЕМИЙН ӨНӨӨГИЙН БАЙДАЛД ХИЙСЭН СУДАЛГАА

Б.БАЯНХИШИГ /УБХИС-ийн АБДС-ийн ЭЗМТ-ийн багш/
З.ХАНДМАА /УБХИС-ийн АБДС-ийн ЭЗМТ-ийн багш/

Түлхүүр үг: Удирдлагын мэдээллийн систем, Дээд боловсролын байгууллага, Цахим шилжилт
Key words: Management information system, Institution of higher education, Electronic transition

“Алсын хараа–2050” Монгол Улсын хөгжлийн урт хугацааны бодлого, Монгол Улсын Боловсролын салбарын хөгжлийн дунд хугацааны 2021–2030 төлөвлөгөө, Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрт “Хүн бүрд чанартай боловсрол эзэмших тэгш боломж бүрдүүлж, тэгш хамруулах тогтолцоог бэхжүүлэх” зорилт дэвшүүлсэн. Цаашид нийгэм болон дижитал технологийн эринд ажиллаж амьдрах, нийгмийн идэвхтэй оролцоотой, тасралтгүй хөгжих чадамжтай, хүмүүнлэг, ёс зүйтэй иргэнийг хөгжүүлэх нь боловсролын ирээдүйн хөгжлийн төлөвлөлт болоод байна.

Мэдээллийн систем бол биднийг хүрээлэн буй системүүдийн нэг төрөл бөгөөд түүний бусад системүүдээс ялгарах гол онцлог бол зөвхөн өгөгдөл мэдээлэлтэй ажилладаг. Мэдээллийн систем бол байгууллага, бизнесийн үйл ажиллагааны хэвийн болоод найдвартай, үр бүтээмжтэй байдлыг хангах замаар автоматжуулах, их хэмжээний өгөгдлийг хадгалах, боловсруулах, удирдлагыг шийдвэр гаргахад цаг тухайд шаардлагатай мэдээллээр хангах, мэдээлэл боловсруулалтыг боловсронгуй болгох нэгэн төрлийн хэрэгсэл юм.

Дээд боловсролын сургалтын байгууллага нь коллеж, дээд сургууль, их сургууль байна¹. Их, дээд сургууль нь маш олон оюутан, багш, хичээл, судалгаа, төлбөр тооцоо, харилцаа, сургалтын материал, анги танхим, лаборатори, тоног төхөөрөмж, салбар нэгжээс тогтсон цогц систем юм. Энэхүү системийг шуурхай, хүртээмжтэй, оновчтой, нээлттэй байдлаар удирдан зохин байгуулж ажиллахад

удирдлагын мэдээллийн системийг ашиглах шаардлага зүй ёсоор гарч байна. Удирдлагын мэдээллийн систем нь их сургуулийн бүх үйл ажиллагааг нэгтгэн харах цонх, удирдан залах жолоодлого, хянан зохицуулах шүүгчийн үүргийг гүйцэтгэнэ. Олон улсын боловсролын стандарт, дээд боловсролын талаарх улс нийтийн бодлого, их сургуулийн дотоод дүрэм журам, сургалтыг зохион байгуулах арга хэлбэр, технологи, хичээлийн болон хичээлээс гадуурх харилцааг бүх нийтээр даган мөрдүүлэхэд удирдлагын мэдээллийн систем онцгой байр суурийг эзэлнэ. Манай Улсын дээд боловсролын салбарт Шинжлэх ухаан, технологийн их сургууль 1997 оноос эхлэн UNIMIS мэдээллийн нэгдсэн системийг өргөжүүлэн хөгжүүлж өөрийн их сургууль төдийгүй бусад их, дээд сургуульд ашиглагдах нэгдсэн систем болгон хөгжүүлж байна. Энэ нь салбарын хэмжээнд удирдлагын мэдээллийн системийг хөгжүүлэх эхлэл тавигдсан гэж үздэг. Одоогийн байдлаар удирдлагын мэдээллийн системийг үйл ажиллагаандаа ашигладаггүй их дээд сургууль байхгүй байгаа бөгөөд тэрхүү системийг өөрийн дотоод нөөцөөр хөгжүүлж эсвэл гадны байгууллагаар хөгжүүлэлт хийлгэж ажиллуулж байна. Дээд боловсрол нь олон шинжлэх ухааны нэгдэл дундаас шинэ мэдлэгийг бүтээх, оюун ухааны илүү өндөр чадварыг оюутанд эзэмшүүлэх, олон талтай, нарийн цогц дээд түвшний боловсрол учраас, уг сургалтыг чанартай хүргэх сургалтын хөтөлбөрийг онцгойлон авч үзэж, нухацтай ойлгох нь их, дээд сургуулийн

¹ Дээд боловсролын тухай хууль



багш нарт тун чухал бөгөөд энэхүү ойлголтоос бидний сургалтаа хэрхэн боловсруулж, хүргэх шалтгаалж, тэр нь төгсөгчийн чанарт шууд нөлөөлж байдаг.

Монгол Улсад 2018 онд БШУЯ-ны захиалгаар Азийн хөгжлийн банкны санхүүжилтээр Дээд боловсролын шинэчлэл төслийн хүрээнд Боловсрол, шинжлэх ухааны яам, түүний харьяа байгууллага, дээд боловсролын сургалтын байгууллага хоорондын үйл ажиллагаа, мэдээллийн урсгалыг хянах, мэдээллийн нэгдсэн санг бий болгох, хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх, мэдээлэлд тулгуурласан бодлого төлөвлөлт, шийдвэр гаргалтад дэмжлэг үзүүлэх удирдлагын hemis.edu.mn системийг боловсруулж эхэлсэн. Энэхүү мэдээллийн систем нь төрийн байгууллагын мэдээлэл цуглуулах зорилготой нэгдсэн систем юм. Дээд боловсролын байгууллагын бүртгэл мэдээлэл хариуцсан албан тушаалтан нь тухайн тайлангийн хугацаанд багш, оюутны мэдээллийг программд оруулах үүрэг хүлээдэг ба харин энэ программд бусад албан тушаалтан нэвтрэх хэрэгцээ шаардлага байхгүй юм. Тиймээс их дээд сургуулиуд тус бүрдээ сургалтын үйл ажиллагааны хэвийн болоод найдвартай, үр бүтээмжтэй байдлыг хангах замаар автоматжуулах, их хэмжээний өгөгдлийг хадгалах, боловсруулах, удирдлагыг шийдвэр гаргахад цаг тухайд шаардлагатай мэдээллээр хангах, мэдээлэл боловсруулалтыг боловсронгуй болгох зорилготойгоор мэдээллийн системийг дотооддоо хөгжүүлж хэрэглэж байна.

Сургуулийн удирдлагын мэдээллийн системийн тусламжтайгаар:

Оюутны хувьд: Цахим картыг ашиглан шалгалтын дүн болон суралцах хугацаандаа судалсан бүх хичээлийн дүн, кредит болон ерөнхий голч дүн, өөрийн хувийн мэдээлэл, төлбөрийн мэдээлэл зэргийг хянах, харах боломжтой.

Хичээл зааж байгаа багш нарын хувьд: Өөрийн хичээлийн явцын үнэлгээг системд

оруулах, сурлагын амжилт, чанарын үзүүлэлтийг авах боломжтой.

Зөвлөх багшийн хувьд: Ангийн оюутнуудын анкет, бусад материал, оюутны судалсан хичээлүүдийн дүн, багц цаг, ерөнхий голч дүн зэрэг мэдээллийг харах боломжтой.

Сургуулийн захиргаа, сургалтын алба, бүртгэл мэдээллийн алба, оюутны хөгжлийн албадын хувьд: Оюутны мэдээллийг харах, түүнийг ашиглан судалгаа хийх; оюутны дүнгийн болон суралцаж байгаа тухай тодорхойлолтыг гаргах; тухайн улиралд орох хичээлүүдийн хуваарь, заалгаж байгаа багшийг нь мэдэх; төгссөн оюутны диплом болон дипломын хавсралтыг бэлтгэх ба хэвлэх; ерөнхий дүгнэлт хийх, шийдвэр гаргах; хичээл заасан багшийн тухай болон хичээлийн тухай судалгаа оюутнуудаас авах боломжтой.

Санхүүгийн системийн хувьд: Тус программаар дамжуулан сургалтын төлбөр төлөлтийг хянах, санхүүгийн орлого зарлагын ангилал, үр дүнгийн мэдээллийг удирдлага авах боломжтой байдаг.

Номын сангийн системийн хувьд: Номын сангийн цогц программыг ашигласнаар оюутан, багш, ажилтан, ажилчид хэрэгцээт номын каталоогоос хайлт хийх, уншлагад байгаа эсэхийг үзэх, шинээр нэмэгдсэн ном сэтгүүлийн мэдээллийг авахын зэрэгцээ онлайн номын сангаар үйлчлүүлэх боломжтой

Судалгааны үр дүн Монгол Улсын хэмжээнд 2023–2024 оны хичээлийн жилд 64 их дээд сургууль үйл ажиллагаа явуулж байгаагийн 33 буюу 51,6% нь их сургууль, 30 буюу 46,8% нь дээд сургууль, 1 коллеж байна. Нийт их дээд сургууль коллежийн 16 нь төрийн өмчийн, 45% нь хувийн өмчийн, 3 нь олон нийтийн/ шашны өмчийн сургалтын байгууллага байна. Дээрх 64 сургалтын байгууллага нь 100% дотоод мэдээллийн систем ашигладаг бөгөөд 30 гаруй сургууль xcloud үүлэн системийг ашиглаж байна.

Их, дээд сургуулиуд мэдээллийн зуунд чадварлаг боловсон хүчин бэлтгэж, асар хурдацтай өсөн нэмэгдэж байгаа мэдээллийн



урсгалыг зөв удирдах, өдөр тутам хувьсан өөрчлөгдөж байгаа нийгмийн орчинд хурдан дасан зохицоход чадварлаг мэдээллийн системтэй байх нь хамгийн чухал юм.

МУИС– нь сургалт, удирдлага, зохион байгуулалттай холбоотой үйл ажиллагааг хөнгөвчлөх, чанаржуулах, шуурхай, найдвартай, ил тод, хяналттай болгох зорилготой вэб–д суурилсан сургалтын мэдээллийн систем SISI–г сургалтандаа хэрэглэдэг. Энэхүү системийг МУИС–ийн салбар сургуулиудын багш ажилтан, оюутан болон удирдлагууд хэрэглэх ба систем нь МУИС–ийн хүрээнд хэрэглэгддэг дэд системүүд болон бусад гаднын системүүдтэй хамтарч ажиллана. SISI систем нь монгол ба англи хэл дээр ашиглах боломжтой бөгөөд диплом, дипломын хавсралтыг англи, кирилл, монгол бичгээр хэвлэхтэй холбоотойгоор монгол бичгийг дэмждэг.

Элсэлтээс төгсөлт хүртэлх сургалтын бүхий л үйл ажиллагаа уг системээр дамжиж явагдана.



1 дүгээр зураг.

МУИС–ийн удирдлагын мэдээллийн систем



2 дугаар зураг.

ҮБХИС–ийн Багшийн вэб хуудас



ШУТИС–ийн удирдлагын мэдээллийн “UNIMIS” системийг монголд их сургуулиудаас анх удаа Төрийн мэдээлэл солилцооны “Хур” системд амжилттай холбосон юм. ШУТИС “ХУР” системээр дамжуулан төрийн байгууллагуудтай нийт 19 төрлийн мэдээллийг солилцох боломжтой болсон бна. ДХИС, ХААИС, ИЗОУИС зэрэг сургуулиуд XCloud үүлэн системийг саяхан болтол ашиглаж байгаад энэ хичээлийн жилээс ХААИС–ISLS ДХИС–Emind, ИЗОУИС–SUS, ХУИС–onemis гэх мэт ухаалаг системийг тус бүр хэрэглэж эхлээд байна. Эдгээр программууд нь XCloud үүлэн системийг бодоход МУБИС нь 2014 оноос хойш өөрсдийн зохиосон ulms гэсэн сургалтын удирдлага, мэдээллийн системийг ашиглаж байна.

Манай сургуулийн хувьд хуульд нийцүүлэн ҮБХИС–ийн захирлын 2021 оны 05 дугаар сарын 28–ны өдрийн А/77 дугаар тушаалаар “Сургалтын баримт бичиг боловсруулалтад тавигдах шаардлага, загварыг батлан гаргасан. Батлагдсан сургалтын хөтөлбөрийг Хөтөлбөрийн дэд хороо богино /2жил/, дунд /4жил/, урт /8жил/ хугацаанд өөрийн үнэлгээ хийхээр заасан байдаг. Сургалтын хөтөлбөртэй холбоотой бодлого, шийдвэрийг боловсронгуй болгох, сайжруулах чиглэлээр санал, зөвлөмж гарган Сургалтын хэлтсээр дамжуулан хүргүүлнэ. Их сургуулийн захирлаар батлагдсан хөтөлбөрийг 4 хувь хэвлэж, Сургалтын хэлтэс, харьяаллын сургуулийн Эрдэм шинжилгээ, сургалтын алба, харьяалах тэнхим болон их сургуулийн архивт хүлээлгэн өгнө. Сургалтын хэлтэс харьяаллын сургуулийн эрдэм шинжилгээ, сургалтын алба болон хэрэгжүүлэгч тэнхим “Цахим сан” үүсгэж



хадгална гэж заасан байна. Гэтэл багш нар нэг хичээлийн жилд зөвхөн хөтөлбөр, төлөвлөгөө, нэгж хичээл, цаг сэдвийн төлөвлөгөө, хичээл удирдах төлөвлөгөө зэргийг хэвлэхэд /1 дүгээр хүснэгт/ дунджаар 1752 ширхэг цаас буюу 3–4 боодол бичгийн цаас хэрэглэж байна.

1 дүгээр хүснэгт.

Нэг хичээлийн жилд зарцуулагддаг бичгийн цаасны тоо

Д/д	Хөтөлбөр, төлөвлөгөө	Нэг хичээлд шаардагдах бичгийн цаасны тоо	Нэг хичээлд нийт шаардагдах бичгийн цаасны тоо	Хичээлийн жилд шаардагдах бичгийн цаасны тоо /Зхичээл/
1	Нэгж хичээлийн дэлгэрэнгүй хөтөлбөр	28–32	32	96
2	Нэгж хичээлийн хураангуй хөтөлбөр	6–8	8	24
3	Нэгж хичээлийн нэн хураангуй хөтөлбөр	4–6	6	18
4	Цаг сэдвийн төлөвлөгөө	4–5	10 /2бүлэгт/	30
5	Хичээл удирдах төлөвлөгөө	2	48	144
6	Нэг сэдэв хичээлийн материал /лекц, семинар, дадлага/	20–30	480	1440
Нийт		83	584	1752

Нэг хичээлийн жилд дунджаар 1752ш бичгийн цаас буюу 3 боодол хагас 70000 төгрөг цаас, Принтерийн хор 40000 төгрөг. Нийт 110000 төгрөг

Дүгнэлт. Боловсролын цахим шилжилт нь цаг хугацаа, орон зайнаас үл хамаарсан, тэгш, хүртээмжтэй боловсролын тогтолцоог бий болгох шийдэл гэж судлаачид үзэж байна. Ялангуяа хүртээмж, чанарыг сайжруулахын тулд технологид суурилсан шийдлээс гадна дижитал суралцахуйн ач холбогдол, үр ашгийг дээшлүүлэх, түүнчлэн суралцагч болон тогтолцооны түвшин дэх саад бэрхшээлийг

даван туулах чадварыг бэхжүүлэхтэй холбоотой юм. Цахим сургалтын аюулгүй, үр дүнтэй хэрэглээ, технологийн тэгш хүртээмжтэй, тогтвортой байдал нь ирээдүйн боловсролын гол стратеги юм.

Одоогоор Монгол Улсын Их Сургууль Sisi, Шинжлэх Ухаан Технологийн Их UNIMIS, Мөн Солонгос улсын удирдлагын мэдээллийн систем ашигладаг Улаанбаатар ОУИС зэрэг сургуулиудын удирдлагын мэдээллийн систем нь хамгийн олон модультай ба найдвартай ажиллагаатай систем болох нь харагдаж байна. Мөн их дээд сургуулиуд үүлэн системээс татгалзаж бусад ухаалаг мэдээллийн системүүдийг ашигладаг болсон байна. Үүлэн системийн XCloud сургалтын мэдээллийн систем нь хамгийн өртөг багатай ч сургалтын байгууллагын мэдээллийн системийн хэрэгцээг боломжийн түвшинд хангаж байна гэж үзэж байна. Гэвч ҮБХИС –ийн хувьд XCloud системийг бүрэн гүйцэт ашиглаж чадахгүй байна. Жишээлбэл өдөр бүр цаасаар ирцийн мэдээ авах шаардлагагүй үүнийг программд шивсэнээр ирцийн мэдээг 7 хоног сараар нэгтгэж гаргах боломжтой юм. Мөн санхүүгийн албанаас сургалтын төлбөр төлсөн тухай мэдээллийг цаг тухай бүрт программд оруулж өгөх хэрэгтэй байна. Нийт их дээд сургууль SUS ухаалаг системийг хэрэглэж эхлээд байгаа бөгөөд энэ систем нь кредит системийг бүрэн дэмждэг, монгол улсын стандартуудыг мөрдлөг болгосон, олон улсын системүүдийн дэвшилтэт боломжуудыг агуулсан систем юм. SUS нь удирдлагын, элсэлтийн, хүний нөөцийн, сургалтын албаны, тестийн, эрдэм шинжилгээний, санхүүгийн, мониторингийн зэрэг дэд модулиудаас бүрддэг.

Санал

- Удирдлагын мэдээллийн системийг боловсронгуй болгох асуудлыг шийдвэрлэхэд байгууллагын дээд удирдлагын дэмжлэг онцгой нөлөөтэй болохыг анхаарах нь чухал юм.
- Удирдлагын мэдээллийн системийн гол цөм нь компьютер биш харин хүн юм.



Хүн энэ системийг судалж, шинжилж, боловсронгуй болгож хөгжүүлдэг. Ийм учраас сайн техник, программ хангамж, мэдээллийн сантай байгаад чадварлаг боловсон хүчингүйгээр энэ системийг өгөөжтэй ашиглах боломжгүй юм.

- Нэгэнт өөр мэдээллийн систем ашиглах боломжгүй байгаа нөхцөлд Xcloud үүлэн системийг бүрэн дүүрэн ашиглаж,

зарим хөгжүүлэлтийг хийж, Үндэсний Батлан Хамгаалах Их Сургуулийн дотоод дүрэм журмыг тус системд тусгаж өгөх хэрэгцээ шаардлага байгааг онцолж байна. Ингэснээр багш нар болон сургалтын албаны мэргэжилтнүүдийн хийдэг механик ажил хөнгөрнө гэж үзэж байна.

Ашигласан материал:

1. Дээд боловсролын тухай хууль
2. ҮБХИС-ийн захирлын 2021 оны 05 дугаар сарын 28-ны өдрийн А/77 дугаар тушаалаар батлагдсан “Сургалтын баримт бичиг боловсруулалтад тавигдах шаардлага, загвар
3. Үндэсний батлан хамгаалахын их сургуулийн Xcloud
4. Монгол Улсын Их Сургууль Sisi
5. Шинжлэх Ухаан Технологийн Их сургуулийн UNIMIS
6. Хөдөө аж ахуйн их сургууль - ISLS
7. Дотоод хэргийн их сургууль - Emind
8. Их засаг олон улсын их сургууль –SUS
9. Хүмүүнлэгийн ухааны их сургууль -Ynemis



ОЮУТАН ТӨВТЭЙ СУРАЛЦАХУЙ БАГШЛАХУЙН ҮЙЛ ЯВЦЫГ ҮНЭЛЭХ НЬ

П.МӨНХТӨР /УБИХС-ийн АБДС-ийн ОУХНУТ-ийн дэд профессор багш/
М.ИНДРАБҮД /УБИХС-ийн АБДС-ийн ОУХНУТ-ийн дэд профессор багш/

Түлхүүр үг: Дээд боловсролын байгууллага, Оюутан төвтэй суралцахуй, багшлахуйн үйл явц, чанарын баталгаажуулалт, Сургалтын хөтөлбөр, Хүлээн зөвшөөрөгдөх байдал

Key words: Manag

Хураангуй. Чанарын баталгаажуулалтын бодлого нь багшлахуй–суралцахуйн үйл явц болон судалгаа хоорондын харилцан хамаарлыг чухалчилж, тухайн дээд боловсролын байгууллага үйл ажиллагаа явуулж, сургуулийн агуулга, стратеги хандлага нь захирагдаж буй үндэсний агуулга, концепцыг харгалзан үзсэн тохиолдолд үр дүнтэй хэрэгжинэ. Оюутан төвтэй суралцахуй, багшлахуйн үйл явц нь оюутны мотиваци /хүсэл сонирхол/, илэрхийлэх чадвар, сургалтын үйл явц дахь оролцоог идэвхжүүлэхэд чухал үүрэгтэй. Энэ нь сургалтын хөтөлбөрийг боловсруулах хүлээн зөвшөөрөх мөн сургалтын үйл явц дахь оролцоог идэвхжүүлэхэд чухал үүрэгтэй. Энэ нь сургалтын хөтөлбөрийг боловсруулах, хүлээн зөвшөөрөх мөн сургалтын амжилтыг үнэлэхдээ үүнийг чухалчилж үзэх шаардлагатай гэсэн үг юм.

Оршил. Дээд боловсролын байгууллага нь стратеги удирдлагынхаа нэг хэсэг болон олон нийтэд мэдээлсэн чанарын баталгаажуулалтын бодлоготой байна. Хөндлөнгийн оролцогч талуудын оролцоог хангахаас гадна, дотоод оролцогч талууд зохих бүтэц, процессоор дамжуулан энэхүү бодлогыг боловсруулах, хэрэгжүүлэхэд оролцдог байна. Бодлого болон үйл явц нь тасралтгүй сайжруулалтын мөчлөгийг бий болгож, байгууллагын хариуцлагыг бэхжүүлэхэд хувь нэмрээ оруулдаг харилцан уялдаатай үндэсний чанарын баталгаажуулалтын тогтолцооны гол тулгуурууд юм. Энэ чанарын төлөөх хариуцлагыг дотоод оролцогч тал бүр дээр ухамсарлаж, сургуулийн бүхий л түвшинд чанарын баталгаажуулалтын үйл ажиллагаанд гар бие оролцдог чанарын соёлыг хөгжүүлэхэд дэмжлэг үзүүлдэг.

Эдгээрийг тодорхой болгохын тулд бодлого нь албан ёсны статустай, олон нийтэд ил тод болсон.

Чанарын баталгаажуулалтын бодлого нь багшлахуй–суралцахуйн үйл явц болон судалгаа хоорондын харилцан хамаарлыг чухалчилж, тухайн дээд боловсролын байгууллага үйл ажиллагаа явуулж, сургуулийн агуулга, стратеги хандлага нь захирагдаж буй үндэсний агуулга, концепцыг харгалзан үзсэн тохиолдолд үр дүнтэй хэрэгжинэ. Эдгээр бодлого нь дараах хүчин зүйлсэд дэмжлэг болдог.

- Чанарын баталгаажуулалтын тогтолцоо–ны зохин байгуулалт
- Чанарын баталгаажуулалтын үүрэг хариуцлага хүлээж буй алба сургууль, факультет болон бусад бүтцийн нэгжүүдээс гадна сургуулийн удирдлага, багш ажилчид, оюутнууд
- Академик эрх чөлөө, нэгдмэл байдал /боловсролын луйвраас ангид эсрэг/
- Багш ажилчид, оюутнуудыг ямар нэгэн байдлаар ялгаварлан гадуурхахыг үл хүлцэн тэвчих зарчмыг хамгаалахад
- Чанарын баталгаажуулалт дахь хөндлөнгийн оролцогч талуудын оролцоо

Сургуулийн түвшин дэх бүх оролцоог хангасан чанарын дотоод баталгаажуулалтын процессын олон янзын байдлаар дамжуулж энэхүү бодлогыг практикт нэвтрүүлэх боломжтой. Иймд чанарын баталгаажуулалтын бодлого нь бусад гэрээлэгч болон хамтрагч талуудын гүйцэтгэж буй бүх үйл ажиллагааг оролцуулаад сургуулийн бүхий л үйл ажиллагааг хамарсан байна.

Үндсэн хэсэг. Оюутан төвтэй суралцахуй,



багшлахуйн үйл явц нь оюутны мотиваци / хүсэл сонирхол/, илэрхийлэх чадвар, сургалтын үйл явц дахь оролцоог идэвхжүүлэхэд чухал үүрэгтэй. Энэ нь сургалтын хөтөлбөрийг боловсруулах хүлээн зөвшөөрөх мөн сургалтын үйл явц дахь оролцоог идэвхжүүлдэг. Сургалтын хөтөлбөрийг боловсруулах, хүлээн зөвшөөрөх мөн сургалтын амжилтыг үнэлэхдээ үүнийг чухалчилж үзэх шаардлагатай гэсэн үг.

Оюутан төвтэй суралцахуй, багшлахуйн үйл явцыг хэмжихдээ:

- Уян хатан сургалтын арга хэлбэрийг нэвтрүүлэн, олон янзын оюутан, тэдгээрийн хэрэгцээ шаардлагыг хүндэтгэх, оролцоог хангана.
- Тохиромжтой олон төрлийн сургалтын арга хэлбэрийг авч үзэж хэрэгжүүлнэ.
- Заах аргын олон төрлийн арга зүйн хэлбэрийг уян хатан ашиглана.
- Тогтмол үнэлгээ хийж, сургалтын болон заах арга зүйн хэлбэрийг уялдуулна.
- Хангалттай зөвлөмж болон багшийн дэмжлэгийг бэхжүүлэхдээ суралцагчийн бие даасан байдлыг дэмжинэ.
- Суралцагч болон багш хоорондын харилцан итгэлцлийг дэмжинэ.
- Оюутны санал хүсэлт гомдлыг авч үздэг холбогдох үйл явцтай байна.

Оюутны хөгжил, тэдний ирээдүйн ажил мэргэжлийн үнэлгээний ач холбогдолд чанарын баталгаажуулалтын үйл явц нь дараах зүйлсийг анхаарч үзнэ. Үүнд:

- Шинжээчид одоо хэрэгжиж буй үнэлгээ, үнэлгээний аргачлал мөн оноо/дүнгийн талаар мэдлэгтэй, энэ чиглэлээр ур чадвараа хөгжүүлэхэд дэмжлэг авдаг байна.
- Үнэлгээний шалгуур үзүүлэлт болон аргачлал мөн оноо/дүнгийн шалгуур үзүүлэлт нь урьдчилсан хэвлэгдсэн ил тод болсон байна.
- Үнэлгээ нь оюутны олж авсан мэдлэг, ур чадварынхаа хэмжээнд өөрийгөө илэрхийлэх боломжийг олгосон байна. Оюутан санал хүсэлтээ илэрхийлдэг, хэрэв шаардлагатай бол үүнийг нь сургалтын үйл явцад зөвлөмж хэлбэрээр тусгадаг байна.
- Үнэлгээ нь аль болох нэг ба түүнээс

дээш шинжээчээр хийхийг зорино.

- Үнэлгээний журам хөнгөвчлөх/ зөөлрүүлэх нөхцөлийг авч үзсэн байна.
- Үнэлгээ нь тогтоосон дарааллын дагуу тогтмол хийгдэхээс гадна бүх оюутанд шударга үйлчилнэ.
- Оюутны санал гомдлыг авах албан ёсны процедуртай байна.

Оюутны элсэлт, хөгжил, хүлээн зөвшөөрөгдөх байдал /recognition/ баталгаажуулалт.

Сургууль нь оюутны амьдралын мөчлөгийн бүхий л үе шат /элсэлт, хөгжил/, хүлээн зөвшөөрөгдсөн байдал, баталгаажуулалт гэх мэт/-ыг хамруулсан урьдчилан тодорхойлсон, хэвлэмэл журмыг ашиглана. Оюутан сонгосон мэргэжлээрээ хөгжихөд шаардлагатай урьдач нөхцөл, дэмжлэгийг хангах нь тухайн оюутан, хөтөлбөр, сургууль боловсролын тогтолцооны тэргүүлэх чиглэл хүчин зүйл байна. Энэ зорилтод нийцсэн элсэлт, хүлээн зөвшөөрөгдөх байдал, төгсөлтийн үйл явцад, тэр дундаа оюутан дээд боловсролын систем хооронд шилжин суралцах тохиолдолд нэн чухал юм.

Элсэлтийн бодлого үйл явц, шалгуур нь ил тод хэлбэрээр, харилцан уялдаатайгаар хэрэгждэг байх нэн чухал юм. Сургууль, хөтөлбөр дэх индукц/дэмжлэг хангагдсан байна. Дээд боловсролын мэдлэг, ур чадвар суралцагсад болон бэлтгэл хугацааг хүлээн зөвшөөрөх мөн албан бус сургалтыг хүлээн зөвшөөрөх нь оюутан шилжин суралцахдаа сонгон суралцаж буй мэргэжилдээ өсөн хөгжих боломжийг олгох чухал хүчин зүйл юм. Тохиромжтой хүлээн зөвшөөрөх байдал төгсөлтийн үйл явц нь дараах зүйл дээр үндэслэгдэнэ. Үүнд:

- Лисабоны харилцан зөвшөөрөх тухай конвенцын зарчмуудтай нийцүүлэн байгууллагын хүлээн зөвшөөрөх талын туршлага/ практик
- Тухайн гишүүн улсын хүрээнд харилцан уялдаатай хүлээн зөвшөөрөх үйл явцыг бэхжүүлэх үзэл баримтлал бүхий бусад ДББ, чанарын баталгаажуулалтын агентлагууд, үндэсний ENC/NARIC төвүүдтэй хамтарсан хамтын ажиллагаа

Төгсөлт нь оюутны сургалтын хугацааг дуусгавар болж байгааг илэрхийлнэ. Оюутан нь амжилттай дүүргэж төгссөн сургалтын амжилт,

агуулга түвшин, сургалт зэрэг олж авсан мэдлэг ур чадварыг тайлбарласан баримт бичгийг хүлээж авна.

Багшлах боловсон хүчин. Сургууль багшлах боловсон хүчний чадамжийг өөрөө бие даан баталгаажуулна. Багшийг хөгжүүлэх, сонгон шалгаруулж авахдаа шударга, ил тод байдлыг баримтална.

Оюутны чанартай мэдлэг, туршлагыг бүтээхэд мөн мэдлэг, ур чадвар, чадамжийг олж авахад багшийн гүйцэтгэх үүрэг чухал юм. Оюутны бүтэц /Population/-ийг төрөлжүүлэх сурлагын амжилтад онцгой анхаарал хандуулахад оюутан төвтэй суралцахуй, багшлахуйн үйл явц шаардлагатай тул багшийн үүрэг үүнийг даган өөрчлөгдөж байна.

Сургууль багш ажилчдынхаа чанарт, мөн тэднийг үр бүтээлтэй ажиллах боломжийг хангасан орчноор хангахад онцгой үүрэг хүлээнэ. Энэ орчинд:

- Багш ажилчдыг сонгон шалгаруулж авах ил тод шударга процесс багшлахуйн ач холбогдлыг хүлээн зөвшөөрсөн нөхцөлийг бий болгож дагаж мөрдөнө.
- Багшлах боловсон хүчний мэргэжлийг хөгжлийг дэмждэг, холбогдох боломжуудыг санал болгодог байна.
- Сургалт болон судалгаа хоорондын уялдаа холбоог бэхжүүлэх судалгааны үйл ажиллагааг урамшуулж дэмждэг байна.
- Багшлах арга зүйд гарсан инновац, технологийн хэрэглээг дэмждэг байна.

Сургалтын нөөц ба оюутны дэмжлэг. Сургууль суралцахуй, багшлахуйн үйл явцад зориулсан тохирох санхүүжилттэй байхаас гадна бэлэн ашиглагдахуйц сургалтын нөөц болон оюутны дэмжлэгийг хангасан байх нөхцөлийг бүрдүүлсэн байна. Дээд боловсрол дахь сайн туршлагаас харахад сургууль, оюутныг суралцахад нь дэмжлэг үзүүлэх өргөн хүрээтэй нөөцөөр хангасан байдаг. Үүнд номын сан, сургалтын хэрэглэгдэхүүн, мэдээлэл технологийн дэд бүтэц гэх мэт материаллаг нөөцөөс гадна багш, зөвлөх гэх мэт хүн хүчний нөөц хамаарна. Дэмжлэг үзүүлэх үйлчилгээний үүрэг нь тухайн сургууль дотроо болон бусад сургуульд оюутан шилжин суралцах үйл явцыг хөнгөвчлөхөд оролцдог.

Оюутны дэмжлэг сургалтын нөөцийг төлөвлөх, хуваарилах, хангахдаа оюутны хүн ам зүйн/популяцийн олон янз байдал /ахимаг насны, хөдөлмөр эхэлдэг, эцнээ/орой ангийн, олон улсын хөгжлийн бэрхшээлтэй оюутнууд гэх мэт/-ын хэрэгцээ шаардлага, оюутан төвтэй сургалтад шилжих үүний тулд уян хатан суралцахуй, багшлахуйн хэлбэр сонгох зэрэг асуудлыг авч үзэх шаардлагатай. Тухайн сургалтын байгууллагын онцлогоос хамааран дэмжлэг үзүүлэх үйл ажиллагаа нь баазыг янз бүрээр зохион байгуулж болно. Гэхдээ чанарын дотоод баталгаажуулалт нь эдгээр нөөц зорилгод нийцэж буй эсэх, хүртээмжтэй байгаа эсэх, оюутнууд энэ төрлийн үйлчилгээний талаар мэдээллээр хангагдсан эсэхийг баталгаажуулдаг байна.

Дэмжлэг үзүүлэх үйлчилгээг хэрэгжүүлэхэд удирдах албан тушаалтны дэмжлэг, үүрэг нэн чухал тул холбогдох албан тушаалтнууд энэ талаар чадавхажсан байхаас гадна мэдлэг, ур чадвараа хөгжүүлэх боломжоор хангагдсан байна.

Мэдээллийн удирдлага. Сургууль өөрийн хөтөлбөр үйл ажиллагааны үр өгөөжтэй удирдлагын талаарх холбогдох мэдээллийг цуглуулдаг дүн шинжилгээ хийдэг, ашигладаг байх боломжийг хангасан байна. Найдвартай үнэн зөв мэдээ баримт нь шийдвэр гаргах, юу сайн ажиллаж байна, юунд анхаарал хандуулах шаардлагатайг олж мэдэхэд нэн чухал юм. Сургалтын хөтөлбөр болон бусад үйл ажиллагааны талаарх мэдээллийг цуглуулах дүн шинжилгээ хийх өгөөжтэй арга хэлбэр нь чанарын дотоод баталгаажуулалтын системийг тэтгэж өгдөг. Цуглуулах мэдээлэл нь байгууллагын зорилго, төрлөөс хамаарна.

Олон нийтийн мэдээлэл. Сургууль нь хэрэгжүүлж буй хөтөлбөр зэрэг өөрийн үйл ажиллагааны талаарх мэдээллийг хэвлэн түгээдэг байх ба энэхүү мэдээлэл нь ойлгомжтой, дэлгэрэнгүй, сүүлийн үеийн мэдээлэл байхаас гадна авч үзэж/танилцаж болохуйц байна. Сургуулийн үйл ажиллагааны тухай мэдээлэл нь элсэн орох гэж байгаа болон одоогийн оюутнууд, төгсөгчид бусад оролцогч тал, олон нийтэд тустай юм.

Байнгын хяналт болон хөтөлбөрийн үечилсэн үнэлгээ. Сургууль нь сургалтын



хөтөлбөрийн зорилт хэрэгжиж буй эсэхийг баталгаажуулах, оюутан, олон нийтийн хэрэгцээнд нийцүүлэх зорилгоор хэрэгжүүлж буй хөтөлбөрүүдээ хянан үзэж, үечилсэн үнэлгээ хийдэг байна. Үр дүнгээс үүдэн төлөвлөж буй авч хэрэгжүүлж буй үйл ажиллагаанд сургалтын үйл ажиллагаанд оролцогч бүх талыг хамруулсан байна.

Сургалтын хөтөлбөрийн байнгын хяналт, үнэлгээ сайжруулалтын зорилго нь сургалтын үйл ажиллагаа нь тохирохуйц, /appropriate/ байх зарчмыг хангах мөн оюутанд зориулсан үр өгөөжтэй, туслан дэмждэг сургалтын орчин бүрдүүлэхэд оршино. Эдгээр хяналт, үнэлгээнд дараах зүйлс хамаарна. Үүнд:

- Тухайн мэргэжил /салбарын сүүлийн үед хийгдсэн судалгаатай уялдуулсан хөтөлбөрийн агуулга, /хөтөлбөр цаг үетэйгээ нийцсэн байх/
 - Нийгмийн хувьсан өөрчлөгдөж буй эрэлт хэрэгцээ
 - Оюутны ачаалал, ахиц дүүргэлт
 - Оюутны үнэлгээнд ашиглагдаж буй процедур үр өгөөж
 - Хөтөлбөртэй холбоотойгоор оюутнаас хүлээх амжилт, тавих шаардлага ба сэтгэл ханамж
 - Сургалтын орчин, дэмжин туслах үйлчилгээ ба хөтөлбөрийн зорилттой уялдсан байдал
- Оюутан болон бусад оролцогч талын

оролцоотойгоор хөтөлбөрийг тогтмол үнэлж, дүгнэн сайжруулж байх шаардлагатай. Цуглуулсан мэдээлэлд дүн шинжилгээ хийж, хөтөлбөрийн цаг үетэй нь нийцүүлж байх шаардлагатай. Засварласан сайжруулсан хөтөлбөрийн үзүүлэлтийг хэвлэн олон нийтэд ил болгоно.

Давтамжит хөндлөнгийн баталгаажуулалт.


Сургууль нь энэхүү чанарын баталгаажуулалтын стандарт зөвлөмжүүддээ нийцүүлэн хөндлөнгийн чанар баталгаажуулалтыг үечилсэн хэлбэрээр хийлгэнэ.

Олон төрлийн хөндлөнгийн баталгаажуулалт нь сургуулийн чанарын дотоод баталгаажуулалтын үр өгөөжийг батлуулж, холбогдох сайжруулалтыг хийж, сургуульд шинэ хандлагыг санал болгодог. Мөн сургуулийн үйл ажиллагааны чанарыг баталгаажуулах мэдээллээр сургууль болон олон нийтийг хангадаг. Сургууль холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн зохих хөндлөнгийн чанарын баталгаажуулалтад давтамжтайгаар оролцдог. Иймд тухайн тогтолцоо /framework/-оос хамааран хөндлөнгийн чанарын баталгаажуулалт олон хэлбэртэй байхаас гадна байгууллагын өөр өөр түвшин /хөтөлбөр факультет, сургууль гэх мэт/ дээр төвлөрнө. Чанарын баталгаажуулалт нь хөндлөнгийн санал дүгнэлт, тайлагнал бүхий эсвэл сургууль доторх засан сайжруулах /follow up/ үйл явц бүхий төгсөшгүй байнгын үйл ажиллагаа юм.

1 дүгээр хүснэгт

ОУХНУТ–ийн элсэгчид

№	Хичээлийн жил	Нийтийн удирдлага			Олон улсын харилцаа		
		Нийт	Эр	эм	Нийт	Эр	Эм
1	2018–2019 он	169	86	83	–	–	–
2	2019–2020 он	92	36	56	–	–	–
3	2020–2021 он	108	41	67	–	–	–
4	2021–2022 он	54	19	35	7	3	4
5	2022–2023 он	52	2	50	28	5	23
Нийт		475	184	291	33	8	27





ОУХНУТ-ийн суралцагчид

№	Хичээлийн жил	Нийтийн удирдлага			Олон улсын харилцаа		
		Нийт	Эр	эм	Нийт	Эр	Эм
1	2018–2019 он	475	185	290	–	–	–
2	2019–2020 он	456	192	264	–	–	–
3	2020–2021 он	421	158	263	–	–	–
4	2021–2022 он	247	57	190	7	3	4
5	2022–2023 он	217	52	165	32	8	25
Нийт		1816	644	1172	39	11	29

ОУХНУТ-ийн нийт суралцагч



3 дугаар хүснэгт.

АБДС-ийн нийт ажиллаж байгаа багш, ажилчдын тоо



АБДС-ийн багш, ажилчдын шилжилт хөдөлгөөн



ДҮГНЭЛТ, САНАЛ. Дээд боловсролын сургалтын байгууллага чанартай сургалт явуулахын тулд суралцахуйн болон багшлахуйн орчин нөхцөлд зөв зүйтэй үнэлгээ, дүгнэлт хийх, болзошгүй сорилт, хүндрэлийг сургуулийн судалгааг дамжуулан урьдчилсан тооцох, тулгамдсан асуудлыг нарийвчлан үзэх, инновацад саад болж буй дотоод, гадаад хүчин зүйлсийг тодорхойлох, чадавхаа бэхжүүлдэг

байх нь суралцахуйн соёлыг төлөвшүүлэхэд шийдвэрлэх чухал хүчин зүйл юм. Иймд сургуулийн түвшинд суралцахуйн болон багшлахуйн үйл ажиллагаанд бодит өөрчлөлт хийхийн тулд дараах зүйлсийг анхаарах шаардлагатай. Үүнд:

- Санал болгож буй хөтөлбөрийн ач холбогдол, үр нөлөөг тасралтгүй сайжруулах уур амьсгал, боловсролын



үзэл баримтлал, үнэт зүйл, урамшуулал, туршлагыг дэмжих

- Инновацын хэрэгжилтийн чанарыг сайжруулах, инновацыг хэрэгжүүлэх хүрээнд бий болсон боломж, хүндрэл бэрхшээлийг тооцон алдаа дутагдлаасаа суралцах чиглэлээр хамтран суралцахыг байнга дэмжих
- Тэнхимийн хөтөлбөрийн нэгж хоорондын болон олон улсын дотоод түншлэл, сургууль бусад байгууллагатай тогтоосон сүлжээ, хамтын ажиллагаагаар дамжуулан суралцахуйн болон багшлахуйн үйлийн инновацыг нэвтрүүлэхэд чиглэсэн нээлттэй хандлагыг дэмжих
- Инновацыг санаачилж, хэрэгжүүлэхэд удирдах болон гүйцэтгэх түвшний ажилтнууд оролцдог байх, инновацын үр дүнд суралцахуйн болон багшлахуйн үйлд бий болсон үнэ, цэнэ, үр өгөөж, цаашдын хандлагад ач холбогдол өгч үнэлдэг байх

Суралцахуйн болон багшлахуйн үйлийн чанарыг үнэлэхээ дараах үндсэн чухал хэтийн төлөвүүдийг тооцож үздэг байна.

1. Дээд боловсролын сургалтын байгууллагын нөхцөл байдалд оролцогч талуудын сэтгэл ханамж
2. Суралцахуйн зорилтот үр дүнгийн биелэлт
3. Чанарыг баталгаажуулахдаа оюутан төвтэй, харилцан, идэвхтэй асууж мэтгэлцэхэд суурилсан арга барил бүхий орчин үеийн суралцахуйн болон багшлахуйн арга, аргачлалын хэрэглээг чухалчилж үнэлдэг байдал
4. Хөтөлбөр нь зах зээлийн эрэлт хэрэгцээг хангаж буй байдал зэрэг юм.

Иймд цаашид:

1. Сургалтын чанарын үнэлгээг сайжруулахын тулд элсэлтийн бодлого нь үйл явц, шалгуурыг ил тод хэлбэрээр, харилцан уялдаатайгаар хэрэгжүүлэх, / оноо хүрээгүй элсэгчийг элсүүлэхгүй байх, элсэгчийн тоог нэмэгдүүлэх/ зэрэг ажлуудыг хийж хэрэгжүүлэх шаардлагатай байна.
2. Багш ажилчдыг сонгон шалгаруулж авах процессыг ил тод шударга байлгах, тоо бүртгэлийг сайжруулах шаардлагатай байна.

Ашигласан материал:

Хууль тогтоомж

1. Монгол Улсын үндсэн хууль. 1992 он
2. Монгол Улсын ;дээд боловсролын тухай хууль. 2002 он

Ном, сурах бичиг

3. Боловсролын магадлан итгэмжлэлийн үндэсний зөвлөл. Чанарын хөндлөнгийн баталгаажуулалтын шинэ эрин. Дээд боловсролын шинэлэг чиг хандлага. УБ.,2022
4. Боловсролын магадлан итгэмжлэлийн үндэсний зөвлөл. Дээд боловсролын сургалтын байгууллагын чанарын дотоод баталгаажуулалтын зөвлөмж. УБ.,2021
5. Боловсролын магадлан итгэмжлэлийн үндэсний зөвлөл. Шинжээчийн гарын авлага /Дээд боловсролын сургалтын байгууллагын магадлан итгэмжлэл. УБ., 2022
6. Боловсролын магадлан итгэмжлэлийн үндэсний зөвлөл. Шинжээчийн гарын авлага /Дээд боловсролын сургалтын хөтөлбөрийн магадлан итгэмжлэл. УБ.,2022
7. Боловсролын магадлан итгэмжлэлийн үндэсний зөвлөл. Шинжээчийн гарын авлага /Дээд боловсролын сургалтын хөтөлбөрийн магадлан итгэмжлэл. УБ.,2022



ТЕЛЛО ДРОН АШИГЛАН ЗУРГААР ӨГӨГДСӨН БАЙГ ИЛРҮҮЛЭН УСТГАХ БОЛОМЖИЙН СУДАЛГАА

М.ЭНХСАРУУЛ /Дундговь, Зэвсэгт хүчний 278 дугаар байгууламж, ШУТИС-ийн магистрант/

Ц.ТЭНГИС /ШУТИС-ийн МХТС-ийн багш доктор (Ph.D), дэд профессор/

Б.ДОРЖ /ШУТИС-ийн МХТС-ийн багш доктор (Ph.D), дэд профессор/

Түлхүүр үг: нисгэгчгүй нисдэг тэрэг, дүрс боловсруулалт, удирдлага, цэрэг, зэвсэглэл

Key words: Unmanned aerial vehicle (UAV), Digital image processing, control, army, armament

Хураангуй: Сүүлийн жилүүдэд техник технологи хурдацтай хөгжиж буй өнөө үед нисгэгчгүй нисэх хэрэгсэл буюу дроны хэрэглээ бүх төрлийн салбарт нэмэгдсээр байна. Дроныг анх зураг авах, барилгын 3D зураг үүсгэх, хөрсний бүтэц тодорхойлох, кино үйлдвэрлэл, ашигт малтмалын хайгуул, гал унтраах, онцгой байдал, хилийн хяналт зэргээр ашигладаг байсан бол өнөөдөр цэрэг, зэвсэглэлийн салбарт төрөл бүрээр ашиглах боломжтой болжээ. Орчин үеийн дайнд бага оврын дрон хэрэглэх замаар хүнд зэвсгүүдийг илрүүлэн устгах даалгаварт өргөнөөр хэрэглэж байна. Энэхүү судалгаанд бидний сонгож авсан Телло дроныг цэрэг зэвсэглэлд ямар аргаар, хэрхэн хэрэглэж болох талаар олон төрлийн туршилтууд хийсэн ба энэхүү туршилтуудын зарим үр дүн болох зургаар өгөгдсөн байг илрүүлэн устгах судалгааны ажлын үр дүнг танилцуулж байна.

УДИРТГАЛ. Нисгэгчгүй агаарын тээврийн хэрэгслийн (UAVs) хурдацтай дэвшил нь дрон гэгддэг бөгөөд агаараас тандалт хийх, хүргэлтийн үйлчилгээ, эрэн хайх, аврах ажиллагаа зэрэг төрөл бүрийн хэрэглээнд шинэ боломжуудыг нээж өгсөн [1–4]. Үүнээс гадна дронууд гэрэл зураг, судалгаа, тээвэр, цэргийн систем гэх мэт төрөл бүрийн салбарт улам бүр түгээмэл болж байна [5–8]. Судлаачдын нэг сонирхлын чиглэл бол компьютерын харааг нисгэгчгүй нисдэг тэрэгний системтэй нэгтгэсэнээр дронд объектуудыг бие даан илрүүлэх, таних боломжийг олгодог байна [9–11].

Масрул Низам нь Телло дрон, OpenCV,

python программчлалын хэл ашиглан ашиглан QR код илрүүлэхийг санал болгосон байна [1]. Мустафа Димасын судалгаагаар COVID–19 үед жижиг орон зайд олон хүмүүсийн цугларалтыг илрүүлэхэд зориулагдсан дронуудын ашиг тусыг тусгасан байна [2]. Shalaw M. Abdallah судалгаагаар санал болгож буй систем нь хүний нүүр царайг илрүүлж, хөдөлгөөнийг хянахыг оролдсон байна [3].

Дрон гэж нэрлэгддэг нисгэгчгүй агаарын тээврийн хэрэгсэл нь энгийн ажиглалт, тагнуулын ажлаас эхлээд улам бүр зорилтот аллага үйлдэх үүрэг рүү хувирсаар байна [6–9]. Сүүлийн жилүүдэд дроныг дайнд өргөнөөр хэрэглэх болсон нь дайны үйл явцыг оронгоор нь эргүүлээд байна. Орос Украины энэхүү мөргөлдөөнд нисгэгчгүй агаарын тээврийн хэрэгслийн өргөн тархалт нь дрон болон бие даасан зэвсгийн системүүд дайныг хэрхэн өөрчилж байгааг харуулж байна [7].

Эдгээр нисгэгчгүй байлдааны нисэх онгоцны зарим онцлог нь өндөрт нисэх, үр дүнтэй мэдээлэл цуглуулах чадвар, энгийн иргэдэд тусламж үзүүлэх, дайны стратегийн шийдвэрт нөлөөлөх юм [8]. Дрон нь дайсны хөдөлгөөн, байршил, стратегийн зорилтуудын байрлалын талаарх чухал мэдээллийг дамжуулж чаддаг. Энэхүү мэдээлэл нь командлагчдад илүү үр дүнтэй байж, талбай дээр байхдаа илүү сайн шийдвэр гаргах боломжийг олгодог байна.

Цэргийн бие даан нисдэг онгоцнууд нь тодорхой газар руу нисэж, өөрийн байг сонгож, алсын удирдлагагүйгээр алах боломжтой юм [6–10]. Тиймээс "алуурчин робот"–ын тухай санаа уран зөгнөлөөс бодит байдал руу шилжсэн байна



[6]. Ийм нисгэгчгүй онгоцнууд нь даалгавраа биелүүлэхэд тулгарч болох янз бүрийн сорилтод хариу арга хэмжээ авах олон тооны хувилбараар хангахаар программчлагдсан байдаг. Мөн нисгэгчгүй онгоцыг нэгэн зэрэг олон чиглэлийн довтолгоонд ашиглаж болох бөгөөд ингэснээр дайсныг дарж болно [9].

EUROUVS нь нисгэгчгүй агаарын тээврийн хэрэгслийн ангиллыг нислэгийн өндөр, нислэгийн үргэлжлэх хугацаа, хурд, хөөрөх хамгийн их жин, онгоцны хэмжээ, дохионы хүрээ зэргээр нь тодорхойлсон байна [11]. Энд:

- 1-р ангилал (жин 1 кг хүртэл, нислэгийн өндөр 50 м хүртэл, Газрын түвшнээс дээш, 150 м хүртэлх зай);
- 2-р ангилал (жин 1 кг-аас 5 кг, нислэгийн өндөр нь 150 м, 500 м хүртэлх зай);
- 3-р ангилал (жин 5 кг-аас 20 кг, нислэгийн өндөр нь 300 м, 2500 м хүртэлх зай);
- 4-р ангилал (масс 20 кг-аас их, нислэгийн өндөр 300 м-ээс дээш, 2500 м-ээс их зай)

Сүүлийн үеийн эрчимтэй хийгдэж байгаа судалгааны чиглэл нь Хиймэл Оюунд суурилсан дрон юм. Дронуудад хиймэл оюун ухааныг хэрэгжүүлэх нь механик төхөөрөмж, навигацийн хэрэгсэл, машины харааны хослолыг бий болгох юм. Дрон технологийн тухайд хиймэл оюун ухааныг ашиглах олон тохиолдол байна [12, 13]. Дроныг бие даан нисэх боломжийг олгохын тулд хиймэл оюун ухааныг ихэвчлэн ашигладаг бөгөөд энэ нь компьютерын хараа, дүрс боловсруулалтыг ихээхэн шаарддаг. Өнөө үед дүрсийн боловсруулалт дээр суурилсан дроны судалгаа өргөн чиглэлд хийгдсээр байна [14]. Хиймэл оюу болон дүрсийн боловсруулалт ашиглан объектыг танил, ялгах, объектыг илрүүлэх, объектыг дагах ажлуудыг хийсээр байна. Бид өмнөх судалгаан дээр хиймэл оюу ашиглан дроны тэнцвэржилтийн асуудлыг шийдсэн [18, 21]. Өөрөөр хэлбэл дрон нь орчин нөхцөлд суралцах замаар өөрийн тэнцвэрийг хадгалах юм [22]. Хиймэл оюун ухаанд гүн сургалтын аргуудыг өргөнөөр хэрэглэж байна.

Үүнд машин сургалтын CNN, RNN, SVM, Бататган сурах болон олон хосолмол арга ашиглаж байна [16–18, 22]. Дүрс танилтаар өндөр үзүүлэлт үзүүлж буй YOLO загварыг мөн ихээхэн ашиглаж байна [8].

Өртөг багатай дронуор их хэмжээний хохирлыг учруулж байгааг сүүлийн үеийн мөргөлдөөнүүдээс харж болно. Иймд судлаачид дронуос хамгаалах технологийн ирэн хайгуулд идэвхтэй ажиллаж байна. Дроныг алсаас удирдах болон түүнийг дохиог барьж унтраах эсвэл өөр чиглэлд нисгэх зорилготой дроны эсрэг RF цахилгаан соронзон буу зах зээлд гарч байна. Эдгээр төхөөрөмжүүд нь нисгэгчгүй онгоцны удирдлагын системд ашигладаг ижил давтамжууд дээр хүчирхэг радио дохиог дамжуулснаар нисгэгчгүй онгоцонд хүрэх командыг үр дүнтэй хааж, аюулгүй горимд шилжих эсвэл гэртээ буцаж ирэхэд хүргэдэг.

GPS-тэй дроны хувьд зарим буу нь GPS дохиог хуурч, дроныг өөр байршилд байна гэж хууран мэхлэх эсвэл навигацийн замыг нь өөрчилдөг. Энэ нь дроныг эмзэг газраас холдуулах эсвэл аюулгүй газардуулахад ашиглаж болно.

Нисгэгчгүй онгоцыг саармагжуулах физик хэрэгслийг ашиглаж болно. Энэ нь нисгэгчгүй онгоцыг агаарт барьж, идэвхгүй болгохын тулд тор, тусгай сум зэргээр харваж болно.

Дроны эсрэг дэвшилтэт системүүд нь нисгэгчгүй онгоцны электрон эд ангиудыг гэмтээх, тасалдуулахын тулд лазер эсвэл богино долгионы туяа зэрэг чиглэсэн эрчим хүчний зэвсгийг ашиглаж болно. Эдгээр өндөр энергитэй цацрагууд нь нисгэгчгүй онгоцны хөдөлгөгч систем, мэдрэгч эсвэл холбооны холболтыг хааж болно.

Гэвч ямар ч дохио хүлээн авдаггүй болон GPS-ийн дохионоос хамааралгүй бие даан нисдэг дроныг буудаж унгаах төвөгтэй байна.

1. ТЕЛЛО ДРОНЫ БОЛОМЖУУД

Энэхүү судалгааны ажлын хүрээнд нисгэгчгүй нисдэг тэрэгний программчлалын боломж, энгийн байдал, өртөг хэмнэлттэй



байдлаас шалтгаалан энэхүү Tello дөрвөн сэнст дроныг сонгосон болно. Телло дроныг доорх Зураг 1–т үзүүлэв.



1 дүгээр зураг. Телло дрон

Телло дрон нь 13 минутын нислэг хийх чадвартай бөгөөд нислэгийн дээд өндөр нь 30 метр юм. Энэ нь радарын системд илрүүлэгдэхгүй бас нэгэн давуу тал байна. Энэхүү дроны техникийн үзүүлэлтийг доорх Хүснэгт 1–д үзүүлэв.

1 дүгээр хүснэгт.

ТЕЛЛО ДРОНЫ ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Материал	Үзүүлэлтүүд
Жин	80 гр
Хэмжээ	98x92.5x41 мм
Сэнс	3 инч
Мэдрүүр	Зай хэмжигч, барометр
Материал	Хуванцар
Усны хамгаалалт	Байхгүй
Камерын систем	720p Live View
Удирдлага	2.4 GHz 802.11n Wi-Fi, Bluetooth
Порт	Micro USB Charging Port
Батарей	1.1Ah/3.8В
Нислэгийн зай	100 м
Нислэгийн өндөр	30 м
Нислэгийн хурд	8 м/с
Нислэгийн хугацаа	13 мин
Нислэгийн ачаа	60 грамм
Нислэгийн дуу	60–70 дБ

Телло дроноос үүсэх дуу чимээ нь 2–3 метрийн цаанаас хүнд сонсогдох ба энэхүү үзүүлэлтийг ашиглан байд ойртох боломжтой юм. Tello дроны бяцхан камер нь нүүр царайг таньж, дагах чадвартай юм. Энэхүү дроны зах зээл дээрх үнэ нь 360000 төгрөг байна. Телло дроны техникийн үзүүлэлт дээр тулгуурлан мөн ижил төстэй дронууд дээр хийсэн судалгаан дээр үндэслэн энэхүү дроныг дайны нөхцөлд

дараах байдлаар ашиглаж болох боломжууд харагдаж байна. Энд:

1. Телло нисгэгчгүй онгоцыг ойрын зайн тагнуулын ажилд ашиглаж, дайсны байрлал, хөдөлгөөн, газар нутгийн онцлогийн талаар бодит цагийн тагнуулын мэдээлэл цуглуулах боломжтой. Түүний жижиг хэмжээтэй, чимээгүй ажиллагаа нь хотын орчин эсвэл том дронуудын анхаарлыг татахуйц хязгаарлагдмал орон зайд далд тандалт хийхэд тохиромжтой.

2. Tello дрон нь радио дохионы хүрээг өргөтгөх эсвэл дэд бүтэц хязгаарлагдмал бүс нутгуудад холболт хийх зорилгоор холбооны реле төхөөрөмжөөр тоноглогдсон байж болно. Энэ нь алслагдсан эсвэл саадтай орчинд ажиллаж буй цэргүүдийн хоорондын харилцаа холбоог хадгалахад ашигтай байж болох юм.

3. Телло дрон дээрх камерын тусламж–тайгаар байлдааны талбарын агаарын зургийг авч, даалгаврыг төлөвлөх, нөхцөл байдлын талаарх ойлголт, үйл ажиллагааны дараах дүн шинжилгээ хийхэд зориулж нарийвчилсан газрын зураг, 3D загвар гаргах боломжтой. Шийдвэр гаргах, зохицуулалтыг сайжруулахын тулд эдгээр мэдээллийг хуурай замын цэрэг, командлалын төвүүдтэй хуваалцаж болно.

4. Теллогийн ачааны багтаамж хязгаар–лагдмал хэдий ч лазер заагч эсвэл тэмдэглэгээ гэх мэт хөнгөн жинтэй зорилтот төхөөрөмжүүдийг авч явах боломжтой. Эдгээрийг нарийн удирддаг сумны байг тодорхойлох эсвэл том хэмжээний нисгэгчгүй онгоц эсвэл нисгэгчтэй нисэх онгоцоор хийсэн агаарын цохилтыг зохицуулахад ашиглаж болно.

5. Телло нисгэгчгүй онгоцыг суртал ухуулгын мессеж, ухуулах хуудас, аудио бичлэг цацаж, дайсны ёс суртахуун эсвэл энгийн ард түмэнд нөлөөлөх замаар сэтгэлзүйн үйл ажиллагаанд (PSYOP) ашиглаж болно. Түүний жижиг хэмжээ, хурдан хөдөлгөөн нь зорилтот байршилд мессежийг нарийвчлалтайгаар хүргэх боломжийг олгоно.

6. Цэргийн ангиуд Телло нисгэгчгүй онгоцыг нисгэгчгүй онгоцны үндсэн ажиллагаа,

агаарын тагнуулын арга техник, даалгаврын төлөвлөлттэй танилцах зорилгоор сургалтын дасгал, загварчлалд ашиглаж болно. Хямд өртөгтэй, ашиглахад хялбар нь сургалтын зориулалтаар ашиглах боломжтой хэрэгсэл болгоно.

7. Телло нисгэгчгүй онгоцыг сураггүй алга болсон болон бэртэж гэмтсэн цэргийн байршлыг тогтоох, тусламж үзүүлэх зорилгоор эрэн хайх, аврах ажиллагаанд ашиглаж болно. Авсаархан хэмжээ, маневрлах чадвар нь түүнийг нягт орон зайд жолоодох эсвэл аюултай орчинд агаарын хайлт хийхэд тохиромжтой болгож байна.

Нэмж дурдахад DJI Tello-г Python программчлалын хэл ашиглан хялбархан программчилж болно.

II. БИДНИЙ САНАЛ БОЛГОЖ БУЙ СИСТЕМ

Телло дрон нь OpenCV санг дэмждэг болон Python хэлээр программчилж болдог нь бидэнд судалгаа, туршилт хийх өргөн боломжийг нээж өгч байна. Энэхүү судалгаагаар бид дроныг дараах байдлаар программчилж, цэргийн зориулалтаар ашиглаж болох талаар судалсан болно. Энд:

- Өнгө таних замар тухай бай руу онилж нисэх
- Хосолсон өнгө таних замар тухай бай руу онилж нисэх
- Тодорхой жижиг тэмдэгт, хэлбэр илрүүлж нисэх, Жишээ нь таван хошуу, цэргийн хувцас дээрх онцгой тэмдэгт
- Тодорхой объект таньж түүн рүү чиглэж нисэх
- Хүний царай таньж түүн рүү чиглэж нисэх

А. Туршилт 1– Өнгө болон хэлбэрээр танийх

Дайны талбарт талууд хоорондоо ялгагдах зорилгоор өөрийн тугийн өнгө эсвэл онцгой өнгөтэй зүйлээр ханцуйвч дээр (Зураг 2) ороодог. Энэ зүйлийг ашиглан эсрэг талын цэргийг илрүүлэх, онилох, дагах бүүр цаашилбал устгах боломжтой юм.



2 дугаар зураг. Дайны талбар дээрх цэргүүдийн ханцуйвч

Компьютерт дүрсийг тоон хэлбэрээр харахдаа өнгөний олон тооны загварууд хэрэглэдэг. Жишээ нь RGB, HSV, Gray, HIS гэх мэт. Компьютерт өнгөт пикселийг Улаан, Ногоон, Хөх (RGB) гэх тус бүр 8 битийн утгаар дүрсэлдэг. Харин компьютерын харааны өнгө танилтад HSV загварыг түлхүү хэрэглэдэг. HSV загварын хувьд өнгийг өнгө (Hue), ханалт (Saturation), гэрэлтэц (Value) гэсэн утгуудаар илэрхийлнэ[20][21]. RGB загварт аливаа өнгө 3 өнгөний нийлмэл байдаг бол HSV загварт, жишээ нь, улаан өнгийг улаан өнгөний ханалт, улаан өнгөний гэрэлтэцээр нь задалдаг тул HSV загварыг өнгө танилтан илүү хэрэглэдэг байна.

H – өнгийг илэрхийлэх ба 360 градусаар тодорхойлно.

S – ханалтыг илэрхийлэх ба тухайн өнгөнд хэр их цагаан өнгө шингэсэн байгааг 0–100% –аар тодорхойлно.

V – гэрэлтэцийг илэрхийлэх ба 0–100% –аар тодорхойлно.

RGB загварыг HSV загварт хөрвүүлэх нь:

$$M = \max\{R, G, B\}$$

$$m = \min\{R, G, B\}$$

$$V = M/255 \quad (1)$$

$$S = 1 - m/M \quad (2)$$

Хэрэв $G \geq B$ бол

$$H = \cos^{-1} \left[\frac{R - 0.5G - 0.5B}{\sqrt{R^2 + G^2 + B^2 - RG - RB - GB}} \right] \quad (3)$$

Хэрэв $G < B$ бол

$$H = 360 - \cos^{-1} \left[\frac{R - 0.5G - 0.5B}{\sqrt{R^2 + G^2 + B^2 - RG - RB - GB}} \right] \quad (4)$$

Босго тавих нь:



$$g(x, y) = \begin{cases} 1 & \text{хэрэв } f(x, y) \geq T \\ 0 & \text{тэй} \end{cases}$$

Үүний дараа бид Гауссын бүдэгрүүлэлтийг хийх замаар зарим цэгүүдийг устгаж шүүнэ. Дараа нь дүрсийг саарал зурагт хөрвүүлнэ. Үүний дараа бид ирмэг илрүүлэх Canny аргыг хэрэглэн онцлогийг тодруулна. Объектыг өнгөөр ялган сегментчилсний дараа босго (threshold), идэх (erode), тэлэх (dilate) аргаар шүүж объектын танилтыг сайжруулна.

Идэлт хийх нь:

Идэх функцийг гол зорилго нь объектын хилээс хол байрлах цэгүүдийг устгахад орших юм.

$$E = I \ominus S \quad (5)$$

$$E(x) = \begin{cases} 1 & \text{хэрэв } S \text{ нь } I - \text{ийн } x \text{ тэй таарах} \\ 0 & \text{тэй} \end{cases}$$

Тэлэлт хийх нь:

Тэлэх функцийг гол зорилго нь объектын хил дээрх цэгүүдийг нөхөхөд оршино.


$$D = I \oplus S \quad (6)$$

$$E(x) = \begin{cases} 1 & \text{хэрэв } S \text{ нь } I - \text{ийн } x \text{ тэй таарах} \\ 0 & \text{тэй} \end{cases}$$

Дээрх шүүлтийн аргыг хэрэглэснээр объектыг бусад өнгөөс салгана, объектоос хол үүссэн төсөөтэй цэгүүдийг идүүлж устгана. Үүний дараа таних объектын зарим хэсгүүдийг тэлэх аргаар сэргээж болно.

Дүрсний гадаргуу дээр нэгэн төрлийн цэгээс бүрдсэн объект илрэн гарч ирэх ба объектын төвийг бид тодорхойлж байрлалыг олно.

Дүрсийг шүүсний дараа бид шар өнгөтэй ханцуйвчийг дроноор илрүүлсэн байдлыг 3 дугаар зурагт үзүүлэв.



3-р зураг. Шар өнгийн ханцуйвчийг илрүүлсэн байдал

Тухайн илрүүлэлтийг зөвхөн өнгөнөөс бус нэмэлтээр объектын хэлбэрээс хамааруулан илрүүлэх бүрэн боломжтой байна.

В. Туршилт 2 – Царай таних, илрүүлэх, дагах

Хаар каскадыг ашиглан дараах туршилтыг хийж гүйцэтгэв. Хаар каскад нь зураг болон бичлэгээс объект илрүүлэх функц дээр суурилсан алгоритм юм. Алгоритм нь өргөн хэмжээний тооцоолол шаардахгүй ба бага тооцоолох хүчин чадалтай жижиг төхөөрөмжүүдэд түгээмэл байдаг. Хаар каскадын алгоритмыг тайлбарлавал 4-н үе шаттай. Үүнд:

1. Онцлогийг тооцоолох
2. Интеграл зураг үүсгэх
3. Adaboost цугралт
4. Каскадын ангиллын хэрэгжилт

1. Онцлогийн тооцоолох: Хаарын функцүүд нь илрүүлэх цонхонд тодорхой байрлалд босоо, зэргэлдээ, хөндлөнгөөр байрлаж пикселийн эрчмийг нэмж, нийлбэрийн зөрүүг тооцдог.


2. Интеграл зураг үүсгэх: Интеграл зураг үүсгэх нь тооцооллыг багасгадаг. Пиксел бүр дээр тооцоололын оронд энэ нь дэд тэгш өнцөгтүүдийг үүсгэдэг бөгөөд массив нь тэдгээр дэд тэгш өнцөгтүүдийг иш татаж, Наагийн онцлогуудыг тооцдог.

3. Adaboost цугралт: Сул шүүлтүүрүүдийг нэгтгэн хүчирхэг шүүлтүүр гаргадаг.


4. Каскадын ангиллын хэрэгжилт: Объект байхгүй бол сөрөг гэж үзэн дараагийн сөрөг рүү шилжиж байхгүй болгох үе шатуудыг үүсгэдэг.

Доорх Зураг 4-т дроноор царай таньж дагах программын алгоритмыг үзүүлэв.

Хаар каскад болон PID удирдлага ашиглан царай танин дагах туршилтын үр дүнг Зураг 5, 6-д үзүүлэв.



5-р зураг. Дроноор царай таньсан байдал




6-р зураг. Дроноор царай таньж, дагасан байдал

С. Туршилт 3 – Өгөгдсөн дүрсээр байг таньж, дагах

Байлдааны талбарт дроныг алсаас удирдах нь дроноос хамгаалах RF буунд өртөх боломжийг олгож болно. Тиймээс дроныг бие даан нисэх боломжоор бүрдүүлснээр RF буунд өртөх боломжийг бууруулна. Бид дронд нисэх чиглэл болон байг программчилж өгч болно. Тухайн байг бид дроны камерт зураг байдлаар таниулснаар дрон уг байг хадгалж, камер дээр орж ирсэн шинэ дүрснээс хайх болно. Тухайн бай илэрсэн тохиолдолд байн байрлалыг тодорхойлж тухайн байруу дроны чиглэлийг PID удирдлагын тусламжтайгаар чиглүүлэн ойртоно.


Дроны камерт танкны зургийг таниулж туршсан. Танкны зургаас гадна ямарч төрлийн дүрсийг таниулж болно. Жишээ нь: дугуй, машин, мотоцикл зэрэг дүрсийг таниулах боломжтой.


Бидний санал болгож буй алгоритмыг Зураг 7-д үзүүлэв.



7-р зураг. Өгөгдсөн зургаар байг таньж, устгах алгоритм

Бид танкны зургийг Телло дронд таниулсан ба тухайн байг дрон алдалгүй дагаж буйг Зураг 8-д үзүүлэв. Туршилтыг олон удаа давтан хийхэд алдах магадлал маш бага байсан.





8-р зураг. Зургаар өгөгдсөн байг таньж, дагасан байдал

ДҮГНЭЛТ. Энэхүү судалгаагаар бид Телло дроныг цэрэг, зэвсэглэлд ашиглах боломжийн судалгаа хийсэн. Телло дрон нь өөр дээрээ өндөр нягтралтай мини камертай ба түүнийг Python программчлалын хэл ашиглан бүрэн программчлах боломжтой байна. Энэхүү жин, овор болон зардлын хэмжээ багатай дроныг хөгжүүлэх замаар сөрөг талд ихээхэн

хохирол учруулах зэвсэг болгон программчилж болохоор байна. Бид дүрс боловсруулалтын 3 төрлийн туршилтуудыг хийсэн бөгөөд үүнд өнгөөр таних, царай таних болон өгөгдсөн зургаар таньж, дагах үйлдлүүдийг амжилттай туршлаа. Судалгаагаар дүрсийн тасалдал бага, зургийг алдахгүй дагаж чадаж байна. Судалгааг лабораторийн орчинд хийсэн ба бодит талбар дээр турших нь судалгааны дараагийн алхам болно.

Дроны хязгаарлагдмал хүчин зүйл нь технологи биш, харин хүний шууд хяналтгүйгээр үхлийн аюултай машинуудыг ажиллуулах боломжийг олгож буй улс төрийн хүсэл эрмэлзэл юм.

Монгол улсын цэрэг, зэвсэглэлд шинэ технологи болгон нэвтрүүлэх бүрэн боломж байна.

Цаашид хиймэл оюун ашиглах замаар дроны үйл ажиллагааг улам боловсронгуй, ухаалаг болгох боломжтой байна.

Ашигласан материал:

- [1] S. Mohammad, P. Branden, D. Shayne, M. Mohammad. "Drone Path Planning and Object Detection via QR Codes" A Surrogate Case Study for Wind Turbine Inspection 2022. 10.1109/IETC54973.2022.9796739.
- [2] M. Pranoto, M. Sani, "Aerial Object Tracking System on Micro Quadrotor Drone for Crowd Detection in Small-Scale Area", Proceedings of the International Conference on Vocational Education Applied Science and Technology (ICVEAST 2023), Advances in Social Science, Education and Humanities Research 783, https://doi.org/10.2991/978-2-38476-132-6_84
- [3] Shalaw M. Abdallah, "Converting a DJI Tello Quadcopter into a Face-follower Machine using the Haar Cascade with PID Controller", Cihan University-Erbil Scientific Journal, 2023
- [4] Z. Jie-Tong, D. Xiang-Yin, "The Development of a Visual Tracking System for a Drone to Follow an Omnidirectional Mobile Robot", Drones 2022, 6, 113. <https://doi.org/10.3390/drones6050113>
- [5] P. Awang, T. Habib, P. Dessyanto. "Drone navigation system based on QR code recognition using fast component-based two-staged algorithm", E3S Web of Conferences 2024, 501. 10.1051/e3sconf/202450101013.
- [6] A. Konert, T. Balcerzak, "Military autonomous drones (UAVs) - from fantasy to reality. Legal and Ethical implications", Transportation Research Procedia, Volume 59, 2021, Pages 292-299, ISSN 2352-1465, <https://doi.org/10.1016/j.trpro.2021.11.121>.
- [7] S. Sotoudehfar, J. Sarkin, "Drones on the Frontline: Charting the Use of Drones in the Russo-Ukrainian Conflict and How Their Use May Be Violating International Humanitarian Law", ICLR, 2023, Vol. 23, No. 2.
- [8] P. Aleksandar, R. Marko. "Application of drones with artificial intelligence for military purposes", 10 th International Scientific Conference on Defensive Technologies - OTEH 2022A: Belgrade Volume: pp. 92-100
- [9] F. C. Sprengel, "Drones in hybrid warfare: Lessons from current battlefields", COI Strategy And Defence, 2021
- [10] K. Tuğrul, "Drone Technologies and Applications", DOI: <http://dx.doi.org/10.5772/intechopen.1001987>



- [11] T. G. Pledger, "The Role of Drones in Future Terrorist Attacks", Land Warfare Paper No. 137, February 2021
- [12] R. Jinjun, B. Li, Z. Zhang, D.Chen, and W.Giernacki. "Position Control of Quadrotor UAV Based on Cascade Fuzzy Neural Network" *Energies* 2022, 15, no. 5: 1763. <https://doi.org/10.3390/en15051763>
- [13] B.Rabab, J.V6s6rhelyi, "Towards Optimization of Energy Consumption of Tello Quad-Rotor with Mpc Model Implementation" *Energies* 2022, 15, no. 23: 9207. <https://doi.org/10.3390/en15239207>
- [14] M. Meurisse, "Autonomous navigation of a drone in indoor environments", Master's thesis, University of Liège, School of Engineering and Computer Science, 2021
- [15] M.Diego, D.Maria, P.Mendoza, "A Drone System with an Object Identification Algorithm for Tracking Dengue Disease". *International Journal of Advanced Computer Science and Applications*. 2022, 13. 10.14569/IJACSA.2022.0131092.
- [16] A.S.Priambodo1, F.Arifin, A.Nasuha, A.Winursito, "Face Tracking for Flying Robot Quadcopter based on Haar Cascade Classifier and PID Controller", *Journal of Physics*, 2021, DOI 10.1088/1742-6596/2111/1/012046
- [17] B.Anuparp, J.Eamsaard, "Real-Time Human Motion Tracking by Tello EDU Drone" *Sensors* 2023. 23, no. 2: 897. <https://doi.org/10.3390/s23020897>
- [18] Ц.Тэнгис, А.Батмөнх, С.Мягмар-Очир, Г.Эрхэмбаяр "Зураас дагах роботын нейрон сүлжээнд суурилсан хөгжүүлэлт", ММТ 2019
- [19] B. Masharipov, "Ryze Tello drone tracking", Bachelor's thesis title in Czech, 2022
- [20] Ts.Tengis, L.Uurtsaikh, A.Batmunkh, "Quadrotor Stabilization in Hovering Mode Based on Stereo Vision", IFOST 2020
- [21] Ts.Tengis, L.Uurtsaikh, A.Batmunkh, "Machine learning for stabilizing quadrotor's single axis using classifier decision boundary", IFOST 2020
- [22] Ц.Тэнгис, А.Батмөнх, Г.Эрхэмбаяр, "Дөрвөн сэнстийн тэнцвэржилтийг машин сургалтын бататган сурах аргаар шийдэх нь", ММТ2020



VIII БОГД ЖАВЗАНДАМБА ХУТАГТЫН ТУСГААР ТОГТНОЛОО ОЛОН УЛСАД ХҮЛЭЭН ЗӨВШӨӨРҮҮЛЭХ ДИПЛОМАТ ГАДААД БОДЛОГЫН ЗАРИМ АСУУДАЛ

И.ӨЛЗИЙСАЙХАН /УБХИС-ийн ЦХПК-ын багш, доктор (Ph.D)/

Түлхүүр үг: Дипломат, геополитик, консул, төр, улс, шашин, гэрээ, хувьсгал, үндэстэн

Key words: Diplomacy, geopolitics, consul, state, country, religion, contract, revolution, nationality

Оршил. XX зууны эхэн үед удаан үргэлжилсэн зөрчилдөөнтэй хямралт байдлыг даван туулж, олон Монголчууд эвлэлдэн, тусгаар тогтносон нэгдмэл нэг улсыг байгуулан түүнийгээ батлан хамгаалах зорилго-үзэл санаа өгүүлэн буй үеийн нийгэм-улс төрийн сэтгэлгээний гол чухал хандлага болон хүчтэй товойн гарч ирсэн тухайд болон VIII Богд Жавзандамба хутагтын тусгаар тогтнолоо олон улсад хүлээн зөвшөөрүүлэх, дипломат гадаад бодлогын зарим асуудлыг энэхүү өгүүлэлдээ тодруулахыг зорив.

Үндсэн хэсэг. Азидаа хамгийн түрүүнд 1911 онд Монгол Улс өөртөө засан тохинох тусгаар эрхтэй, бие даасан, бүрэн эрхт улс болохоо илэрхийлж тусгаар тогтнолоо зарлалаа. Гадаад олон улсын харилцаанд анхлан гарч ирэх асуулт, гадаад бодлого бол дэлхийн олон улсууд үүнийг хэрхэн яаж хүлээж авсан бэ, одоо дэлхийд хандах ёстой. Өмнө талд мөн шинээр бий болсон Дундад Иргэн Улс байгаа бөгөөд эхлээд хөрш орнуудаараа тусгаар тогтнолоо хүлээн зөвшөөрүүлэх дипломат бодлого шаардлагатай болсон юм.

1 дүгээр хүснэгт.

Богд хаант Монгол улсын тусгаар тогтнолын талаарх бусад гүрнүүдийн байр суурь

Дундад Иргэн улс	VIII Богд Жавзандамба тэргүүтэй хэсэгхэн ноёд, дээд лам нар Хаант Орос улсын улс төрийн явуулга, арга мэхэнд автагдаж хийсэн урван тэрслэл.
Хаант Орос улс	Тусгаар тогтнох чадавхи эргэлзээтэй. “Автономийн төлөө хөдөлгөөн”, “Автономит засгийн газар”
Япон улс	Ханддорж чин вантай хуйвалдан, Жибзундамба хутагтын нэр сүрийг

	ашигласан Оросын урьдаас төлөвлөсөн ажил явуулга.
Их Британи улс	1907 онд Оростой байгуулсан гэрээний дагуу Монголыг Оросын, Төвдийг Британий нөлөөний бүс гэдгийг хүлээн зөвшөөрсөн.
Франц улс	Хаант Орос улсын байр суурийг дэмжсэн.
Герман улс	Хятадыг хуваах гэсэн оролдлого.
АНУ	Үл тоосон
Төвд	Сайшаан зөвшөөрч 1912 онд Монгол-Төвдийн найрамдлын гэрээ байгуулсан.

ДИУ-ын ерөнхийлөгч Юань Шикайн зүгээс Богд хааныг элдвээр ятгасан, Монголыг Хятадтай нэгтгэх талаар сануулсан, сүрдүүлсэн өнгө аяс бүхий цахилгаан мэдээ илгээх болж үүний хариуд VIII Богд Жавзандамба хутагт Монголчууд язгуур угаас тусгаар улс байсан, одоо цаг нь ирж өөртөө эзэн болж буй бүхий тул Манжаас тусгаар болж тунхагласнаа мэдэгдсэн Монгол, ДИУ улс цаашид айл хөршийн хувьд харилцахыг санал болгосоор байлаа. 1912 оны хавар Юань Шикайгаас Богдод ирсэн цахилгаанд “... Гадаад Монгол, Дундад улсын иргэн төрөл лүгээ хамт хэд хэдэн зуун жилээс янагш нэгэн гэр мэт болсон... Монгол газар хэдий уудам боловч хүний тоо даанч цөөхөн. Олон монголыг нийлүүлэн бодвоос дотоод газрын нэгэн мужийн тоонд хараахан үл хүрэхийн дээр монголчуудын аж ахуй ядуу зүдүү, эд агуурс олох нь маш бага... Эдүгээ харин түшмэл байгуулах цэрэг тэжээх, зэвсэг худалдан авах олон зүйлийн сүйтгэл тулгаж гаргуулсугай хэмээн шахамдуулах болохул



урвахгүй боловч гуу сувгийг дүүртэл унаж үхмүй... Хутганы ишийг урвуулан барьсан мэт. ... олон аймгийн сумны эр харвуул, намналыг мэдэхийн төдий илд жадыг ч харахан хэрэглэж үл чадах бөгөөтөл буу, үхэр буга юун өгүүлэх аж. ...Засаг цаазыг хэлэлцэх болбаас даруй эрхэм овгийн хууль бас засгийг явуулах, цаазыг захирах явдлыг олон хойгийн хүчирхэг улс лугаа үлгэрлэвээс хэрхэвч адил болж үл чадах тул өөртөө тогтноход нэн ч бэрхтэй. Тэр ч байтугай олон монгол одоо ер бүрмөсөн дагалдан чадаагүй. Эрхэм баламын сүр цааз хүрэлцэх нь Түшээтхан, Сэцэнхан, Сайн ноён гурван аймгийн төдийхөн болохын дээр сонсвоос мөн ч бүрмөсөн дагалдаагүй. ... Олон монголчууд хятад лугаа зах нийлэн сууж харилцан туслалцаас харин улс төрд тустай бөгөөд нийлэлцвээс хоёр этгээдэд ашиг буй. Салалцаас хоёр этгээдэд хор хохирол буй... Гэмт засгийг... шүүрдэн арилгах болой. ... Хэрхэвч бээр бүү гажуу үгэнд баширлагдан Гадаад Монголд мохошгүй гэмшлийг хоцоотугай! хэмээн чин үнэнхүүг гүйцэтгэж ухуулан илгээв. Даруй хариу ирүүлмү..."¹ хэмээн сүрдүүлсэн, дорд үзсэн, тусгаар тогтнолыг төлөөх үзэл санаа, үйл ажиллагааг илтэд буруутгасан цахилгаан ирүүлсэн ба үүний хариуд VIII Богд Жавзандамба хутагт мэргэн цэцэн хариу өгч "Толгойн үс олон боловч ганцхан тонгоргоор хусдаг... ДИУ тавган дээр хураасан өндөг мэт. Тариа будаа олон боловч нэг тахиа л тоншдог"² гэсэн үг хэлж шууд ДИУ-тай эн зиндаанд харьцаж, адилхан Манж Чин улсын дарлалаас салж байж бие биеэ дэмжиж ажиллах ёстой гэж дипломат аргаар хэлж байв. Үүний тод илэрхийлэл нь VIII Богд Жавзандамба хутагтын хариу цахилгаанд "... айл ойрх байдал нь овоолсон өндөг мэт дөрвөн зүг туслах хүнгүй ... Дундад улс говьд хол алслагдсан тул ташуур хэдий урт боловч хүрэлцэхгүй, цэрэг иргэн хэдүй олон боловч хэрэглэх газаргүй..."³ гэх мэт юм.

VIII Богд Жавзандамба хутагтаас Юан Ши Кайд тусгаар байдлаа эрс илэрхийлж илгээсэн

цахилгаан мэдээнүүдийн агуулгад ерөнхийдөө Монгол улс тусгаар улс болон зарласан тухайн учир шалтгаан, Манжийн дор зовж зүдэрсэн байдал, улс төрийн байдал түгшүүртэй байгаа ч гаднын нөлөөллөөр бус өөрсдийн чин хүслээр улс орон газар нутгаа бүрэн бүтэх болгох, шашин соёлоо бататган бэхжүүлэх эрмэлзэл, тусгаар улс болох үйл хэрэг нь нэгэнт эхэлсэн тул зогсоох боломжгүйг өгүүлсэн, Монгол хятад хоёр улсын ирээдүйн хөрш найрамдалт байдлыг бодолцоод Монголчуудын зорилго үйл хэрэгт саад хийхгүйгээр хятадын тойргоос гаргахыг далд утгаар шаардан Монголын тусгаар тогтнолыг үгүйсгэх гэсэн ДИУ-ын санаархлыг эрс няцаасан шинж чанар илэрхий мэдэгдэж байна.

VIII Богд Жавзандамба хутагт 1912 онд Оросын хаант явуулсан бичигтээ ч Монгол бол ДИУ-с огт хамааралгүй бие даасан тусгаар түүх уламжлалтай улс гэдгээ онцлон "...Ер нь Хятад улсыг анх хаант төр байгуулснаас нааших 5000 илүү жил болтол манай Монгол тэдэн дор захирагдах байтугай найрамдан явсан удаа үгүй..."⁴ гэж дурдсан байдаг.

1912 оны нэгэн цахилгаанд "... Монголчууд Дайчин улсын засгийн ёсон төвгүй болж, шар шашны ёсонд их харштай, хүний сэтгэлэг амаргүй гашуун болсон байдлыг айл улсад хэлж, олноор зөвлөлдөн, багш Богд гэгээнээ шашин төрийг хослон баригч хаанд өргөмжилж, улсын нэрийг Монгол хэмээн нэрийдэж, ойр залгаа олон газар сонсгон зарласныг нэгэнт толилсон буй за... Гагцхүү манай монголчууд угаас тусгай улс бөлгөө. Иргэн хүн лүгээ зан суртал, шүтэх ёсон, аж ахуй, нутаг газрын амьсгал чанх өөр... Одоо ч иргэд бидний Монголын шар шашны ёсыг дагаж, хуучнаа халахгүй болбоос, манай монголчууд хэрхэвч бээр иргэний сурталд орж, шар шашны үнэн гол ёсоо гэж чадахгүй. Хэдийгээр танай иргэн хүн журмыг үүсгэн улсын засгийг засаж бүгдийн тэргүүн байгуулна

¹ Н.Магсаржав. Монгол Улсын шинэ түүх. УБ., 2010. тал 30–32.

² Д.Өлзийбаатар. Монголчууд. Цахим түүх. УБ 2015. 3-р бүлгийн 12-р хэсэгт.

³ Н.Магсаржав. Монгол Улсын шинэ түүх. УБ., 2010. тал 32–33.

⁴ Д.Чулаанжав. Монголын түүхийн философи. УБ., 2014. тал 7.



хэмээвч, чухамдаа хоёр ёсыг нэвтэрхий ухаж шар шашны хамтаар барьж эгнэгт чадахгүй нь үнэхээр үлгэрлэвээс, шашин төр хэмээгч эцэг эхийн адил, хүн амьтан түүний хөвгүүн мэт. Тэр самуурваас хөвгүүд хүмүүжин чадахгүйн адил болуузай хэмээнэ... Иймийн тул, бид өөртөө тусгай улс байгуулсан болой. Ер эрх мэдэл, эд агуурс тэмцэхийн төдийхөн аар саар хэрэг бус... их хэргийн тул болой... Нэг ч хүний амийг хөнөөсөн явдалгүй... Эрхэм улс лугаа харилцан найртай ёсоор ханилж, тус тусдаа газар нутгаа эзэлж, өөр өөрийн шашин, төрийн ёсыг хамгаалахад хүрэхүй болов уу..."⁵ хэмээн бичсэн нь ДИУ-ын зүгээс Монголыг өөрийн нэгэн муж мэт үзсэнийг няцаан, Манжийн төрийн эрхшээсэн үед Монголчуудын амьдрал, ард олны амьдрал хэцүү гашуун, уугуул шашин шүтээнд ээлгүй харш байсан тухай өгүүлээд, Монголчууд нэгдэж Богд хаанаа ширээнд залж, Монгол улсаа сэргээн мандуулж, Манжийн төр засаг захиргаанаас нэгэнт хамааралгүй болон тусгаар тогтносноо олон улсуудад тунхагласныг сануулаад, Монгол, Хятад хоёр үндэстэн язгуураасаа тус тусдаа улс, бид хятадуудаас зан суртахуун, шашин шүтлэг, эрхлэх аж ахуй тэс өөр, нутаг орны байгаль цаг агаар ч эрс өөр учраас цаашид Монгол, Хятад хоёр нэгэн төрийн дор орших учиргүй гэдгийг маш тодорхой эрс тайлбарласан хэрэг байлаа. Энд Монголчуудын тусгаар тогтнол, хэнээс ч хамааралгүй тусгаар улс байгуулсан явдал нь хэн нэгний эрх мэдэл, эд баялгийн төлөө хийсэн хэрэг бус харин ард иргэдийнхээ эрх ашиг, хойчийн сайн сайхан ирээдүйн төлөө хийсэн их хэрэг мөн болохыг нотлон шинэ байгуулагдсан Монгол улс хүний амь насыг үл хөнөөн, хөрш улсуудтайгаа харилцан найрамдалтайгаар оршин тогтнох бодлоготойгоо илэрхийлж, ДИУ-д Монгол газар нутаг руу өнгөлзөхөө зогсоож түүхээс оноогдсон тус тусдаа газар нутгаа эзэлж, өөр

өөрийн төр ёсоо сахин байхыг сануулсан өнгө аястай байна.

Хоёр улс харилцан цахилгаан бичиг солилцсоны сүүлээр ДИУ-ын хандлага өөрчлөгдөн сүрдүүлсэн бус ятгасан, Монгол тусгаар байдлаа орхих тухайд хэлэлцээ хийх санал тавьсан шинж чанар агуулгатай болж ирсэн байна. Энэ тухайд доктор О.Батсайхан "Хятад Монгол хоёр хоорондоо бичиг цахилгаан солилцсоны эцэст 1912 оны 4 дүгээр сарын эхээр ДИУ-ын Засгийн газраас ирүүлсэн цахилгаандаа: Чин улсын үеийн өмнөх бурангуй ёс өнгөрсөн, эрх чөлөөт таван угсаатны Бүгд найрамдах улс тогтов, Монгол салан тусгаарлах нь ашиггүй гэсэн санаагаа дахин давтаж, Монгол тунхагласан тусгаар тогтнолоо цуцалж, ДИУ-тай нэгдэх хэрэгтэй. Үүний тул хоёр талын хэлэлцээ хийе гэж мэдэгджээ. Монголын засгийн газар энэ цахилгааныг хүлээж аваад нэгэнт олж авсан тусгаар тогтнолоо цуцлах хэлэлцээ хийхийг эрс татгалзсан хариу өгчээ. Монголчууд өөрийн тусгаар тогтнол, үндэснийхээ бие даасан байдлын төлөө тууштай зогсохоо хятадуудад илтгэн харуулсан юм"⁶ гэж бичжээ. 1912 онд Өвөр Монголын дайчин хамба Сэдбалжир гэгчийг Их хүрээнд очуулж, Өвөр зургаан чуулганы өмнөөс хэрэг хэлэлцүүлэх гэснийг Монголын засгийн газар ганц түүнтэй хэрэг хэлэлцэхгүй хэмээн буцааж байсан бол Бээжингээс Халхын Сэцэн хан аймгийн засаг ван Доржпалам нарыг хүрээ рүү томилон явуулж Монголыг Дундад улстай найрамдуулах хэлэлцээ хийлгүүлэх гэсэн оролдлогыг ч бас Монголын засгийн газар хүлээж аваагүй юм⁷.

1912 онд Хүрээнд байгуулагдсан Монгол-Оросын найрамдлын гэрээ нь Хятадын дургүйцлийг хүргэсэн юм. Хятадын сонин "Хэрэв Хятад татгалзах аваас энэхүү хэлэлцээр нь ямар ч хууль ёсны болж чадахгүй" гэх буюу

⁵ Богд хаант Монгол Улсын Дотоод яамны сайдаас Дундад Иргэн Улсын Дотоод яаманд явуулсан цахилгаан мэдээнээс. 1912 он, Монголын Хууль тогтоомжийн түүхэн эмхэтгэл. II боть (1911–1926. V сар) УБ., 2010. тал 30–31: Монгол Улсын Засгийн газрын Хэрэг Эрхлэх газар. Засгийн газрын ажлын алба (1911–2011). УБ., 2011. тал 230.

⁶ О.Батсайхан. Монголын тусгаар тогтнол ба Хятад, Орос, Монгол гурван улсын 1915 оны Хиагтын гэрээ. УБ., 2007. Тал 52.

⁷ О.Батсайхан. Монголын тусгаар тогтнол ба Хятад, Орос, Монгол гурван улсын 1915 оны Хиагтын гэрээ. УБ., 2007. Тал 98.



Хятад Монголын эсрэг, бүр оросуудын эсрэг дайн зарлавал таарна гэж бичиж байжээ⁸. 1912.11.14-ны ДИУ-ын Засгийн газрын хуралдаанаар Орос-Монголын хэлэлцээрийн тухай асуудлыг авч хэлэлцээд энэхүү гэрээг хүлээн зөвшөөрөхөөс татгалзаж, Монголын тусгаар тогтнолыг нухчин дарах цэрэг илгээх дайны хөтөлбөрийг баталж, Монголын хилд ойр орших бүх мужийн захирагч нарт хүргэсэн бөгөөд энэхүү хөтөлбөрийн дагуу Шиньжиянаас 20 000 цэрэг хөдөлгөсөн байна⁹. Үүнд Оросын засгийн газар эсэргүүцэл илэрхийлж, Монголтой мөргөлдөнө гэдэг бол Орос оронтой шууд дайнд орно хэмээсэн үг гэжээ. Төв Азид дайн гарч болох хямралын байдал бий болов. Оросын холбоотон болох Англи, Япон ч дуугүй байсангүй, тэд Хятадын Засгийн газарт Орос улстай эвлэрч, хэлэлцээр хийхийн чухлыг ойлгуулж чадав. Иймээс Юань Шикай 1913.01.02-нд цэргээ Монголын хилээс татах тухай тушаал өгөхөд хүрсэн байна¹⁰.

Монголчуудын тусгаар тогтнолын асуудлаар Хятадад тогтож байсан уламжлалт болон шинэ хоёр засгийн газар адилхан байр суурийг баримталж байсан нь баримт материал, судлаачдын дүгнэлтээс тодорхой харагдаж байгаа бөгөөд тэдгээр Засгийн газруудын гаргасан тунхаг, зарлиг, хууль тогтоомж, Богд хаант Монгол улсад ирүүлсэн олон удаагийн цахилгаан утас, Монгол, Хятад төрийн тэргүүнүүдийн хоорондоо харилцсан байдлаас үзвэл Манж, Хятадын зүгээс Үндэсний эрх

чөлөөний хувьсгал, тусгаар тогтнолын төлөө хийсэн Монголчуудын тэмцлийн хүчийг сарниулах, задлан бутаргах гэсэн явуулга, үйлдэл бүрэн илэрхийгээр харагдаж байна. Ийнхүү ижилхэн шинээр байгуулагдсан боловч өөрсдийгөө Манжийн төрийн өв залгамжлагч хэмээн эндүүрсэн ДИУ Манжийн нөлөөнд байсан бүх улсууд шинэ байгуулагдсан хятадын бүрэлдэхүүнд байх ёстой гэсэн байр сууринаас Богд хаант Монгол улсад хандаж эхэлсэн нь тусгаар тогтнолоо олон улсад хүлээн зөвшөөрүүлэх гэсэн Монголчуудын бодлого үйл ажиллагаанд бодитой бэрхшээл үүсгэсэн байна. Төрт улсаа шинээр сэргээн мандуулсан ч Богд хаант Монгол улс түүнийгээ олон улсын эрх зүйн чиг хандлагын дагуу гадаад орчинд, юуны өмнө Хаант Орос улс, ДИУ хоёроор хүлээн зөвшөөрүүлэх, найдвартай батлан хамгаалах шаардлагатай байлаа. Төв Азид тусгаар Монгол улс бий болсон нь бодит үйл явдал мөн боловч цаашдын ирээдүй нь зөвхөн дотоод хүчин зүйлээс хамаарахгүй бөгөөд дэлхийн олон улсуудад тусгаар тогтнолоо хүлээн зөвшөөрүүлэх, гадаад хүчин зүйлээс ихээхэн хамааралтай байв. Тухайн үеийн Богд хаант Монгол улсын гадаад олон улсын байдал эгзэгтэй, тусгаар тогтнолоо хүлээн зөвшөөрүүлэх, дэлхийн олон улс орнуудтай эн тэгшээр харилцах боломж бий болгох эсэх нь төрийн түшээдийнх нь улс төрийн үйл ажиллагааны зөв холч бодлого, уужуу ухаанаас ихээхэн хамаарахаар байв.

2 дугаар хүснэгт.

Богд Хаант Монгол улсын тусгаар тогтнолтой холбоо бүхий олон улсын гэрээ хэлэлцээрүүд			
Огноо	Олон улсын гэрээ, хэлэлцээр	Агуулга	Үр дүн
1907.07.30	Хаант Орос-Японы гэрээ	Солонгосын хойг дахь Японы тусгай эрх ашгийг Орос, Гадаад Монгол дахь Оросын тусгай эрх ашгийг Япон хүлээн зөвшөөрсөн	Монгол дахь нөлөөний хүрээгээ Ар, Өвөр Монголоор хуваарилсан

⁸ АВПРИ., ф.Китайский стол., д.631., л.51: О.Батсайхан. Монголын тусгаар тогтнол ба Хятад, Орос, Монгол гурван улсын 1915 оны Хиагтын гэрээ. УБ., 2007. Тал 98.

⁹ Белов.Е.А. Реакция в Китае на русско-монгольское соглашение 1912 года Проблемы Дальнего Востока., М., 1994, Ио 4: О.Батсайхан. Монголын тусгаар тогтнол ба Хятад, Орос, Монгол гурван улсын 1915 оны Хиагтын гэрээ. УБ., 2007. Тал 98.

¹⁰ АВПРИ., ф.Китайский стол., д.631., л.51: О.Батсайхан. Монголын тусгаар тогтнол ба Хятад, Орос, Монгол гурван улсын 1915 оны Хиагтын гэрээ. УБ., 2007. Тал 98.



1910.07	Хаант Орос-Японы хоёр дахь нууц гэрээ	1907 оны гэрээнийхээ байр суурийг дахин нотолж, тусгай сонирхлоо бэхжүүлэн бататгахыг хэрхэвч үл эсэргүүцэхээр тохиролцсон	Монгол дахь нөлөөний хүрээгээ Ар, Өвөр Монголоор хуваарилсан
1912.07.08	Хаант-Орос Японы нууц конвенци	2-р зүйл Ар, Өвөр Монголыг бээжингийн өргөргөөр (Гринвичийн 116°27') Орос, Японы нөлөөний хүрээ гэж хуваасан	Орос Монголыг Хятадаас бүрмөсөн тусгаарлуулахгүй өөртөө засах эрхтэй болгож, хараандаа барьж байх боломж
1912.11.03	Монгол-Оросын найрамдлын гэрээ	Худалдааны эрх, хаан, Засгийн газар, цэрэг, “өөртөө тогтнож, өөртөө эзэрхэх” хятад цэрэг орохгүй байх	Хиагтын гэрээний үндэс, олон улсын харилцаанд эзлэх статусыг тодорхойлсон
1913.01.11	Монгол-Төвдийн найрамдлын гэрээ	Тусгаар тогтнолоо харилцан хүлээн зөвшөөрч, шашин, найрамдал, туслалцах, худалдаа	Бага улсын хоорондох гэрээ нь Монголын дипломатын түүхэнд шинэ зүйл
1913.11.05	Орос-Хятадын Бээжингийн тунхаглал	Орос ДИУ-ын Гадаад Монгол дахь сюзеренитет эрхийг хүлээн зөвшөөрч, автономит эрхийг нь ДИУ хүлээн зөвшөөрсөн	Монголд Хаант Орос болон ДИУ-ын эрх ашигтай холбоотой асуудал бий болсон тухай бүрд зөвхөн гэрээлэгч хоёр улс хэлэлцэн шийдвэрлэнэ
1914.08.25-1915	Хятад, Орос, Монгол гурван улсын Хиагтын гэрээ	Тусгаар тогтнолыг Хятадын автономоор хязгаарлаж нэгдсэн Монголын асуудалд цэг тавьсан, Урианхайн хязгаар, Өвөр Монгол орхигдсон.	1945 оны Ялтын бага хурлын статускво гэрээний үндэс, Монгол хуваагдмал улс болсон ОУ-ын эрх зүйн үндэс. Геополитикийн томоохон сүйрэл.
1919.11.22	Монголын автономит эрхийг халсан	1917-1919 онд Орост хаант засаг унаж Сибирь, Алс Дорнодод зөвлөлдчих, иргэний дайн дэгдэх явцад “Хиагтын систем” задарсан. Олон улсын нөхцөл өөрчлөгдөж өмнө гэрээг хүчингүйд тооцсон.	Автономит эрх алга болж тусгаар тогтнолоо дахин алдсан. Хятадыг эрхшээлд орсон ганцхан тохиолдол (2 жил)

Дүгнэлт. VIII Богд Жавзандамба хутагт ба тухайн үеийн Монголын төрийн түшээдийн нийгэм-улс төрийн сэтгэлгээг авч үзэхэд, тэд олон улсын харилцаанд оролцож, гадаад бодлогын аливаа шийдвэрийг гаргахдаа гаргасан шийдвэрийнхээ ололт, алдаа хоёрын харьцааг сайтар тунгаан бодож, хэрэгжилт үр дүнг сайтар бодолцон, юуны өмнө Монгол үндэстний эрх ашигт хэрхэн нөлөөлөхийг урьтал болгон харж, үүнийгээ үйл ажиллагааныхаа гол баримжаа, үнэт зүйл болгосон нь тодорхой харагдаж байна. Үүгээрээ үүнээс хойших Монголын аль ч төр засгийн гадаад бодлогын хамгийн гол баримтлах үнэт зүйл бол улс үндэстэн, ард түмний эрх ашиг байх ёстой гэсэн үзэл санааны язгуур үндсийг улам баталгаажуулж үлдээсэн.

VIII Богд Жавзандамба хутагт 1911 онд

Монгол улс ДИУ хандаж тусгаар тогтнолоо зарлаагүй, хараахан бүрэн нурж амжаагүй байсан Манж Чин улсад хандан тусгаар тогтнолоо зарласан хийгээд энэ логигоор Монголчуудыг харьяалан захирч байсан улс бол Дундад Иргэн бус Манж Чин улс байсан. Тиймээс ДИУ бол Манжийн өв залгамжлагч биш бөгөөд Монголтой адилхан харийн дарангуйлалд байсан, хоёр ард түмэн тус тусдаа тусгаар тогтносон учир цаашид хөрш улсын ёсоор эрх тэгш харилцан оршин тогтноно, тусгаар тогтнолоо юугаар ч солихгүй гэсэн үзэл санааг хатуу тууштай баримталж, улсаа Манж Чин гүрнээс тусгаарлан, батлан хамгаалснаас гадна шинээр гарч ирсэн ДИУ-д эх орноо алдаагүй явдал нь геополитикт маш чухал ач холбогдолтой.

**Ашигласан материал:**

1. Батбаяр Ц. XX зууны Монгол улсын гадаад харилцаа °2. Монгол ба Түвд XX зууны эхээр (XIII далай лам Түвдэнжамц, VIII Богд Жибзундамба, Агваан Доржиев) УБ., 2015
2. Батсайхан О. Монгол үндэстэн бүрэн эрхт улс болох замд (1911-1946). УБ., 2007
3. Батсайхан О. Монголын тусгаар тогтнол ба Хятад, Орос, Монгол гурван улсын 1915 оны гэрээ (1911-1916). УБ., 2007
4. Батсайхан О. 1911 оны үндэсний хувьсгал Монголын сүүлчийн эзэн хаан VIII Богд Жавзандамба. УБ., 2008
5. Коростовец И.Я. Монголд өнгөрүүлсэн есөн сар. (Монгол дахь Оросын Бүрэн эрхт төлөөлөгчийн өдрийн тэмдэглэл. 1912 оны 8-р сараас 1913 оны 5-р сар) УБ., 2010
6. Магсаржав Н. Монгол улсын шинэ түүх. УБ., 2010
7. Монгол судлалын өгүүллүүд. УБ., 2019
8. Монголын ард түмний 1911 оны үндэсний эрх чөлөө, тусгаар тогтнолын төлөө тэмцэл, баримт бичгийн эмхэтгэл. УБ., 1982
9. Монголын төрийн байгуулал улс төрийн сэтгэлгээний хөгжил (МЭӨ III-МЭ XX зуун) тэргүүн, хоёрдугаар боть. УБ., 1995
10. Монголын тусгаар тогтнол ба Монголчууд. УБ., 2012
11. Монголын түүхийн дээж бичиг ° 3. УБ., 1992
12. Монголын түүхийн дээж бичиг ° 4. УБ., 1992
13. Монголын түүхийн эх сурвалж (1911-1921). УБ., 2010
14. МҮОНТВ ШУА Түүх археологийн хүрээлэн, “Монголын түүх” цуврал нэвтрүүлэг 2020.07.21 өдрийн дугаар (Академич Чулуун С, МУИС түүхийн тэнхимийн багш, түүхийн ухааны доктор профессор, шинжлэх ухааны гавьяат зүтгэлтэн Урангуа Ж, Түүх археологийн хүрээлэн Орчин үеийн түүхийн салбарын эрхлэгч доктор, профессор Мягмарсамбуу Г, Түүхийн шинжлэх ухааны доктор Батбаяр Ц)
15. Олон улсын эрдэм шинжилгээний хурлын илтгэлийн эмхэтгэл. Эмхэтгэсэн Чулуун С. (2011 оны 12 сарын 9-12). УБ., 2012
16. Өлзийбаатар Д. Монголчууд-цахим түүх. УБ., 2015
17. Пунцагноров Ц. Монголын автономитын үеийн түүх. УБ., 1955
18. Төмөрхүлэг Т. Франц болон бусад гадаад хэлээрх Монголын түүхийн холбогдолтой баримт бичгийн эмхтгэл. Эмхтгэн орчуулсан. УБ., 2006
19. Төмөрхүлэг Т. Орос, Монгол, Хятад: Улс төр, дипломатын харилцаа. УБ., 2016
20. Төмөрчулуун Г. Монголын гадаад бодлого, XX, XXI зууны зааг дээр. УБ., 2016
21. Төмөрчулуун Г. 1911 оны үндэсний эрх чөлөөний хувьсгалын үеийн олон улсын нөхцөл байдал (Гадаад харилцааны яаманд болсон эрдэм шинжилгээний бага хуралд тавьсан илтгэл. УБ., 2016.12.23).
22. Урангуа Ж. XX зууны эхэн үеийн Монгол улс (1911-1919). УБ., 2010



МОНГОЛ ЦЭРГИЙН УРЛАГИЙН ТҮҮХ БИЧЛЭГИЙН АСУУДАЛД

Ч.СОСОРБАРАМ /УБХИС-ийн ЦНДС-ийн багш, доктор (Ph.D), дэд профессор/

Түлхүүр үг: Тусгаар тогтнол, бүтээл, цэргийн түүх, баримт

Key words: Independence, book, military history, facts

Оршил. Түүх бичлэгийн судалгаа нь судлаач эрдэмтдээс баримтуудын утга санааны боломжуудын тодорхой хэсгийг оюуны соёлдоо шингээн бүтээлчээр хэрэглэж ойлголтыг бий болгодог. Өнөө үед монгол цэргийн урлагийн түүх бичлэгийн судалгааг хийх шаардлага тулгарч байна. Иймд энэ өгүүлэлд монгол цэргийн урлагийн түүх бичлэгийн талаар өгүүлэхийг зорилгоо.

Үндсэн хэсэг. Тусгаар тогтнолоо сэргээсэн монголчууд 1911 оноос шинэ тутам байгуулагдсан Богд хаант улсын цэргийн талаар, ялангуяа цэргийн байгуулалт урлагийн талаар анхаарч эхэлж байсныг Цэнд гүний “Нууц товчооны анхны орчуулга”, Манлай баатар Дамдинсүрэнгийн “бодрол” өргөх бичгүүд¹, Өвөр Монголын Алтан–Очирын “Богд Чингис хааны байлдааны бичиг”², Эрдэмбатын цэргийн урлагийн талаарх бүтээлүүд гэрчилдэг.

1912 оны 12 дугаар сарын 28–нд Монгол Улсын цэргийн зохион байгуулалтын үндсийг тодорхойлсон 23 зүйл бүхий “Дайчилсан болон илгээсэн цэргийн дагаж явах түр дүрэм”-ийг баталж мөрдүүлэв. Энэ бол Монгол улсын цэргийн зохион байгуулалтын зарчим, байлдах арга ухааныг тодорхойлсон анхны эрх зүйн бичиг юм.

Үндэсний ардчилсан хувьсгалын эхний

жилүүдэд Магсар хурцын бичсэн “Монгол ард улсын засаг төрийн байдал хэрхэн уламжилсан явдлыг тайлбарласан бичиг”, А.Амар “Монголын товч түүх”, Ж.Цэвээн³, Д.Нацагдорж⁴, Л.Дэндэв⁵ нарын түүхийн бүтээлүүд шинэ үеийн хэлбэр агуулгаар бичигдсэн түүхэн бичлэгийн эхлэлийг тавьж, эртнээс нааш туурга тусгаар оршиж ирсэн Монгол Улсын эрт эдүгээгийн түүх, төрийн тусгаар тогтнолоо хамгаалсан түүх, үндэсний аюулгүй байдлын холбогдол бүхий асуудлыг ч хөндөж тавьсан бүтээлүүд юм.

Намтар судлалын чиглэлээр түүхч Ц.Пунцагноровын Сүхбаатар, Чойбалсан, Дилав⁶ нарын тухай бичиж байсан бол түүхч З.Лонжидын Д.Сүхбаатар, Х.Чойбалсан, Ю.Цэдэнбал, Лаварын Сумьяа, Ц.Жигжиджав, Магсар хурцын Дугаржав, Наваандоржийн Жадамбаа, Магсар хурц, Бавуужав баатар нарын түүхийг түүний сүүлийн үеийн “Түүх сөхөхүй” 2011 оны номд 1921 оны хувьсгалын удирдагчдын намтар бичигджээ.

1921 оноос хойш Х.Чойбалсангийн ардын хувьсгал, цэргийн түүх, жанжин Г.Дэмидийн(цэргийн дарга Өлзийбат) бичсэн “Улаан цэргийн хөгжсөн түүх” зэрэг нь цэргийн түүхийн анхны бүтээлүүд байсан. Нам төрийн удирдагчид байсан Ц.Дамбадорж “Толбо нуур”, Н.Жадамбаа⁷ Оросын судлаач Иванины

¹ 2012 оны 3 дугаар сарын 11. Гадаад яамны дэд сайд Дамдинсүрэн Богд хаанд эхний бодрол бичгээ өргөн барив. Уг бичигт Монгол улсын улс төр, гадаад харилцаа, цэрэг, эдийн засаг, соёл боловсролыг хөгжүүлж, тус улсын тусгаар тогтнол, аюулгүй байдлыг бататгах талаар тодорхой саналууд дэвшүүлжээ. 2013 оны 2 дугаар сарын 4–нд. Манлайбаатар Дамдинсүрэн Богд хаанд хоёр дахь бодрол бичгээ өргөн барив. Уг бичигт Монгол улсын улс төр, нийгэм, эдийн засгийг хөгжүүлэх талаар олон санал туссаны дотор олон улсын жишгээр цэрэг, эдийн засаг, хууль цаазыг шинэчлэх замаар тусгаар тогтнол, аюулгүй байдлаа бэхжүүлэх асуудал гол байр суурь эзэлж байв.

² Алтан–Очир. “Богд Чингис хааны байлдааны бичиг” А.Пунсаг нар хөрвүүлсэн. УБ., 2020

³ Ж.Цэвээн “Монгол улсын түүх, түүвэр зохиолууд”. Хэвлэлд бэлдсэн С.Идшинноров. УБ., 1987 он

⁴ Д.Нацагдорж “Монгол түүхийн товч. Бичиг соёлын өвөөс” Хэвлэлд бэлдсэн З.Лонжид. УБ., 1984 он

⁵ Л.Дэндэв “Монголын товч түүх” УБ., 1934 он.

⁶ Дээр нь Латтимор, Ш.Бира, Рерих нарын тухай бий

⁷ Х.Чойбалсан, Ц.Дамбадоржаа “Толбо нуур”, Н.Жадамбаа нар автономтын үед Оросын гимназид анх суралцсан 14–ын ангийнхан



бүтээлээс монгол цэргийн урлагийн талаарх хэсгийг орчуулсан байдаг. Ялангуяа А.Амарын Чингис хааны тухай бүтээлд монгол цэргийн урлаг, байлдааны талаарх анхны дорвитой үнэлэлт, дүгнэлтүүд хийгджээ.

Дайны жилүүдэд Х.Чойбалсангийн үүргийн дагуу Ц.Дамдинсүрэнгийн Нууц товчооны анхны яруу сайхан орчуулга олон нийтэд хүрч байв⁸.

1959 онд “Цэргийн түүх боловсруулах секц БНМАУ–ын Цэрэг ба Нийгмийг аюулаас хамгаалах яамны сайдын тушаалаар байгуулагдаж байв”⁹. Анхны эрдэмтэд судалгаагаа МАХЦ–ын түүх, Халх голын байлдаанаар эхлүүлж байжээ.

1979 онд МАХН–ын тогтоол, БХЯ–ны сайд Ж.Авхиагийн тушаалаар цэргийн эрдэм шинжилгээний хүрээлэн байгуулагджээ. 1990 он хүртэл манай цэргийн сургуулиудад монгол цэргийн түүх, цэргийн урлагийн талаар хичээл заадаггүй ЗХУКН–ын түүх, МАХН–ын түүх л заадаг улсын шалгалт авдаг байсан.

1990 оноос өмнө Ч.Жүгдэр¹⁰ “Чингисийн төрийн үзэл, цэргийн урлаг”, А.Дамдинсүрэн “Монгол зэвсгийн товч түүх (НТӨ III зуунаас 1916 он)”, номууд гарч байжээ. 1990 оноос Д.Майдар¹¹ “Чингис хаан ба Монгол гүрэн”, Ш.Нацагдорж Чингис хааны цадиг, УБ хот 1991, Ж.Болдбаатар Чингис хаан III боть “Хаадын сан” цуврал. УБ 1999 он, номууд бидний судлан буй асуудалд чухал ач холбогдолтой. Ялангуяа эрдэмтэн Ш.Гаадамбын МНТ–ны талаарх номуудад¹² Чингис хааны байлдааны ажиллагааны талаарх нэр томъёог нарийвчлан бичсэн байдаг.

Ардчиллын эхэн үед олон зохиогчтой “Чингис хааны цэргийн арга ухаан ном” 1993 онд хэвлэгдэж байжээ. Энэхүү номонд хөдөөгийн Пэрлээ, Д.Мягмар, Ж.Базарсүрэн, Б.Даваасүрэн, А.Дамдинсүрэн, Б.Амгаланбаатар, Б.Отгон–уул, И.Цоодол, Өвөр Монголын түүхч Далантай, Цэнгэлт, Жо Хэйгүй, Кан ше нар түүхийн өгүүллээ бичжээ.

Тухайн үедээ цэргийн ухааны дэд доктор байсан Д.Мягмар¹³ “Чингис хааны цэргийн түүхийг судлах түүний явуулсан аян дайн, байлдааныг тухайн цаг үетэй нь холбон тусгайлан судлахаас эхлэх ёстой. ...тэр үеийн цэрэг, армийн бүтэц, зохион байгуулалт, зэвсэглэлийг задлан, шинжилж эцэст нь нэгтгэн дүгнэх аргыг хэрэглэдэг” гээд судлах чиглэлүүдийг: –аян дайны түүх, –цэргийн байгуулалт, –цэргийн урлаг, –цэргийн зэр зэвсэг, жанжнууд, –түүх бичлэгийн судлал, эх сурвалж, эд өлгийн судлал нараас бүрдэнэ” гэж цэргийн түүх бодлогын хэлбэртэй өгүүлэл бичиж байв.

1994 онд Х.Шагдар Чингис хааны цэргийн байлдааны арга, хэлбэрээр түүхийн ухааны докторын зэрэг анх хамгаалжээ.

1996 онд БХЯ–ын сайд генерал Ш.Жадамбаа өөрөө гардан редакц хийсэн, Батлан хамгаалахын эрдэм шинжилгээний хүрээлэнгийн Цэргийн түүх судлалын төвийн хамгийн том дорвитой бүтээл бол “Монголын цэргийн түүхийн товчоон” хоёр боть зохиол юм. Эл бүтээлд Монгол цэргийн 2000 гаруй жилийн түүхийг анх удаа нэгэн бүхэллэг болгон улируулан шинжилжээ.

“Монгол цэргийн түүхийн товчоон” I боть (НТӨ III зуунаас XX зууны эхэн хүртэл)

⁸ Д.Цэрэнсодном МНТ–ны 3 дахь орчуулга хийв. Алтан товчтой харьцуулсан ЭШ орчуулга, Монгол Улсын төрийн шагнал хүртсэн. Б.Сумъяабаатар –хятад үсгийн латин галиг, монгол харьцуулалт. 1990 Д. Цэдэв – бэлгэдлийн судалгаа бичив. Т.Дашцэдэн 1985 латин үсгийн галигт буулгав.Ц.Хандсүрэн Цэнд гүний эхийг фото зургаар 1997, 2002 кирил үсэгт хөрвүүлэв. Гаадамбын Билгүүдэй “аман уламжлал”–сэдвээр эрдмийн зэрэг хамгаалав. Ш.Бира, Б.Сумъяабаатар, Д.Төмөртоого, Д. Цэдэв, Дашцэдэн, Ш.Чоймаа –Сонгомол эх. 2005 он. Дараа нь Ш.Чоймаа. Сонгомол орчуулгын шинэ хөрвүүлгэ хэвлүүлэв.

⁹ 1979 онд БХЯ–ны бүтцэд байсан МАА–ийн Улс төрийн Газрын Цэргийн түүхийн тасаг, ЗХЖШ–ын Цэргийн эрдэм шинжилгээний тасгийг нийлүүлж, 19 хүний бүрэлдэхүүнтэй Цэргийн эрдэм шинжилгээний институт болгожээ. ЦЭШИ нь БХЯ–ны бүтцэд байж байгаад 1998 оноос ЦИС–ийн бүтцэд орсон байна.

¹⁰ Ч.Жүгдэр. Чингисийн төрийн үзэл, цэргийн урлаг. УБ., 1990

¹¹ Д.Майдар. Чингис хаан ба Монгол гүрэн. УБ., 1990

¹² Ш.Гаадамба Нууц товчооны нууцаас. 1990. МНТ бол XIII зууны монголын уран зохиолын дурсгалт бичиг. Монголын нууц товчооны судлалын зарим асуудал. 1958–1961.ЗХУ–д хэл бичгийн ухааны дэд эрдэмтний зэрэг хамгаалав. 1976. Монгол Улсын төрийн шагнал хүртсэн.

¹³ Мягмар.Д Чингис хааны цэргийн түүхийг судлахын ач холбогдол, арга зүйн тухай. УБ., 1993 он

Ш.Жадамбаа, Г.Сүхбаатар, Ш.Паламдорж, Б.Даваасүрэн¹⁴ нар хянан тохиолдуулж, Д.Гомбосүрэн, Т.Эрдэнэхишиг, Ж.Базарсүрэн, Х.Шагдар, Г.Мягмарсамбуу, Г.Ариунболд нар бүлгүүдийг бичжээ.

“Монгол цэргийн түүхийн товчоон” II боть (1911–1990) Ш.Жадамбаа, М.Санждорж, Д.Гомбосүрэн, Ш.Паламдорж, Б.Бадарч нар хянан тохиолдуулж С.Гангааням, С.Ганболд, Н.Хишигт, хошууч генерал С.Гомбосүрэн нар бүлгүүдийг бичжээ. Түүнчлэн: Х.Шагдар Монголчуудын аян дайн, цэргийн урлагийн түүх (XIII зуун) I, II боть УБ 1999 он, Х.Шагдар “Сэтгэшгүй суутны цэрэглэхүй урлагийн түүх оршивой” 2006 он, Балжинням Б “Монголчуудын бүрэн түүхийн товчоон” УБ., 2005 он, 2–р боть, Ч.Сосорбарам “Монголын түүх ба хар хайрцагны бодлогын...” УБ., 2005 он, Ж.Базарсүрэн “Чингис хааны цэргийн зэр зэвсэг” УБ., 2006 он, Ш.Паламдорж “Их монгол улсын цэргийн урлаг” Улаанбаатар хот 2006 он, БХЭШХ Цэргийн түүхийн өгүүллүүд. Улаанбаатар. 2009, Ш.Насанбат Монголчуудын түүхэнд тодорсон 33 цуут жанжин УБ 2009 он, Ш.Насанбат “Монголын түүхийн эрт, эдүгээх 33 баатар эр”. УБ 2010 он, БХЭШХ. ЭШХ эмхэтгэл. “Монголын цэргийн үндэсний урлагийн уламжлал, хувьсал өөрчлөлт, хөгжлийн хандлага”. Улаанбаатар 2011, Ч.Сосорбарам “Чингис хааны геополитик” УБ., 2012 он, Х.Шагдар, Ц.Цолмон, Г.Мягмаржав “Монгол цэргийн урлаг” УБ 2015 он, БХЭШХ Ш.Паламдорж нарын. “Батлан хамгаалах стратеги” УБ хот 2017 он, БХЭШХ Ш.Паламдорж нарын. Цэргийн стратеги УБ хот 2017 он, Ж.Базарсүрэн. Т.Эрдэнэхишиг Хувилай хааны цэргийн түүх УБ 2017 он, Х.Шагдар Энэ дэлхийд эгнэшгүй эцэг, хүү гурван жанжин УБ 2019 он, Т.Сүхбаатар Алтан ордны улсын цэргийн түүх УБ 2019 он, БХЭШХ Ш.Паламдорж нарын. Цэргийн операцын урлаг УБ хот 2020 он, БХЭШХ Ш.Паламдорж нарын. Цэргийн тактик УБ хот 2021 он, Ж.Базарсүрэн. Чингис хааны цэрэг, дайтах ухаан, зэр зэвсэг УБ 2021 он, БХЭШХ Ш.Паламдорж нарын ТБ.

Мэдээллийн дайн, түүний стратеги, тактик УБ хот 2022 он, Б.Балжинням “Өвөг монголчууд хийгээд, монголчуудын үе үеийн төр улсын цэргийн зэр зэвсэг, агсаргатны уламжлал түүх” УБ 2022 он , Ч.Сосорбарам нарын. “Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын түүхийн он цагийн товчоон” УБ 2022 он зэрэг бүтээлүүд хэвлэгджээ.

Түүнчлэн С.Гангааням¹⁵ “Үндэсний эрх чөлөөний тэмцлийн талаар” ном, Б.Даваасүрэн¹⁶ “Батмөнх даян хааны талаар” бүтээлүүд, Н.Хишигт “1921–ны хувьсгал” зэрэг дорвитой бүтээлүүдээ хэвлүүлж, Г.Мягмарсамбуу “Чингис хааны хар сүлд”, “Таван замын байлдаан”, “Хатанбаатар Магсаржав”, С.Ганболд “Халх голын дайн”, Б.Батсүрэн¹⁷ түүхийн тодорхой үеүдээр дагнан судалж, профессор Ц.Дашзэвэг Сунзын “Дайтах урлаг”, Суворовын “Ялан дийлэхийн ухаан”, Ж.Мэн¹⁸ нарын номыг орчуулж, бүтээлүүдээ хэвлүүлж байжээ. Ш.Паламдоржийн “Их монгол улсын цэргийн урлаг” 2006 оны ном цэргийн урлагийн олон талыг хамруулсан, Х.Шагдар, Ж.Базарсүрэн нарын бүтээлд тулгуурласан бүтээл юм.

2011 онд “Монголын цэргийн үндэсний урлагийн уламжлал, хувьсал өөрчлөлт, хөгжлийн хандлага” сэдвээр БХИС дээр ЭШХ хийж, хэлэлцсэн бөгөөд хурлын үндсэн илтгэлд “Монгол цэргийн стратеги, Их монгол улсын цэргийн тактик” гэж юу болохыг тодорхойлох оролдлого хийж, монгол цэргийн байлдааны тактикийн ажиллагааны түүхэн баримтаас “байлдах аргууд”–ыг нэрлэжээ.

Мөн хурлын дүгнэлтэд: Нэгд: монгол цэргийн үндэсний урлаг хөгжихөд монголын цэргийн жанжнууд, монгол цэрэг, агт морьд, байлдааны зэр зэвсэг гэсэн дөрвөл нэн чухал үүрэг гүйцэтгэсэн. Хоёрт: Үндэсний цэргийн урлагийн стратеги, тактикийн төвшин дэх уламжлал, туршлага, сургамжийг сэргээн судалж, орчин үеийн онол, арга зүйг удирдамж

¹⁴ МАХН–аас цэргийн боловсон хүчин бэлтгэх талаар явуулсан бодлого, үйл ажиллагаа.УБ., 1990 тал 42.

¹⁵ С.Гангааням Монголчууд тусгаар тогтнолоо хамгаалан тэмцсэн нь. УБ., 1993

¹⁶ МАХН–аас цэргийн боловсон хүчин бэлтгэх талаар явуулсан бодлого, үйл ажиллагаа.УБ., 1990 тал 42.

¹⁷ Батсүрэн Б.1911–1913 оны Монгол цэргийн тухай өгүүллүүд. УБ., 2017

¹⁸ Жон Мэн Чингис хааны манлайлын нууц орчуулсан. УБ., 2012



болгон цэргийн ажиллагааны удирдлагын стратеги, тактикийн төвшинд нарийн боловсруулах шаардлага хэрэгцээ бий болсныг тэмдэглэжээ.

Ингээд энэхүү бодлогын хүрээнд доктор Ш.Паламдорж, генерал Ц.Дашзэвэг нарын төслийн баг “Батлан хамгаалах стратеги”, “Цэргийн стратеги”, “Цэргийн операцын урлаг”, “Цэргийн тактик” номуудыг салбарын олон эрдэмтэд, судлаачдыг оролцуулан Боловсролын яамны төслөөр бүтээжээ. Олон судлаачдын хүчээр бүтсэн дээрх судалгаанууд нь монгол улсад анх удаа стратеги, оператив, тактикийн онолын үндсийг монгол хэл дээр орчуулан нэгтгэсэн бүтээл болсон тул эрдэмтэн судлаачдын анхаарлыг ихээхэн татаж, бас мэтгэлцэх ч болжээ^{19,20}.

Цэргийн урлаг, цэргийн байгуулалт, зэр зэвсгээр туурвисан бүтээлүүдээс Олхонуд Х.Шагдар²¹ “Чингисийн цэрэг үүсэл, бүтэц,

зохион байгуулалт, байлдах арга ухаан 1178–1206”, “Д.Гомбосүрэн. “ХХ зууны эхэн үеийн Монгол Улсын цэргийн байгууламж”, Ж.Базарсүрэнгийн²² “Чингис хааны цэргийн зэр зэвсэг”–ийг дорвитой судалгаанууд гэж үздэг.

Мөн сүүлийн үед 1921, 1930 оны үеийн цэрэг улс төрийн байдал, Халх голын дайны талаар Р.Болд²³, Ц.Батбаяр²⁴ нарын олон талын мэдээлэлтэй, шинэлэг бүтээлүүд гарах болсон.

Төвчхондоо дүгнэхэд сүүлийн 30 жилд л монголчууд цэргийн түүх, урлагаа дахин өөрсдөө судлах болжээ. Цаашид Чингис хааны маневрын дайныг цэргийн урлагийн судлах зүйл болгох, монгол цэргийн дайн, байлдааны жишээ, цэргийн аугаа жанжин Сүбээдэй, Зэв нарын талаар дэлхийн цэргийн түүхийн сурах бичгүүдэд оруулах талаар манай цэргийн түүхчид, аюулгүй байдлын судлаачид хамтран ажиллах үүрэгтэй гэдгийг тэмдэглэн хэлэх нь зүйтэй.

Ашигласан материал:

1. Алтан-Очир. “Богд Чингис хааны байлдааны бичиг” А.Пунсаг нар хөрвүүлсэн. УБ., 2020
2. Ж.Цэвээн “Монгол улсын түүх, түүвэр зохиолууд”. Хэвлэлд бэлдсэн С.Идшинноров. УБ., 1987 он
3. Д.Нацагдорж “Монгол түүхийн товч. Бичиг соёлын өвөөс” Хэвлэлд бэлдсэн З.Лонжид. УБ., 1984 он
4. Л.Дэндэв “Монголын товч түүх” УБ., 1934 он
5. Ч.Жүгдэр. Чингисийн төрийн үзэл, цэргийн урлаг. УБ., 1990
6. Д.Майдар. Чингис хаан ба Монгол гүрэн. УБ., 1990
7. Мягмар.Д Чингис хааны цэргийн түүхийг судлахын ач холбогдол, арга зүйн тухай. УБ., 1993 он
8. МАХН-аас цэргийн боловсон хүчин бэлтгэх талаар явуулсан бодлого, үйл ажиллагаа. УБ., 1990 тал 42.
9. С.Гангааням Монголчууд тусгаар тогтнолоо хамгаалан тэмцсэн нь. УБ., 1993
10. Батсүрэн Б. 1911-1913 оны Монгол цэргийн тухай өгүүллүүд. УБ., 2017
11. Жон Мэн Чингис хааны манлайллын нууц орчуулсан. УБ., 2012
12. Ч.Сосорбарам “Батлан хамгаалах стратеги” номын шүүмж. Соёмбо №45 2017.11
13. Х.Шагдар. “Чингисийн цэрэг үүсэл, бүтэц, зохион байгуулалт, байлдах арга ухаан 1178-1206. УБ., 1996, Сэтгэшгүй суутны цэрэглэхүй урлагийн түүх оршивой. УБ., 2006
14. Ж.Базарсүрэн. Чингис хааны цэргийн зэр зэвсэг

¹⁹ Ч.Сосорбарам “Батлан хамгаалах стратеги” номын шүүмж. Соёмбо №45 2017.11.

²⁰ Доктор Түмэн, Онцгойбаяр нар “операцын урлаг” биш “оперативын урлаг” гэж мэтгэлцдэг.

²¹ Х.Шагдар. “Чингисийн цэрэг үүсэл, бүтэц, зохион байгуулалт, байлдах арга ухаан 1178–1206”. УБ., 1996, Сэтгэшгүй суутны цэрэглэхүй урлагийн түүх оршивой. УБ., 2006

²² Ж.Базарсүрэн. Чингис хааны цэргийн зэр зэвсэг. УБ., 2006

²³ Болд Р. Зарлаагүй дайн, УБ. 2014 он, Р.Болд Бүрэн эрхээ хязгаарлуулсан тусгаар тогтнол. УБ., НЭПКО 2021

²⁴ Батбаяр.Ц Чингис хаан ба ХХ зуун. УБ., 2023



МОНГОЛЧУУДЫН ЦЭРЭГ БИЕ ХҮНИЙГ ТӨЛӨВШҮҮЛЖ ИРСЭН ЗАРИМ ОНЦЛОГ

Х.ОРХОНЧИМЭГ /БХЭШХ-ийн АБСТ-ийн ЭШАА, доктор (Ph.D), дэд/ профессор/

Түлхүүр үг: Нийгэм, цэрэг, бие хүн, төлөвшил

Key words: Society, military, individual, maturity

Оршил. Аливаа ард түмний ахуй амьдралын онцлог, хэв заншил, соёлын уламжлалтай холбоотойгоор тухайн үндэстний өвөрмөц сэтгэхүй үүсэн бүрэлдэж, уламжлагдан хөгжиж байдаг билээ. Тэгвэл монгол угсаатан үүсэн бүрэлдсэн нэн эрт үеэс эхлээд өөрийн үндэсний өвөрмөц аж ахуй эрхлэлт, байгаль экологийн онцлог, эдийн ба оюуны соёлын онцлог шинжийг хадгалсан зан чанар, сэтгэлгээний хувьд дэлхийн аль ч улс үндэстнээс ялгарах шинжийг агуулж чаджээ. Ялангуяа эрт үеэс Монголчуудын зориг баатарлагийн уг сурвалж юунд байсныг бэдрэн хайх ажил хийгдээгүй өдий хүрчээ. Иймээс энэхүү өгүүлэлд монголчуудын цэрэг бие хүнийг төлөвшүүлж ирсэн зарим онцлогийг гаргахаар зорилоо.

Үндсэн хэсэг. Монголын нийгмийн хөгжлийн түүхийн урт удаан хугацаанд монгол цэрэг бие хүнийг хүмүүжүүлэн төлөвшүүлж ирсэн онцлог уламжлалыг эрт, дундад үе, орчин үе, нэн шинэ үе гэсэн ерөнхий томоохон үед хуваан үзэж болмоор байна. Үүнд, нэгдүгээр үеийг монголчуудад цэрэг эрсийг сурган боловсруулах үзэл санаа бүрэлдэн тогтсон үе, хоёрдугаар үеийг монгол цэргүүдийг хүмүүжүүлэх үзэл санаа нь улмаар сэтгэлгээний түвшинд боловсорч хөгжсөн үе, гуравдугаар үеийг орчин цагийн монгол цэргүүд дэлхийн улс орнуудын дэвшилтэд арга технологиос сурч хүмүүжүүлэн сургах болсон, сургалт үйлс шинэ түвшинд гарсан шинжлэх ухааны сэтгэлгээний хөгжлийн үе, дөрөвдүгээр үеийг техник технологи, шинжлэх ухааны оргилд хүрч хүний сэтгэлгээ хөгжлийн хиймлээр бүтээх болсон гэж хөгжлийн үеүдээр ялган үзэж болох байна. Нэгдэх үе буюу монгол цэргүүдийг сурган боловсруулах үзэл санаа бүрэлдэн тогтсон

үеийн гол онцлог нь байгалийг шүтэх, бишрэх, байгальч үзэл, сүсэг бишрэл, баатарлаг эрсийг шүтэж онцолж байснаар энэ үеийн үнэлэх үнэлэмж тодорхойлогдох болсон. Амьд үлдэх, амьдралын төлөөх тэмцэлд дайтах эрдэм ухаанд боловсорсон чадварлаг дайчид биеийн хүч чадалд найдах, биеэр бүхнийг хийх бүтээх зайлшгүй шаардлагатай байсан учраас их хүч чадалтай баатарлаг эр хүнийг хүний төгс төгөлдрийн шинж хэмээх үзэл санаа хүчтэй болж энэхүү үзэл санаанаас дээр дурдсан онцлог хүнийг сурган боловсруулах хэрэгцээ гарч байсан үе гэж тодорхойлж болно. Аливаа хүн хүч чадалтай байвал өрсөлдөгч дайснаа амархан ялж дийлнэ гэсэн тийм үзэл санаанаас шалтгаалж, монгол сурган хүмүүжүүлэх сэтгэлгээнд баатарлаг үйл, баатарлаг сэтгэлгээ давамгайлах хандлагатай гарч ирсэн. Чухам энэ үеэс л монголчуудын цэрэг бие хүнийг сургаж боловсруулах үзэл сэтгэлгээ тогтох болжээ.

Хоёр дахь үед тэнгэрлэг үзэл сургаал баатарлаг өвөг дээдсийн дайтах, амьдрах арга ухаантай хосолсон ухаалаг удирдагчдын мэргэн ухааныг дээдлэх үзэл санаа улмаар дэлгэрч, ухаалаг, чадварлаг төр түмнийг удирдан залах манлайлагчдыг эрхэмлэх болсон онцлогтой үе. Энэ үед монголчууд арга ухаан, цэргийн хэргийн үйлст дэлхийг байлдан дагуулсан үе юм.

Гурав дахь үед орчин цагийн зэвсэг техникийг эзэмшүүлэх, цэрэг армийн сургаж байсан бусад улс орнуудын арга барилтай хослуулан сургаж байсан үе юм. Орчин цагийн зэвсэгт хүчнийг өрнө дахины цэргийн сургалтын үзэл арга барилаар сургаж байсан онцлог хөгжлийн үе юм.

Дөрөв дэхь үе бол техник технологийн



хүчээр сансар огторгуйд хэн ноёлно тэрэнд хүч чадал оршино гэх үзэл арга барил давамгайлах боллоо. Шинэ зууны цэрэг эрс ялангуяа оибер цэргийн үзүүлэх хүч нөлөө их болж байна. Иймд оюун санаа, техник технологийг хослуулсан монгол цэргүүдийг сургаж бэлтгэх ажил чухал болсон ийм онцлогтой үе болж байна.

Монголын сургалт боловсролын хөгжлийн аль үед, түүхэн тодорхой ямар нөхцөл шалтгааны улмаас монгол цэрэг бие хүнийг шинжин таних, үнэлэх, хөгжүүлэх, төлөвшүүлэх үзэл санаа, сэтгэлгээнд ямар өөрчлөлт гарсан, хүнд боловсрол олгох арга ухаан хэрхэн төлөвшсөнийг судлахад юуны өмнө тухайн үндэстний сурган хүмүүжүүлж ирсэн үзэл санааны онолыг судлах чингэхдээ монголчуудын сурган хүмүүжүүлэх үзэл санаа хэдий үеэс үүсэн бүрэлдэж тогтсон бэ? гэдэг асуултад тодорхой хариулт өгөх хэрэгтэй. Монгол нутагтаа монгол хүн мөнхөд аж төрж амьдарсан тэрхүү эрт үеэс эхлэн өөрсдийгөө залгамжлах үр хөвгүүнээ өсгөн хүмүүжүүлж, хүний дайтай хүн, улсын иргэн болгож байсан тэр эрт үеэс эхтэй байсан гэж хэлж болно. Эцгийн болон эхийн эрхт ёсны ноёрхлын үед буюу монголчуудын хүйгээр амьдрах болсон үеэс л овгийн дотор хөдөлмөрийн хувиар тогтох болж эрчүүдийн үүрэг тодорч эхэлсэн. Энэ үеэс л монголчуудын цэрэг бие хүнийг сурган хүмүүжүүлэх үзэл санаа бүрэлдэн тогтож эхэлсэн бөгөөд энэхүү үзэл санаа нь анхандаа овгийн хүрээнд явагдаж байсан тул овог хүй дотор өсгөх, хүмүүжүүлэх туршлага, ахмадын сургаал, үлгэрлэлээс эхлээд үр хүүхдээ хүмүүжүүлэн сургах арга барил, туршлага зэрэг нь цөм овгоо хамгаалах шинжтэй байсан бөгөөд улмаар үр хүүхдээ хүмүүжүүлэх, ер монгол айл гэрт монгол хүн төлөвшсөн бүхий л үйл явц тасралтгүй үргэлжилж өнөөдөр хүрчээ. Монгол угсаатан ард түмний дунд гэр бүл, ураг төрлийн харилцаа, улмаар цэрэг эрсийг сурган хүмүүжүүлэх дэг сургууль үүссэн нь сурган хүмүүжүүлэх үзэл санааны хөгжлийн

бодит үр дүн мөн. Гэвч энэ том үзэл онолын онцлог уламжлалыг бид нарийвчлан судлаагүй байсаар байна.

Хүн өөрөө өөрийгөө юм уу хүнээс хүнийг үнэлэх үнэлэмж, сайн муу хүний тухай ойлголт, “хүнээр хүн хийх” монгол арга ухаан гагцхүү гэр бүл, улмаар төр улсын хүрээнд боловсорч хөгжсөн бөгөөд харин энэ харилцааны онцлогийг бид судлан тодорхойлох хэрэгтэй юм. Монгол хүн байгальтай харьцах харилцааны дунд байгальч үзэл улмаар овог удмаа хамгаалах цэрэг эрсийг бэлтгэх арга уламжлал баяжин эртний монгол хүний байгаль ертөнц, хүнийг үзэх гол үзэл санаа, ойлголт болж байжээ.

“Зэрлэг араатан адил газрын өрх, хадны агуй, эрэг хунхад сууж, сүрэг гөрөөс мэт ургамлын үндэс үр жимс түүх цуглуулах, эсвэл сүрэг чонын ан гөрөөсөнд олноороо довтлох зэргийн аж төрөлтэй байсны анхны үед тэдний аж төрөл бараг бүхлээрээ ган зуд, гал түймэр, араатан жигүүртэн, аянга цахилгаан, салхи шуурга тэргүүтэн байгалийн эрхшээлд байсан нь зайлбаргүй тул тэдний нялх бага ухамсарт эхлээд байгалийн юм үзэгдлийг шүтэх фетишизм, амьтныг шүтэх анимизмын илрэл бүхий сэтгэлгээ үүссэн нь магадтай”¹. Ерөөс байгальч үзэл, бөө мөргөл, тотем шүтлэгээс хүн төрөлхтний үзэл санаа, онол сэтгэлгээний хөгжлийн үе эхэлдэг. Үүний дараа тэднээс овог үр удмаа хамгаалах арга ухаан сэтгэлгээ дэлгэрэх болжээ гэж үзэж болох юм.

Нийгмийн бичил орчин гэгддэг овог хүйгээс үүдэлтэй сурган хүмүүжүүлэх үзэл санаа нь улмаар монголд анхны ханлиг улс болох Хүннү, Сяньби, Тоба, Нирун, Хятан зэрэг эртний төрт улсын үеэс уламжлагдан хөгжиж, хүчирхэг цэрэг бие хүн, армийг сургаж боловсруулах ёсон буй болсон. Цэрэг эрчүүдийг хүмүүжүүлэн сурган боловсруулах үйл хэрэг овог хүйгийн хүрээнээс халин тэлж, улс нийгмийн чанартай болж төрийн хууль цааз, хэм хэмжээг иргэн бүр сахин биелүүлэх үүрэгтэй болохоор хүний нийгэмшил буюу нийгэмших үйл явц хурдацтай

¹ Гаадамба.Ш, Цэрэнсодном.Д.Монголын нууц товчоо.Эрдэм шинжилгээний орчуулга тайлбар.УБ.,2000.т.54–55



хөгжсөн юм.

Монголчууд байгалийн бэрхшээл, нийгмийн олон сорилт туршилтад өртөж, тэдгээрт дасан зохицож, үлдэх гойд чадвартайгаа харуулсан ард түмэн юм. Байгалийн бэрхшээлийг давахуйц өлчир чийрэг, бие даан амьдрах чадвар сайтай, төрөлхийн эрэлч гярхай, холын хараа сонсгол сайтай, мэдрэмтгий хүмүүс юм. Өвөг дээдсээс уламжилсан бясалгах сэтгэлгээтэй, өөрөөр хэлбэл аливаа юмыг уужуу тайван олон талаас нь эргэцүүлэн бодож, алтан дунджийг нь олж чаддаг, голч үнэнч шийдвэр гаргаж чаддаг хүмүүс билээ. Түүнийхээ ачаар газар нутгаа амьдралын эх үндэс, эх гэж үздэг байгальтайгаа зохицон, түүний эмзэг байдлыг хадгалж, хишиг буяныг нь хүртэн амьдарсаар иржээ.

Эх болсон газар нутгаа монгол хүн бүрийн амин чухал эрх ашиг гэж хамтран хамгаалж ирсэн онцлогтой. Аливаа хүндрэл бэрхшээлийг эр зоригийн хүчээр даван туулж, дэвшин хөгжиж байв. Ахмад настнаа хүндлэн, тэдний нэр хүнд, мэдлэг туршлагад түшиглэн эрдэм ухааны эрхэм баян хэмээн тэргүүн зэрэгт тавих, аливаа зүйлийг авсаархан мөртөө оновчтой, хэрэглээгээ хангах өргөн боломжтой хийж бүтээж, хэрэглэдэг онцлогтой ард түмэн. Чухам дээрх онцлогийн үр дүнд монголчуудын цэрэг

бие хүнийг сургаж хүмүүжүүлж ирсэн үзэл сургаалын үндэс бүрэлдэн бий болсон гэж үзэж болох юм.

Дүгнэлт. Монголын нийгмийн хөгжлийн түүхийн урт удаан хугацаанд монгол цэрэг бие хүнийг хүмүүжүүлэн төлөвшүүлж ирсэн онцлог уламжлалын нэгдүгээр үеийг монголчуудад цэрэг эрсийг сурган боловсруулах үзэл санаа бүрэлдэн тогтсон үе, хоёрдугаар үеийг монгол цэргүүдийг хүмүүжүүлэх үзэл санаа нь улмаар сэтгэлгээний түвшинд боловсорч хөгжсөн үе, гуравдугаар үеийг орчин цагийн монгол цэргүүд дэлхийн улс орнуудын дэвшилтэд арга технологиос сурч хүмүүжүүлэн сургах болсон, сургалт үйлс шинэ түвшинд гарсан шинжлэх ухааны сэтгэлгээний хөгжлийн үе, дөрөвдүгээр үеийг техник технологи, шинжлэх ухааны оргилд хүрч хүний сэтгэлгээ хөгжлийн хиймлээр бүтээх болсон гэж хөгжлийн үеүдээр ялган үзэж болох байна. Мөн Монгол цэрэг эрчүүдийг хүмүүжүүлэн сурган боловсруулах үйл хэрэг эрт үед овог хүйгийн хүрэнээс халин тэлж, улс нийгмийн чанартай болж төрийн хууль цааз, хэм хэмжээг иргэн бүр сахин биелүүлэх үүрэгтэй болохоор хүний нийгэмшил буюу нийгэмших үйл явц хурдацтай хөгжиж монгол нутагт зохицсон цэрэг бие хүнийг төлөвшүүлэх үйл явц тасралтгүй үргэлжлэх болжээ.

Ашигласан материал:

1. Бромлей.Ю.В. Очерки теорий этноса.М.,1983.Дэлгэржаргал.П.Монголчуудын угсаа гарвал.УБ.,2005.т.22
2. Гаадамба.Ш, Цэрэнсодном.Д.Монголын нууц товчоо.Эрдэм шинжилгээний орчуулга тайлбар.УБ.,2000
3. Гумилев.Л.Н.Этногенез и биосфера.М.,1994
4. Гонгор.Д. Халх товчоон.И.УБ.,1978
5. Гегель.Философия историй.СПБ.1993.стр.57.Хавх.Н.Соёл иргэншлийн онол. УБ.,2004



ХИЙМЭЛ ОЮУН УХААНААР БОЛОВСРОЛЫГ ӨӨРЧЛӨХ НЬ

П.ЦЭДЭВ /Эрдмийн сургуулийн БХСХ-ийн багш, доктор (Ph.D), профессор/
А.ТЭМҮҮЖИН /ҮБХИС-ийн АБДС-ийн "Инженерчлэлийн тэнхим"-ийн багш, магистрант/
Ү.ДЭЛГЭРСҮҮРЬ /ҮБХИС-ийн БХЦСТ-ийн Сургалт, арга зүйн ахлах мэргэжилтэн, магистрант/

Түлхүүр үг: Хиймэл оюун ухаан, сургалтын орчин, суралцагчид, багш, мэдлэг, өгөгдөл, мэдээлэл

Key words: Artificial intelligence, learning environment, students, teacher, knowledge, data, information

Хураангуй. Хиймэл оюун ухаан нь техник технологийн чиглэлд хурдацтай нэвтэрч хөгжсөөр байна. Ихэнх хүний бодолд хиймэл оюун ухаан гэдэг өндөр хүчин чадалтай робот эсвэл супер компьютер, процессор байх нь олонтой. Гэсэн хэдий ч ирээдүйд хэрхэн өөрчлөгдөхийг бид таашгүй билээ. Хиймэл оюун ухаан гэдэг аль хэдийн бидний эргэн тойронд нэвтэрч технологийн бас нэгэн салшгүй том хэсэг болсон. Бид өөрсдийн ч мэдэлгүй хиймэл оюун ухааныг өдөр тутамдаа хэрэглэж байгаа ба тэдгээр нь бидний эргэн тойронд гар утас, компьютер гэх мэт бүхий л ухаалаг төхөөрөмж, цахим сүлжээнүүд хиймэл оюун ухаанд тулгуурлан хөгжиж байна. Тэгвэл энэхүү өгүүлэлд боловсрол сургалтын орчинд технологийн энэ салбар хэрхэн ашиглагдаж буй талаарх ба ашиглах боломж цаашид хөгжих чиглэлийг судлахаар зорилоо.

Оршил. Хиймэл оюун ухаан (AI) нь ирээдүйн футурист ойлголт байхаа больсон. Энэ нь бидний амьдралын хэв маягт хурдан нэвтэрч байгаа бөгөөд боловсролд ч мөн адил. Хувийн сургалтын туршлагаас эхлээд виртуал багш хүртэл AI нь бидний заах, сурах арга барилд хувьсгал хийхэд бэлэн болжээ. Гэхдээ үүний боломжит ашиг тус, бэрхшээлүүд юу вэ? [3]

Сүүлийн жилүүдэд хиймэл оюун ухаан нь (AI) боловсролд нэгтгэснээр суралцагчдын сурах арга барил, багш нарын зааварчилгааг өөрчлөн шинэ сургалтын арга барилыг нэвтрүүлсэн өөрчлөлтийн эрин үеийг эхлүүлсэн.[3] Энэхүү дэвшилтэт технологи нь хувь хүний сургалтын туршлагаас эхлээд өгөгдөлд тулгуурласан ойлголт хүртэл асар их боломжийг бий болгодог.[2] Энэ өгүүлэлд бид хиймэл оюун

ухаан нь боловсролын орчныг өөрчилж, илүү үр дүнтэй, сонирхолтой суралцахуйн арга барил бүрдүүлэхэд хувь нэмэр оруулж буй янз бүрийн арга замуудыг судлах болно.

Үндсэн хэсэг. Хиймэл оюун ухааныг боловсролын салбарт сурган хүмүүжүүлэгч болон суралцагчид ашиглахад дараах байдлаар ашигтай талууд илэрч болно. Түргэн хугацаанд хэрэгцээт мэдээлэл хүргэх цаг хугацаа, сургалт судалгаа хийхэд зарцуулагдах үнэ өртөгийн хэмжээг багасгах санхүү гэх мэт. Хиймэл оюун ухаан нь хөгжин улам боловсронгуй болсоор байгаа хэдий ч аль хэдийн хүний хэрэглээний салшгүй нэгэн хэсэг болоод байгаа юм. Жишээ нь: voice assistant (дуу хоолойгоор удирдах, харилцан ярилцах), газрын зураг байршил тогтоогч ба чиглүүлэгч, shopping assistant (дэлгүүрийн худалдан авалтад туслах зөвлөгөө өгөх), daily assistant (таны өдөр тутмын үйл ажиллагаанд туслах тэмдэглэл хийж танд сануулах), сургалт, шинэ мэдлэг мэдээлэл олж авахад тань туслах search engine гэх мэтээр хөгжсөөр байна. [1]

Тэгвэл сургалтын үйл ажиллагаанд буюу сурган хүмүүжүүлэгчид болон суралцагчдад хэрхэн нөлөө үзүүлэх вэ?

Суралцагчдад дараах байдлаар сургалтын үйл явцад тусламж үзүүлэх бололцоотой гэж таамаглаж байна.

1. Хувийн ганцаарчилсан сургалт: Хичээлийг суралцагч бүрийн хурд, ойлголтод тохируулсан платформыг төсөөлөөд үз дээ. Хиймэл оюун ухаанаар ажилладаг хэрэгслүүд нь сургалтын хэв маяг, давуу болон сул талуудад дүн шинжилгээ хийж, хувь хүний суралцах онцлог

тохируулан үр дүнтэй сурах аргыг бий болгохын тулд агуулга, хүндрэлийг суралцагч болон сурган хүмүүжүүлэгч өөрөө тохируулах боломжтой. Энэхүү аргаар суралцах нь бүх оюутнуудын оролцоог нэмэгдүүлж, сургалтын үр дүнг сайжруулах боломжтой.[2]

2. Ухаалаг сургалтын системүүд: Эдгээр виртуал туслахууд нь зорилтот дэмжлэг үзүүлж, асуултад хариулж, тайлбар өгч, оюутанд нэмэлт тусламж хэрэгтэй байж болох хэсгийг тодорхойлдог.[4] Уламжлалт анги танхимын орхигдсон орон зайг нөхөж, 24/7 цагийн турш уйгагүй, тэвчээртэй багштай байна хэмээн төсөөлөөд үз дээ.
3. Хүртээмжтэй байдал: Бичвэрээс яриа, ярианаас бичвэрт, бичвэрээс зураг ба бичлэг зэрэг хиймэл оюун ухаанаар ажилладаг хэрэгслүүд нь хэлний бэрхшээлийг арилгаж, хөгжлийн бэрхшээлтэй оюутнуудыг дэмжих боломжтой.[1] Нэмж дурдахад, хиймэл оюун ухаан нь суралцах бэрхшээлийг эрт илрүүлж, шийдвэрлэх боломжтой бөгөөд ингэснээр нэг ч суралцагч сургалт болон мэдлэгийг авахад хоцрогдол үүсгэхгүй хэмээн үзэж байна.[2]

Сурган хүмүүжүүлэгч, багшид хиймэл оюун ухаан хэрхэн туслах вэ?

AI нь боловсрол болон хичээлийн асар их хэмжээний өгөгдөл, мэдээлэлд дүн шинжилгээ хийж, сурган хүмүүжүүлэгч нарт заах, сургах чиг хандлагыг тодорхойлох, заах аргыг үнэлэх, сургалтын хөтөлбөрийг оновчтой болгоход тусалдаг.[2]

Цагийн хуваарь гаргах, бүртгэл хөтөлөөс эхлээд ирц, харилцаа холбоог автоматжуулах хүртэл хиймэл оюун ухаан нь захиргааны ажлыг оновчтой болгож, багш нарын цаг хугацааг хэмнэж үндсэн заан сургах ажилд илүү цаг гаргахад тусална.[2]

Хиймэл оюун ухааныг үр дүнтэй нэгтгэх, ашиглахад багшийг шаардлагатай ур чадвар, мэдлэгээр хангах шаардлагатай. Багш нар технологиор солигдохгүй, эрх мэдэлтэй гэдгээ суралцагчдад мэдрүүлэхийн тулд байнгын сургалт, дэмжлэг суралцагчдад үзүүлэх хэрэгтэй.[4]

Хиймэл оюун ухаанаар ажилладаг платформ хэрэгслүүд нь уламжлалт ангиас гадна бүх насны болон сонирхсон хүмүүст зориулсан суралцах боломжуудыг санал болгож чадна. Энэ нь насан туршийн суралцах соёлыг төлөвшүүлж, хувь хүнийг хурдацтай өөрчлөгдөж буй ертөнцөд хөгжихөд шаардлагатай ур чадвараар хангадаг.

Сүүлийн үед технологи түүнчлэн хиймэл оюун ухааныг хөгжүүлэн ашиглах нь хэдий сайн давуу талтай ч тухайн эрсдлийг зайлшгүй тооцох хэрэгтэй.

Бид цаашид хиймэл оюун ухаанаас өөрсдийн хувийн мэдээллийг хамгаалж чадах болов уу, түүгээр ч зогсохгүй хөгжлийн хэрээрээ хэрэглэгчдийг ч эрсдэлд оруулах магадлалтай юм. Зүгээр л сонирхож хайлт хийсэн зүйлийн илэрц нь санамсаргүй байдлаар хүний хувийн мэдээлэлд халдах, худал мэдээлэл бусдад түгээх гэсэн асуудлууд тулгарч болох юм.

Харин боловсрол сургалтын салбарын ирээдүйд багш хэмээх мэргэжлийг орлох вий гэсэн айдсыг дагуулаад буй...

Хиймэл оюун ухаан буюу AI-г сургалтад ашиглан туршсан хэд хэдэн туршилт, судалгааны ажлууд урьд өмнө нь хийгдэж байжээ.

1. DreamBox сургалтын туршилт

Гүйцэтгэсэн: Бие даасан судлаачид

Анхаарах зүйл: 8-р ангийн сурагчдад зориулсан хувийн математикийн заавар.

Арга зүй: Оюутнуудыг санамсаргүй байдлаар DreamBox эсвэл уламжлалт тэнхимийн математикийн сургалтын хөтөлбөрийг хэдэн сарын турш ашиглахаар томилсон.

Үр дүн: Судалгаанаас харахад DreamBox ашигладаг оюутнууд нь Математикийн түвшин тогтоох шалгалтад уламжлалт арга барилаар сурсан сурагчдаас өндөр оноо авсан.

2. Knewton AI ашигласан сургалт

Гүйцэтгэсэн: Knewton өөрөө болон бие даасан судлаачид

Анхаарах зүйл: Ангийн түвшний олныг хамарсан төрөл бүрийн хичээлүүдэд зориулсан хувийн сургалтын платформ.

Арга зүй: Оюутнууд уламжлалт сургалтын хажуугаар Knewton-ийн бие даасан сургалтын платформыг ашигласан.

Үр дүн: Судалгаанаас үзэхэд Knewton ашигладаг оюутнууд уламжлалт аргыг



ашигласан оюутнуудтай харьцуулахад илүү өндөр оноо авсан.

Сэдвийн талаар илүү сайн мэдлэг, ойлголт эзэмшсэнийг харуулсан.

3. Duolingo туршилт

Удирдагч: Duolingo болон бие даасан судлаачид

Анхаарах зүйл: Duolingo платформын AI-ээр ажилладаг хувийн тохиргоог ашиглан хэл сурах программын үр дүнтэй байдал.

Арга зүй: Үгийн сан эзэмших, харилцан ярих чадварыг үнэлэхийн тулд хэрэглэгчдийг цаг хугацааны явцад хянаж байсан.

Үр дүн: Судалгаанаас үзэхэд Duolingo нь үгийн санг мэдэгдэхүйц нэмэгдүүлэх, дүрмийн үр чадварыг сайжруулсан.

Тогтмол хэрэглээнд дунджаар 34 цагийн дотор шинэ хэл сурах боломжийг хэрэглэгчдэд олгох боломжтой.

Туршилтын дүгнэлт: Эдгээр туршилтууд нь суралцах явцыг бие даасан хувийн болгох, зорилтот дэмжлэг үзүүлж, илүү гүнзгий ойлголтыг бий болгоход хиймэл оюун ухааны чадамжийг харуулж байна. Гэсэн хэдий ч тасралтгүй судалгаа хийх, болзошгүй өрөөсгөл ойлголтыг арилгах, хариуцлагатай сургалт зохион байгуулсанаар хиймэл оюун ухааныг ашиглах цаашлаад боловсрол дахь ашиг тусыг нэмэгдүүлэхэд маш чухал юм.

Одоогийн байдлаар манай улсад хиймэл оюун ухааныг сургалтад ашигласан туршилт, судалгаа дутмаг байгаа хэдий ч цаашид энэхүү технологийг ашиглах бүрэн бололцоотой учир үргэлжлүүлэн судалгааны ажлыг явуулахаар төлөвлөж байна.

Судалгааны үр дүн. Хиймэл оюун ухааныг сургалтад ашиглах бүрэн боломжтой. AI-г

ашиглан сурган хүмүүжүүлэгчид болон суралцагчид өөрсдийн суралцах хэв маягтаа тааруулан цаг хугацаа алдалгүй хэрэгтэй мэдээллийг хүртээмжтэй байдлаар олж авах боломжтой гэж үзэж байна. Цаашид энэ технологийн салбарын хөгжлийг тааж мэдэхгүй ч мэдээж хэрэг боловсролын салбарт үр өгөөжтэй байх нь дамжиггүй.

ДҮГНЭЛТ. Боловсролын хивсэнцэр нь хиймэл оюун ухааны утаснуудаар шинэчлэгдэж, хувь хүний сургалт, ухаалаг удирдамж, өгөгдөл суурилсан ойлголтоор өөрчлөгдсөн ирээдүйг амлаж байна. Хиймэл оюун ухаан нь сурган хүмүүжүүлэгчдийг чадавхжуулах, туршлагыг нь өөрчлөх, оюутны чадавхыг нээх чадвартай хэдий ч өрөөсгөл ойлголт, мэдээллийн нууцлал, багшийн дэмжлэгтэйгээр ёс зүйн асуудлыг суралцагчдад хүргэх асуудлыг нухацтай авч үзэх ёстой. Хиймэл оюун ухааныг хариуцлагатай хүлээн авснаар бид эдгээр сорилтуудыг даван туулж, технологи нь хүн хоорондын харилцааг холбоог бэхжүүлж, суралцагч бүрийн суралцах хүсэл эрмэлзлийг өдөөнө хэмээн дүгнэж байна. Энэ нь зөвхөн анги танхимд хувьсгал хийх тухай биш юм. Харин суралцах явцдаа хувьсгал хийж, оюутан бүр өөрийн чадавхыг бүрэн дүүрэн ашиглах боломжийг хангах тухай юм. Хиймэл оюун ухаан бол зөвхөн нэг хэрэгсэл бөгөөд үүнийг ухаалгаар ашиглах, шинэлэг, хүртээмжтэй, хувь хүний харилцаанд суурилсан боловсролын тогтолцоог бий болгох нь бидний гарт гэдгийг санах хэрэгтэй. Энэ бол төгсгөл биш, харин хиймэл оюун ухаан нь хүчирхэг холбоотон болж, биднийг хаа сайгүй суралцагчдад гэрэлт ирээдүй рүү түлхэж буй боловсролын шинэ бүлгийн сэтгэл хөдөлгөм эхлэл юм.

Ашигласан материал:

1. "Artificial intelligence and the future of teaching and learning" 2023 Office of technology office
2. "Journal of cases on information technology" volume 23, issue 1 2021 years
3. "Artificial intelligence in education" Promises and implications for teaching and learning- Wayne Holmes, Maya Bialik, Charles Fadel
4. "Artificial Intelligence A modern approach" Third edition- Stuart Russel, Peter Norvig
5. Journal of Artificial Intelligence in Education: <https://link.springer.com/journal/40593>
6. <https://link.springer.com/journal/11423/updates/17758834>
7. AI дахь түншлэл (PAI) "Partnership of artificial intelligence " <https://partnershiponai.org/>



ХҮҮХЭД ЗАЛУУЧУУДЫГ ЭХ ОРОНЧ ИРГЭН БОЛГОН ТӨЛӨВШҮҮЛЭХ ҮЙЛ ЯВЦЫН ОНОЛЫН ҮНДЭСЛЭЛ

Д.БАТ-ЭРДЭНЭ /БХЭШХ-ийн БХСТ-ийн ЭШАА, хурандаа/

Түлхүүр үг: Эх орон, нийгэм, хүмүүжил, үзэл
Key words: Motherland, society, upbringing, idea

Оршил. Аливаа улсын үндэсний аюулгүй байдлыг хангах үйл ажиллагааны бүрэлдэхүүн хэсэг нь аюулгүй байдлаа хамгаалах үйл ажиллагаа юм. Тэгвэл тухайн улсын ард иргэдэд эх оронч, үндэсний үзэл, итгэл үнэмшил, төлөвшилтэй иргэн бэлтгэснээр үндэсний аюулгүй байдлаа хангах нэг нөхцөл бүрдэх юм.

Даяаршлын үйл явц нийгмийн бүхий л хүрээг хамарч, гадаад дотоод орчин маш хурдан өөрчлөгдөж буй нь ирээдүйн төлөв байдлыг урьдчилан төсөөлөх бүх боломжийг ашиглах, улмаар улс орнуудад дотоод хүч чадавхаа нэмэгдүүлэхийг ямагт сануулсаар байна.

Аюулгүй байдалд хандах хандлага, улс орныг батлан хамгаалах үйл ажиллагаа нь цэрэг, батлан хамгаалахын онол, арга зүйн мэдлэгт суурилах нь нэн чухал. Аюулгүй байдлын онол, үзэл баримтлал, арга зүйд томоохон өөрчлөлт гарч, аюулын чиг хандлагын судалгаа, дүн шинжилгээ, эрсдэлийн үнэлгээ хийх, цаашид учирч болзошгүй аюулаас улс орноо хамгаалах хүч чадавхыг бий болгох явдал бол тэргүүн зэргийн зорилт болох юм. Энэ зорилттой уялдан тус өгүүлэлд хүүхэд залуучуудыг эх оронч иргэн болгон төлөвшүүлэх үйл явцын онолын зарим асуудлыг тодруулан гаргахыг зорилоо.

Үндсэн хэсэг. Шинэ зууны нийгмийн өөрчлөлтүүд, онолын хөгжлийн чиг хандлагатай уялдан эх орноо хамгаалах сэтгэхүйтэй иргэдийг төлөвшүүлэх шаардлага бий болсон. “Хүн нийгэмших явцдаа бусадтай харилцан ажиллаж, харилцааны туршлага хуримтлуулж бие хүн болон төлөвшдөг”¹ Иргэдийг

төлөвшүүлэх асуудал нь боловсрол олгох үйл явцтай нягт уялдана.

Боловсрол нь хүн төрөлхтний хуримтлуулсан байгаль, нийгэм, техник, урлагийн тухай мэдлэг, чадвар, дадал, арга туршлагыг хойч үедээ дамжуулан өвлүүлдэг нийгмийн үйл явц, үзэгдэл түүний үр дүн юм². Өөрөөр хэлбэл, боловсрол нь нэг талаас бие хүн төлөвшүүлэх үйл явц, нөгөө талаас бие хүний хөгжил, төлөвшлийн түвшин, үр дүнг тодорхойлох ухагдахуун юм. Энэ ч утгаараа “Өнөөдөр дэлхий дахины шинжлэх ухаан, технологи, улс төр, нийгмийн хурдтай өөрчлөлтүүд нь соёлт ертөнцийг ойлгон хүндэтгэдэг, улс орны аюулгүй байдал, батлан хамгаалах асуудлыг ойлгож мэдрэн аливаа сөргөлдөөнтэй хүнд асуудлыг зөвшилцөл, улс төр, дипломатын аргаар оновчтой шийдвэрлэх чадвартай, ирээдүй рүүгээ чиглэсэн тэмүүлэлтэй, идэвхтэй байр суурьтай, боловсролтой иргэдийг нэн даруй бэлтгэн төлөвшүүлэхийг шаардаж байна”³.

Хүн ард нь оюун ухааныхаа хүчээр нийгмийн баялгийг хэрхэн бүтээж, ашиглаж байгааг өнөөдөр аливаа улс орны хөгжил дэвшлийн илэрхийлэл хэмээн үзэж, шинжлэх ухаан технологийн чадамжаар нь тухайн орны хөгжлийн түвшинг хэмждэг билээ. Улмаар технологи, инновац, мэдээлэл харилцаа холбооны хөгжил өндөр түвшинд хүрсэн энэ үед улс орнууд материаллаг нөөц баялгаар бус, хүний чадавх, оюуны хүчээр өрсөлдөх болж, хүний хөгжиж боловсрох асуудлыг бодлогын

¹ Орхончимэг.Х.Нийгэм хүмүүнлэгийн ухааны судалгааны арга зүйн үндэс.УБ.,2022.т.25

² Жамц Л. Боловсрол судлалын үндэс. –УБ., 2017. т.28.

³ Өлзийхуяг Б. Батлан хамгаалах боловсрол түүний хэрэгцээ шаардлага. Монгол Улсын Засгийн Газрын хэрэгжүүлэгч агентлаг. Удирдлагын академи. Удирдах эрдэм сэтгүүл. –УБ., 2009. т.163.

түвшинд авч үзэх болсон.

Оюунлаг, ёс суртахуунтай, ажил амьдралаа чиглэл зорилготой хөтлөх шинж чанаруудыг иргэнд бий болгож төлөвшүүлэх нийгмийн хүчин зүйл нь боловсрол, түүнийг хөгжүүлэх нийгмийн үйл ажиллагаа юм. Орчин үед боловсролыг сургуулийн хүрээнд биш жинхэнэ хүн төлөвшүүлэх нийгмийн хүрээгээр нь ойлгож, түүнд шинэ байдлаар хандаж, өргөн утгатай томъёолох хэрэгцээ шаардлага бий болсон.

Боловсрол бидний амьдрах орчин болж, цаашид амар тайван, эрүүл энх аж төрөх суурь хэрэгцээ шаардлага боловсролыг хэрхэн олгохоос ихээхэн хамаарна. Академич Н.Бэгзийн тодорхойлсноор "... хувь хүнийг нийгэмшүүлэх үйл явцын гол зорилго нь хүнийг амьдрах ухаан, соёлын өв, ёс суртахууны хэм хэмжээнд суралцуулж, түүнийг нийгмийн бүрэн төгс гишүүн болгон төлөвшүүлэхэд оршино. Иймээс хүнийг нийгмийн гишүүн болгоно гэдэг нь цаанаа төлөвшиж тогтсон нийгэм, хамт олон өөрийн хамтын аюулгүй байдлаа хадгалахад чиглэж байгаа бөгөөд хүнийг нийгэмд аюулгүй, өмнөх үеийнхний тогтоосон амьдралын хэм хэмжээ, ёс заншлыг бүрнээ даган биелүүлдэг дуулгавартай хүн, нийгмийн иргэн төлөвшүүлэхэд үндэслэгдэнэ"⁴ гэжээ. Өөрөөр хэлбэл, боловсролын үндсэн хэрэгцээ шаардлага нь иргэнийг нийгэмшүүлж төлөвшүүлэхэд чиглэнэ гэсэн үг.

Улс орны нийгэм эдийн засаг, байгаль цаг уурын нөхцөл өөрчлөгдөхийн хирээр нийгмийн гишүүдээс бие хүний шинэ шинж чанар, бүтээлч идэвх болон шинжлэх ухаан, технологийн хөгжилтэй уялдсан мэдлэг, чадварыг шаардаж, улмаар бие хүнийг сурган төлөвшүүлж, эрдэм боловсрол олгож буй бүхий л тогтолцоонд нийгмийн энэхүү хэрэгцээтэй уялдсан өөрчлөлт шинэчлэлт шаардагддаг. Нийгмийн хөгжлийн тодорхой үе шатууд цөм өөртөө тохирсон боловсролын тогтолцоог бий болгож, өөрчлөн хөгжүүлж иржээ.

Боловсрол нь нийгмийн хөгжил, хүмүүсийн

оюуны хэрэгцээтэй уялдан байнга хөгжиж байдаг нарийн нийлмэл тогтолцоо бүхий үйл явц юм. Шинэ зууны хөгжлийн хөдөлгөгч хүчин зүйл нь нийгмийн иргэн төлөвшүүлэх боловсрол, түүний агуулга болон арга зүйтэй салшгүй холбоотой.

Дэлхийн улс орнуудын хүүхэд, залуучуудаа сургаж иргэн төлөвшүүлж ирсэн хөгжлийн чиг хандлагуудаас үзэхэд манай улсын эх оронч иргэнийг төлөвших үйл явцын шинэчлэлд анхаарах хэрэгцээ, шаардлага урган гарсан юм.

Монгол Улсын үндэсний аюулгүй байдлыг хангах үйл ажиллагааны бүрэлдэхүүн хэсэг соёл иргэншил оршин тогтнох, эх оронч иргэдийг төлөвшүүлэх асуудал нь хүүхэд, залуучуудын боловсрол, мэдлэг, чадвараас хамаарч байдаг. Өнөө үед улс орны аюулгүй байдлаа хамгаалах хүч чадавх, нөлөөлж байдаг үндсэн хүчин зүйлүүдийн эх оронч иргэн төлөвшүүлэх асуудлыг боловсронгуй болгож, түүний чанар, үр дүнг дээшлүүлэх явдал тулгамдсан зорилт болж байна.

“Эх орон, үндэс угсаагаа тэргүүн зэрэгт тавьж хамгаалах, хайрлах ухамсартай монгол хүнийг үе шаттайгаар төлөвшүүлэн бэлтгэх нь төрөөс боловсролоор дамжуулан ард иргэдээ соён гэгээрүүлэх үйл явц хэмээн ойлгож, энэхүү үйл ажиллагааг ямар арга замаар дамжуулан хэрэгжүүлбэл үр дүнтэй болохыг судлах нь чухал юм.”⁵

Эх оронч иргэн төлөвшүүлэх асуудлын онолын зарим асуудлыг тодруулж үзье. Боловсролыг өргөн ба явцуу утгаар хэрхэн тодорхойлох талаар эрдэмтэн судлаачдын дунд одоо хүртэл маргаан үргэлжилж байна. Гэвч “Төрөөсөс насан эцэс хүртэл хүн төлөвших, хөгжихөд нөлөөлж буй нийгмийн орчин тэр чигээрээ боловсрол юм” гэсэн үзэл бодол давамгайлж эхэлсэн. Мөн боловсрол хэмээх ойлголтыг судлаачид олон талаас нь тайлбарлаж авч үзсэн байна. Тухайлбал “Боловсрол гэдэг нь латин хэлний “educare”, английн “education” гэсэн үгнээс гаралтай тэжээх, боловсруулах

⁴ Бэгз.Н. Монголын боловсрол судлалын шинэ парадигм. –УБ.,2013.т.127–128

⁵ Орхончимэг.Х.Нийгэм хүмүүнлэгийн ухааны судалгааны арга зүйн үндэс.УБ.,2022.т.13



гэсэн утгатай үг юм. Ийм ч учраас боловсрол нь эхний үед хүүхдийг өсгөх хооллох гэсэн үгтэй ижил утгаар хэрэглэгдэж байсан байна. Орос хэлний “воспитание” гэдэг үг нь дахин тэжээх, тэтгэх гэсэн санааг агуулж байхад хүмүүжил гэдэг нь англи хэлэнд боловсруулах, герман хэлэнд ургуулах өсгөх гэсэн санаагаар илэрч байна. Гэвч хүн төрөлхтөн хойч үеэ сурган хүмүүжүүлэх боловсрол хэмээх нийгмийн институтыг бий болгож хөгжлийнхөө тодорхой үед түүний шинжлэх ухааныг бий болгохдоо эцсийн бүлэгт “боловсрол”, “education”, “образование” хэмээх үгийг хэрэглэж заншжээ.

Өнөөгийн боловсролын ухаан нь дээрх тодорхойлолтоос хальж түүнийг зөвхөн боловсрол мэдлэг олгох талаас нь биш харин бие хүний төлөвшил, түүний үр дүн болох эзэмшсэн мэдлэг, чадвар, амьдрах ерөнхий арга чадварын цогц гэсэн утгаар нь авч үзэх болжээ. Төрөөс боловсролын талаар баримтлах бодлогод “Боловсрол нь Монгол Улсын иргэн бүрийг бүх талаар хөгжүүлэх, шинжлэх ухаан технологийн дэвшил, эдийн засаг, нийгмийн хөгжлийг хурдасгах, материаллаг болон оюуны баялгийг бүтээх чухал эх сурвалж, үндэсний тусгаар тогтнол, аюулгүй байдлын баталгаа мөн” гэж заасан байна.

Боловсрол нь иргэн бүрийг бүх талаар хөгжүүлэх, хүмүүжүүлэх төдийгүй үндэсний тусгаар тогтнол аюулгүй байдлын баталгаа болохын хувьд улсын тусгаар тогтнол, бүрэн эрхт байдал, нутаг дэвсгэрийн бүрэн бүтэн байдал, улсын хилийн халдашгүй дархан байдлыг хамгаалах хүч хэрэгсэл болно. Эх орноо хамгаалах зорилго бүхий улс төр, нийгэм, эдийн засаг, оюун санаа, мэдээлэл, эрх зүй, цэргийн нэгдмэл арга хэмжээтэй салшгүй нарийн холбоотой ойлголт юм.

Боловсрол хүний нийгмийн шинжүүдийг илэрхийлэх нэгэн том үзүүлэлт бөгөөд хүний

хөгжлийн чухал хөшүүрэг болдог. Нийгмийн үзэгдэл, үйл явц болохынхоо хувьд хүний үйл ажиллагаанд шууд тусгалаа олдог олон талтай, өргөн хүрээг хамарсан ойлголт учир боловсролыг олон янзаар тодорхойлж байгаа юм. “Боловсрол нь үр дүн талаасаа түүхэн урт хугацааны явцад хүн төрөлхтний амьдрах ухаан, соёлыг үеэс үед дамжуулж байгаа нийгмийн үзэгдэл, байгаль, нийгмийн орчинд дасан зохицож амьдрах чадвар”⁶ гэснээс харахад үе үеийнхний бүтээн бий болгосон амьдрах арга ухааны цогцыг боловсрол хэмээн харвал эх оронч иргэн төлөвшүүлэх үйл явцыг эрүүл, аюулгүй оршин амьдрах арга ухааны цогц хэмээн ойлгох боломжтой.

Шинжлэх ухааны судлагдахуун, судалгааны чиглэл олон салбартай, өөр өөр үүрэг зорилготой, арга хэрэглүүртэй байдаг учраас тухайн шинжлэх ухааны мэдлэг бүрийг системчлэх, онол тогтолцоонд оруулах явдал нэн чухал болно. Шинжлэх ухаанд тасархай, салангид мэдлэгийн зүйлийг нэгтгэн цэгцэлж, ангилан төрөлжүүлж, онолжуулан дүрэмжүүлэхийг тогтолцоонд оруулах гэнэ. Ингэж танин мэдэхүйн олон талт мэдлэгийн зүйлийг нээн илрүүлж, нэгдсэн тогтолцоонд оруулах, мэдлэгийн системт чанарыг тогтоох нь онолын судалгаа болно”⁷.

Хүн төлөвшүүлэх боловсрол сургалтын асуудлуудыг сурган хүмүүжүүлэх ухаан, сэтгэл судлалын шинжлэх ухааны хүрээнд тайлбарлаж ирсэн нь өнөөдөр хангалтгүй болж, боловсролын тогтолцоо нийгэм, бие хүний хэрэгцээг хангахаа болив. Хүн төрөлхтний иргэншил, нийгмийн хөгжил, шинжлэх ухаан технологи тэр дундаа хүний өөрийн хөгжил, хэрэгцээ нь боловсролыг өөрчлөх, шаардлагыг бий болгож, энэ өөрчлөлтийн талаарх үзэл баримтлал дутагдаж эхэллээ.

Ерөөс нийгмийн үйл явцуудад хүн ихэнх

⁶ Фельдштэйн Д.И. Социальное развитие в пространстве–времени детства М.,1997.стр 29, Санжаабадам.С. Боловсролын чанар ба монголын хүний хөгжлийн хамаарал. Сурган хүмүүжүүлэх ухааны философийн ухааны докторын зэрэг горилсон диссертаци.–УБ.,2001.т.16.

⁷ Баттогтох. Д. Монголын уламжлалт боловсролын онол түүхийн судалгаа. Боловсрол судлалын шинжлэх ухааны докторын зэрэг горилсон диссертаци.–УБ.,2019.т.12.



тохиолдолд бусдын нөлөөллийн үр дүнд янз бүрийн ажиллагаанд татагдан ордог. “ Ийм нөлөө хууль тогтоомж, ёс суртахууны хэм хэмжээ, олон нийтийн дэг журмыг сахихыг хувь хүнээс шаардсан албадлагын шинжтэй байдаг. Үр нөлөөтэй албадлага аажим зуршил болон тогтож, албадлага мэт мэдрэгдэхгүй болдог. Хүүхдийг хүмүүжүүлэх нь үндсэндээ нийгэмд хэвшин тогтсон хэм хэмжээ, зан заншил, биеэ авч явах ёс журмыг сахиулахыг албадахад хүргэдэг. Ер нь хүмүүжил нийгмийн иргэдийг төлөвшүүлэх зорилготой байдаг”⁸ ажээ.

Дүгнэлт

Эх оронч иргэн төлөвшүүлэх үйл явц, мөн чанар, түүний нийгэмд үзүүлэх нөлөө,

аюулгүй байдлын тухай ойлголт, шинэ зууны боловсролын хэрэгцээ, шинж чанар, агуулга, загварын тухай төсөөллүүд яригдаж хийгддэг ч энэ цаг үед тохирсон арга зам түүнийг системчлэн шинжлэх ухааны түвшинд авч үзэх, боловсролын зүй тогтлыг тайлбарлах шинжлэх ухааны зарчим бий болгохыг шаардаж байна. Манай улсын тухайд дотоод аюулгүй байдлаа бэхжүүлэхийн тулд бүх иргэдийг сурган боловсруулах, улс орон, эх нутаг, үндэс угсаа, тусгаар тогтнолоо хамгаалан бэхжүүлэх чадвартай иргэдийг бэлтгэн төлөвшүүлэх нь гагцхүү дан ганц боловсролын салбарын үүрэг биш юм.

Ашигласан материал:

1. Баттогтох. Д. Монголын уламжлалт боловсролын онол түүхийн судалгаа. Боловсрол судлалын шинжлэх ухааны докторын зэрэг горилсон диссертаци.-УБ.,2019.т.12.
2. Бэгз.Н. Монголын боловсрол судлалын шинэ парадигм. -УБ.,2013.т.127–128.
3. Жамц Л. Боловсрол судлалын үндэс. -УБ., 2017. т.28.
4. Өлзийхуяг Б. Батлан хамгаалах боловсрол түүний хэрэгцээ шаардлага. Монгол Улсын Засгийн Газрын хэрэгжүүлэгч агентлаг. Удирдлагын академи. Удирдах эрдэм сэтгүүл. -УБ., 2009. т.163.
5. Орхончимэг.Х.Нийгэм хүмүүнлэгийн ухааны судалгааны арга зүйн үндэс.УБ.,2022.т.13,19,25
6. Фельдштэйн Д.И. Социальное развитие в пространстве–времени детства М.,1997.стр 29, Санжаабадам.С. Боловсролын чанар ба монголын хүний хөгжлийн хамаарал. Сурган хүмүүжүүлэх ухааны философийн хөгжлийн хамаарал. Сурган хүмүүжүүлэх ухааны философийн ухааны докторын зэрэг горилсон диссертаци.-УБ.,2001.т.16.

⁸ Орхончимэг.Х.Нийгэм хүмүүнлэгийн ухааны судалгааны арга зүйн үндэс.УБ.,2022.т.13



МОНГОЛ УЛСЫН БАТЛАН ХАМГААЛАХ БОДЛОГЫН ТҮҮХ (ХХ ЗУУН)

Д.БАТТӨР /УБХИС-ийн ДАЧҮА-ны дарга, дэд хурандаа, магистрант/

Түлхүүр үг: Батлан хамгаалах бодлого, тусгаар тогтнол, эрх чөлөө, энх тайван

Key words: defence policy, independence, freedom, peace

Оршил. Батлан хамгаалах бодлого (*Defence policy, Оборонная политика*) судлал нь анх эртний Грек, Ромын соёл иргэншлийн нөлөөн дор хөгжиж ирсэн байдаг. Онолын хувьд авч үзвэл **батлан хамгаалах бодлого** гэдэг нь улс орноо гаднын зэвсэгт халдлагаас хамгаалах бэлтгэлийг хангах, хамгаалахад чиглэсэн улс төр, эдийн засаг, нийгэм, эрх зүй, цэрэг–техник, оюун санааны агуулга бүхий үйл ажиллагааны хүрээг хамардаг төрийн бодлого юм.

Монгол Улсын батлан хамгаалах бодлогын түүх нь эртний төрт улс Хүннү гүрэн байгуулагдсан цаг үеэс эхлэн тооцогддог. Хүннү гүрэн болон түүнээс хойш байгуулагдсан хаант улс болон эзэн Чингис хааны байгуулсан эзэнт гүрний үед чадварлаг батлан хамгаалах бодлогын хүчээр улс орноо батлан хамгаалж иржээ. Монголын бага хаадын үед улс төрийн хямрал нүүрлэн батлан хамгаалах бодлого алдагдаж харийн орны нөлөөнд орж тусгаар тогтнолоо алдсан түүхтэй.

Манжийн нөлөөнд 200 гаруй жил оршсон Монголын ард түмэн ХХ зууны эхээр тусгаар тогтнолоо сэргээн мандуулж Богд хаант Монгол Улсыг байгуулснаар манай улсын батлан хамгаалахын бодлогын нэгэн шинэ үеийн түүх эхэлж байгаа юм.

Цэргийн нэрт түүхч Д.Гомбосүрэн агсан “Монгол Улсын Зэвсэгт хүчний байгуулалтын түүх” бүтээлдээ ХХ зууны Монгол Улсын батлан хамгаалах бодлогыг судалгааны арга зүйн үүднээс дараах таван үед хувааж үзсэн байдаг. Үүнд:

1. Олноо өргөгдсөн Монгол Улсын батлан хамгаалалт /1911.11–1921.07 сар/;
2. Батлан хамгаалах төрийн бие даасан бодлогын төлөөнөө /1921.07–1936.03

сар/;

3. Зөвлөлт Холбоот Улсын цэргийн хүчийг давуутай ашиглах батлан хамгаалах бодлого /1936.03–1945.09/;
4. Монгол Улсын энх тайван ч гадаад бодлого /1946–1960–аад он/;
5. Дэлхийн социалист хамтын нөхөрлөлийг цэргийн хүчинд тулгуурласан батлан хамгаалах төрийн бодлого /1960–аад он 1980–аад оны сүүл/.

Өгүүлэн буй үеийн батлан хамгаалах бодлогын мөн чанар, өөрчлөлт хувьсал, агуулга чиглэлийг тус бүрд нь тэрээр тодорхой байдлаар оновчтой тайлбарлан бичсэнтэй санал нийлэхийн сацуу өөрийн санал дүгнэлтийг ч нэмэр болгох үүднээс уг судалгааг хийлээ.

1. Олноо Өргөгдсөн Монгол Улсын батлан хамгаалалт /1911.12–1921.07/.

Үндэсний чөлөөний 1911 оны хувьсгалын дараахан зовж олсон эрх чөлөө, тусгаар байдлаа батлан хамгаалахын тулд үндэсний цэргийг сэргээн байгуулах явдал шинэ төрийн нэн чухал зорилт болж байсан юм.

Гэхдээ тэр зэвсэгт хүчин нь үндэсний уламжлалд (морьт цэрэг) суурилахын зэрэгцээ орчин цагийн Европ маягийн байх ёстой байлаа. Ийм байхыг ч цаг үе шаардаж байв. Тиймээс хамгийн ойр дотно Хаант Орос Улсад хандан тусламж хүсжээ.

Энэ саналыг Оросын тал хүлээн авч, улмаар Монгол, Орос хоёр улсын хооронд 1912.11.02–нд байгуулсан найрамдлын гэрээ бичигт тусгажээ. Уг гэрээний §1–д: “Их Орос Улсын Хаан эзний засгийн газраас Монгол улсад туслахад өөртөө тогтнож, өөртөө зээрхэх ёс журам, өөрийн газарт Хятадын цэрэг ба



нүүдлийн иргэдийг оруулахгүй¹ байлгах, түүнээс хамгаалах зэвсэгт хүчинтэй болоход нь тусална” гэсэн байна.

Ингээд Хаант Оросын зээл хөрөнгө, сургагч нарын тусламжтайгаар европ ба монгол уламжлал хосолсон үндэсний цэрэгтэй болох үүднээс 1912 онд Хужирбулан Европ маягийн анхны цэргийн сургуулийг байгуулжээ. Уг сургуулийн төгсөгчид 1912 онд Ховдыг чөлөөлөх, Өвөр Монголыг чөлөөлөх 1913 оны Таван замын байлдааны ажиллагаанд тус тус оролцжээ. Энэ тухай зарим судлаачдын бичсэнчлэн “ХХ зууны эхэнд төр улсаа сэргээн мандуулсан Богд Хаант Монгол Улсын засгийн газар улс орны хил хязгаарыг батлан хамгаалах, тусгаар тогтнолоо бэхжүүлэх олон асуудлуудтай нүүр тулсан билээ. Чухам энэ үед Монгол Улсын Баруун хязгаарт цагийн байдал тайвангүй, Ховд хот Манж, Хятадын хоргодох үүр болж, тэднээс хотыг чөлөөлөх явдал нь нэн тулгамдсан асуудал болж байсан²”. Гэвч тун удалгүй Хаант Орос, Дундад Иргэн Улсын явцуу бодлогын уршгаар 1915.06 сард Хиагтын гурван улсын хэлэлцээрийн дунд Монгол Улсын тусгаар тогтнол цуцлагдаж, зэвсэгт хүчин үгүй болж батлан хамгаалах бодлого алдагдаж автономит эрхтэй үлдсэн юм.

Монголын ард түмний хүсэл дахин биелж 1921 онд ардын хувьсгалыг эхлүүлснээр батлан хамгаалах бодлогын бас нэгэн шинэ үе эхэлсэн юм. Үндэсний ардчилсан хувьсгалын үр дүнд улс төрийн тусгаар тогтнолоо дахин мандуулж чадсан Монгол Улсад олсон эрх чөлөөгөө гадаадынхны гарт дахин алдахгүй байх нь төрийн бодлогын гол цөм болж байв. Тиймээс Хаант Оросын суурин дээр байгуулагдсан Зөвлөлт Орос Улсын тусламжаар зэвсэгт хүчнээ дахин байгуулж батлан хамгаалах бодлогоо жинхэнэ социалист маягаар байгуулах замдаа

оржээ.

Улсын анхдугаар Их хурал (1924.4 сар) хуралдаж, Монголын түүхэнд анхны Үндсэн хуулиа баталсан бөгөөд БНМАУ-ын Үндсэн хуульд: “Жинхэнэ ард түмний эрх чөлөөг бүрэн бүтнээр хамгаалах ба басхүү гадаад, дотоодын харгис шунахай нарын эрх мэдэл дахин хөгжих замыг таслан сэргийлэх³”-ийн тулд нэгд, ардын хувьсгалт цэргийг байгуулах, хоёрт, бүх улсын залуу ардыг цэргийн эрдэмд боловсруулахыг заажээ.

МАХН-ын VII Их хурал (1929 он), БНМАУ-ын VI Их хурал (1930)-ын шийдвэрийг үндэслэн хориод оны сүүлчээс “феодалын хөрөнгө хураах”, “жасын компани”, “хамтралжуулах” гэх зэрэг ангич хатуу бодлогыг нам, төрөөс баримтлах болсон нь сөрөг үр дагаварт хүргэж, улмаар дээр өгүүлсэн “дотоодын” дайсныг дарахад батлан хамгаалах бодлогын үүргийг гажуудалд хүргэсэн гашуун туршлага бидэнд бий. Энэ бол 1929–1932 онд улс орныг хамарч гарсан үймээн самуун, цагаачлал, эцэст нь 1932 оны зэвсэгт бослого гаргахад хүргэсэн юм. Хэдийгээр батлан хамгаалах бодлогод ийм гажуудал доголдол илэрч байсан боловч энэ талаарх төрийн бие даасан бодлого хараахан алдагдаагүй гэж үзэж болно.

Улсын VII Их хуралд (1934 он) Улсын Бага хурлын дарга, монгол төрийн томоохон түшээ А.Амар тавьсан илтгэлдээ: “Улсыг батлан хамгаалах явдлыг зузаатгах, харьяат улсыг эзэрхэг түрэмгий нарын зүгээс довтлон халдахыг (гадаадын) бэлтгэж буй байдлаас аль болохоор хамгаалах зэрэг явдлууд нь үүний урьд ч, эдүгээ ч бат бэхээр явж байна⁴” гэж онцлон хэлжээ. Энэ бол батлан хамгаалах бие даасан бодлогын илэрхийлэл мөн.

Энэ үеийн батлан хамгаалах бодлого нь Улаан армийн туслан хамгаалах цэргийн ба

¹ Монголын ард түмний 1911 оны үндэсний эрх чөлөө, тусгаар тогтнолын төлөө тэмцэл. Баримт бичгийн эмхэтгэл. 1900–1914. УБ., 1982.т.75

² Орхончимэг.Х, Оюундэлгэр.Н. Ховдыг чөлөөлөх байлдаанд гавьяа байгуулсан зарим хүмүүсийн үүргийг тодруулах нь. Ховд хотыг Магжийн эрхшээлээс чөлөөлсний 110 жилийн ойд зориулсан эрдэм шинжилгээний хурлын илтгэл. 2022.09.15–16

³ БНМАУ-ын Их, Бага хурлын тогтоол. Үндсэн хууль. Тушаалууд. УБ., 1956.т.31

⁴ Улсын VII Их хуралд илтгэх ... Амарын илтгэл. УБ., 1934. т.11



мэргэжилтнүүдийн тусламжтайгаар өөрийн зэвсэгт хүчнээр эх орноо хамгаалах үзэл баримтлал болж байжээ.

БНМАУ-ын хувьд хамгийн ээдрээтэй бөгөөд дэлхийн хоёрдугаар дайны хүнд үетэй давхацсан үе байлаа. Учир нь дэлхийн улс төрийн бодлогыг АНУ, Англи, ЗСБНХУ зэрэг холбоотон улс гүрэн, нөгөө талаас Гитлерын Герман, Итали, Япон зэрэг хүчин тодорхойлох болсон явдал бүх улс орныг, түүний дотор БНМАУ-ыг аль нэг хүчний талд зүй ёсоор татан оруулахад хүргэв.

БНМАУ, ЗСБНХУ-ын Засгийн газар харилцан туслах протоколд 1936.03.12-нд гарын үсэг зурав. Уг баримт бичигт: *“Бүгд Найрамдах Монгол Ард Улс ба Зөвлөлийн засаг нийгэм журамт Бүгд Найрамдах Холбоот Улсын Засгийн газрууд хэрэв энэхүү гэрээг тогтоосон нэг этгээдийг цэргээр довтолбол бие биедээ элдэв тусламж, мөн цэргийн зэвсгийн тусламжийг үзүүлэх үүргийг хүлээнэ”*⁵ хэмээсэн нь батлан хамгаалах бодлогоо гаднын тусламжтайгаар хэрэгжүүлнэ гэж шууд тодорхойлсон акт болжээ.

БНМАУ-ын хил хязгаарт Япон-манжийн зүгээс учруулж байсан зэвсэгт халдлага нь 1939 оны Халхын голын дайнд хүргэсэн бөгөөд энэ дайнд улсын батлан хамгаалах бодлого өндөр түвшинд хүрч улс орон бүхэлдээ дайны байдалд шилжсэн нь улсын төсвийнхөө 60 хувийг зарцуулснаас харагдана.

Халхын голын дайны дараа дэлхийн хоёрдугаар дайны үед болон дайны төгсгөлд БНМАУ-ын батлан хамгаалах бодлого нь цэвэр улс орныхоо аюулгүй байдлыг хангахад чиглэгдэж байлаа.

Дэлхийн II дайн дууссаны дараа дэлхийн улс орнууд энх тайван ч гадаад бодлогыг баримтлах болсон тэр цаг үед БНМАУ-ын батлан хамгаалах бодлого ЗХУ-ын гадаад бодлогыг дагаад өөрчлөгдсөн билээ. Энэ

жилүүдэд БНМАУ Зэвсэгт хүчнээ татан буулгаж, бие бүрэлдэхүүнээ улс орны энх цагийн бүтээн байгуулалтад оролцуулсан нь ЗХУ тэргүүтэй ардын ардчилсан орнуудын дэлхий дахины хандлагын бодит жишээ юм.

Манай улсын хөршүүд болох ЗСБНХУ ба БНХАУ-ын улс төр, үзэл суртлын харилцаанд гарсан зөрчлөөс үүдэлтэйгээр батлан хамгаалах бодлого дайны дараа өөрчлөгдөж эхэлсэн юм.

Зөвлөлт Хятадын хилийн маргаан болох Даманы арлын хэрэг явдлаас болж хоёр улс муудалцсан бөгөөд БНМАУ нь энэ сөргөлдөөний талбар болох шахсан бөгөөд эргээд зэвсэгт хүчнээ шинэчлэн зохион байгуулж батлан хамгаалах бодлогоо ч гэсэн эргэж харах зайлшгүй шаардлагатай тулгарсан.

Ийм нөхцөлд МАХН-ын Төв Хороо, БНМАУ-ын Засгийн газар улс орны батлан хамгаалалтыг зузаатгахад чиглэсэн тодорхой бодлого боловсруулж, баримтлах болсон юм.

ЗСБНХУ-аас БНМАУ-д тусгай эд хогшил нийлүүлэх тухай Монгол-Зөвлөлтийн хэлэлцээрийг 1964.09.21-нд байгуулжээ. Энэ хэлэлцээрийн дагуу Зөвлөлт Социалист Бүгд Найрамдах Холбоот Улсын засгийн газраас Бүгд Найрамдах Монгол Ард Улсын Засгийн газарт ихээхэн хэмжээний цэргийн эд хогшлыг буцалтгүй тусламжийн хэлбэрээр нийлүүлэх болсон байна. Энэ бол цэргийн зэвсэг техник байсан юм.

БНМАУ-ын Засгийн газар төсвийнхөө тодорхой хэсгийг батлан хамгаалахад зориулдаг болов. Тухайлбал, батлан хамгаалах зардал 1960 онд 63.1 сая төгрөг 6.4 хувь⁶ байсан бол 1980 онд батлан хамгаалах ба бусад зардал 650.1 сая төгрөг 16.1 хувь, 1987 онд 762.2 сая төгрөг 11.8 хувь⁷ болж байв.

БНМАУ, ЗСБНХУ-ын хооронд 1966 оны 01 сард байгуулсан найрамдал, нөхөрлөл, харилцан туслалцах тухай гэрээний дагуу хоёр орны засгийн газрууд БНМАУ-ын нутаг

⁵ Монгол-Зөвлөлтийн харилцаа. Баримт бичиг, материалын эмхэтгэл. I боть. УБ., 1976.т.395

⁶ Долгормаа Б. БНМАУ-ын төсөв. УБ., 1982.т. 24

⁷ Долгорын Лувсанцэрэн. Действенности финансово-бюджетных рычагов в новых условиях хозяйствования в МНР. М.,1990. с.91



дэвсгэрт Зөвлөлтийн цэргийг байрлуулах тухай хэлэлцээрт 1967.03.04–нд гарын үсэг зуржээ. Энэ үндсэн дээр Зөвлөлтийн цэргийн бүлэг 1967–1992 онд Монголд байрлаж байв.

Зөвлөлтийн тэргүүн М.С.Горбачев 1986.07.28–нд Владивостокт хэлсэн үгэндээ анх *“Монгол улсаас Зөвлөлтийн цэргийн үлэмж хэсгийг гаргах тухай асуудлыг БНМАУ–ын удирдлагатай одоо хэлэлцэж байна”* гэж мэдэгдсэний дагуу Монголын нутгаас 1987–1992 онд оросын цэргийн томоохон бүлэглэлийг гаргасан билээ. Улмаар 1992 онд Монгол Улс шинэ үндсэн хуулиа батлан батлан хамгаалах бодлогоо гаднын ямар нэгэн улсын дэмжлэггүйгээр бие даан хэрэгжүүлэх үндэс бий болжээ.

Дүгнэлт. БНМАУ–ын удирдлага 1921–

1980–д оны сүүл үе хүртэл батлан хамгаалах асуудлаа социалист хамтын нөхөрлөлийн хүчинд, Варшавын гэрээний байгууллага, түүний дотор Зөвлөлтийн цэргийн хүчинд тулгуурлан шийдвэрлэж байсан юм.

Учир нь тухайн үеийн БНМАУ–ын хүн ам, нийгэм эдийн засгийн хүчин чадал, цэргийн чадавх сул, эргэн тойрон дахь улс төрийн нөхцөл байдал хүнд, манай улсын тусгаар тогтнолыг хүлээн зөвшөөрөх хандлагагүй, мөн НҮБ–ын гишүүн болоход их цаг хугацаа шаардаж байсан юм. Батлан хамгаалах бодлого бол улс орны нийгэм эдийн засгийн хүчин зүйлстэй шууд уялдаж байдаг учир жижиг буурай орны хувьд аль улсын нөмөр нөөлөгт найдах нөхцөлийг бий болгож байсан нь өнгөрсөн XX зууны түүхээс тодорхой харагдаж байна.

Ашигласан материал:

1. Монголын ард түмний 1911 оны үндэсний эрх чөлөө, тусгаар тогтнолын төлөө тэмцэл. Баримт бичгийн эмхэтгэл. 1900-1914. УБ., 1982
2. БНМАУ–ын Их, Бага хурлын тогтоол. Үндсэн хууль. Тушаалууд. УБ., 1956
3. Улсын VII Их хуралд илтгэх . . . Амарын илтгэл. УБ., 1934
4. Монгол-Зөвлөлтийн харилцаа. Баримт бичиг, материалын эмхэтгэл. I боть. УБ., 1976
5. Долгормаа Б. БНМАУ–ын төсөв. УБ., 1982
6. БХЭШХ. “XX зууны Монгол цэрэг” УБ., 2001
7. БХЭШХ. “Монгол цэргийн түүхийн товчоон” УБ., 1996 он
8. Д.Гомбосүрэн. “Монголын зэвсэгт хүчний байгуулалтын түүх-XX зуун” УБ., 2013



ҮНДЭСНИЙ ЭВ НЭГДЭЛД НӨЛӨӨЛЖ БҮЙ ХҮЧИН ЗҮЙЛСИЙН ЗАРИМ АСУУДАЛ

Б.ТАМЖИДДОРЖ /УБХИС-ийн магистрант/

Түлхүүр үг: Үндэсний эв нэгдэл, нөлөөлөх хүчин зүйлс, Авилга ба шудрага бус байдал, Ядуурал ба тэгш бус байдал, Төрийн тогтворгүй байдал, улс төрийн хямрал.

Key words: National Unity, Influencing Factors, Corruption and Dishonesty, Poverty and Inequality, State Instability, Political Crisis

ОРШИЛ. Даяаршиж буй өнөө үед цагаачлал, эдийн засгийн хямрал, зэвсэгт мөргөлдөөн, шашин хоорондын зөрчил зэрэг олон хүчин зүйлсийн улмаас дэлхийн улс орнууд үндэсний эв нэгдлээ хангахыг аюулгүй байдлын бодлого, үйл ажиллагааныхаа тэргүүлэх чиглэл болгон, улмаар ард түмнийг нэгтгэдэг шинэ үндэсний онцлог хэв шинж, үнэт зүйлийн эрэлд мордоод буй. Европын орнуудад цагаачид, дүрвэгчид олноор суурьшснаар үндэсний эв нэгдлээ хангахын тулд “олон ургалч” байдлыг эрхэмлэсэн шинэ үнэт зүйлсийг эрэлхийлэх болсон бөгөөд уламжлалт “зан заншил”, “шашин” зэрэг үндэсний онцлогоос илүүтэй өөр өөр шашин шүтлэг, арьс өнгө, угсаа гаралтай, өөр өөр хэлээр ярьдаг хүмүүсийг нэгэн улс оронд эв нэгдэлтэй амьдрах үнэт зүйлийг бүтээх, дэлгэрүүлэхийг эрмэлзэж байна. Улс үндэстнүүд дотоодын эвдэрэл, хагарал, зөрчил, мөргөлдөөнөөс зайлсхийх, улмаар улс үндэстнээ хамтын хүчээр хөгжүүлэн урагшлуулахад нэгдмэл үнэт зүйлтэй байх нь чухал тул цагаачид, дүрвэгчид, олон үндэстэн угсаатнаас бүрдсэн улс орнууд үндэсний онцлогоо шинээр тодорхойлоход хүрч байна.

ҮНДСЭН ХЭСЭГ. Үндэсний эв нэгдлийг бэхжүүлэхийн тулд үндэсний онцлог хэв шинжийг бүрдүүлэх нь хамгийн чухал юм. Үндэсний хэв шинжийг бүрдүүлж чадаагүй тохиолдолд угсаатны, нийгмийн давхаргын, бүлгийн гэх мэт хэв шинж давамгайлж нийгэмд хуваагдал, задрал үүссээр байх болно. Монгол хүн иргэний хувьд ямар байх, ямар боловсрол

хүмүүжилтэй байх, амьдралын ямар хэв шинж, үзэл бодолтой байх, ямар мөрөөдөл тэмүүлэлтэй байх талаар нэгдсэн ойлголт бүрдээгүй, үндэсний нэгдмэл ухамсар, үзэл санаа дутмаг байна. Монгол хүн өнгөрсөн түүхээрээ бахархахын зэрэгцээ ирээдүйд чиглэсэн хүсэл эрмэлзэлтэй байх ёстой бөгөөд үүнд төрийн, ялангуяа боловсролын салбарын бодлого, үйл ажиллагаа чухал үүрэгтэй.

Улс төр судлаач Фрэнсис Фукуяама “Identity” номондоо “Үндэсний ялгарал нь сул байгаа Сири, Йемен, Ливи зэрэг орнуудад дотоод, зөрчил мөргөлдөөн салдаггүй. Ирак, Афганистан, Сомалид ч орчин үеийн төр бий болоход нэгдмэл бус байдал нь хойш татсаар байна. Гэтэл Япон, Өмнөд солонгос, Хятад зэрэг орнуудад барууны ертөнцтөй тулгарахаас өмнө ч үндэсний ялгарал бий болсон байжээ” хэмээн тодорхойлжээ.

“Үндэсний ижилсэл буюу бусад улс үндэстнээс ялгарах онцлог (national identity) гэдэг нь аливаа хүн аль нэг улс орон эсвэл үндэстэнд харъяалагддаг гэх хувь хүний мэдрэмж, өвөрмөц, онцлог шинж байдал юм”¹ хэмээн тодорхойлсон байдаг. Сэтгэл судлалын ухааны өнцгөөс харвал өөр ялгаатай байдлаа мэдрэх, “тэд”–нээс ялгарах “бид” хэмээх нэг бүлэгт хамааруулах хандлагатай байдаг.

Үндэсний эв нэгдэлд нөлөөлөгч хамгийн чухал хүчин зүйлсийн нэг нь Үндэсний онцлогоо дээдлэх явдал бөгөөд шинжлэх ухаан технологийн дэвшил хурдацтай хөгжин даяаршиж буй өнөөгийн нийгэмд нэгдмэл, нэг

¹ Ashmore, Richard D.; Jussim, Lee; Wilder, David, eds. (2001). Social Identity, Intergroup Conflict, and Conflict Reduction. Oxford University

үнэт зүйлтэй байх нь улс орны эв нэгдлийг бэхжүүлдэг.

АНУ-ын Вашингтонд төвтэй Пев судалгааны төвөөс гаргасан судалгаагаар улс үндэстнийг нэгтгэж байдаг үндэсний ижилсэл буюу Дэлхийн хаана ч явсан би “Монгол хүн”, би “Америк хүн” гэж тодотгож байдаг тэрхүү үндэсний онцлог гэдэгт дараах 4 зүйлийг хамруулж судалгаа хийжээ. Үүнд:

- Эх хэл
- Үндэсний зан заншил, өв уламжлал
- Төрсөн газар орон
- Итгэл үнэмшил буюу шашин зэргийг

хамруулсан

Үндэсний түүх, хэл, соёл, өв уламжлал, зан заншлаа хадгалж, хамгаалж хөгжүүлэх нь аливаа үндэстний оршин тогтнохын үндэс, амин чухал дархлаа юм. Улс үндэстнийг нэгтгэн зангидаж байдаг үндэсний ижилсэл буюу бусад улс үндэстнээс ялгах тэрхүү онцлог нь хэл, бичиг, үндэсний соёл, өв уламжлал, зан заншил хэмээн ерөнхийлөн тодорхойлж болох юм. Аливаа улс үндэстнийг нэгтгэн зангидаж байдаг үндэсний ижилсэл буюу бусад улс үндэстнээс ялгах тэрхүү онцлог болох хэл соёл, өв уламжлал, зан заншлаа хадгалан хамгаалж үеийн үед өвлүүлэн уламжилж, үргэлж бахархан дээдэлж явах нь үндэсний аюулгүй байдлын гол тулгуур болох үндэсний эв нэгдлийг хангахад чухал ач холбогдолтой юм.

Өөр өөр гарал угсаа, хэл соёл, шашин шүтлэг, амьдралын хэв маягтай үндэстэн угсаатангууд нэг улсын газар нутагт, эх орноо гэсэн нэг итгэл үнэмшилийн дор үндэсний эв нэгдлээ эрхэмлэн хамтдаа оршин тогтноход хэл, боловсрол, хууль, эдийн засаг, нийгмийн хүчин зүйлс нөлөөлдөг.

Монгол Улс ардчилсан тогтолцоонд шилжиж 1992 оны нэгдүгээр сард үндсэн хууль батлагдсанаар түүний Нэгдүгээр бүлгийн агуулгаар үндэсний аюулгүй байдлын үзэл санаа бэхжих үндэс суурь тавигджээ.

Үндсэн хуулийн оршил хэсэгт “Монголын

ард түмэн бид: улсынхаа тусгаар тогтнол, бүрэн эрхт байдлыг бататган бэхжүүлж, хүний эрх, эрх чөлөө, шударга ёс, үндэснийхээ эв нэгдлийг эрхэмлэн дээдлэж, төрт ёс, түүх, соёлынхоо уламжлалыг нандигнан өвлөж, хүн төрөлхтөний соёл иргэншлийн ололтыг хүндэтгэн үзэж, эх орондоо хүмүүнлэг, иргэний ардчилсан нийгэм цогцлуулан хөгжүүлэхийг эрхэм зорилго болгоно” гэж тодорхойлсон юм.

Үндсэн хуулийн хүрээнд батлагдан гарсан үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалуудад (1994, 2010), Үндэсний аюулгүй байдлыг хамгаалан, бэхжүүлэх төрийн бодлогыг тодорхойлохдоо үндэсний эв нэгдлийг чухалд авч үзсээр иржээ.

Үндэсний эв нэгдэл бол нийгмийн болон соёлын бүлгүүдийг нэгтгэхэд хувь нэмэр оруулах үйл явц юм. Үндэсний нэгдмэл байдал нь нийгмийн дэг журмыг бий болгох, түүний үндсэн болон суурь үзэл баримтлал, үнэт зүйлсийг хөгжүүлэхэд тусалдаг. Үндэсний хэмжээнд эв нэгдэл нь улс орны тогтвортой байдлыг бэхжүүлж, хөгжил цэцэглэлтийг дэмжиж, үндэстнээ нэгтгэх үйл явц юм. Эв нэгдэл нь нэг талаас нийгэм, соёлын нэгдмэл байдлыг бий болгох замаар хүчирхэг, нэгдмэл улс байгуулах үндэсний ашиг сонирхол дээр тулгуурладаг.

Үндэсний эв нэгдэл. Үндэсний эв нэгдэл нь үндэсний тогтвортой байдалд чухал ач холбогдолтой бөгөөд тогтвортой байдал нь нийгэм, эдийн засгийн хөгжлийн хөтөлбөрүүдийн хэрэгжилтийг хангаж өгдөг. Аливаа улс оронд үндэсний эв нэгдэл яагаад чухал вэ? гэдэг асуултад хариулахдаа нийгэм судлаачид дараах дөрвөн үзэгдэлийг онцолсон байдаг². Үүнд:

Үндэсний эв нэгдэл улс оронд баттай тогтсоноор:

1. Үндэстэн, ястан хоорондын сөргөлдөөн тэмцэл багасч, нэг улс оронд амьдарч буй өөр өөр үндэстэн, ястангуудын хооронд **эв найрамдал** бий болдог.
2. Эх оронч сэтгэлгээг бий болгодог. Өөр

² Social Studies by Simiyu Wandibba, pp. 231–233.



өөр үндэстэн ястны нэг төлөөлөл гэхээс илүүтэйгээр нэг улс орны иргэн гэдгээ ойлгож, **эх орноо хайрладаг**.

3. **Энх тайван байдал** бий болно. Үр дүнд нь улс орныхоо өнцөг булан бүрт тайван амгалан ажиллаж, амьдрах боломж хүн бүрийн өмнө нээгддэг.
4. Өөр өөр угсаатан, ястангууд **хоорондоо гэр бүл болохыг дэмждэг**. Энэ нь үндэсний эв нэгдэлийг илүү ахисан түвшинд гаргаж, бэхжүүлж байдаг гэсэн байна.

Үндэсний эв нэгдэлийг бэхжүүлэх үндсэн үзэл баримтлал нь:

1. Үндэсний нэгдмэл байдал нь өөр өөр угсаатан, ястан, шашны бүлгүүд хоорондын харилцан ойлголцлыг нэмэгдүүлэхэд чиглэсэн төрийн бодлогын зорилт юм.
2. Нэгдмэл байдал нь нийтлэг хэм хэмжээ, үнэт зүйлс, эрх ашиг бүхий нэгдмэл бүлгийг бий болгох үйл явц юм.
3. Үндэсний эв нэгдлийн үзэл баримтлал нь нийгэм, улс орныг бүхэлд нь үндэсний үзэл баримтлалаар нэгтгэх үйл явц бөгөөд ингэснээр иргэдэд нийтлэг эрхэмлэдэг зүйлс, нийтлэг үнэт зүйлст хамаарах мэдрэмжийг бий болгож чадна.
4. Төрөөс интеграцийн гурван үндсэн ойлголтыг нийгэмд ойлгуулах хэрэгтэй ба энэ нь соёлын нэгдмэл байдал, хамтын ажиллагаа, олон ургалч үзэл юм.

Үндэсний эв нэгдэл нь эх оронч үзэл дээр суурилдаг. Эх оронч үзэл нь ард түмнээ нэгтгэж, улс орныхоо сайн сайхны төлөө хамтран ажиллахад урам зориг өгч дэмждэг юм. Үндэсний эв нэгдэл нь соёл, нийгэм, бие махбод, хэл шинжлэл, шашин шүтлэг, улс төр, үзэл суртал, сэтгэл зүйн олон ялгаатай байдгаас үл хамааран эв нэгдлийг бий болгоход чиглэдэг. Тэгвэл Монгол Улсын эв нэгдэлд сөргөөр нөлөөлж буй **дотоод хүчин зүйлсийг** Стратеги судалгааны хүрээлэнгийн Нийгэм, төрийн судалгааны секторын 2021 оны 5 дугаар сард хийсэн судалгааны үр дүнд тодорхойлсон бөгөөд тэдгээрийг нөлөөллийн эрэмбэлсэн

байна. Үүнд:

1. Улс төрийн намаараа талцан хуваагдах үзэгдэл
2. Нийгмийн ёс суртахууны доройтол
3. Төрийн тогтворгүй байдал
4. Төрийн албаны мерит зарчмын алдагдал
5. Улс төрийн сонгуулийн гажуудал
6. Хуулийн хэрэгжилтийн ялгавартай байдал
7. Авилга
8. Ажилгүйдэл, орлогын тэгш бус хуваарилалт
9. Хэвлэл мэдээллийн байгууллагын тэнцвэргүй мэдээлэл
10. Мэдээллийн хяналтгүй урсгал, нийгмийн сүлжээний соёлгүй хэрэглээ
11. Даяаршил ба гадны зөөлөн хүчний бодлогын нөлөөлөл, шашин шүтлэгийн хуваагдал гэсэн асуудлууд оржээ. Эдгээрээс дараах хүчин зүйлсүүдэд дүн шинжилгээ хийж үзвэл:

Авилга ба шудрага бус байдал. Бие даасан, хараат бус, ил тод, сайн нөөцтэй шүүх болон хууль сахиулах байгууллагууд нь авилгатай тэмцэхэд нэн чухал. Гэхдээ улс төрийн эрх мэдлийг урвуулан ашиглах, хахуульдах зэрэг авилгын бусад хэлбэрээр шудрага ёсны тогтолцоог үр нөлөөтэй байлгах үндэс юм.

“Авилга нийгэм дэх шудрага бус байдлыг дордуулж, хамгийн эмзэг бүлгүүдэд тэгш бус нөлөөлдөг. Ихэнх улс орнуудад авлигаас хохирогч нарт хэргээ шударгаар шийдүүлэхэд саад байсаар байна. Шат бүрдээ хохирогч нарын дуу хоолойг сонсдог шудрага бөгөөд хүртээмжтэй эрх зүйн тогтолцоог хүн бүр хүртэх эрхтэй. Үүнээс бусад зүйл бол шудрага ёсыг дормжилсон явдал юм” гэж Транспэрэнси интернэшнлийн Гүйцэтгэх захирал Daniel P. Eriksson тэмдэглэсэн байна.

“Авилга гэдэг нь итгэж хүлээлгэсэн эрх мэдлийг амин хувийн сонирхлоор ашиглах явдал юм. Авилгын өртөг, өртөгдсөн салбараас хамаарч жижиг авилга, өндөр түвшний авилга, улс төрийн авилга гэх мэт төрөлүүдтэй байж болно.

Авилгын төсөөллийн индекс нь дараах



хүчин зүйлсийн хамруулж үздэг.

- Улсын төсвийн хөрөнгийг зориулалтын бусаар зарцуулж байгаа эсэх,
- Нийтийн албан хаагч албан тушаалаа урвуулан ашиглаж байгаа эсэх,
- Төр засаг авилгын эсрэг үр дүнтэйгээр тэмцэж шудрага байдлыг төрийн салбарт хэвшүүлж байгаа эсэх,
- Зориудаар хүнд суртлыг бий болгож авилгыг өөгшүүлж байгаа эсэх,
- Төрийн албанд ур чадвар эсвэл танил талаараа томилгоо хийж байгаа эсэх,
- Авилгын хэрэгт холбогдсон төрийн албан тушаалтанд хариуцлага тооцож байгаа эсэх,
- Албан тушалтны хөрөнгө орлогын мэдүүлэг авах, ашиг сонирхлын зөрчлөөс сэргийлэх хангалттай хууль эрх зүйн орчин байгаа эсэх,
- Авилгыг мэдээлсэн шүгэл үлээгч, сэтгүүлч нарыг хамгаалсан хууль зүйн орчин байгаа эсэх,
- Төрийн үйл ажиллагааны мэдээлэл олон нийт, иргэний нийгэм, хэвлэл мэдээллээр нээлттэй эсэх,
- Бизнес, улс төрийн бүлэглэлүүдийн далд ашиг сонирхол зэрэг хамаарна.

Хүснэгт №1.

Монгол Улсын Авилгын төсөөллийн индексийн сүүлийн таван жилийн үнэлгээ

Он	2018	2019	2020	2021	2022	2023
Оноо /100 хүртэл/	37	35	35	35	33	33
Байр /180 орноос/	93	106	111	110	116	121

Ядуурал ба тэгш бус байдал. Тэгш бус байдал гэлэг ойлголт ардчилал, чөлөөт зах зээлийн сүүдэрт нуугдсаар байжээ. Багагүй хугацаанд эрдэмтэд орлого болон хөрөнгийн тэгш бус байдал нь нийт эдийн засагт үр өгөөжтөй өсөлтийг нэмэгдүүлэх нөлөөтөй учраас асуудалгүй гэж үзсээр ирсэн бол Олон Улсын валютын сан, Эдийн засгийн хамтын ажиллагааны байгууллага, олон улсын зарим эдийн засагчид улам гүнзгийрч буй эдийн

засгийн тэгш бус байдал нь нийт эдийн засгийн хөгжилд сөрөг нөлөө үзүүлж байна гэдгийг анхааруулсаар иржээ.

Халамжаар амьдрагсдын тоог бууруулж, иргэдийнхээ амьдралын чанарыг дээшлүүлэхийн тулд нийгэмд тэгш бус байдлыг бий болгож, гүнзгийрүүлж байдаг үндэс шалтгааныг олж арилгах шийдлүүдийг хайж, алдаагаа засаж залруулах шаардлага тулгардаа.

Нийгмийн тэгш бус байдлыг бууруулах нь ардчиллыг бэхжүүлэх гол үндэс болдог бол нийгмийн гишүүдийн орлогын ялгаа гүнзгийрэх нь үндэсний эв нэгдэлд ихээхэн халтай юм.

Монгол Улсын хувьд хүн амын ядруулын түвшин 2018 онд 28.4 хувь, 2020 онд 27.8 хувь, 2022 онд 27.1 хувь болж 0.7 хувиар буурсан үзүүлэлттэй байна.

Ядуурлын томоохон хүчин зүйлийн нэг нь боловсролын тэгш бус байдал гэдгийг сүүлийн үеийн судлаачид тодотгон авч үзэж байна. Үүний зэрэгцээ улсын хэмжээнд нийт хадгаламж эзэмшигчдийн нэг хувь нь нийт хадгаламжийн дүнгийн 60 хувийг эзэмшдэг бол үлдсэн 99 хувь нь нийт хадгаламжийн дүнгийн 40 орчим хувийг бүрдүүлж байна.

Манай улсад орлогын тэгш бус байдал гэхээсээ хөрөнгийн тэгш бус байдал, боловсролын тэгш бус байдал, эрх мэдлийн тэгш бус хуваарилалт гээд шудрага ёс, ёс зүйд суурилах тэгш бус байдал их байгааг бид өдөр бүр харж байна. Тэгш бус байдалтай тэмцэх хамгийн шилдэг арга нь ядууралыг бууруулах, ажлын байрыг нэмэгдүүлэх, халамжийн бодлогыг нээлттэй болгож давхардал хийдлийг арилгах, амьдралын хэвшил, сэтгэлгээнд шинэчлэл хийх явдал юм.

Хүснэгт №2.

Монгол Улсын ядуурлын үнэлгээ

Үзүүлэлт	2016	2018	2020	2022
Ядуурлын хамралтын хүрээ	29.6	28.4	27.8	27.1
Ядуурлын гүнзгийрэлт	7.7	7.2	7.4	6.5
Ядуурлын мэдрэмж	2.9	2.7	2.8	2.3

Төрийн тогтворгүй байдал, улс төрийн хямрал. Төрийг улс төрийн институт болохынх нь хувьд хөнддөг мөргөлдөөнийг тодорхойлоход улс төрийн хямрал хэмээх ухагдахууныг ашиглах хэрэгтэй болдог. Улс төрийн хямрал гэдэг нь буй болсон мөргөлдөөн гүнзгийрэн хурцдах, төрийн түгшүүртэй байдал эрс нэмэгдэхэд илэрч гардаг нийгэм–улс төрийн тогтолцооны төлөв байдал юм.

Олон улсын зөрчил, мөргөлдөөнөөр нөхцөлдсөн хямралыг гадаад улс төрийн, харин тухайн улс орны дотоодоос угшилтай хямралыг дотоод улс төрийн хямрал гэж хуваан үзэж болно. Үндэсний эв нэгдэлд гадаад хүчин зүйлээс илүүтэй дотоодын хямрал аюул учруулдаг. Монгол улсад ч энэхүү улс төрийн дотоод хямрал оршиж байна. Тухайлбал гадаад хэргийн сайд асан Л.Пүрэвсүрэн өдрийн сонинд өгсөн ярилцлагадаа энэ талаар дурьдсан байдаг.

Л.Пүрэвсүрэн: Ерөнхийлөгчийн Үндэсний аюулгүй байдлын гадаад бодлогын зөвлөхөөр 10 жил ажилласан. Тэр хугацаанд олон хүн “Монголын үндэсний аюулгүй байдалд нөлөөлөх хүчин зүйл юу байна вэ” гэж асуудаг байсан. Хүмүүс голдуу буруутнаа гаднаас хайдаг. Орос уу, Хятад уу аль нь илүү аюул учруулдаг вэ гэж асуудаг. Би нэг л зүйлийг хэлдэг. Энэ хоёроос хамаарахгүй. **Нэгдүгээр зэргийн нөлөөлөх зүйл бол дотоодын эв нэгдлийн асуудал.** Дотооддоо эв нэгдэлтэй байж, гадаадад нэг цонхоор, нэг амаар ярьж байж гадаад бодлого маань амжилттай болно. Өмнөх засгийн газар биш, тэрний өмнөх, өмнөх засгийн газрууд ч гэсэн гадаад бодлогыг нэг цонхоор явуулах асуудалд алдаа гаргаж байсан. Ялангуяа хоёр хөрштэй харьцдаг асуудал дээр ихээхэн хэмжээний алдаа, дутагдал гарч байсан. Гадныхны олз болно гэсэн үг шүү дээ. Сайд нар нь өөр юм ярина, УИХ–ын гишүүд нь өөр, өөр байр суурь илэрхийлнэ³.

Засгийн газрын хямрал. Засгийн газар нэр хүндээ алдах, түүний захирамжуудыг гүйцэтгэх байгууллагууд нь үл биелүүлэх зэргээр

илэрдэг, нэн олонтаа үзэгддэг үзэгдэл. Хэрвээ засгийн газар нөхцөл байдлыг даван туулж чадахгүй байвал парламент түүнийг дэмжихээс татгалзаж, сайд нарын тэнхимийг огцруулж болно. Засгийн газрын хямрал нь лидерүүдийн болон удирдан захирах хэлбэрүүдийн халаа сэлгээг дагалдуулж болзошгүй байдаг.

Парламентын хямрал. Парламентын гаргасан шийдвэрүүд улс орны ихэнх иргэдийн хүсэл зорилгод нийцэхгүй байгаагийн улмаас хууль тогтоох засаглал дахь хүчний харьцаа өөрчлөгдөх нь бий. Үр дүн нь парламентыг тарааж, шинэ сонгууль товлон явуулах асуудал үүсдэг. Парламент дахь гол сөргөлдөгч хүчнүүд барагцаагаар тэнцүү хүчтэй байгаа тохиолдолд уг хямрал үүсч болзошгүй бөгөөд энэ нь шийдвэр гаргахад саад болж, хууль тогтоох засаглалын ажлыг саармагжуулдаг. Үр дүнд нь мөн адил парламентыг тарааж, шинэ сонгууль товлон зарлах хэрэгтэй болдог.

Үндсэн хуулийн хямрал. Энэ нь улс орны гол хуулийн үйлчлэл бараг зогссонтой холбоотой байдаг. Хямралын үед үндсэн хууль нь хууль ёсны шинжээ алдаж, түүнийг чанарын хувьд цоо шинээр хянан үзэхийг шаардана.

Улс төрийн хямрал. Засаглалын бүтцүүдийн хууль ёсны шинж байдал алдагдан, янз бүрийн төвүүдийн хоорондын харилцан ажиллагаа байхгүй болж, нэг төв нь нөгөөдөө саад хаалт, хориг тавьж, нийгэм–улс төрийн зохицуулалт, хяналтын үр нөлөө багасан, улс төрийн эсэргүүцэл багасан, улс төрийн эсэргүүцэлийн аяндаа гардаг хэлбэрүүд шатлан өргөжих явдлаар тодорхойлогдоно. Улс төрийн хямрал үүсэх шалтгаан, түүний илрэх онцлогоос хамааран улс төр судлалд дараах хэлбэрүүдийг онцлон авч үздэг. Үүнд юуны өмнө легитим чанартай болох адилсах шинжтэй хямрал, улс төрийн оролцооны хийгээд нэвтрэлтийн хямрал багтана.

Легитим буюу хууль зүйн шинжтэй хямрал:

Эрх баригч дэглэмийн зорилго ба үнэт зүйлс нь шударга засаглалын хэм хэмжээ, улс төрийн

³ Гадаад хэргийн сайд Л.Пүрэвсүрэн: Дотооддоо эв нэгдэлтэй байж, гадаад бодлогоо нэг цонхоор явуулах ёстой, Өдрийн сонин, 2015.05.14



зохицуулалтын арга хэрэгсэл, хэлбэрийн талаарх олон түмний төсөөлөлтэй зөрчилдөх үед үүснэ. Уг хямрал нь мөргөлдөөний субъектив тал луугаа шууд холбоотой байна. Чухам ийм учраас бодит байдлыг сайжруулсан ч гэсэн тэр нь иргэдийн олонхийн хүсэн хүлээж байсан хэмжээтэй жишихэд нэг их шалихгүй бол хямралд хүргэж, цаашдаа нийгмийн ил нээлттэй эсэргүүцэл юм уу бүүр хувьсгалд хүргэж болно.

Ижилсэлийн хямрал: Тухайн нийгмийн улс төрийн соёлд зонхилж байсан эрхэмлэл, үнэт зүйлс задран унаснаас үүсдэг. Энэ нь хүмүүс нийгэмд өөрийн эзлэх байр суурь, төр лүгээ ямар холбоотойгоо ухаарахын тулд оюун санааны чиг баримжаа эрж сүвэгчлэх явдлаар илэрдэг байна. Ялангуяа эрс шинэтгэл хийх үед санал болгож байгаа нийгмийн болон улс төрийн амьдралын шинэ хэм хэмжээг хувь хүний оршин амьдрахад хангалттай нэмэлт бололцоо өгөхгүй байна гэж үзсэний улмаас ижилсэлийн хямрал онцгой хурцаддаг талтай. Улс төрийн оролцооны хямрал нь эрх мэдэл олж авахыг санаархаж буйгаа зарлан тунхагладаг бүлгүүдийг улс төрийн идэвхтэй амьдралд оролцоход нь эрх баригч элит хэсгийнхэн зориудаар саад хийх явдлаар, мөн зөрчилтэй ашиг сонирхол бүхий бүлгүүдийн улс төрийн оролцоо түргэн өсөж буй нөхцөлд нутаг дэвсгэрийн бүрэн бүтэн байдал, үндэсний эв нэгдэл болон улс төрийн тогтвортой байдлыг хадгалах асуудал хурцдах байдлаар тодорхойлогддог.

Улс төрийн хүрээ байнга өргөжиж байгаа нөхцөлд засгийн эрхийн залуурт хүрэхийн төлөө өрсөлдөж буй бүлгүүдийн ашиг сонирхол төрөлжих явдал мэдэгдэхүйц ажиглагдана. Үүний сацуу нийгмийн ашиг сонирхолыг төлөөлөх системийн хөгжил сул, улс төрийн бүтэц, байгууламж нь ард иргэдийн эрэлт, мөрөөдөлд бүрэн тохирдоггүй, улс төрийн тэрс

үзэлтэн, хэт даврагчдын явууллагыг тас цохих талаар эрх баригчдын зориг шийдвэр муу байх нь нийт улс төрийн нөхцөл байдлыг хурцатгаж, засаг хийгээд нийт нийгмийн хувьд урьдаас мэдэхийн аргагүй уршиг балаг тарьдаг байна.

Нэвтрэлтийн хямрал нь нийгмийн амьдралын янз бүрийн салбарт өөрийнхөө шийдвэрийг хэрэгжүүлэх төрийн удирдлагын чадвар буурах явдлаар илэрдэг. Уг үзэгдэл үүсэх шалтгаан нь бодит бодлого болон засгийн газраас тунхагласан зорилтуудын хоорондын зөрүүтэй байдалтай холбоотой. Нэвтрэлтийн хямрал нь голдуу төв-орон нутаг гэсэн босоо чиглэлийн харилцааг нэрвэдэг аж. Үүнээс гадна иргэдийн улс төрийн туршлага бага, олон түмний ухамсар доройн улмаас төвийн шийдвэрийг буруу ташаа ойлгох явдал уг үзэгдлийг дэгдэхэд багагүй үүрэг гүйцэтгэдэг байна.

Дотоод улс төрийн мөргөлдөөн: Дотоод улс төрийн мөргөлдөөний онцлог нь улс төрийн ашиг сонирхол, манлайллын төлөөх нийгмийн аливаа анги давхраа, улс төрийн нам, хөдөлгөөн, бүлгийн хийж буй тэмцэл юм. Дотоод улс төрийн мөргөлдөөнөөс сэрэмжлэн зайлсхийх арга замууд гэвэл юуны түрүүнд, нийгмийн болон улс төрийн маневралт, улс төрийн манипуляц, сөрөг элитүүдийг өөрт нэгтгэх, системийн сөрөг хүчнийг сулруулах, түүнчлэн хүчээр дарангуйлах зэрэг арга тактик юм⁴.

Хэвлэл, мэдээлэл. Шат, шатны сонгуулийн үеэр нийгмийн цахим сүлжээгээр хүний эрхийн зөрчилтэй, үзэн ядсан, гутаан доромжилсон үймээн самуунд уриалсан постууд ихэсдэг байна⁵.

Худал ташаа мэдээлэл нь улс орны сэтгэл зүйн даван туулах чадвар, хүн амын өөрийгөө хамгаалах, хүсэл зоригийг сулруулах, хүмүүсийн үзэл бодол, зан үйл шийдвэр гаргахад зүй бусаар нөлөөлж иргэдийн түгшүүрт байдал, эргэлзээг нэмэгдүүлж, нийгмийг илүү эмзэг болгодог байна. Хуурамч мэдээллийг

⁴ ОУХХ Мөргөлдөөн, Жанчив Алтангэрэл

<https://sites.google.com/a/biliginst.edu.mn/ouhbzsh/ouhnm-rg-ld-n/lekc%D2%AF%D2%AFd>

⁵ Нээлттэй нийгэм форум., 2021 оны монгол улсын ерөнхийлөгчийн сонгуулийн сурталчилгааны үеийн фейсбүүк дэх хүний эрх, хэвлэлийн эрх чөлөөний хэрэгжилт.,2021., УБ



нийгэмд түгээснээр дараах эрсдэлийг учруулж болзошгүй юм. Үүнд:

- Ардчилсан нийгмийн нэр хүндийг унагах, улс орондоо итгэх итгэлийг алдагдуулах,
- Хувь хүнийг гүтгэж тухайн хүнийг шудрага бусаар шүүж, яллах нийгмийн суурь хөрсийг бүрдүүлэх,
- Төрийн байгуулалтуудад дарамт үзүүлж нийгэмд хохиролтой, популист шийдвэр гаргуулах,
- Иргэдийн бухимдал, эсэргүүцэл, гутранги үзлийн уур амьсгал бүрдүүлж, улмаар жагсаал цуглаанд уриалах, эх орноосоо дүрвэх хөрсийг бүрдүүлэх зэрэг байж болно.

Үүний хамгийн тод илрэл, муу үр дагавар авчирсан үйл явдал 2008 оны 7 сарын 1 –нд тохиолдож байлаа. Үүний эсрэг эвлэлдэн нэгдсэн үйл явдал 2008 оны 8 сарын 14–нд Бээжингийн олимпоос Монгол хүн анхны алтан медаль авснаар нийгэмд илрэн гарсан юм.

Эрүүгийн хуулийн 19–р зүйлийн 9–д заасан Үндэсний эв нэгдэл бусниулах (Хүмүүсийг

үндэс, угсаа, хэл, арьсны өнгө, шашны номлол, үзэл бодлоор дайсагнуулах, эвдрэлцүүлэх, салан тусгаарлахыг ухуулсан, уриалсан, ялгаварлан гадуурхсан, хүчирхийлсэн, эрхийг нь хязгаарласан, давуу байдал тогтоосон) гэмт хэрэг 2017–2023 оны хооронд 157 бүртгэгдэж шүүхээр шийдвэрлэгджээ⁶.

ДҮГНЭЛТ

1. Улс орны авилгын түшинг бууруулж, шудрага ёсыг нэмэгдүүлэх, ядуурлыг бууруулж, иргэдэд тэгш боломж олгох нь үндэсний эв нэгдлийг хангах суурь үндэс болж байна.
2. Хуурамч мэдээллийн нийгмийн сэтгэл зүйд нөлөөлөх байдлыг үнэлэх, хариу арга хэмжээ авах талаар хуулийн зохицуулалт шаардлагатай байна.
3. Үндэсний эв нэгдлийн бүрэлдэхүүн хэсгүүд, нийгмийн хүчин зүйлс, тэдгээрийн уялдаа холбоог тогтмол үнэлэх, арга хэмжээ авах цогц тогтолцооны талаар дэлгэрүүлэн судлах хэрэгцээ байна.

Ашигласан материал:

1. Монгол Улсын Үндсэн хууль 1992 он
2. Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал 2010 он
3. "Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого" 2020 он
4. Гадаад хэргийн сайд Л.Пүрэвсүрэн: Дотооддоо эв нэгдэлтэй байж, гадаад бодлогоо нэг цонхоор явуулах ёстой, Өдрийн сонин, 2015.05.14
5. ОУХХ Мөргөлдөөн, Жанчив Алтангэрэл <https://sites.google.com/a/biliginst.edu.mn/ouhzbzsh/ouhbm-rg-ld-n/lekс%D2%AF%D2%AFd>
6. Нээлттэй нийгэм форум., 2021 оны монгол улсын ерөнхийлөгчийн сонгуулийн сурталчилгааны үеийн фейсбүүк дэх хүний эрх, хэвлэлийн эрх чөлөөний хэрэгжилт., 2021., УБ
7. Ashmore, Richard D.; Jussim, Lee; Wilder, David, eds. (2001). Social Identity, Intergroup Conflict, and Conflict Reduction. Oxford University
8. Social Studies by Simiyu Wandibba, pp. 231-233.

⁵ http://case.shuukh.mn/site/statistic_full/1/41?year=2017

